САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 он

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025.12.18

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ыг тус тус баримталсан.

## Хоёр. Танилцуулга

Төрийн захиргааны удирдлагын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус газраас ирүүлсэн төлөвлөгөө, тайлангийн биелэлтийг үндсэн материал болгон ашигласан.

## Гурав. Хяналт-шинжилгээний ажлын үнэлгээ

Тус газар нь 2025 онд 7 зорилтын 82 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 94,3 хувьтай буюу "бүрэн хангалттай" үнэлэв. Үүнд: 85-аас дээш хувьтай-73, 70-85 хувьтай-3, 70 хүртэл хувьтай-5, хугацаа болоогүй-1 арга хэмжээ тус тус байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээний биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1-т үзүүлэв.

*Хүснэгт-1*

| № | Арга хэмжээ | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилт /хувиар/ | | | | Гүйцэтгэл /Хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 85 буюу түүнээс дээш "бүрэн хангалттай" | 70-85% "хангалттай" | 70 хүртэл "хангалтгүй" | ХБ | |
| 1 | Нийт арга хэмжээ | 7 | 82 | 73 | 3 | 5 | 1 | **94,3** |

*Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:*

Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|
| Стратегийн зорилт: 4.2.2.2.Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх цахим төрийн тогтолцоонд шилжинэ. | | | | |
| **Зорилт 1**: 2.4.5. төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, хууль зүйн зөвлөгөө өгөх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, гамшгаас хамгаалах асуудлыг хариуцах, салбарын болон гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх; | | | | |
| 2.5.5.1. төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, салбарын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх болон салбарын хүний эрхийн асуудал болон яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл болон аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах, гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах; | | | | |
| 1.1.1 | Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулж, орон тооны бус зөвлөлийг хуралдуулна. | Салбарын инженер техникийн ажилчид, мэргэжилтнүүдэд давтан сургасан, зэрэг олгох, сунгах ажлын тайланг орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлнэ. | Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 198 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж орон тооны бус зөвлөлийн хурлыг 4 удаа зохион байгуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | "Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл"-ийн хуралдааныг 2025 оны 01 дүгээр сарын 09, 03 дугаар сарын 18, 05 дугаар сарын 13, 09 дүгээр сарын 22 -ний өдөр зохион байгуулж хуралдаанаар Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт, үйл ажиллагааны 2024 оны тайлан, 2025 онд Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох зохион байгуулагдах "Зөвлөх, тэргүүлэх, мэргэшсэн зэрэг" горилогч, сунгагчдад зориулсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/99 дүгээр, Шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг томилох тушаалыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/02, Монголын барилгын инженерүүдийн холбооны түншлэлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталж Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/134, Шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг томилох тушаалыг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/135 дугаар тушаалаар тус тус батлуулсан. | |
| 1.1.2 | Салбарын инженер техникийн ажилчид, мэргэжилтнүүдэд давтан, зэрэг олгох, сунгах ажлыг зохион байгуулна. (Монгол Улсын Засгийн газрын Үндсэн чиглэл-2.4.2; Алсын хараа урт хугацааны бодлого-2.1.5.) | 2.000 | "Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл"-ийн хуралдааныг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт, үйл ажиллагааны 2024 оны тайланг, 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр орон тооны бус зөвлөлийн 2 дугаар хурлаар Мэргэжлийн зэрэг олгох, сунгах шалгалтын тайланг хэлэлцэж Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/54 дүгээр тушаалаар мэргэжлийн зэрэг 194 мэргэжилтэнд олгож, 401 мэргэжилтэний эрхийг сунгасан. 2025 оны 1-р сарын 29, 2-р сарын 23-ны өдрүүдэд зохион байгуулсан шалгалтад нийт 940 инженер хамрагдсан. 2025 оны 11-р сарын 03-28-ны өдрүүдэд зохион байгуулсан шалгалтад урьдчилсан байдлаар нийт 1210 инженер хамрагдсан. Шалгалтад тэнцсэн ИТА мэдээлэл 12.15-наар дуусч тайлан ирнэ. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхээр Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг Монголын Архитекторуудын эвлэл ТББ-тай 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 2025/50 дугаартай гэрээг 3 жилийн хугацаатай байгуулсан. | 100 |
| 1.1.3. | Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрмийг шинэчилж боловсруулна. | Ажлын хэсэг байгуулж, Дүрмийн төслийг боловсруулж ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох дүрэм, Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн дүрэм, Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг горилох, сунгах, шалгалтын журам боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/53 дугаар тушаалаар батлуулж ажлын хэсгийн хурлыг 5 удаа зохион байгуулж журам, дүрмийн төслийг хэлэлцсэн. Журам, дүрмийн төсөлд санал авахаар салбарын төрийн бус | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | байгууллагудад 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 08/1839 тоот бичгээр хүргүүлж, саналыг авч журам, дүрмийн төсөлд тусгасан.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн А/133 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. | |
| 1.1.4. | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулж, ТАЗ-ийн тогтоолын хэрэгжилтйг хангаж ажиллана. | Салбарын бодлогын баримт бичигт тусгуулна. ТАЗ-ийн тогтоолын хэрэгжилтйг хангаж ажиллана. | Удирдлагын академиас зохион байгуулсан цахим 3 шатны сургалтад яам, БХТ, ТОСК албан хаагчдыг Монгол хэлний онлайн сургалтад хамруулсан. Яамнаас явж байгаа албан бичиг монгол бичгээр явж хэвшсэн. Мөн албан хаагчдын нэрийн хуудас, өрөө тасалгааны хаягыг монгол бичгээр хэвлүүлж байршуулсан. Барилга, хот байгуулалтын салбарын орон тооны бус хэлний бодлогын салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, Барилга, хот байгуулалтын салбарт төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. "Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 165 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор яам болон харьяа газрууд Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, ТОСК ТӨХХК-иудад албан бичгээр тогтоолыг хүргүүлж тайланг авч Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.<br>Салбарын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 132 тушаалаар батлуулж Монгол бичгээр албан хэрэг хөтлөлт, албан хаагчдыг сургах талаар тусгуулах саналыг оруулсан. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр монгол бичгийн хөтлөлт, хэрэгжүүлж буй арга хэмжээг сайн байна гэж дүгнэсэн. | 100 |
| 1.1.5. | Салбарын ажиллах хүч, хөдөлмөрийн зах зээлд хомсдолтой мэргэжлийн судалгааг гаргаж, ИТА, ажиллах хүчин бэлтгэх их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран ажиллана. (ЗГҮАХХАХТ-2.5.10) | Хамтран ажиллах боломжтой их, дээд сургуулийг судална. эрэлттэй мэргэжилээр орон нутгаас оюутан суралцуулах нөхцөл боломжийг судалж, зохион байгуулна. | ШУТИС, Барилга, Архитектурын Сургуулийн удирдлагатай НАА-н салбарт нэн шаардлагатай байгаа дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэлд орсон "Ус хангамж, ариутгах татуургын инженерчлэл" хөтөлбөрөөр Аймгуудын нийтийн аж ахуйн байгууллагад ажиллаж байгаа болон цаашид тогтвор суурьшилтай ажиллах суралцагчдыг суралцуулах чиглэлээр уулзалтуудыг зохион байгуулсан. ШУТИС-ын Барилга, архитектурын сургуультай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж эрэлттэй ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр орон нутгаас сургах нэмэлт гэрээнд 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр яамны Төрийн нарийн бичгийн дарга, ШУТИС-ийн БАС-ийн захирал нар гарын үсэг зурсан.<br>Боловсролын зээлийн сан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам хоорондын санамж бичгийг 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр, сургалтын төлбөрийн нөхцөлт тэтгэлгийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2025/25 дугаар гэрээг тус тус үзэглэсэн.<br>Суралцагчдийг сонгон шалгаруулж Сайдын нэрэмжит тэтгэлгийг 11 дүгээр сарын 05-ны өдөр шилжүүлж 15 аймгийн суралцагч ШУТИС-ийн БАС-д суралцах эрхээ авч суралцаж байна. | 100 |
| 1.1.6. | Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлыг зохион байгуулах, тухай бүр бүртгэлд оруулна. | Аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн ажлын байрны төлбөрөөс хөнгөлүүлэхээр холбогдох газарт | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 99 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөх журам", 2025 онд | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | (ЗГҮАХХАХТ-2.5.10) | асуудлыг уламжилна. Засгийн газрын шугамаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, шинэ хотын бүтээн байгуулалтын ажилд гадаадаас ажиллах хүч авах ажлыг зохион байгуулж ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 31, 49, 96, 155 дугаар тогтоолоор 57 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 17,562 гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн. Эдгээр тогтоолын хэрэгжилтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар гаргахад 17,562 гадаад ажилтнаас 8,708 гадаад ажилтан Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр орж ирсэн байна.<br>Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэл, шинэ хотын бүтээн байгуулалтын ажилд 2026 онд гадаадаас ажиллах хүч авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлт ирүүлсэн 15 аж ахуйн нэгжийн хүсэлтийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/4259 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.1.7. | ХББОС-ын сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээ, төлөвлөгөөг боловсруулж, байгуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ. (ЗГҮАХХАХТ-4.2.10) | ХББОС-ын сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээг байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | ХББОС-ын сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн 2025 оны гэрээнд хавсаргасан.<br>ХББОС-ын сайд аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах гэрээний төслийг бэлтгэн гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр байгуулсан.<br>Аймаг , нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор авч нэгтгэн ХШҮ хийлгэж ажлыг дүгнэхээр ажиллаж байна. | 100 |
| Зорилт 2: Нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн хүрээнд төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, төрийн зарим чиг үүргийг нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагуудаар төлөөлүүлэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (ЗГҮАХХАХТ-4.2.10) | | | | |
| 1.1.8 | Салбарын 3 талт хэлэлцээр, төлөвлөгөөний биелэлтийг хангуулахад дэмжлэг үзүүлнэ. | Салбарын 3 талт хэлэлцээр, төлөвлөгөөний биелэлтийг хангуулахад дэмжлэг үзүүлнэ.<br>3 талт хамтын хэлэлцээрийн төсөлд ирүүлсэн саналуудыг нэгтгэж, талуудтай уулзалт зохион байгуулж, 2025-2027 оны барилгын салбарын 3 талт хамтын хэлэлцээрийг байгуулна. | Салбарын 3 талт хэлэлцээр, төлөвлөгөөний биелэлтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлж үнэлгээ хийлгэсэн. 2025-2027 оны Барилгын салбарын гурван талт хамтын хэлэлцээрийн төслийг Монголын Барилгачдын нэгдсэн холбоо, Монголын Барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоотой хамтран боловсруулж яамны ББМҮБЗГ, Хуулийн хэлтсээс саналыг авч нэгтгэн боловсруулсан.<br>3 талтай 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр уулзалт зохион байгуулж хэлэлцээрийн төсөлд нэгдсэн. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 216 дугаар тушаалаар Хамтын хэлэлцээрт оролцох, хэлэлцээр байгуулах тухай тушаалыг гаргасан.<br>Хамтын хэлэлцээрт 2025 оны 12 дугаар сард гарын үсэг зурахаар бэлтгэл хангаж ажиллаж байна. | 100 |
| 1.1.9. | Хүний эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулна. | Тайлан-2<br>Барилгын салбарын хүний эрхийн шинжээчдийн сургалтыг зохион байгуулна. | НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 03/308 тоот албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.<br>Улсын Их Хурлын 2024 оны 37 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан болон Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/661 тоот албан | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | бичгээр Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтоолоор батлагдсан "Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)"-ний тайланг гаргаж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн.<br>Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй Өөрчлөлтийн элч төлөөлөгчид: "Хариуцлагатай бизнес ба хүний эрх, Хүний эрхийн магадлан шинжилгээ" сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтад Барилгын салбарт хүний эрхийн магадлан шинжилгээ хийх зорилгоор салбарын төрийн болон төрийн бус байгууллагын 21 мэргэжилтэнг 2025 оны 11 дүгээр сарын 27-28-ний өдрүүдэд хамруулсан.<br>2025 оны Хүний эрхийн үндэсний форумын "Хамтын эрх-хариуцлага" сэдвийн хүрээнд нэгдсэн хуралдаан болон "Хүний эрх ба уур амсгалын өөрчлөлт, ногоон хөгжил", "Хүний эрх ба хот төлөвлөлт", Хүний эрх ба бизнес" салбар хуралдаанд 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр оролцов. https://mcud.gov.mn/p/423 | |
| Зорилт 3.<br>2.5.5.2. салбарын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулах, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайдын гадаад, дотоод айлчлалыг зохион байгуулах, яамны үйл ажиллагааг хэвлэл мэдээллээр сурталчлах, туслалцаа үзүүлэх;<br>Салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, төрийн албан хаагч, инженерийн ёс зүйн чадамжийг дээшлүүлэхэд холбогдох ажлыг зохион байгуулна. (ЗГҮАХХАХТ-2.5.8; 4.2.5; 4.2.7) | | | | |
| 1.1.10 | Салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах, Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 51 | Салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөлийн 2024 оны тайлан, мэдээг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03/111 тоот албан бичгээр Жендэрийн Үндэсний хороонд хүргүүлсэн.<br>Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргаас 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хэг/1561 тоот албан бичгээр ирүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу Засгийн газраас Улсын Их Хуралд танилцуулагдах Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн Монгол Улсын Засгийн газрын тайланд тус яам 60.5 хувийн үнэлгээтэйгээр үнэлэгдсэн болно. | 100 |
| 1.1.11 | http://medee.1212.mn/ тайлан мэдээ боловсруулалтын цахим системд төрийн захиргааны төв байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн жилийн мэдээ /б-жэтб-1/-г **оруулна.** | Цахим систем мэдээ-1 | http://medee.1212.mn/ тайлан мэдээ боловсруулалтын цахим системд төрийн захиргааны төв байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн 2024 оны жилийн мэдээ /б-жэтб-1/-г 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр оруулж баталгаажуулсан болно. | 100 |
| 1.1.12 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулна. | Сайдын тушаал -1<br>Бодлогын баримт бичиг -1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөө, төсвийг батлуулсан. Энэ хүрээнд Жендэрийн | 50 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэхээр тусгасан болно. Жендэрийн талаар баримтлах бодлого, төлөвлөгөөг салбарт хэрэгжүүлж ажиллах тухай албан бичгийг харьяа газар, төслийн нэгжүүдэд 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 03/483 тоот албан бичгээр хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын хугацаа 2025 оны 12 дугаар сард дуусч буйтай холбогдуулан хяналт, шинжилгээ үнэлгээг хийлгэхээр талуудтай яриа хэлэлцээрийн шатанд байна. | |
| 1.1.13 | Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулна. Хэрэгжилтийг ЖҮХ-нд тайлагнан ажиллана. | Төлөвлөгөө-1<br>Тайлан-1<br>Хурлын тоо-2 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж, салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөө, төсвийг батлуулсан.<br>Хэрэгжилт, явцын тайланг ЖҮХ-нд 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 08/1180 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.<br>Жендэртэй холбоотой тайлан, мэдээг тухай бүр орон тооны бус зөвлөлийн Viber группт байршуулан ажиллаж байна. | 100 |
| 1.1.14 | БХБЯ, Монголын Мянганы сорилтын сан хооронд байгуулсан салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд холбогдох ажлыг зохион байгуулна. | тайлан – 1 | “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд МСС-ын төлөөллийг Жендэрийн орон тооны бус зөвлөлд оролцуулан ажиллаж байна. Жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин бүрдүүлэхийг уриалж РИЙЛ танилцуулга хийхэд МССантай хамтран ажилласан.<br>2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй барилгын салбар” хэлэлцүүлгийг МСС, Азийн хөгжлийн банк, Монгол дахь GIZ ”Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төсөлтэй хамтран зохион байгуулж ТББ, аж ахуйн нэгжийн төлөөлөл 80 гаруй хүн оролцсон. https://www.facebook.com/share/v/1APaE96JUt/ | 100 |
| 1.1.15 | Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулна. | Сургалт – 1<br>Үзлэг – 1 | 2025 оны 03 дугаар сарын 26- ны өдөр “ХББОСЯ-ны албан хаагчдад “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах арга хэмжээ” сургалтыг ОБЕГ-ын хурандаа н.Галбадрах тэргүүтэй албан хаагчид ирж танилцуулсан.<br>2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг иргэд, олон нийтэд таниулах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуульд яамны 41 албан хаагч хамрагдсан.<br>Онцгой байдлын ерөнхий газар зохион байгуулагдсан “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах” хэлэлцүүлэгт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын улсын албыг төлөөлөн 2025 оны 04 дүгээр сарын 01-04-ний өдрүүдэд оролцсон.<br>Төрийн ордны Онцгой байдын албанаас зохион байгуулсан “Байгууллагын гамшгийн эрсдлийн үзлэг”-т 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр хамрагдав.<br>2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, “ТОСК” ТӨХХК-ийн 40 гаруй албан хаагчид Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дугаар анги дээр "Гамшгийн удирдлагын менежмент", "Газар хөдлөлт ба туршлага сургамж" биет дадлага, сургалтад хамрагдсан.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Улсын албаны шуурхай штабын 2023-2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг Үндэсний аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 02/3861 тоот албан бичгээр хүргүүлэв. | |
| 1.1.16 | Эрсдэл ба стандарт" үндэсний форумааср гарсан санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана. | Төлөвлөгөө, тайлан-1<br>Тайлангийн хэрэгжилтийн хувь-80 | Эрсдэл ба стандарт" үндэсний форумаас гарсан санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох газруудаас авч нэгтгэн ОБЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| 1.1.17 | Хот байгуулалт, барилга, оррон сууцжуулалтын яамны үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг яамны газар, хэлтсүүд, ТББ-тай хамтран зохион байгуулна. | Сургалт-1<br>Хэрэгжилтийн хувь-80 | Дотоод газар, хэлтсүүдэд 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 08/1048 тоот албан бичгээр төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах тухай үүрэг чиглэлийг хүргүүлсэн. | 50 |
| 1.1.18 | Олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ISO -365 хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ. | Тайлан-1 | ISO-365 хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар батлуулан ажиллаж байна. | 100 |
| 1.1.19 | Жендэрийн Үндэсний хороо, Гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний зөвлөлийг шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаагаар ханган салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллана. | Судалгаа мэдээлэл-1 | Жендэрийн үндэсний хороо, Гамшгийн эсрдлийг бууруулах үндэсний зөвлөл, ОБЕГ-тай тухай бүр хамтран ажиллаж шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллаж байна. Тухайлбал:<br>1. Жендэрийн боловсролыг нэмэгдүүлэх мэдээ, мэдээллийг түгээх, бодлогын нөлөөллийн 1 сарын аяны хүрээнд тус яамны зүгээс хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Жендэрийн үндэсний хороонд 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 08/1180 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2. Улсын онцгой комиссын 2024 оны 06 дугаар хурлын тэмдэглэлээр өгөгдсөн тус яамны эрхлэх асуудлыг хүрээнд хамаарах үүрэг даалгаврын биелэлтийг гарган 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03/110 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>3. Улсын онцгой комиссын 2024 оны IV хурлын тэмдэглэлээр өгөгдсөн тус яамны эрхлэх асуудлын хүрээний 8 арга хэмжээний хэрэгжилтийг гарган 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 03/276 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>4. НҮБ-ын дэргэдэх Гамшгийн эрсдлийг бууруулах чадавхийг хэрэгжүүлэх түншлэл буюу Кадри түншлэлийн үнэлгээнээс гарсан зөвлөлжийг хэрэгжүүлэх хэлэлцүүлэгт 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдөр оролцов.<br>5. Европын Холбооны санхүүжилттэй, НҮБ-ын Хүн Амын Сантай хамтран Жендэрийн үндэсний хорооноос хэрэгжүүлж буй "Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд "Менторшип" хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, менторуудын | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нэгдсэн уулзалтад 2025.03.31-ний өдөр оролцов.<br>6. 2025 оны 05 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд "Жендэрийн эрх тэгш байдал ба уур амьсгалын өөрчлөлт" Олон Улсын хуралд оролцов.<br>7. Онцгой байдлын ерөнхий газар зохион байгуулагдсан "ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ" хэлэлцүүлэгт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын улсын албыг төлөөлөн 2025 оны 04 дүгээр сарын 01-04-ний өдрүүдэд оролцов.<br>8.Гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга, ОБЕГ-ын хошууч генерал Г.Ариунбуянд 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 03/2230 тоот албан бичгээр ГЭБҮЗ-ийн 2024 оны 01 дүгээр зөвлөмжийн биелэлтийг хүргүүлэв.<br>9. Гамшгийн эрсдлийг бууруулан Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх II үе шатны хэрэгжилтийн ХББОСЯ хамаарах хэсгийн биелэлтийг гарган ОБЕГ-ын дарга, Гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга хошууч, генерал Г.Ариунбуянд 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 01/3779 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>10.Кадри түншлэлийн үнэлгээнээс гарсан тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зөвлөмжийн биелэлтийг гарган ОБЕГ-т 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 01/3775 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>11.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний төсөлд ХББОС-ын улсын албаны чиг үүргийн талаарх саналыг 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 01/3813 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>12.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Улсын албаны шуурхай штабын 2023-2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг Үндэсний аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 02/3861 тоот албан бичгээр хүргүүлэв. | |
| 1.1.20 | Ажиллагсдын ажлын орчин нөхцөлийн Жендэрийн мэдрэмжийг үнэлэх тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт, шалгах хуудсыг сурталчлах зорилгоор постер гаргана. Рийл хийлгэнэ. | Тайлан-1 | Жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин бүрдүүлэхийг уриалж РИЙЛ танилцуулга хийж яамны вэб хуудас болон фэйсбүүк группт байршуулсан. https://www.facebook.com/share/v/18XLpvApaq/ /2025.04.01-ний өдрийн байдлаар 14.5 мянган хандалттай байна/<br>А3 зурагт хуудас 500 ш хэвлүүлэн салбарын аж ахуйн нэгж байгууллагуудад хүргэх ажлыг Төрийн бус байгууллагуудаараа уламжлан түгээж байна. Түүнчлэн qr код үүсгүүлэн яамны web хуудас болон зурагт хуудаст байршуулж, ингэснээр аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогч, ажилтан "Ажиллагсдын ажлын орчин нөхцөлийн жендэрийн мэдрэмжийг үнэлэх тоон болон чанарын багц шалгуур үзүүлэлт болон ажилчдын байрны шалгах хуудас"-ыг бүрэн эхээр нь үзэх боломжтой болсон. https://www.facebook.com/photo/ | 100 |
| 1.1.21 | Ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах Япон менежмент-5s стандартыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд | Тайлан-1 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны тайлан, сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хийсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нэвтрүүлэх удирдамжийг батлуулна. | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн анхдугаар хурал 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр ХБХХЕГ-т зохион байгуулагдсан.<br>2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03/627 тоот албан бичгээр харьяа газар, төсөл хөтөлбөрүүдэд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр 8 чиглэлийг хүргүүлсэн.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, орон тооны бус Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг ХББОСС-ын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 77 дугаар тушаалаар батлуулсан.<br>ХБХЭХОБТ бус дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулан батлуулахаар хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баталсан.<br>2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан "Бүсчилсэн хөгжил-Салбарын санхүүгийн чадамж-нийгмийн баталгаа" сэдэвт Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтын зөвлөгөөнд "Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь", "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ба тэдэнд хүртээмжтэй ажлын байрны тохируулга хийх нь" сэдвээр АХБ-ны Жендэрийн зөвлөх Б.Болорцэцэг, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны тэргүүн Б.Чулуундолгор нар илтгэл тавьсан.<br>Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан яамны албан хаагчдын хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн үйлдвэрлэсэн "Тэрэм" Монгол бэлэг дурсгалын бараа бүтээгдэхүүнээс худалдан авалт хийж дэмжлэг үзүүлсэн.<br>2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт болсон "Өглөөний уулзалт"-д оролцож салбарт ХБИ талаар хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар санал солилцов.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газарт 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 03/2256 тоот албан бичгээр "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний биелэлтийг гарган хүргүүлэв.<br>Mongolia try 2025 арга хэмжээний хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр 2025.06.13-ны өдөр ХБХХЕГ-т зохион байгуулагдсан арга хэмжээнд СХОСБГ-ын ОСХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Одбаатарын хамт оролцсон болно.<br>2025 оны 08 дугаар сарын 14-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилт ба улсын төсөв" Санхүүгийн бодлогыг хүний эрхэд нийцүүлэх нь хэлэлцүүлэгт НААДБХ-ийн дарга Э.Батболд оролцож "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2026 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний талаар мэдээлэл хийсэн болно. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | УИХ-ын Хүний эрхийн дэд хорооноос НҮБХХ-ийн дэмжлэгтэй НҮБийн Хөгжлийн бөрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос МУ-ын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжүүдийг 2025-2031 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төвлөгөөг хэлэлцүүлэх хэлэлцүүлэгт 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр тус яамны төлөөлөл 3 албан хаагч оролцов.<br>"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг гарган албан бичгээр хүргүүлсэн.<br>2025 оны 12 дугаар сарын 08-нд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн мэдрэмжтэй бодлого төвлөлт хэлэлцүүлэгт яамны дэд зөвлөлийн 5 гишүүнийг оролцуулахаар нэрсийг хүргүүлсэн.<br>Мөн яамны web хуудасанд Хүний эрх ба Жендэр цонхийг нээж холбогдох мэдээ, мэдээлэл, ХБИ-ийн хүртээмжтэй холбоотой видео танилцуулга зэргийг байршуулсан. https://mcud.gov.mn/p/423 | |
| 1.1.22 | Техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авна. | 2 | 1. Сургалтын чөлөөний гэрээний хугацаа хугацаа дуусаж ТНБД-ын 2025 оны Б/12 дугаар тушаалаар Төрийн захиргааны удирдлагын газрын салбарын олон талт хамтын ажиллагаа, менежмент хариуцсан ахлах мэргэжилтнээр Пүрэвжавын Билгүүнтөрийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн томилж, өөрийнх нь гаргасан хүсэлт, хоёр байгууллагын удирдлагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр ТНБД-ын 2025 оны Б/21 дүгээр тушаалаар Соёл ,спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны мэдэлд 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөр тасалбар болгон шилжүүлсэн.<br>2. Сургалтын чөлөөний хугацаа нь дуусаж ТНБД-ын 2025 оны Б/20 дугаар тушаалаар Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн даргаар Содномцэрэнгийн Должинсүрэнг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс томилсон. Тэрээр "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын дагуу шалгалтад хамрагдан хамгийн сайн үнэлгээ авч ТНБД-ын 2025 оны Б/78 дугаартай тушаал 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөр тасалбар болгон Боловсролын яамны мэдэлд шилжсэн. | 100 |
| 1.1.23 | Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санд орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, шинэчлэлийг хийж хэвшүүлнэ. | 1. Албан хаагчдын дотоод цахим сүлжээ егр-emongolia.mn холбох<br>2. Мэдээллийн санг хүний нөөцийн хөдөлгөөн бүрд шинэчлэл хийнэ.<br>3. ХНУМТ-ны цахим системд албан хаагчдын мэдээллийг тухай бүр оруулна. | Монгол Улсын засгийн газрын 2024 оны 238 дугаар "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ"-ний дагуу бүх албан хаагчдын цалингийн мэдээллийг хүний нөөцийн программд шинэчлэн бүртгэсэн. Мөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд 2024 оны 136 дугаар "Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв, нэмэгдэл олгох тухай" тушаалаар зэрэг дэв шинээр болон ахиулан авч байгаа албан хаагчдын цалингийн нэмэгдлийг бүртгэсэн. Нэг өдрийн хоолны хөнгөлөлт нэмэгдсэнтэй холбоотой бүртгэлийг хийсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1.24 | Яамны "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах | 1.Төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсээр тайлагнасан байна.<br>2.Нийгмийн баталгааг хангахад чиглэсэн эрүүл, мэндийн болон бусад төрлийн дэмжлэгийг нийт албан хаагчдын хэмжээнд үзүүлсэн байна. | Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах бэлтгэлийг хангаж эрүүл мэндийн байгууллагатай тохирсон боловч санхүүгийн асуудлаас шалтгаалан түр хойшлогдсон.<br>Хагас жилийн гүйцэтгэлийн тайлангийн үр дүнгээр урамшуулал олгосон.<br>Шүүхийн үйл ажиллагаанд амжилттай оролцож төсөвт учирсан их хэмжээний хохирлыг төлүүлэх шийдвэр гаргуулсан холбогдох албан хаагчдад урамшуулал олгосон. Мөн ажилдаа үр бүтээл идэвх санаачилга гаргасан 8 албан хаагчийг Төрийн дээд одон медалиар шагнуулахаар уламжилж шагналыг гардуулсан. Салбарын шагналаар 6 албан хаагчийг шагнасан байна.<br>Ар гэрийн гачигдал гарсан, шинээр эцэг эх болсон албан хаагчдад дотоод журмын дагуу мөнгөн тэтгэлэг, түлээ түлшний хөнгөлөлт олгох шийдвэрүүдийг гаргуулсан.<br>Цалинтай цалингүй чөлөөг удирдлагын шийдвэрийн дагуу гаргасан хүсэлтийг нь үндэслэн олгож ажилласан. | 50 |
| 1.1.25 | Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулна. | Төлөвлөгөө – 1<br>Тайлангийн хэрэгжилтийн хувь | Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 59 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 6.1-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг 2025.01.16-ны өдрийн 11/187 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 12-ний өдрийн ээлжит хурлыг зохион байгуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу Төрийн албаны эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр болон ахиулан олгох албан хаагчдын мэдээллийг нэгтгэн 2025.01.15-ны өдрийн 01/170 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг яамны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг 2025.01.21-ний өдөр зохион байгуулж, шалгалт зохион байгуулсан тайланг 2025.01.27-ны өдөр Салбар зөвлөлийн ээлжит хуралдаанд танилцуулж, сонгон шалгаруулалтад оролцсон иргэдийг нэр дэвшүүлсэн. Мөн Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны "Ажлын хэсэг байгуулах" тухай 04 дүгээр тогтоолын дагуу тус яамны гүйцэтгэх албан | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны тусгай шалгалтыг 2025.04.24-ний өдөр зохион байгуулж, шалгалт зохион байгуулсан тайланг салбар зөвлөлийн 2025.04.29-ний өдрийн ээлжит хуралдаанд танилцуулж, сонгон шалгаруулалтад оролцсон иргэдийг нэр дэвшүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны 159 дугаар тушаал 2025 оны "Төрийн албаны өдөр"-ийг угтан зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон 2025 оны 15 дугаар тушаал "Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл аяныг зохион байгуулах тухай"-уудаар баталсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн нарийн бичгийн даргаар яамны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Төрийн албаны өдөр-2025"-ийг угтах арга хэмжээний төлөвлөгөө болон "Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяныг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төрийн албан хаагчдын төрийн албанд ажиллахын давуу талыг илэрхийлсэн 3 видео контентийг бэлтгэн яамны цахим сүлжээ болон Төрийн албаны зөвлөлийн цахим сүлжээнд байршуулж олон нийтэд хүргэсэн. "Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн" сэдвээр хийсэн хүний нөөцийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр батлуулсан. | |
| 1.1.26 | Албан хаагчдын хувийн хэрэг, тоо бүртгэлийг хөтлөх, хувийн хэрэгт баяжилт хийх, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүлнэ. | 1.Нийт албан хаагчдын анкет, хувийн хэргийг бүрдэлийг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу дахин шинэчлэх ажлыг зохион байгуулсан Төрийн албаны үйл ажиллагааны чиглэлээр хийгдэх хяналт шалгалтад хамрагдаж, зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлнэ. | Албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийж, тоо бүртгэлийг хөтлөн, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж ажилласан. | 100 |
| 1.1.27 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хэрэгжиж буй төслийн нэгжийн сул орон тоог нөхөж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. | Төслийн нэгжүүд бүтэн орон тоогоор ажиллана. | 2025 оны эхний хагас жилд нийт хэрэгжиж буй төслүүдийн сул орон тоог нөхөх тухай ирүүлсэн хүсэлтийн дагуу 6 ажлын байрны сонгон шалгаруулалтын зарыг хүргэж сул орон тоог нөхөж ажилласан. | 100 |
| 1.1.28 | Салбарын шагналаар шагнуулах хүсэлт хууль журмын дагуу шийдвэрлэгдсэн байх ажлыг зохион байгуулна. | Шагнагдсан хүний тоо-1600<br>Тушаалын тоо-4 | Салбарын шагналаар шагнуулах 200 гаруй байгууллагын ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч Сайдын тушаалаар нийт 1600 гаруй хүн салбарын шагналаар шагнагдсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1.29 | Яам, харьяа байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчид, салбарын ахмадуудыг төрийн дээд одон медалиар шагнуулах асуудлыг хууль журмын дагуу шийдвэрлүүлэх хүсэлтийг холбогдох дээд байгууллагад уламжлах | Уламжилсан хүний тоо-80<br>Шагнагдсан хүний тоо-75 | "Журам шинэчлэн батлах тухай" ХББОС-ын сайдын 2025.02.21-ны өдрийн №47 дугаар тушаалыг баталгаажуулж салбарын шагналаар шагнуулах журмыг холбогдох нэгжүүд, салбарын ТББ-аас санал авч шинэчилсэн. Яамны веб хуудаст байршуулж олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан.<br>Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан салбарын шагналаар шагнуулах төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтүүдийг хүлээн авсан.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалт ТНБД-ын 2025 оны 08 дугаар сарын 01-ний Б/117 тушаалаар өөрчлөгдсөн тул шагналын асуудлыг хүний нөөцийн ахлах шинжээч хариуцаж байна. Төрийн дээд одон медалиар шагнуулах 80 гаруй хүсэлтийг хүлээн авч холбогдох дээд байгууллагад уламжилж ажилласан. Шагнуулсан 70 гаруй хүний шагналыг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. | 100 |
| 1.1.30 | Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг нэгтгэж батлуулах, тайлагнах ажлыг зохион байгуулна. | Батлагдсан төлөвлөгөө-1<br>Тайлан-2,<br>хэрэгжилт-97%-д хүрнэ | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 8 газар, 10 хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн баталгаажуулах ажлыг зохион байгуулав.<br>Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр шинэчлэгдэн батлагдсан тул тус яамны 6 газар, 5 хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 08 дугарын 05-нд шинэчлэн батлуулав. | 100 |
| 1.1.31 | Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг бүртгэлжүүлж, холбогдох нэгжид хүлээлгэн өгч хугацаандаа шийдвэрлэхэд хяналт тавьж ажиллана. | Тайлан -4<br>Хэрэгжилтийн хувь-95% | 2024 оны жилийн эцсийн тайланг 2025.01.07-ны 03/63 албан тоотоор ЗГХХГ-т хүргүүлсэн. Нийт 2690 өргөдөл гомдол ирүүлсэн ба шийдвэрлэлт 98%, хяналтад 25 өргөдөл гомдол байсан.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, түүний харьяа байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын I,II,III улирлын шийдвэрлэлтийн тайланг 2025 оны 04.11-ний өдрийн 03/1280, 07.03-ны өдрийн 03/2615, 10.06-ны өдрийн 02/3745 албан тоотоор тус тус ЗГХХГ хүргүүлсэн.<br>2025 оны 01 сараас 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс тус яаманд шилжүүлсэн өргөдөл, санал хүсэлт, гомдлын тайланг 12 дугаар сарын 04-ний өдөр цахимаар илгээсэн. Нийт 150 өргөдөл шилжүүлсэнээс 128 өргөдлийг шийдвэрлэж (шийдвэрлэлт 82,5%) хяналтанд 22 өргөдөл гомдол байна.<br>Жилийн эцсийн тайланг 1 дүгээр сард ЗГХХГ-т танилцуулах бэлтгэлийг хангаж байна.<br>Иргэн төвтэй төрийн албыг төлөвлшүүлэх ажлын хүрээнд яам, иргэдийг хүлээн авч уулздаг өдөр, хуваарийг гарган мөрдүүлж, иргэдээс тавьсан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, үйлчилгээний соёл, чанарыг төлөвшүүлэх арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосны дагуу Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын иргэдийг хүлээн авч уулзах өдрүүдийн хуваарийг гарган баталгаажуулж, сайд болон яамны удирдлагатай биечлэн уулзах хүсэлт гаргасан 30 гаруй иргэдийг 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авч уулзаж мэдээ мэдээлэл өгч, санал хүсэлтийг нь сонсох ажлыг зохион байгуулсан. Иргэдээс санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авах 264556 дугаарын утсыг ажилуулж байна. 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр Удирдлагын зөвлөлийн хурлаар иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар мэдээллийг сонсож, хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, хариуг хугацаанд нь хүнд сурталгүй, шуурхай шийдвэрлэх үүргийг өгч, хяналт тавьж ажиллаж байна.<br>Мэдээллийн самбарыг шинэчлэн байршуулж иргэдийн санал хүсэлт авах хайрцагийг ажилуулж байна. | |
| 1.1.32 | Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж ахмадын хороотой хамтарч ажиллана. | Арга хэмжээ-2<br><br>Сэтгэл ханамжийн хувь-100% | ХББОС-ын сайд Ж.Батсуурь Хөдөлмөрийн баатрууд, салбарын ахмад эрдэмтэдийг хүлээн авч уулзаж хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулав. Сар шинийн баярыг тохиолдуулан яамны "Ахмадын зөвлөл"-тэй хамтран 61 ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн.<br>Ахмадын баярыг тохиолдуулан яамны ахмадын зөвлөлтэй хамтран 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, салбарын сайд, орлогч сайд, алдар цолтой ахмадууд, тус яамнаас өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 80 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.<br>Нас барсан ахмадуудад хүндэтгэл үзүүлж эмгэнэлийг яамны пэйж хуудас болон веб сайтад тавьсан. | 100 |
| 1.1.33 | Алдар цолтой, мөнгөн урамшуулал авдаг ахмадын бүртгэлийг үүсгэж сар бүр мөнгөн урамшууллыг олгох ажлыг зохион байгуулж СЯ-нд мэдээллийг хүргүүлж шийдвэрлүүлнэ. | Нэгдсэн бүртгэл-1<br><br>Ахмадын тоо-161 | Шинээр алдар цол хүртсэн ахмадын урамшуулал авах хүсэлтийг шуурхай хүлээн авч шийдвэрлэж байна.<br>Алдар цолтой, мөнгөн урамшуулал авдаг 174 ахмадын мөнгөн урамшууллыг олгох ажлыг зохион байгуулж СЯ-нд мэдээллийг хүргүүлж байна. 2025 онд 18 ахмад Гавьяат цол хүртэж алдар цолны урамшуулал авах хүсэлт ирүүлсэнийг хүлээн авч СХОГ-т танилцуулж шийдвэрлүүлсэн. | 100 |
| 1.1.34 | Яамны ахмадуудыг төрийн дээд одон медалиар шагнуулах асуудлыг хууль журмын дагуу шийдвэрлүүлэх хүсэлтийг холбогдох дээд байгууллагад уламжлах | Уламжилсан хүний тоо-80<br>Шагнагдсан хүний тоо-75 | Яам болон салбарын хэмжээнд 2025 онд Гавьяат цол хүртсэн 20 гаруй ахмад, бусад төрийн дээд одон медалиар шагнагдсан ахмадын тоо 70 гаруй байна. | 100 |
| 1.1.35 | Сайдын зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж, гишүүдийг мэдээ мэдээллээр хангах, хуралдаанаас гарсан шийдвэрийг холбогдох нэгжид хүргүүлж ажиллана. | Хэлэлцэх асуудлын тоо-<br>8-аас доошгүй<br><br>Шийдвэрийн тоо- 8-аас доошгүй | Сайдын зөвлөл 03.25-ны өдөр хуралдаж 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Хуралдааны бэлтгэл ажлыг зохион байгуулж, тэмдэглэл хөтөлж, хуралдаанаас гарсан шийдвэрийг албажуулан холбогдох газруудад хүргүүлсэн. | 100 |
| 1.1.36 | Удирдлагын шуурхай зөвлөгөөнөөр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, тайлагналыг зохицуулалтаар хангана. | Өгсөн үүрэг даалгаврын тоо-80-аас доошгүй<br><br>Биелэлтийн хувь- | Сайдын шуурхай 9 удаа, ТНБД-ын шуурхай 18 удаа тус тус хуралдаж нэгжийн дарга нартай цаг үеийн мэдээ мэдээллийг ярилцаж, шуурхай үүрэг даалгаврыг өгч ажилласан. Өгсөн үүрэг даалгаврын | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 100%. | тэмдэглэлийг хөтөлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | |
| 1.1.37 | Төрийн болон байгууллагын нууцтай холбоотой үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна. | Бүртгэл хөтлөгдсөн байна.<br>Архивын нэгж бүрдүүлсэн байна. | Нууцын зэрэглэлтэй албан бичгийг хүлээн авч холбогдох албан тушаалтанд танилцуулж, хариу бичгийн боловсруулалт, хадгалалтад хяналт тавьж холбогдох байгууллагад нууцын зэрэглэлтэй хүргэн ажиллаж байна.<br>ТЕГ-тай хамтран төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт, кибер аюулгүй байдал болон цахим орчинд ажиллах тухай сургалтыг зохион байгуулсан. Төрийн болон албаны нууцтай холбоотой тайлан мэдээг ТЕГ-т хүргүүлж ажилласан. | 100 |
| 1.1.38 | Байгууллагын бичиг хэргийн эргэлтийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулж, баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллана.<br>Албан хэрэг хөтлөлтийг монгол бичгээр хөтлөх ажлыг зохион байгуулалтаар хангах | 12000 | 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд 7187 албан бичиг ирж, 4568 албан бичиг явуулсан байна. Нийт ирсэн 7187 албан бичгийн 2816 нь хариугүй, 4371 нь хариутай албан бичиг ба үүнээс 4008 албан бичгийг шийдвэрлэсэн, шийдвэрлэх шатандаа буюу судлагдаж байгаа 363 албан бичиг байна.Шийдвэрлэлт 91,6%.<br>Нийт 21 удаа хугацаа хэтэрсэн мэдээ болон баримт бичиг хянан шийдвэрлэсэн мэдээг гаргаж удирдлагуудад болон яамны дотоод сүлжээнд танилцуулсан.<br>Архивын ерөнхий газартай хамтран албан хаагчдын дунд "Архив, албан хэрэг хөтлөлт"-ийн талаарх сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан.<br>Нийт явуулсан 4568 албан бичгийн 2682 буюу 58,7% нь цахимаар явуулсан албан бичиг байна. Цаасан суурьтай албан бичгийг монгол бичгээр давхар хөтлөн явуулж байна. | 100 |
| 1.1.39 | Байгууллагын архивын үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм журам, стандартад нийцүүлэн хөтлөнө.<br>Албан хэрэг хөтлөлтийг монгол бичгээр хөтлөх ажлыг эрчимжүүлэх | | Албан хаагчдаас архивын хадгаламжийн нэгжийг цахим файлын хамт хүлээн авч цэгцэлсэн.<br>Иргэд, байгууллага, албан хаагчдад бүртгэлийн дагуу архивын лавлагаа хэсэгчилсэн хуулбар олгосон.<br>Байгууллага, албан хаагчдад архивын баримтыг түр ашиглуулахаар олгосон<br>1, 3 давхрын архивын өрөөг цэгцэлж 2012-2024 оны байнга хадгалах архивын баримтуудыг бүртгэлтэй тулган шинээр өрж байршуулсан.<br>Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ээлжит улсын үзлэгээр 80,3% дүгнэгдэж хангалттай үнэлгээ авсан.<br>Дотоод зохион байгуулалтын нэгжүүдээс 2024 оны баримтуудыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээн авч техник боловсруулалтын ажлыг хийж 1185 хадгаламжийн нэгж бүрдүүлж үдэж хавтаслан байршуулсан. | 100 |
| 1.1.40 | Салбарын үйл ажиллагааг сурталчилах арга хэмжээг холбогдох харьяа байгууллагуудтай хамтран зохион байгуулах | 30 гаруй байгууллагатай хамтарч ажиллана.<br>1300 гаруй мэдээ мэдээлэл бэлтгэнэ. | 25 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж яамны пейж хуудас, цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сайтуудад 1600 гаруй мэдээ мэдээлэл, шторк, ярилцлага, реел бэлтгэж олон нийтэд түгээн ажилласан.<br>"Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн төсөлд тусгагдсан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны "Инженерийн дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна", "Орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ" гэсэн үр дүнгүүдийн хүрээнд бодлогын өөрчлөлт, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хийж хэрэгжүүлэх ажлыг танилцуулсан танилцуулга мэдээллийг бэлтгэн 2025 оны 11 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд яамны цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан. https://mcud.gov.mn/a/1669, https://mcud.gov.mn/a/1671 | |
| Зорилт 4.<br>Салбарын статистик, суурь судалгааг боловсруулах, хөгжүүлэх, мэдээлэл, технологийг нэвтрүүлэх, цахим шилжилтийг идэвхижүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | |
| 1.1.41 | Салбарын цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх | 15% | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.2.2.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөө"-г харьяа байгууллагуудаас саналыг авч нэгтгэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ний өдрийн 117 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөөгөөр 2025-2028 онд 14 зорилтын 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 03/2243 тоот албан бичгийг харъяа байгууллагуудад хүргүүлсэн.<br>Тус төлөвлөгөөний 1.1-т туссан тусгай зөвшөөрлийн цахим системийг "license.mn"-д холбох, мэдээлэл солилцох урсгалыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Санхүүгийн мэдээллийн технологийн төв"-тэй Тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем "license.mn"-д шинээр хөгжүүлэлт хийлгэн барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг тус системээр олгож байна. Аж ахуй нэгж байгууллагын мэдээлэл болон инженер техникийн ажилтнуудын мэдээллийг mcis.gov.mn системээс API сервис холболтоор хүлээн авч боловсруулалт хийгдсэний дараа буцаан дамжуулах тохиргоо хийгдсэн.<br>Төлөвлөгөөний 1.3-т заасан "Барилгын материалын мэдээллийн нэгдсэн сангийн цахим системийг хөгжүүлэх" ажлын санхүүжилтийг "Барилга, байгууламжийн норм, нормативын сан"-ийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгуулан, барилгын материалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-н мэдээллийг дэлгэрэнгүй харах, барилгын материалын сорилт шинжилгээний лабораториос хариу авах, технологийн заавар хянуулах, батлуулах, тохирлын гэрчилгээний хүсэлт илгээх зэрэг барилгын материалтай холбоотой үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, https://materials.mcis.gov.mn/ системийг ашиглалтад оруулсан. Мөн төлөвлөгөөний 1.4-т туссан барилгын салбарт BIM нэвтрүүлэх бэлтгэл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн А/102 дугаар тушаалаар салбарт "Барилгын мэдээлэлтэй загварчлал-BIM"-ийг нэвтрүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | байгуулж “BIM”-г үе шаттай нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна.<br>Төлөвлөгөөний 1.6 “Хот байгуулалтын кадастрын системд 21 аймгийн хэмжээнд барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж бүртгэх, нөхөн бүрдүүлэлт хийх”, “21 аймгийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт хот байгуулалтын кадастрын системд тогтмол тоон мэдээллийг бүрдүүлэх сургалтад хамруулах, арга зүйгээр хангах” ажлын хүрээнд системийн нэмэлт хөгжүүлэлтийг системийг хариуцаж байгаа ГЗБГЗЗЕГазарт улсын төсвийн хөрөнгөөр хийж дуусгуулан, 21 аймгийн холбогдох мэргэжилтнүүдэд ГЗБГЗЗЕГазартай хамтран яаман дээр сургалт явуулж, нөхөн бүрдүүлэлтийн ажлыг эрчимжүүлж байна.<br>Төлөвлөгөөний 1.9-т заасан “Ундны усны чанар болон усны үйлчилгээний тарифын мэдээллийн системийг сайжруулах” ажлын хүрээнд ХСУХАТАҮЗЗөвлөл, НҮБ-ийн Хүүхдийн сан хамтран санхүүжилтийг шийдвэрлэн https://water.wsrc.mn/ цахим системийн эхний хувилбарыг боловсруулаад байна.<br>Мөн төлөвлөгөөний 2.2-т заасан “Салбарын цахим системүүдийн кибер аюулгүй байдлыг хангах” ажлын хүрээнд ТЕГ-н Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүсэлт гаргаж “Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ”-г 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 27-ны өдрийн хооронд хийлгүүлж, заавар зөвлөмж хүргүүлэн авсан. Үүний дагуу “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулаллтын яамны мэдээллийн аюулгүй байдлыг хангах 2025 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г газрын даргаар батлуулсан. 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газартай хамтран ХББОСЯ-ны эрсдэлийн үнэлгээний тайланг танилцуулж, “Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, анхаарах зарим асуудал”-н талаарх сургалтыг нийт албан хаагчдад заавар зөвлөмжийг өгч ажилласан. | |
| 1.1.42 | Нээлттэй өгөгдлийг байгууллагын цахим хуудас болон "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д тогтоосон хугацаанд байршуулах. | 15ш | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын 5.3 дахь хэсэгт заасны дагуу “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр батлуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-д орсон ХББОСЯ-ны нээлттэй өгөгдөл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр баталсан “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд орсон нээлттэй өгөгдлийг “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын дагуу хөрвүүлэн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем"-д тогтоосон хугацаанд тогтмол шинэчлэн нийтэлж байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон нээлттэй өгөгдлийн хэрэгжилтийн 2025 оны эхний хагас жилийн тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 03/2465 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус салбарын мэдээлэл сүүлийн жилүүдэд тогтмол хамгийн өндөр хандалттай мэдээллээр шалгарсан ба 6 сарын 1-нээс хойш 36 удаа өгөгдөл оруулсан ба хамгийн сүүлд 2025 оны 11 дүгээр сарын 20-нд өгөгдлүүдийг хөрвүүлж оруулсан байна. | |
| 1.1.43 | Барилгын нэгдсэн мэдээллийн системээр дамжуулан салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааны тайлан мэдээг хүлээн авах ажлыг зохион байгуулж, салбарын статистикийн мэдээлэл, орон сууцны албан ёсны статистикийн мэдээг тогтоосон хугацаанд Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх, хамтран ажиллах. | 2025 оны эхний хагас жил, жилийн тайланг хүргүүлнэ.<br>Мэдээллийн тоо-1 | Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 206, А/184 дугаартай хамтарсан тушаалаар баталсан "Салбарын бүртгэл, мэдээллийн маягт, нөхөх заавар"-ын дагуу барилгын ажил гүйцэтгэх, зураг төсөл боловсруулах, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх, нийтийн аж ахуйн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны мэдээ, барилгын материалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ, барилгын материалын түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын мэдээ, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлгөөний мэдээ, тусгай зөвшөөрөл шинээр авсан аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн мэдээг 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 03/813 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 2024 оны бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-1), ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан нийтийн зориулалттай болон амины орон сууцны байшингийн 2024 оны бүтэн жилийн мэдээ (маягт А-ОС-2)-г батлагдсан маягтын дагуу нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 03/354 дугаар албан бичгээр, хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт", "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт"-ын дагуу холбогдох мэдээллийг 2025 оны II улирлын байдлаар нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 03/2524 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний Ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшингийн 2025 оны хагас жилийн мэдээ (маягт АОС-1)-г батлагдсан маягтын дагуу нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 03/2464 дугаар албан бичгээр 2025 оны III дугаар улирлын мэдээг 2025 оны 10 дугаар сарын 23-ний | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 02/3953 албан бичгээр тус тус хүргүүлж, улсын хэмжээний мэдээнд нэгтгэгдэн тархаагдсан. | |
| 1.1.44 | Салбарын статистик, тоон мэдээллийн жагсаалтыг шинэчлэн батлуулах, мэдээллийг цуглуулж өгөгдлийн сан үүсгэх, мэдээллийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах. | Статистик, тоон мэдээллийн жагсаалтыг шинэчлэн батлуулах. Өгөгдлийн санг боловсруулах дотоод болон нээлттэй мэдээллийг шинэчлэх. | Барилгын салбарын 2016-2024 оны жилийн статистикийн мэдээллийг нэгтгэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын даргад тус тус танилцуулсан. Ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны мэдээ (маягт А-ОС-1)-г батлагдсан маягтын дагуу 2024 он, 2025 оны I улиралд аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан орон сууцны барилгын судалгааг нэгтгэн гаргаж, Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын Орон сууцжуулалтын хэлтэст хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалын дагуу Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн 2024 он, 2025 оны I, II, III дугаар улирлын судалгааг нэгтгэн гаргасан. Барилгын зарим нэр төрлийн материалын 2024 оны жилийн эцэс, 2025 оны I, II улирлын импортын дүн мэдээг нэгтгэн Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын Барилгын материалын хэлтэст хүргүүлсэн. Үндэсний статистикийн хорооны аж үйлдвэрийн салбарын сар болон жилийн мэдээнд барилгын материалын зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг оруулж, зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны I, II улирлын мэдээг БМХ-т хүргүүлсэн. Мөн Барилгын салбарын статистик, тоон мэдээллийг 2025 оны I, II улирлын байдлаар нэгтгэн гарган, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх, газрын дарга нарт танилцуулж, албан хаагчдад тархаасан. Үүнд: Барилга угсралт, их засварын ажил 2025 оны II улирлын байдлаар, салбарын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээлэл, барилгын салбарын ажиллах хүчний судалгаа, барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшингийн мэдээ, салбарын мэргэшлийн зэрэгтэй инженер техникийн ажилтны тоон мэдээлэл, барилгын салбарын нэмэгдэл өртөг, барилгын салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, барилгын зарим нэр төрлийн барааны импортын мэдээ. Мөн Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарын инженер техникийн ажилтны судалгааг нэгтгэн гаргасан. Судалгааны хүрээнд дараах мэдээллүүдийг бүдүүлсэн. Үүнд: Барилгын салбарын ажиллах хүчний эрэлт, хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь хүчинтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын тоон мэдээлэл, салбарын ажиллах хүчний судалгаа, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээ, мэргэжлийн чиглэлээр, дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээ, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | мэргэжлийн чиглэлээр, дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээ, мэргэжлийн чиглэлээр, хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарын инженер техникийн ажилтны дэлгэрэнгүй судалгааг нарийвчилсэн чиглэл, мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/-ийн дагуу нэгтгэн гаргасан.<br>Улсын хэмжээнд 2025-2028 онуудад ашиглалтад оруулах орон сууцны төслүүдийн мэдээллийг бүрдүүлэх зорилгоор орон сууцны төслийн судалгааг 2025.02.27-03.21-ний өдрүүдэд цахимаар зохион байгуулан явуулж, судалгааны дүнг нэгтгэн боловсруулж СХОСБЗГ-ын дарга болон ОСХ-ийн даргад танилцуулсан. Статистикийн мэдээллийг буй болгох, статистикийн мэдээллийг холбогдох газруудаас авч нэгтгэн, тогтмол баяжилт хийх, харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагч, судлаачид болон бусад хэрэглэгчдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/150 дугаар тушаалын хавсралт салбарын албан ёсны статистик, тоон өгөгдөл мэдээллийн жагсаалтын дагуу 12 бүлгийн статистик, өгөгдөл мэдээллийг шинэчлэн, баяжуулж салбарын 2025 оны I, II, III дугаар улирлын статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, инфографик, танилцуулга бэлтгэн ХББОСЯ-ны албан хаагчдад дотоод сүлжээгээр болон яамны сайтаар тархаасан. | |
| 1.1.45 | Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл маягтын дагуу мэдээллийг улирал тутам гаргаж, тогтоосон хугацаанд Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх. | Мэдээллийн тоо-2 | Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт", "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэлийн маягт"-ын дагуу аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээллийг 2024 оны жилийн эцсийн байдлаар тус тус нэгтгэн Үндэсний статистикийн хороонд 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 3/353 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>2025 оны I улирлын мэдээг нэгтгэн 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03/1079 дугаар албан бичгээр, II дугаар улирлын мэдээг нэгтгэн 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 03/2464 дугаар албан бичгээр 2025 оны III дугаар улирлын мэдээг 2025 оны 10 дугаар сарын 23-ний 02/3953 албан бичгээр тус тус Үндэсний статистикийн хороонд хүргүүлж, улсын хэмжээний мэдээнд нэгтгэгдэн тархаагдсан байна. | 100 |
| 1.1.46 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбартай холбоотой судалгаа мэдээллийг нэгтгэх, өгөгдлийн сан үүсгэх, холбогдох газруудыг мэдээллээр хангах. | Мэдээллийн тоо-2 | Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбартай холбоотой судалгаа мэдээллийг нэгтгэж, өгөгдлийн сан үүсгэн ажиллаж байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан "Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор "Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан" (https://metadata.nso.mn)-г Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороо хамтран хөгжүүлж, ашиглалтад оруулсан. Өгөгдлийн багцын мета мэдээлэл, өгөгдлийн сангийн хүснэгтийн мета мэдээлэл, үзүүлэлт, үзүүлэлтийн ангиллын мета мэдээлэл, ангиллын задаргаа, маягтын мета мэдээллийг бэлтгэж "Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан"-д мета өгөгдлийг оруулах, шинэчлэх үйл ажиллагаатай холбоотой сургалтад 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр оролцож, өөрийн хариуцдаг өгөгдлийн сангийн мета өгөгдлийг системд оруулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлээр "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих дашбоард" хөгжүүлэхийг Санхүүгийн мэдээллийн технологийн төвд үүрэг болгож, хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн, төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг тогтмол нийлүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасан. Энэ ажлын хүрээнд "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих дашбоард" системд оруулах Орон сууцны албан ёсны статистикийн мэдээний Ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны байшингийн 2020-2024 оны мэдээг 2025.05.23-ны өдөр temuujin.g@itc.gov.mn цахим шуудангаар Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-т хүргүүлсэн. Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлд аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жил тутам зохион байгуулахаар заасан бөгөөд аж ахуйн нэгжийн 2026 оны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд тооллогын үзэл баримтлал, асуулгын төслийг боловсруулах, суурь болон төрөлжсөн мэдээллийн санг ашиглахад мэдээллийн бэлэн байдал, эх үүсвэрийг тодорхойлох, ангилал кодыг уялдуулах, мэдээллийн сангийн чанарыг үнэлэх уулзалтуудад тогтмол оролцож, Аж ахуйн нэгжийн 2026 оны тооллогын Улсын комиссын хуралд Төрийн нарийн бичгийн даргын үүрэг болгосны дагуу оролцож, ажиллах журмын болон төлөвлөгөөний төслүүдэд санал өгч хамтран ажиллаж байна. Мөн Хүн ам, орон сууны 2025 оны завсрын тооллогын Техникийн болон Улсын комиссын гишүүнээр ажиллаж, яамны албан хаагчдад болон салбарын төрийн бус байгууллагын удирдлагуудад энэ талаар мэдээлэл хүргүүлж, хамрагдалтад анхааран ажиллаж байна. Үндэсний Статистикийн Хороо үндэсний олон хэмжээст ядуурлын индексийн арга зүйг боловсруулах зорилгын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Оксфордын Их Сургуулийн Ядуурал, Хүний Хөгжлийн Институттэй хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Үндэсний олон хэмжээст ядуурлын хэмжээс, үзүүлэлтүүдийг тодорхойлох, тооцооны арга зүйг боловсруулахад бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулж, санал, | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | зөвлөмжийг тусгах зорилгоор Үндэсний статистикийн хорооны даргын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/72 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж 5 удаа ажлын хэсгийн хурал, зөвлөгөөнүүдэд орж ажилласан ба Монгол Улс Үндэсний олон хэмжээст ядуурлын хэмжээс, үзүүлэлтүүдийг тодорхойлж батлуулахаар хүргүүлээд байна. | |
| 1.1.47 | Салбарын цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх | Эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт 8% | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.2.2.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөө"-г харьяа байгууллагуудаас саналыг авч нэгтгэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ний өдрийн 117 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөөгөөр 2025-2028 онд 14 зорилтын 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 03/2243 тоот албан бичгийг харъяа байгууллагуудад хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний 1.1-т туссан тусгай зөвшөөрлийн цахим системийг "license.mn"-д холбох, мэдээлэл солилцох урсгалыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Санхүүгийн мэдээллийн технологийн төв"-тэй Тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем "license.mn"-д шинээр хөгжүүлэлт хийлгэн барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг тус системээр олгож байна. Аж ахуй нэгж байгууллагын мэдээлэл болон инженер техникийн ажилтнуудын мэдээллийг mcis.gov.mn системээс API сервис холболтоор хүлээн авч боловсруулалт хийгдсэний дараа буцаан дамжуулах тохиргоо хийгдсэн. Төлөвлөгөөний 1.3-т заасан "Барилгын материалын мэдээллийн нэгдсэн сангийн цахим системийг хөгжүүлэх" ажлын санхүүжилтийг "Барилга, байгууламжийн норм, нормативын сан"-ийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгуулан, барилгын материалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-н мэдээллийг дэлгэрэнгүй харах, барилгын материалын сорилт шинжилгээний лабораториос хариу авах, технологийн заавар хянуулах, батлуулах, тохирлын гэрчилгээний хүсэлт илгээх зэрэг барилгын материалтай холбоотой үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, https://materials.mcis.gov.mn/ системийг ашиглалтад оруулсан. Мөн төлөвлөгөөний 1.4-т туссан барилгын салбарт BIM нэвтрүүлэх бэлтгэл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн А/102 дугаар тушаалаар салбарт "Барилгын мэдээлэлтэй загварчлал BIM"-ийг нэвтрүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж "BIM"-г үе шаттай нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. 2025 оны 11 | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дүгээр сарын 24-ний өдөр Их Британи, Умард Ирландийн Нэгдсэн Вант Улсын Элчин сайдын яамны төлөөлөл болон тус улсын төр, хувийн байгууллагатай хамтарсан "Дижитал бүтээн байгуулалт" сэдэвт форум зохион байгуулж, төлөвлөлт, зураг төсөл, үйлдвэрлэл, барилга угсралт, хяналт, ашиглалт хүртэлх бүх үе шатыг өгөгдөлд суурилсан шийдлээр уялдуулах талаар холбогдох ААНБ, иргэдэд мэдээлэл хүргүүлэн ажилласан. Төлөвлөгөөний 1.6 "Хот байгуулалтын кадастрын системд 21 аймгийн хэмжээнд барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж бүртгэх, нөхөн бүрдүүлэлт хийх", "21 аймгийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт хот байгуулалтын кадастрын системд тогтмол тоон мэдээллийг бүрдүүлэх сургалтад хамруулах, арга зүйгээр хангах" ажлын хүрээнд системийн нэмэлт хөгжүүлэлтийг системийг хариуцаж байгаа ГЗБГЗЗЕГазарт улсын төсвийн хөрөнгөөр хийж дуусгуулан, 21 аймгийн холбогдох мэргэжилтнүүдэд ГЗБГЗЗЕГазартай хамтран яаман дээр сургалт явуулж, нөхөн бүрдүүлэлтийг ажлыг эрчимжүүлж байна.<br>Төлөвлөгөөний 1.9-т заасан "Үндны усны чанар болон усны үйлчилгээний тарифын мэдээллийн системийг сайжруулах" ажлын хүрээнд ХСУХАТАУЗЗөвлөл, НҮБ-ийн Хүүхдийн сан хамтран санхүүжилтийг шийдвэрлэн https://water.wsrc.mn/ цахим системийн эхний хувилбарыг боловсруулаад байна.<br>Мөн төлөвлөгөөний 2.2-т заасан "Салбарын цахим системүүдийн кибер аюулгүй байдлыг хангах" ажлын хүрээнд ТЕГ-н Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүсэлт гаргаж "Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ"-г 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 27-ны өдрийн хооронд хийлгүүлж, заавар зөвлөмж хүргүүлэн авсан. Үүний дагуу "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны мэдээллийн аюулгүй байдлыг хангах 2025 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г газрын даргаар батлуулсан. 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газартай хамтран ХББОСЯ-ны эрсдэлийн үнэлгээний тайланг танилцуулж, "Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, анхаарах зарим асуудал"-н талаарх сургалтыг нийт албан хаагчдад орж, заавар зөвлөмжийг өгч ажилласан. | |
| 1.1.48 | Барилгын тусгай зөвшөөрөл, инженер техникийн ажилтны нэгдсэн мэдээллийн сангийн цахим системийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавих | Цахим системийн тогтвортой, хэвийн, аюулгүй үйл ажиллагаанд шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдсэн байна.<br>Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | Тусгай зөвшөөрлийн цахим систем /www.mcis.gov.mn/-ээр дамжуулан 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 5636 хүсэлтийг хүлээн авч, 2253 ААНБ-д тусгай зөвшөөрөл олгоод байна. Уг системийн үндсэн сервер "Үндэсний дата төв" УТҮГ-д байрлаж, Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем, Танилт нэвтрэлтийн ДАН системүүдтэй холбогдон ажиллаж байна. Тусгай зөвшөөрлийн нэгдсэн системийг Зөвшөөрлийн хуультай уялдуулан нэмэлт сайжруулалт хийх ажлын хүрээнд барилгын тусгай зөвшөөрлийг Барилгын нэгдсэн мэдээллийн систем /www.mcis.gov.mn/-ээр олгодог байсанг Тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | “license.mn”-д шинээр хөгжүүлэлт хийлгэн барилгын салбарын тусгай зөвшөөрлийг олгохоор болсон. Аж ахуй нэгж байгууллагын мэдээлэл болон Инженер техникийн ажилтаны мэдээллийг mcis.gov.mn системээс API сервис холболтоор хүлээн авч боловсруулалт хийгдсэний дараа буцаан дамжуулах тохиргоо хийгдсэн. Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлүүдийг тус системээр олгож байна. Мэдээллийн сангийн цахим системд хандах үндсэн хэрэглэгчийн эрх олгох тухай Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/04, 02 дугаар сарын 19-ны өдрийн А/24, 05 дугаар сарын 21-ны өдрийн А/92 дугаар тушаалуудыг батлуулан ХББОСЯ-ны тусгайлсан чиг үүрэг бүхий албан хаагч нар болон Монголын үндэсний ассоциаци НҮТББ-н албан хаагч нарт эрх олгосон. Тус системийн холболт тохиргоо хийгдэн ашиглалтад оруулснаас хойш нийт Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл 88, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 14, Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл 413 тус тус олгоод байна. | |
| 1.1.49 | Яамны цахим хуудсыг сайжруулж, нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулна. | 100 хувь | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралт “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-ийн дагуу яамны 2024 оны ил тод байдлын тайланг нэгтгэн гаргаж 2025 оны 01 дүгээр сард ХШҮДАГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сан /new.unelgee.gov.mn/-д баталгаажуулж, 2025.01.02-ны өдрийн 03/03 дугаар бичгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. ЦХИХХЯ-наас яамдын нээлттэй мэдээллийг ил тод болгож, байршуулсан тайланд үнэлгээ хийж, үнэлгээг шинэчлэгдсэн шилэн систем /shilen.gov.mn/-д улирал бүр тайланг илгээж 87 шалгуур үзүүлэлтийг тус бүр ил тод нээлттэй байршуулсан. Цахим хуудасны лого-г шинэчилж, стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор газар хэлтсүүдийн мэдээллүүдийг шинэчилсэн. “Дулаан байшин” нээлттэй өдөрлөгт зориулж амины орон сууцны мэдээллийн төвийг бүрэн виртуал хэлбэрт шилжүүлсэн. Мөн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | эрчим хүчний хэмнэлттэй ногоон амины орон сууцуудыг виртуал хэлбэрт оруулж иргэдэд цахим хуудсаар дамжуулан виртуал орчинд өөрсдөө очиж үзэн мэдээ, мэдээлэл авах, 40 гаруй нэг маягийн зураг төслийг үнэгүй ашиглах, паспортжуулсан барилгын мэдээллийг ил тод болгож дүүрэг тус бүрээр ялган харах зэрэг нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан. Цахим хуудасны нүүр хэсэгт шинээр салбарын системүүд, тусгай зөвшөөрлийн мэдээллүүд, хууль, эрх зүйн мэдээллийг шинээр үүсгэж байршуулсан. Цахим хуудасны мэдээллийн аюулгүй байдал, найдвартай байдлыг хангаж, яамны албан хаагчдаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж, цэс нэмэх, линк холбох, холбогдох мэдээ мэдээллийг бүрэн оруулж нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан. | |
| Зорилт 5. Салбарын өгөгдлийн сан, мэдээллийн системийн уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах, харилцан мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | | | | |
| 1.1.50 | Барилгын материалын мэдээллийн нэгдсэн сангийн системийг хөгжүүлэх ажлыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | | Барилгын материалын мэдээллийн нэгдсэн сангийн системийг хөгжүүлэх ажлын санхүүжилтийг "Барилга, байгууламжийн норм, нормативын сан"-ийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгуулан, барилгын материалын нэгдсэн мэдээллийн сангийн цахим систем /materials.mcis.gov.mn/-ийг хөгжүүлэх ажлын хүрээнд барилгын материалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-н мэдээллийг дэлгэрэнгүй харах, барилгын материалын сорилт шинжилгээний лаборториос хариу авах, технологийн заавар хянуулах, батлуулах, тохирлын гэрчилгээний хүсэлт илгээх зэрэг барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан. | 100 |
| 1.1.51 | Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийг нэвтрүүлэх ажлыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | 100% | Хүлэмжийн хийн тооллогын цахим систем /ghgconstruction.gov.mn/-ийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв, Үндэсний дата төв УТҮГ"-уудтай хамтран Хүлэмжийн хийн тооллогын системийн "10.2.109.11 – 103.48.116.165 NAT хаяг"/-ийн серверээс "auth", "bash history" зэрэг файлуудыг гарган авч, кибер аюулгүй байдлыг хангах ажлыг хамтран хэрэгжүүлж, нэвтрэх нууц үгийг шинэчилж, тус систем дотор үүссэн халдлагын чанартай хортой кодуудыг цэвэрлэн кибер халдлагаас урьдчилан сэргийлж гадаад хаяг, хандах эрхийн портуудыг хаалган хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (ҮТХН буюу NDC)-ыг хэрэгжүүлэх зорилгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй "Эн Ди Си" төслийн хүрээнд Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, хөтлөх, бүрдүүлэх чиглэлээр салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулахад хамтарч ажиллан, Барилгын салбарын мэдээллийн /pmis/ систем болон хүлэмжийн хийн тооллогын цахим системийн уялдаа, үйл ажиллагааны талаарх танилцуулга сургалт хийсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1.52 | Орон сууцны бүртгэл, мэдээллийн нэгдсэн портал, гар утасны аппликейшн хөгжүүлж, нэвтрүүлэх ажлыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | Орон сууцны бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх | Төрөөс иргэдийг орлогод нийцсэн орон сууцаар хангах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд “Орон сууцны зах зээлийн борлуулалт, үнэ, нийлүүлэлт, эрэлтийн мэдээлэл, төсөл хөтөлбөр, түрээсийн орон сууц, Ипотекийн 6 хувийн орон сууцны зээлийн хүсэлт, сонгон шалгаруулалт, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний мэдээлэл” зэргийг нэгтгэн удирдах, хянах, шинжлэх боломжийг бүрдүүлж, орон сууцны эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан, иргэдийн худалдан авах чадварыг дэмжих, шийдвэр гаргалтад шаардлагатай зах зээл дээрх орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн статистик, тоон мэдээллийг бодит агшинд бүрдүүлэх цахим систем хөгжүүлэх техникийн баримт бичгийг боловсруулж “Төрийн орон сууц корпораци” ТӨХХК-д хүргүүлсэн. Мөн төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан систем хөгжүүлэх компанийг сонгон шалгаруулах ажиллагаанд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллаж байна. | 90 |
| 1.1.53 | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн системийн мэдээллийн баазыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулж, бүрдүүлэх | Цахим системийг нийслэлийн хот байгуулалтын мэдээллийн сантай холбох, сайжруулах ажлыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэн байна. | Хот байгуулалтын кадастрын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтэд Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах;” гэж заасны дагуу Улсын хэмжээнд паспортжуулалт хийсэн барилга байгууламжийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, мөн ерөнхий архитектуруудын тайлан, жижүүр хөтлөлтийн тайланг системээр авах саналыг хүргүүлж, “Хот байгуулалтын кадастрын цахим системийн хөгжүүлэлт хийх үйлчилгээн”-ний 2025/76 дугаар гэрээг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Эрхэт-Инноваци” ХХК-тай байгуулсан. Гэрээт ажлын хүрээнд Зургийн давхаргын үзүүлэлт, өгөгдөл мэдээллийн давхардлыг арилгах, Гүйцэтгэлийн зураг оруулахад хавсралт дотор нь нэг удаа гүйцэтгэгч, захиалагчийн мэдээлэл оруулдаг болох, Шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг нэгдсэн байдлаар оруулах, акт гаргах боломжтой болгох, Инженерийн шугам сүлжээний зургийн даалгаврын хүчин чадал дээр цахилгааны хэмжих нэгж байхгүй байгааг оруулах, Зургийн даалгавар хэвлэхэд цахилгаан, холбооны даалгаврын сонголт гарч ирэхгүй байгааг засварлах, Барилгын зориулалтаас хамаарч маягт өөрчлөгддөг болгох, Зургийн давхаргад өгөгдөл оруулан хадгалахаас өмнө зургийг хаана орж байгааг харах байдлаар дэлгэцэнд харах боломжтой болгох, Хавсралт файлыг *.rar өргөтгөлөөр оруулж болдог болгох, Өгөгдлийн үзүүлэлтийг олноор нь сонгож нэгээс нөгөөд хуулах боломжтой болгох, Барилга, байгууламжийн өгөгдөл мэдээллээс боловсруулалт анализ хийж нийгмийн дэд бүтэц болох сургууль, цэцэрлэг, соёл, спорт, худалдаа үйлчилгээний барилгуудыг зориулалтаар нь өнгөөр ялган харуулдаг болгох, Зургийн давхарга дээр барилгыг зориулалтаар нь ялгаж харах боломжийг бүрдүүлэх, Барилга, инженерийн шугам сүлжээний зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэх үед барилга, трассын лайн тус бүрд зураг төсөл зохиогч, захиалагч, гүйцэтгэгчийн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | мэдээллийг олон талбарт дахин давтан бичдэгийг болиулах, Барилга барих хүсэлт илгээхэд нэгж талбар болон барилгын талбайн хэмжээг тооцоолон 60х40 харьцааг бариагүй тохиолдолд хүсэлт илгээх боломжгүй болгох, Мэргэжилтнээс хүсэлт буцаахад иргэн, аан засаж оруулах, мэдээлэл нэмх, хасах боломжтой болгох, Нэвтэрч ороогүй хүсэлтийг өнгөөр ялгах зэрэг ажлууд хийгдсэн. Хот байгуулалтын кадастрын системд 21 аймгийн хэмжээнд барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламжийг бүртгэх, нөхөн бүрдүүлэлт хийх чиглэлээр удирдамж гарган арга зүйгээр хангах, төлөвлөгөө боловсруулж батлуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| 1.1.54 | Салбарын мэдээллийн сан, цахим системийн уялдаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийн нэгтгэлийг хөгжүүлэх бодлого, удирдамжаар хангах | Төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, тоног төхөөрөмжийг сайжруулсан байна. | Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/66 тушаалаар баталсан "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам, Мэдээллийн систем ашиглах журам, Мэдээллийн системийн администраторын журам"-д заасныг үндэслэн "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны мэдээллийн аюулгүй байдлыг хангах 2025 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд туссан Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн баталгаажуулалт, хөндлөнгийн хяналтын тогтолцоо бий болгож эмзэг байдлыг бууруулах ажлын хүрээнд Албан ёсны лиценз бүхий программ хангамжуудыг худалдан авч техник, хэрэгслийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж эрсдэлийг бууруулсан. Төрийн нэгдмэл сангийн сүлжээний тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн сайжруулж хэвийн, найдвартай аюулгүй үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. Мөн Төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, үнэлгээ хийлгэх ажлын хүрээнд ТЕГ-н Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүсэлт гаргаж "Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ"-г 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 27-ны өдрийн хооронд хийлгүүлж, заавар зөвлөмж хүргүүлэн авсан. 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газартай хамтран ХББОСЯ-ны эрсдэлийн үнэлгээний тайланг танилцуулж, "Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, анхаарах зарим асуудал"-н талаарх сургалтыг нийт албан хаагчдад орж, заавар зөвлөмжийг өгч ажилласан.<br>Яамны дотоод сүлжээ, интернэтэд суурилсан харилцаа, программ хангамжийн Рүүтэр төхөөрөмжийн Галт ханын тохиргоонд аюулгүй байдлыг сайжруулах тохиргоо хийн, хориглосон веб сайтуудыг блоклосон. Мөн кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төвөөс ирүүлсэн Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд танай байгууллагаас хортой кодын С2 сервер болох 146.66.215.206 хаяг руу хандалт тогтоож байгааг илрүүлсэн мэдэгдэл ирсний дагуу яамны бүх компьютер серверийн төхөөрөмжүүдийн хортой кодыг | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | устган цэвэрлэж аюулгүй байдлыг хангаж хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан. Салбарын мэдээллийн сан, цахим системийн уялдаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийн нэгтгэлийг хөгжүүлэх бодлого, удирдамжаар хангах ажлын хүрээнд Яамны цахим хуудсанд салбарт нийт ашиглагддаг системүүд, тусгай зөвшөөрлийн мэдээллүүд, хууль, эрх зүйн мэдээллүүдийн линк /URL/ хаягийг холбож нэг хуудаснаас иргэд болон ААНБ-уудад салбарын бүхий л мэдээ, мэдээлэлүүдийг ил тод нээлттэй харуулах боломжийг бүрдүүлэн ажилласан. Мөн бүх шатны төрийн захиргааны байгууллагуудад зориулсан төсвийн нэгдсэн систем "Opengov"-ийг салбарын хэмжээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/120 дугаар тушаалаар байгуулж "Дataланд" ХХК-тай хамтран "Үндэсний дата төв" УТҮГ-т Cloud сервер үүсгүүлж программ хангамжийг бүрэн суулган системийг ажиллагаанд оруулж Сангийн яамны Төрийн сангийн цахим хуулга систем /и-хуулга/ болон /Fiscal B/ системүүдтэй интеграци хийж мэдээлэл солилцох боломжоор хангаж /API/ сервис холболт хийн хэвийн үйл ажиллагаанд оруулж бүрэн нэвтрүүлэх боломжийг хангаж ажилласан. | |
| Зорилт 5.<br>Мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагаа хангана. | | | | |
| 1.1.55 | Яамны техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангана. | Компьютер-10<br>Принтер-6<br>Сканнер-2<br>Microsoft Office 365 программын лицензийн тоо-88 | ХББОСЯ-ны барилгын их засварын ажлын хүрээнд 3 болон 4 давхрын коридорын сүлжээг шинэчлэн татаж, ашиглагдахгүй сүлжээний кабель, холбооны кабель, шилэн кабелуудыг тасдан авч, өрөө тус бүрт UTP кабель шинээр татаж, сүлжээнд холбох, сүлжээг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Шинээр цаг бүртгэлийн төхөөрөмж суурилуулж албан хаагчдын бүртгэл тохиргоог хийсэн. Албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд 2025 эхний хагас жилд нийт 15 албан хаагчын компьютеруудыг шинээр сольж, 7 албан хаагчын компьютерт нэмэлтээр ram, hard зэрэг бусад тоног төхөөрөмж суурилуулж, сайжруулан холболт тохиргоог хийн программ хангамжуудыг суулган хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан. Мөн "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-с төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын ажил хийгдэж байгаатай холбогдуулан Яамны сүлжээний рүүтер төхөөрөмж нь унтарч асахдаа автоматаар хаяг тараах, зарим хаяг нь өөрчлөгдөж болохгүй төхөөрөмжид тогтмол хаяг өгөх тохиргоо хийж, байгууллагын компьютерийн дотоод болон гадаад сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажилласан. Хортой код эсэргүүцэх программ хангамж /Kaspersky antivirus/-ийн лицензийн хугацаа дууссан тул 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 2025/338 дугаар "Лиценз худалдан авах гэрээ"-г байгуулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж гэрээнд заасан төлбөр нэхэмжлэлийг | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. | |
| 1.1.56 | Байгууллагын албан хаагчдын мэдээлэл, технологийн мэдлэгийг дээшлүүлэх, цахим орчинд ажиллах боломжийг бүрдүүлнэ. | Сургалтын тоо-8<br>Цахим хурлын тоо-300 | Яамны хэмжээнд видео хурлын ZOOM, Teams программ хангамжуудыг ашиглан 2025 оны 1-р сараас 12-р сар хүртэл 900 гаруй цахим уулзалт болон хурал зохион байгуулах ажлыг тухай бүр хэрэглэгчдэд эрхийг нээж хурлын зааланд холболт тохиргоог хийж хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.<br>Албан хаагчдыг цахим гарын үсгийн И-токен төхөөрөмжөөр хангаж, шаардлагатай тохиолдолд токен төхөөрөмжүүдийн мэдээллийг шинэчлэх, ашиглах нөхцөл, бололцоог бүрдүүлэн хэвийн үйл ажилагааг ханган ажилласан.<br>Албан хаагчдад цахим соёлыг төлөвшүүлэх, ажлын бүтээмж, чанарыг нэмэгдүүлэх, цахим орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх, мэдээлэл, технологийн мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд “Могул сервис” ХХК-тай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Office болон Teams программ хангамжийн хэрэглээ, ашиглах талаар онлайн сургалтыг зохион байгуулсан.<br>2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр цахим болон танхим хослуулан нийт албан хаагчдад ERP системээр Албан бичиг боловсруулах, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг боловсруулах сургалтыг, 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын статистик мэдээлэл, цахимжуулалтын өнөөгийн байдал, мониторинг” сэдвээр нийт албан хаагчдад сургалтыг зохион байгуулж, ашиглаж буй нийт систем, программ хангамжуудын ашиглалтын талаарх заавар зөвлөмжийг өгч ажилласан. Яамны албан хаагчдын ашиглаж буй Microsoft 365 программ хангамжийн лицензийн хугацаа нь 12 дугаар сарын 25-ны өдөр дуусах тул гэрээг үргэлжлүүлэн сунгах бэлтгэлийг хангаж байна. | 100 |
| 1.1.57 | Байгууллагын дотоод удирдлагын систем (ERP), цаг бүртгэлийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, албан хэрэг хөтлөлтийг цахимаар явуулахад дэмжлэг үзүүлнэ. | Систем-1<br>И-Токен төхөөрөмжийн тоо-16 | Байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP системээр дамжуулж цахимаар албан бичиг боловсруулах ажлын хүрээнд нийт албан хаагчдыг чадавхжуулах, тогтмол заавар зөвлөмж сургалт орж, яамны нийт албан бичгийн 80% нь бүрэн цахимжсан байна. Мөн ХББОСЯ-ны Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг цахимаар боловсруулах боломжтой болгож 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр нийт албан хаагчдад сургалт орж, заавар зөвлөмж өгч ажилласан. Сайд, ТНБД-н тушаалын саналын хуудсыг цахимаар тойруулах боломжтой болгож нийт тушаалын 80%-г цахимаар боловсруулж байна. Цаг бүртгэлийн төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн дотоод журмын дагуу цаг бүртгэлийг уян хатан болгож 08-09 цагийн хооронд бүртгүүлэх боломжтой болгож, 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Б/133 “Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Төрийн нарийн бичгийн даргын тушаалын дагуу системийн тохиргоонуудыг хийсэн. Яамны бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | өдрийн “Б/118” тушаалын дагуу бүтэц, зохион байгуулалт, нэгж, албан тушаалын өөрчлөлт, сэлгэн, шилжин ажиллах албан хаагч тус бүрийн бүртгэл, албан бичиг зэргийг шилжүүлж хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. | |
| Зорилт 6. 2.5.5.3. салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх. | | | | |
| 1.1.58 | “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Зорилт 3.6-ын “3.6.1-д газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна.” гэж, “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний “2.1.1.9.Хот төлөвлөлтийн бичиг баримтыг боловсруулахад оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг тусгах, хөрөнгө оруулалттай уялдсан хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль, эрх зүйн шинэчлэлийн бэлтгэл ажлыг эхлүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “4.2.4.3.Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.” гэж заасан зорилтуудын хүрээнд салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | ЗТ-1. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.4-8.1.6-д заасан үе шатны ажлыг хийж гүйцэтгэн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж дууссан. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 96 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2025 оны I, II улиралд 3 удаа хуралдаж хуулийн үзэл баримтлалын төслийг эцэслэсэн. Хуулийн үзэл баримтлалын төсөлд холбогдох яамдууд, төрийн бус байгууллага болон олон нийтээс санал авч ажилласан. Мөн Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг яаралтай батлуулах арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 216 дугаар тушаалаар шинэчлэн баталж, ажиллаж байна. | 90 |
| | | ЗТ-2. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.3-8.1.6-д заасан үе шатны ажлыг хийж гүйцэтгэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | Орон сууцны тухай хууль, Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хуралдаанд тухай бүр оролцож, мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж ажилласан. Хуулийн төсөл боловсруулах ажлын явц, агуулгыг мөн оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, сайдын зөвлөх И.Баттөгс, Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа болон холбогдох нэгжийн дарга нарт танилцуулсан. Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон Төрийн өмчийн орон сууцыг зорилтод бүлгийн иргэдэд хөлслүүлэх, өмчлүүлэх, борлуулах журмын төслүүдийг эцэслэн хянаж, холбогдох | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | саналыг тусган Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар болон ажлын хэсэгт хүргүүлсэн. | |
| | | Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.3-8.1.6-д заасан үе шатны ажлыг хийж гүйцэтгэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 79 дүгээр тушаалаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.<br>Хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр "Хууль зүйн бичигт хүрээлэн" НҮТББ шалгарч, 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдөр зөвлөх үйлчилгээний 2024/192 тоот гэрээг байгуулан ажиллаж байна. Хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд "Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Улсын Их Хурлаас Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Засгийн газар шинээр эмхлэн зохион байгуулагдсан тул Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 206 дугаар тушаалаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Хуулийн төсөл боловсруулах ажлын явц, агуулгыг мөн оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, сайдын зөвлөх И.Баттөгс, Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа болон холбогдох нэгжийн дарга нарт танилцуулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалын анхны төслийг боловсруулж, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 02/3384 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ болон "Монголын архитекторуудын эвлэл" ТББ, "Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо" ТББ-д тус тус хандаж тус тус санал авахаар хүргүүлсэн.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгаланаар 10 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/4006 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд тус яамнаас үзэл баримтлалыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар мөн батлуулах нь зүйтэй гэсэн чиглэл ирүүлсний дагуу үзэл баримтлалын төслийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар батлуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар руу 2025 оны 11 дүгээр 27-ны өдрийн 01/4361 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.<br>2. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн хуралдаанд тухай бүр оролцож, мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж ажилласан. | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Хуулийн төслийг боловсруулах Зөвлөх үйлчилгээ авах Ажлын даалгаварыг хянаж, нарийн бичгийн даргатай хамтран эцэслэн батлуулсан болно. | |
| | | Тайлан-2 | 1. Сайдын батлан гаргах 258 тушаалын, Төрийн нарийн бичгийн даргын батлан гаргах яамны үйл ажиллагаатай холбоотой А-159, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б-206 тушаалын хууль эрх зүйн үндэслэлийг хянаж хуульд нийцүүлэн, холбогдох саналыг тусган ажиллалаа.<br>2. Яамнаас бусад иргэн, хуулийн этгээдтэй байгуулах 348 гэрээ хэлцлийн төслийг хянаж, хуульд нийцүүлэн бүртгэж дугаар олгосон. | 90 |
| | | Хөтлөгдсөн бүртгэл-1 | 1. Сайдын батлан гаргах 258 тушаалын, Төрийн нарийн бичгийн даргын батлан гаргах яамны үйл ажиллагаатай холбоотой А-159, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б-206 тушаалын хууль эрх зүйн үндэслэлийг хянаж хуульд нийцүүлэн, холбогдох саналыг тусган ажиллалаа.<br>2. Яамнаас бусад иргэн, хуулийн этгээдтэй байгуулах 348 гэрээ хэлцлийн төслийг хянаж, хуульд нийцүүлэн бүртгэж дугаар олгосон. | 90 |
| 1.1.59 | УИХ, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг журамд заасны дагуу улирал тус бүрээр холбогдох нэгжүүдээс авч нэгтгэн, удирдлагыг мэдээллээр хангах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах. | 4 | 1. Улсын Их Хурлын хаврын чуулганы нэгдсэн хуралдаан болон намрын чуулганы нэгдсэн хуралдаанаар тус яамнаас санаачлан боловсруулсан хууль тогтоомжийн нийт 8 төслийг хэлэлцүүлэх тухай саналыг холбогдох бодлогын газруудаас авч, нэгтгэн удирдлагуудад танилцуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүр хүргүүлсэн.<br>2. Засгийн газрын 2025 оны 20 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам”-ын 4.3-т заасны дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас 2025 онд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг нийт 30 асуудлын жагсаалтыг холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн, боловсруулалтыг хийж, тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн. Үүнд:<br>I дүгээр улиралд:<br>- “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,<br>- “Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын тогтоол,<br>- “Хөдөө, орон нутагт ипотекийн 3 хувийн хүүгийн татаас олгох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- “Барилгын материал бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт” зэрэг нийт 5 асуудал,<br>II дугаар улиралд:<br>- “Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- Нийтийн аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хэрэгжсэн болон одоо хэрэгжиж байгаа төслүүдийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн талаар 2 асуудал, | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | III улиралд:<br>- "Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- Нийтийн аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр дамжуулан зээлдүүлэх гэрээгээр хэрэгжсэн болон одоо хэрэгжиж байгаа төслүүдийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн талаар"<br>- "Журам батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл (Амины орон сууцанд татаас олгох),<br>- Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл,<br>- Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,<br>- Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,<br>- Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг нийт 7 асуудал;<br>IY улиралд:<br>- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын Бүгд Найрамдах Солонгос Улсад хийх айлчлалын талаар,<br>- "Дүрэм шинэчлэн батлах тухай" (Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм) Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- "Техникийн зохицуулалт батлах тухай" (Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт батлах тухай) Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" (20 минутын хот хөгжлийн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай") Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- "20 минутын хотын үзэл баримтлал батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, "Барилгын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай" Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- "Журам батлах тухай" (Түрээсийн орон сууцны журам) Засгийн газрын тогтоолын төсөл,<br>- Хүн амыг ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар тэгш хангах, хүртээмжийн ялгааг бууруулах зорилгоор улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах талаар, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, эмч нарт зориулсан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн талаар,<br>- "Дүрэм батлах тухай" (Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм)<br>Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл зэрэг нийт 16 асуудлын жагсаалтыг холбогдох нэгжүүдээс санал авч нэгтгэн, тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн. | |
| 1.1.60 | Улсын Их Хурал, Засгийн газар, Сайд, Төрийн нарийн бичгийн даргаас баталсан барилгын норм, нормативын баримт бичгийн судалгаа хийх | Судалгаа-1<br>Санал-1<br>Тайлан-1 | 1. Салбарын хуулиар эрх олгосны дагуу хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын баталж, нийтээр мөрдүүлж буй улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажлыг холбогдох нэгжүүдтэй хамтран зохион байгуулж, санал боловсруулж, тайлан гаргах ажилд дэмжлэг үзүүлэх | | үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-тэй хамтран БХБЯ-ны цахим архивд хадгалагдаж буй Сайдын тушаалтай нэг бүрчлэн тулгалт хийн шалгаж, нэгтгэн тайланг боловсруулж, холбогдох саналын хамтаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн.<br>2. Ерөнхий сайдын 2025 оны 64 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан "Авлигатай тэмцэх, авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 3.1-д заасан тусгай зөвшөөрлийн тоог цөөлөх арга хэмжээний хүрээнд барилгын салбарын хэмжээнд хуулиар эрх олгогдоогүй дүрэм, журам болон бусад захиргааны хэм хэмжээний актуудыг хамтран шийдвэрлэх ажлын хүрээнд улсын нэгдсэн санд бүртгэлгүй, хуульд тусгаж эрх олгох, нийтээр дагаж мөрдүүлэх шаардлагатай актын судалгааг мөн хуульд нийцүүлэх, шинэчлэн боловсруулах шаардлагатай актын судалгааг тус тус ЗГХЭГТ-т хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд 8 хэм хэмжээний актын төслийг бодлогын газраас боловсруулан ирүүлсэнийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж, бүртгэх эрх бүхий байгууллагад бүртгүүлэхээр хүргүүлсэн. | |
| 1.1.61 | ЗГ болон яамны хууль ёсны эрх ашгийг итгэмжлэлийн үндсэн дээр хууль хяналтын байгууллагад төлөөлж, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллана. | Бүртгэл-1<br>Тайлан-2 | 1.Тайлант хугацаанд шүүхээр 4 хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлүүлсэн.<br>Захиргааны хэрэг:<br>-"Эрэл групп" ХХК,<br>-Таван хан энержи" ХХК,<br>-"Солит констракшн" ХХК,<br>-"Сүхжин" ХХК-ийн нэхэмжлэлтэй хэргийн захиргааны хэргийн анхан болон давж заалдах анхан шатны шүүхээр,<br>-иргэн О.Лхагвацэдэнгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг УДШ-д хянагдаж тус тус нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож,<br>-УДШ иргэн Ганбатын нэхэмжлэлтэй хэрэгт нэхэмжлэлийг хангаж, тус яамнаас 61,200,000 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн.<br>Иргэний хэрэг:<br>-"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ-ын 299,900,000 төгрөгийн нэхэмжлэлтэй хэргийг анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлүүлж тус тус хэрэгсэхгүй болгуулсан.<br>2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийт 6 хэрэг байна.<br>- Захиргааны хэрэг-2<br>- Иргэний хэрэг-3<br>- Арбитрын маргаан-3.<br>Тодруулбал: "Онч шийдэл" ТББ болон "Очит-Уул" ХХК нэхэмжлэлтэй хэрэг маргааныг захиргааны хэргийн шүүх анхан шатны журмаар, "Аттачр" ХХК-ийн 1,430,696,380 төгрөгийн, "Хүрд" ХХК-ийн 351,593,001 төгрөгийг тус тус гаргуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг маргааныг ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны журмаар шийдвэрлэсэн байна.<br>Харин "Ханжинстэй" ХХК, "Ремикон" ХХК, "Анто-Од" ХХК-ийн нэхэмжлэлтэй ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүх нэгтгэж, 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 191/ШШ2025/09940 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагын | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | зарим хэсгийг дараах байдлаар хангаж шийдвэрлэсэн. Үүнд:<br>"Ханжинстэй" ХХК-97,052,509 төг;<br>"Ремикон" ХХК-253,777,128 төг;<br>"Анто-Од" ХХК-64,237,372 төг;<br>Нийт- 415,067,009 төгрөг<br>Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргахаар ажиллаж байна.<br>"Бэрэн групп" ХХК-д холбогдох хэргийг арбитр 2025-06-04-ний өдөр хянан шийдвэрлэж 236,000,000,000 тэрбум төгрөг гаргуулахаар, "Цагаан хуаран консалтинг" ХХК-д холбогдох хэргийг арбитр 2025-04-16-ны өдөр хянан хэлэлцэж 36,348,591,776 тэрбум төгрөгийн шаардлагыг хангаж тус тус шийдвэрлэсэн. Арбитрын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа бөгөөд "Цагаан хуаран консалтинг" ХХК нийт 1,300,000,000 төгрөг төлж барагдуулсан байна. | |
| 1.1.62 | Бусад төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж хүргүүлэх. | Тайлан-2 | Тайлант хугацаанд 476 бичиг ирснээс хариутай 399 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хариу хүргүүлсэн байна. Үүнд:<br>Хуулийн төсөл- 124;<br>ЗГ-ын тогтоолын төсөл-325;<br>Хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол-18; | 90 |
| 1.1.63 | Дайчилгааны даалгавар шинэчлэн батлагдсантай холбогдуулан дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж баталж, Батлан хамгаалах яаманд хүргүүлэх ажлыг зохион байгуулах.<br>/Энэхүү ажил нь маш нууц/ | Төлөвлөгөө-1<br>Сургалт-1 | 1.Дайчилгааны төлөвлөгөөг төрийн болон албаны нууцын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж "Маш нууц"-ын зэрэглэлтэйгээр батлуулсан.<br>"Дайчилгааны хууль тогтоомжийн хэрэгжилт болон Үндэсний сөрөн тэсвэрлэх стратеги" сургалтыг Батлан хамгаалах яамны холбогдох албан тушаалтнуудтай хамтран 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад яамны нийт албан хаагчид (65) бүрэн хамрагдсан.<br>2.Батлан хамгаалах яам, холбогдох албан тушаалтнуудтай хамтран харьяа байгууллагуудын дайчилгааны даалгавар болон дайчилгааны төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаатай танилцаж, дайчилгаа хариуцсан албан хаагчдад 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлсэн.<br>3."Хот суурины ус хангамж, ариутгах, татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороо" болон "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын дайчилгааны даалгавар болон дайчилгааны даалгаврын төслийг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. | 90 |
| Зорилт 7: Салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайдын гадаад, дотоод айлчлалыг зохион байгуулах, | | | | |
| 1.1.64 | Барилгын салбарын хууль эрх зүйн орчин болон ногоон барилга, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр судалгаа хийх | Өндөр хөгжилтэй улсын барилгын салбарын хууль эрх зүйн орчин болон ногоон барилга, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр Канад, Герман улсын талаар судалгаа хийх зорилгоор томилолтоор ажилласан байна. | Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраа Бүгд Найрамдах Солонгос Улсын Газар, дэд бүтэц, тээврийн яамны урилгаар Сөүл хотод 2025 оны 09 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулах "К-Гео Феста" арга хэмжээнд оролцсон. Энэ үеэр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.<br>2. Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч М.Баяраа Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Орон сууцжуулалтын "Шпаркассе" банкны төлөөлөлтэй хоёр талт уулзалт хийх зорилгоор 2025 оны 10 | 80 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дугаар сарын 05-10-ны өдрүүдэд гадаад албан томилолтоор ажилласан. | |
| 1.1.65 | Ногоон уур амьсгаль, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр гадаадын туршлага судлах ажлыг зохион байгуулах | 1. ХББОСЯ болон харъяа байгууллагуудын Ногоон уур амьсгал, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр Солонгос, Австри Улсуудын туршлага судлах бүхий 2 удаагийн сургалт зохион байгуулах асуудлаар холбогдох гадаадын төрийн байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож, хөтөлбөрийг эцэслэн тохирсон байна.<br>2. Сургалтыг зохион байгуулах зардлыг цаад талын зардлаар шийдвэрлүүлсэн байна. | 1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Газар, дэд бүтэц, тээврийн яамны урилгаар Сөүл хотод 2025 оны 09 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулах "К-Гео Феста" арга хэмжээнд ТНБД М.Баяраа тэргүүтэй төлөөлөл оролцсон. Энэ үеэр хамтран ажилах санамж бичиг зурсан. | 100 |
| 1.1.66 | Монгол Улс, БНПУ-ын Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдааныг зохион байгуулах. | Засгийн газрын хоорондын комиссын ээлжит хуралдааныг зохион байгуулах товыг тохирох, шаардлагатай зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааны саналуудыг эрчимжүүлэх чиглэлээр ажилласан байна. | Засгийн газрын хоорондын комиссын ээлжит хуралдааныг зохион байгуулах товыг тохирох, шаардлагатай зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааны саналуудыг эрчимжүүлэх чиглэлээр ажилласан. Засгийн газрын бүтэц зохион байгуулалттай холбоотойгоор түр хойшлогдсон. | ХБ |
| 1.1.67 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Япон Улсын Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын яам хооронд 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан санамж бичгийг шинэчлэн байгуулах чиглэлээр ажиллана. | Япон Улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр яриа хэлэлцээ өрнүүлж, энэ чиглэлээр хамтын ажиллагааны баримт бичгийн төслийг солилцож, эцэслэн тохирсон байна. | Япон улсын барилга, орон сууцны эрчим хүчний хэмнэлт, пассив болон ногоон барилга байгууламжид хэрэгжүүлж байгаа бодлого, норм норматив, техникийн зохицуулалт, ач аолбогдол, үр нөлөөг судлах, шинэ технологи, инновац, туршлага судлах, мөн Орон сууцны санхүүжилтийн агентлаг (JHF)-аас ногоон орон сууцны санхүүжилтийг нэмэгдүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн бондын зах зээлийг хөгжүүлэх техникийн туслалцаа хэрэгжиж байгаатай холбогдуулан 12 албан хаагч сургалтад хамрагдсан. | 100 |
| 1.1.68 | НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын газартай хамтын ажиллагааг хөгжүүлэх. | НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын газартай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр яриа хэлэлцээ өрнүүлж, энэ чиглэлээр хамтын ажиллагааны баримт бичгийн төслийг эцэслэн тохирсон байна. | "Хот байгуулалт, орон сууцжуулалтын чиглэлээр хамтран ажиллах тухай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн төсөлд холбогдох яамдаас ирүүлсэн саналыг тусган хавсралтаар хүргүүлсэн. Үүний дагуу ГХЯ-аас холбогдох чиглэлийн дагуу ХЗДХЯ-аас санал авах чиглэл өгсөн. 2025 оны 12 дугаар сард UN-Habitat-ын Монгол дахь салбар орон нутгийн хотуудын удирдлагуудтай уулзаж, Шинэ хотын хөтөлбөрийн хэрэгжилт, хоёр дахь тайлангийн бэлтгэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, Монгол дахь төслүүдийн явцыг танилцуулсан. Хотын өгөгдөл бүрдүүлэх, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дасан зохицох аргачлал нэвтрүүлэх, WUF13-д оролцох бэлтгэл ажлыг хамтран хийх шаардлагыг хэлэлцэв. Уулзалтын үр дүнд хамтын ажиллагааг өргөжүүлэх, тайлангийн бэлтгэл болон техник туслалцааны чиглэлээр цаашдын ажлуудыг үнэлж, дараагийн алхмуудаа тохиролцож хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурхад бэлэн болсон. | |
| 1.1.69 | Европын Холбооны хүйтэн бүс нутгийн гишүүн орнуудтай ногоон барилга, түүнд шаардлагатай сэргээгдэх эрчим хүчний дулааныг хөгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх; | Аймаг болон сумын төвүүдийн дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэвтрүүлэх чиглэлээр яриа хэлэлцээ өрнүүлж, энэ чиглэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг эхлүүлсэн байна. | Европын Холбооны хүйтэн бүс нутгийн гишүүн орнуудтай ногоон барилга, түүнд шаардлагатай сэргээгдэх эрчим хүчний дулааныг хөгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр БНАвстри улсад сургалт зохион байгуулсан. | 90 |
| 1.1.70 | Монгол Улсын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, БНСиУ-ын Хамтын ажиллагааны байгууллагатай "Хот байгуулалтын хамтын ажиллагааны санамж бичиг" –ийг эрчимжүүлэх, мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллана. | Бүгд Найрамдах Сингапур Улстай орон сууц, хот байгуулалтын чиглэлээр хамтын ажиллагаа өргөжүүлэх замаар хамтарсан хурал зохион байгуулах, жишиг хот байгуулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, БНСиУ-ын Хамтын ажиллагааны байгууллагатай "Хот байгуулалтын хамтын ажиллагааны санамж бичиг" –ийг эрчимжүүлэх, мөрөөр Монгол Улс болон Бүгд Найрамдах Сингапур Улсын хөгжил хот байгуулалт, барилга, дэд бүтэц, орон сууцжуулалтын салбарын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хоёр улсын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжлийн төсөл, хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлэх хүрээнд БНСиУ-ын Темасек сан, "Орон сууц, хөгжлийн зөвлөл"-тэй хамтран зохион байгуулах "Хот байгуулалт, орон сууцжуулалтын хөгжил" хамтын ажиллагааны чуулганы хамтран зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. | 50 |
| 1.1.71 | Яам, харьяа байгууллагын удирдлагуудын гадаадад хийх айлчлалууд, олон улсын байгууллагын шугамаар оролцох хурал, уулзалт, экспо, сургалт зэрэг арга хэмжээнүүдийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангах, томилолтын асуудлыг шийдвэрлүүлж, дэмжлэг үзүүлэх. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд айлчлалыг амжилттай зохион байгуулсан байна.<br><br>Сайдын айлчлал- 2<br>Гадаад томилолтын тушаал- 23 | 1. Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч М.Баяраа Бүгд Найрамдах Солонгос Улсын Газар, дэд бүтэц, тээврийн яамны урилгаар Сөүл хотод 2025 оны 09 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулах "К-Гео Феста" арга хэмжээнд оролцсон. Энэ үеэр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан болно.<br>2. Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч М.Баяраа Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Орон сууцжуулалтын "Шпаркассе" банкны төлөөлөлтэй хоёр талт уулзалт хийх зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 05-10-ны өдрүүдэд гадаад албан томилолтоор ажилласан. | 100 |
| 1.1.72 | Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдээс гадаад хөрөнгө оруулалтын талаар төсвийн хязгаарт санал авч, 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа, тайлбар | Төсвийн саналын тоо-8<br>Сайдын тушаал-23. | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт хэрэгжүүлж буй төслүүдээс төсвийн хязгаарт санал авч, 2026 оны төсвийн төсөлд тусгах гадаад зээл тусламжаас санхүүжих 240,586.08 сая төгрөг, Улсын төсвөөс санхүүжих 32,657.48 сая төгрөгийн саналыг хүргүүлж, 2027-2028 оны төсвийн төсөөллийн нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгыг бэлтгэж хүргүүлсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | танилцуулгын хамт хүргүүлэх. | | | |
| 1.1.74 | Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй нийт 6 төслийн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг хянан, баталгаажуулж, зарцуулалтад хяналт тавих, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлын төсвийг хянан боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэн батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Гадаад зээл ашиглалтын хувь-90%.<br>Хөрөнгө оруулалт /Монголын тал/-ын гүйцэтгэл 80 дээш хувьд хүргэнэ.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хувь-90 хувь. | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй нийт 6 төслийн хүрээнд гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг цаг тухайд нь хянан баталгаажуулж, Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Үүнд: "Ногоон нуур 1008 айлын орон сууц барих төсөл"-ийн гадаад тусламжийн санхүүжилт 40,019.12 сая төгрөг буюу 99 хувийн гүйцэтгэлтэй, Монголын талын хөрөнгөөс 837.14 сая төгрөг, "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл"-ийн гадаадын зээлийн санхүүжилт 6,758.03 сая төгрөг буюу 82 хувийн гүйцэтгэлтэй, "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн гадаадын зээлийн санхүүжилт 29,152.70 сая төгрөг буюу 36 хувийн гүйцэтгэлтэй, Монголын талын хөрөнгөөс 1,460.21 сая төгрөг, "Солонго 1 орон сууцны хороолол барих төсөл"-ийн гадаадын зээлийн санхүүжилт 45,925.70 сая төгрөг буюу 51 хувийн гүйцэтгэлтэй, Монголын талын хөрөнгөөс 2,676.42 сая төгрөг, "Солонго 2 орон сууцны хороолол барих төсөл"-ийн гадаадын зээлийн санхүүжилт 39,781.61 сая төгрөг буюу 46 хувийн гүйцэтгэлтэй, "Аймгуудын бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн, шинэчлэх, шинээр барих (Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Увс) төсөл"-ийн гадаад зээлийн санхүүжилт 10,264.49 сая төгрөг буюу 53 хувийн гүйцэтгэлтэй, Монголын талын санхүүжилт 1,108.16 сая төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй байна.Төсөл хэрэгжүүлэх 4 нэгжийн 04 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлын төсвийг хянан баталгаажуулан Сангийн яаманд 2025.10.17-ны өдрийн 02/3865, 02/3866, 02/3867, 02/3868 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. | 100 |
| 1.1.75 | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй 6 төслийн гэрээ хэлэлцээрийн дагуу импортоор оруулж ирэх бараа материал, тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ чөлөөлөлтөд хяналт тавьж, шийдвэрлүүлэх, дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын жагсаалт батлуулах арга хэмжээ авах. | Импортын хүсэлтийн албан бичгийн тоо-131.<br>Тооцоо нийлсэн акт-8,<br>Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын жагсаалт-8. | Нийт 2025 оны байдлаар 73 нэр төрлийн бараа, материалын хүсэлт ирж 30,131,409,981.95 төгрөгийн үнийн дүнтэй бараа материалаас 4,519,711,497.29 төгрөгийн гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлж ажилласан. Гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх 73 нэр төрлийн бараа материалын хүсэлт 9 консерциум байгууллагад хуваагдаж 402 хүсэлтийг www.odamis.mof.gov.mn системд шивж хянан баталгаажуулан ХББОСЯ, Сангийн яам хүлээн авч баталгаажуулан гааль руу илгээж туслан гүйцэтгэгч 9 консерциум байгууллага гааль, нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт эдэлсэн байна.<br>Үүнд:<br>Чөлөөлөгдсөн-160 хүсэлт<br>Гааль баталгаажсан-86 хүсэлт<br>Гааль хүлээн авсан-80 хүсэлт<br>Сангийн яам руу илгээсэн-38 хүсэлт байна. | 100 |
| 1.1.76 | Салбарын хэмжээнд гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн Төслийн удирдах хорооны хурлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах. | ТУХ-ны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө - 12;<br>Төслийн удирдах хорооны шийдвэр-тогтоол, зөвлөмж-12; | Төслийн захирлуудыг ТНБД-ын 2025.08.12-ны өдрийн Б/132 дугаар тушаалаар шинэчлэн томилсон. Яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсантай холбогдуулан "Ногоон нуур 1008 айлын орон сууц барих төсөл"-ийн ТУХ-ыг Сайдын 2025.08.12-ны өдрийн 181 дүгээр | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ТУХ-аас гарсан шийдвэрийн биелэлт-95% | тушаалаар шинэчлэн байгуулж 2025.10.03-ны өдөр хуралдуулж хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, 3 зөвлөмж, “Солонго 1, 2 орон сууцны хороолол барих төсөл”-ийн ТУХ-ыг Сайдын 2025.08.12-ны өдрийн 183 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж 2025.10.03-ны өдөр хуралдуулж хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, 2 зөвлөмж, мөн 2025.12.04-ний өдөр хуралдуулж хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, 2 зөвлөмж, “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийн ТУХ-ыг Сайдын 2025.08.12-ны өдрийн 180 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж 2025.10.16-ны өдөр хуралдуулж хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, 2 зөвлөмжийг тус тус батлуулж хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна. “Аймгуудын бохир усны цэвэрлэх байгууламжийг өргөтгөн, шинэчлэх, шинээр барих (Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Увс) төсөл”-ийн ТУХ-ыг Сайдын 2025.08.12-ны өдрийн 182 дугаар тушаалаар, “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн ТУХ-ыг Сайдын 2025.08.12-ны өдрийн 184 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн байгуулсан. | |
| 1.1.77 | Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналыг бодлогын газруудаас авч нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах. | Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна. | 1.Хүнну хотод Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх "Хүнну хотын ногоон, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх төсөл"-ийн бэлтгэл ажлыг 2025-2026 онуудад бүрэн хэрэгжүүлж дуусгаснаар 2027 оны барилгын улирлаас эхлэн төслийн барилга угсралтын ажлыг цаг алдалгүй эхлүүлэх боломжийг бүрдүүлэхээр ажилласан.<br>2. Бүгд Найрамдах Австри Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулах төсөл (Сэлэнгэ, Баянхонгор, Ховд аймаг)”-ийг хэрэгжүүлэх саналыг Сангийн яаманд хүргүүлж төслийн урьдчилсан ТЭЗҮ-г бэлтгэхээр ажиллаж байна.<br>3. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Сумын төвийн дэд бүтцийг бэхжүүлэх болон ногоон хөгжлийг дэмжих” төслийг хэрэгжүүлж, уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгч багатай дэд бүтцийг төлөвлөн хөгжүүлэхийн зэрэгцээ олон нийтийн тав тухыг цогцоор хангах, үйлчилгээний шинэ стандартыг нэвтрүүлэхээр чиглэж байна. Мөн тус төслөөр дамжуулан орон нутгийн бизнесийн орчин, хувийн хэвшлийн өсөлтөд түлхэц өгч, сумын төвийг хөгжүүлэх бодлого болон институцийн чадавхийг стратегийн түвшинд бэхжүүлэхийг зорьж байна. | 90 |
| 1.1.78 | Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн 2024 оны гадаад зээл ашиглалтын тооцоог СЯ-тай нийлж, тайланд тусгуулах. | Төслийн тоо-6, Тооцоо нийлсэн акт, Гадаад зээл тусламжийн ашиглалтын хэмжээ-704,302.08 сая төгрөг. | Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн 2025 оны 3 дугаар улирлын байдлаар гадаад зээл ашиглалтын тооцоог нийлж тайланд тусгуулсан. 4-р улирлын тооцоо нийлсэн акт хүлээгдэж буй гүйцэтгэлээр 100%. | 100 |
| 1.1.79 | Салбарын чиглэлээр гадаад болон ногоон эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татах загвар, схемийг төрөлжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч нарт таатай | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний санал-3; Санхүүжилтийн хэлэлцээр-2; | Анхан шатны бүтээгдэхүүнд суурилсан аж үйлдвэрийн босоо кластерын концепци боловсруулах болон ногоон барилгын стандарт Bestger -ийг хөгжүүлж сургалт зохион байгуулах зорилго бүхий АЗийн хөгжлийн банзны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Ногоон амьдрахад таатай | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нөхцөлийг бий болгох асуудлыг хууль, дүрэм журмын дагуу зохион байгуулах. | Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах санал-2. | хот" техник туслалцааны төслийн 2026 оноос хэрэгжүүлж эхлэхээр санамж бичгийг байгуулсан. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжуудын өргөтгөл, шинэчлэлт, шинээр барих төсөл /Сэлэнгэ, Ховд, Баянхонгор, аймгийн төв/, Сумын төвүүдийн дэд бүтэц ба ногоон хөгжлийг сайжруулах төсөл, "Хүннү хотын ногоон, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх төсөл"-үүдийн мэдээллийг аргачлалын дагуу боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | |
| 1.1.80 | Хөрөнгө оруулалт, зээл тусламжийн үйл ажиллагааг зохицуулсан бодлого, төлөвлөлт, журам, стандартын сайн туршлагыг судлах, олон улсад туршлага судлах аялал, сургалт зохион байгуулах | Өндөр хөгжилтэй улсын хот, төлөвлөлт, барилга орон сууцжуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр төслийн санал боловсруулах журам стандартыг судалж танилцуулсан байна. | Хот байгуулалт, дэд бүтэц, ухаалаг үйлчилгээний чиглэлийн туршлага судлах сургалтад хамрагдаж, бохир усны менежмент, үерийн ухаалаг систем, чөлөөт бүсийн нэгдсэн удирдлага, хот төлөвлөлт-судалгааны байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж сайн туршлагыг нутагшуулах чиглэлээр БНСУ-д туршлага судлах сургалтыг зохион байгуулсан. Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025 оны 11 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Тэсвэртэй, бага нүүрстөрөгч бүхий хот байгуулалтын бодлого ба туршлага" сэдэвт арга хэмжээнд ХБОСБЗГ-ын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан болон 20 минут хөгжлийн корпорацийн төлөөллийг оролцуулсан. | 70 |
| 1.1.81 | Техник туслалцааны төсөл боловсруулах, талуудаас санал авах, чадамжийг дээшлүүлэх сургалт судалгаа болон хөгжүүлэлтийн төслүүд санаачлах, төслийн санал хүргүүлэх, хэрэгжүүлэх | Техник туслалцааны санхүүжилтийн хэлэлцээрийн төсөлд холбогдох газруудын саналыг авч нэгтгэн Сангийн яам болон олон улсын донор байгууллагад хүргүүлэх | Монгол Улс болон Бүгд Найрамдах Сингапур Улсын хөгжил хот байгуулалт, барилга, дэд бүтэц, орон сууцжуулалтын салбарын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хоёр улсын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжлийн төсөл, хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлэх хүрээнд БНСиУ-ын Темасек сан, "Орон сууц, хөгжлийн зөвлөл"-тэй хамтран зохион байгуулах "Хот байгуулалт, орон сууцжуулалтын хөгжил" хамтын ажиллагааны чуулганыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж 2026 оны хоёрдугаар улиралд зохион байгуулахаар ажиллаж байна. | 30 |
| 1.1.82 | Сайдын багцын хэмжээнд улсын төсвөөс санхүүжих гадаадын техник туслалцааны төслүүдийн хөрөнгийг шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 1.Техник туслалцааны санхүүжилтийн хэлэлцээрийн төсөлд холбогдох газруудын саналыг тусгуулах ажлыг зохион байгуулсан байна.<br>2. Техник туслалцааны хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Төрийн нарийн бичгийн дарга болон асуудал хариуцсан газрын даргын хэмжээнд тус тус уулзалтууд зохион байгуулсан байна.<br>3. Бэлтгэл ажилтай холбогдуулан цахим шуудангаар харилцаж ажилласан байна. | 1. "Техникийн туслалцаа 10306–MON: Сумын төвийн дэд бүтцийг бэхжүүлэх ба ногоон хөгжлийг дэмжих төслийн хүрээнд холбогдох уулзалтуудыг төлөвлөж, удирдан зохион байгуулсан.<br>2. Хот байгуулалт, барилга, орон суужуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга О.Одбаяр 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Дэлхийн банкны төлөөллийг хүлээн авч "Гамшгийн эрсдэлийн менежмент, хотын тэсвэртэй байдал ба орон сууцжуулалтын техник туслалцааны хүрээнд" хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцох уулзалтыг зохион байгуулсан.<br>3. АХБ болон бусад олон улсын байгууллагын төслүүдийн туршлага, сургамжийг ашиглан хот байгуулалтын салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чигэлсэн АХБ-ны 500.0 мянган ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх техник туслалцааг хэрэгжүүлэх зорилгоор 3 удаагийн уулзалтын АХБ-тай зохион байгуулж санамж бичигт гарын үсэг зурсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 3. Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт"-ын 1-д туссан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг дэмжих байгууллага (Mitigation Action Facility)-ын буцалтгүй тусламж, улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжих "Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх" төслийн ХББОСЯ-ны хариуцах 8 сая еврогийн санхүүжилтээс 16,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Монголын талын хөрөнгөнд тусгуулж 2026 оноос эхлэн санхүүжүүлэхээр тохирсон. | |

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 70 хүртэл хувьтай "хангалтгүй" хэрэгжсэн 5 арга хэмжээ байна. Үүнд:

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулна;
2. Хот байгуулалт, барилга, оррон сууцжуулалтын яамны үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг яамны газар, хэлтсүүд, ТББ-тай хамтран зохион байгуулна;
3. Яамны "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулах;
4. Монгол Улсын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, БНСиУ-ын Хамтын ажиллагааны байгууллагатай "Хот байгуулалтын хамтын ажиллагааны санамж бичиг" –ийг эрчимжүүлэх, мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллана;
5. Техник туслалцааны төсөл боловсруулах, талуудаас санал авах, чадамжийг дээшлүүлэх сургалт судалгаа болон хөгжүүлэлтийн төслүүд санаачлах, төслийн санал хүргүүлэх, хэрэгжүүлэх.

**Дөрөв. Дүгнэлт:**

Төрийн захиргааны удирдлагын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 94,3 хувьтай, "Бүрэн хангалттай" байна.

**Тав. Санал, зөвлөмж:**

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө төлөвлөхдөө хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хагас, бүтэн жилээр төлөвлөж, хүрэх буюу зорилтот түвшин, суурь түвшинийг тоогоор эсвэл хувиар илэрхийлж төлөвлөгөөндөө тусгах;
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний "хангалтгүй" хэрэгжсэн 5 арга хэмжээний хэрэгжилтийг хангахад анхаарч 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах.

**ХЯНАСАН:**

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Б.НАЙРАМДАЛ

**НЭГТГЭСЭН:**

ШИНЖЭЭЧ Ц.УУГАНБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

# БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ**
**2025 он**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ**

# БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.12.18

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримталсан.

## Хоёр. Танилцуулга

Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус газраас ирүүлсэн төлөвлөгөө, тайлангийн биелэлтийг үндсэн материал болгон ашигласан.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар нь 2025 онд 7 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 91.01 хувьтай буюу "бүрэн хангалттай" үнэлэв. Үүнд: 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 51 арга хэмжээ, 70-85% хүртэлх хэрэгжсэн 9 арга хэмжээ, 70 хүртэлх хэрэгжсэн 4 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээний биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1, хүснэгт-1.1-д тус тус үзүүлэв.

*Хүснэгт-1*

| № | Ажил үйлчилгээ | Зорилт | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэл | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 85-аас дээш хувьтай | 70-85% хүртэлх | 70 хүртэлх | |
| 1 | Нийт арга хэмжээ | 7 | 64 | 51 | 9 | 4 | **91.01** |

*Хүснэгт-1.1*

| № | Зорилт | % | Зорилт | % | Зорилт | % | Зорилт | % | Зорилт | % | Зорилт | % | Зорилт | % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | **5.1** | 90 | **5.2** | 93.5 | **5.3** | 95 | **5.4** | 88.3 | **5.5** | 90.7 | **5.6** | **92** | **5.7** | **90** |
| 1 | 5.1.1. | 100 | 5.2.1. | 90 | 5.3.1. | 90 | 5.4.1. | 100 | 5.5.1. | 100 | 5.6.1. | 100 | 5.7.1. | 100 |
| 2 | 5.1.2. | 100 | 5.2.2. | 90 | 5.3.2. | 100 | 5.4.2. | 100 | 5.5.2. | 100 | 5.6.2. | 100 | 5.7.2. | 70 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 5.1.3 | 100 | 5.2.3. | 100 | | | 5.4.3. | 100 | 5.5.3. | 90 | 5.6.3. | 100 | 5.7.3. | 100 |
| 4 | 5.1.4. | 100 | 5.2.4. | 90 | | | 5.4.4. | 85 | 5.5.4. | 100 | 5.6.4. | 90 | 5.7.4. | 90 |
| 5 | 5.1.5. | 100 | 5.2.5. | 100 | | | 5.4.5. | 70 | 5.5.5. | 100 | 5.6.5. | 70 | | |
| 6 | 5.1.6. | 100 | 5.2.6. | 100 | | | 5.4.6. | 100 | 5.5.6. | 100 | | | | |
| 7 | 5.1.7. | 40 | 5.2.7. | 80 | | | 5.4.7. | 70 | 5.5.7. | 80 | | | | |
| 8 | 5.1.8. | 60 | 5.2.8. | 100 | | | 5.4.8. | 70 | 5.5.8. | 90 | | | | |
| 9 | 5.1.9. | 100 | 5.2.9. | 100 | | | 5.4.9. | 100 | 5.5.9. | 30 | | | | |
| 10 | 5.1.10. | 70 | 5.2.10. | 100 | | | | | 5.5.10. | 90 | | | | |
| 11 | 5.1.11. | 100 | 5.2.11. | 100 | | | | | 5.5.11. | 100 | | | | |
| 12 | 5.1.12. | 80 | 5.2.12. | 100 | | | | | 5.5.12. | 90 | | | | |
| 13 | 5.1.13. | 100 | 5.2.13. | 100 | | | | | 5.5.13. | 100 | | | | |
| 14 | 5.1.14. | 100 | 5.2.14. | 60 | | | | | 5.5.14. | 100 | | | | |
| 15 | 5.1.15. | 100 | | | | | | | | | | | | |
| 16 | 5.1.16. | 90 | | | | | | | | | | | | |

## Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

*Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:*

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго 3. "барилга, барилгын материалын салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, теслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" зорилтын хүрээнд: | | | | |
| 5.1. Барилга, барилгын материалын салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих зорилтын хүрээнд: | | | | 90 |
| 5.1.1. | Барилгын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөлд санал авч, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулна. /ЗГҮАХХАХТ-ний 4.2.4.3.1286/ | Барилгын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсөлд ирүүлсэн саналыг нэгтгэн үзэл баримтлалын төслийг боловсруулж ХЗДХЯ-нд хүргүүлнэ. | Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал боловсруулах, батлуулах хүртэлх холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг ХББОСС-ын 2025.09.15-ны өдрийн 210, 2025.10.17-ны өдрийн 228 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг нийт 6 удаа хуралдаж үзэл баримтлалын төслийг боловсруулсан.<br>Хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал болон Барилгын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн хамт 2025.12.15-ны өдрийн 01/4591 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | 100% |
| 5.1.2. | Барилгын материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай | Барилгын материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл | Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх дулаан тусгаарлах материалын жагсаалт гаргаж, эдгээр материалыг "Барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем"-ийн дагуу кодлуулахаар Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хуулийн төсөл боловсруулна. | боловсруулж, Сангийн сайдад хүргүүлнэ. | үнэлгээний хэлтэст 2025.08.04-ний өдрийн 02/2859 дугаартай албан бичгээр хүргүүлж, татвараас чөлөөлөх барааны кодыг ижил төстэй материалаас ялган кодлох, нарийвчлан тогтоохоор салбарын ТББ-ууд, ААН-үүдийн төлөөллүүдтэй хамтран ажилласан.<br><br>Дулаан тусгаарлах материалыг НӨАТ-аас чөлөөлөх хуулийн төсөл болон уг хуулийг дагалдан гарах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, танилцуулгын хамт Сангийн сайдад 2025.08.27-ны өдрийн 01/3189 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Сангийн сайдаас 2025.10.31-ний 01/9837 дугаартай албан бичгээр "...2026 оны улсын төсөв УИХ-д өргөн баригдсан тул татварын асуудлыг шийдвэрлэх боломжгүй" гэсэн хариу ирүүлсэн. | |
| 5.1.3 | Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр боловсруулна. | Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр боловсруулна. | "Барилгын материалын үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих хөтөлбөр"-ийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ХББОСС-ын 2025.08.08-ны өдрийн 175 дугаар тушаалаар байгуулсан.<br>- Хөтөлбөр боловсруулах шаардлагатай судалгааны арга, аргачлал, асуумж боловсруулж, салбарын ТББ-ууд болон аймгуудаас албан бичгээр судалгаа авч, салбарын суурь судалгаа, нөхцөл байдлын үнэлгээг боловсруулж, "Барилгын материал ханган нийлүүлэгчдийн холбоо", "Эрчим хүчний хэмнэлттэй цонх, хаалганы холбоо", Стандарт, хэмжил зүйн газар, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх газар, Хөгжлийн банкнаас албан бичгээр санал авч, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд тусгасан. - "Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр"-ийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар Засгийн газрын гишүүдэд 2025.09.24-ний өдрийн 01/3626 дугаартай албан бичгээр хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн ЗГХЭГ-т 2025.12.03-ны өдрийн 01/4480 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 100% |
| 5.1.4. | Барилга байгууламжийн газар хөдлөлт, тэсвэрлэлтийг хангах ажлыг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна. | Олон улсын сайн туршлага бодлогын хувилбаруудыг хэлэлцэн урьдчилсан тандан судалгааг хийж, үндэслэл шаардлагыг тодорхойлж, санал боловсруулна. | Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Япон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран Барилга байгууламжийн газар хөдлөлт, тэсвэрлэлтийг хангах анхдагч хуулийн хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж ажилласан. Төслийн ахлагч К.Овада, барилгын хүчитгэлийн инженер С.Фүкүшима, төслийн ажилтан Д.Эрдэнэбат, С.Пүрэвдорж нартай 2025 оны 8 дугаар сарын 05-наас 12 дугаар сарын 12-ны хооронд нийт 6 удаагийн уулзалтыг зохион байгуулж ажиллалаа.<br>Тус яамны зүгээс "Барилгын тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөлд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн үйл ажиллагааны талаар зүйл заалтаар оруулахаар шийдвэрлэж хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 11 дүгээр бүлэгт тусгасан. | 100% |
| 5.1.5. | Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам, суурь | Барилгын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам, суурь | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.02.10-ны өдрийн 36 дугаар тушаалаар Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн эзэмшигчидэд тавих нөхцөл шаардлагыг батлуулсан. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нөхцөл шаардлагыг шинэчилнэ. | нөхцөл шаардлагыг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч, нэгтгэн батлуулна. | | |
| 5.1.6. | "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг шинэчлэн боловсруулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.3.479/ | Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийг шинэчлэн боловсруулж, ЗГ-ын гишүүдээс санал авч, ирүүлсэн саналыг тусгаж, ЗГ-т хүргүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна. | "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийн төсөл болон Засгийн газрын тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2025.11.03-ны өдрийн 01/4069 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Засгийн газрын гишүүд болон мэргэжлийн байгууллага, холбоодоос ирсэн саналыг дүрмийн төсөлд тусган Засгийн газрын 2025.12.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр Сайдын 2025.12.15-ны өдрийн 01/4642 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100% |
| 5.1.7. | "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг шинэчлэн боловсруулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.3.479/ | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг шинэчлэн боловсруулж, ЗГ-ын гишүүдээс санал авч, ирүүлсэн саналыг тусгаж, ЗГ-т хүргүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна. | Дүрмийн төслийг эхний хувилбарыг боловсруулсан. | 40% |
| 5.1.8. | "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам"-ийг шинэчлэн боловсруулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.3.479/ | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг шинэчлэн боловсруулж, ЗГ-ын гишүүдээс санал авч, ирүүлсэн саналыг тусгаж, ЗГ-т хүргүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна. | Засгийн газрын 2021 оны 343 дугаар тогтоолоор баталсан "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам" болон ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн төслийг боловсруулсан. Төсөлд холбогдох байгууллагуудаас санал авахаар бэлтгэж байна. Уг журам болон дүрмийг хооронд нь уялдуулан цаашид Захиалагчийн хяналтыг барилгын ажилд тавихдаа зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг чадавхжуулах, хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтыг төсөлд тусгасан. | 60% |
| 5.1.9. | Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалтын баримт бичгийг батлуулна. | Техникийн зохицуулалтын төсөлд ЗГ-ын гишүүдийн саналыг тусган, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЗГ-т хүргүүлэн батлуулах ажлыг зохион байгуулна. | - "Барилгын материалын аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын төслийг Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2025.01.31-ний өдөр хэлэлцүүлсэн.<br>- Техникийн зохицуулалтын төсөлд хянан тохиолдуулга хийх ажлыг 2025.03.19-ний өдрийн 2025/89 дугаартай гэрээгээр, шүүмж хийх ажлыг 2025.05.14-ний өдрийн "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Ш-26/2025)-гээр Монгол Улсын Зөвлөх инженер Б.Лхагваатай байгуулан шинэчлэн боловсруулсан.<br>- "Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын төсөлд санал | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | авахаар 2025.08.20-ны өдрийн 02/3088 дугаартай албан бичгээр СХЗГ-т хүргүүлэн санал, дүгнэлт гаргуулсан.<br>- Техникийн зохицуулалтын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөлд санал авах тухай хүсэлтийг Засгийн газрын гишүүдэд 2025.10.30-ны өдрийн 01/4013 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд ирүүлсэн саналыг нэгтгэж, Засгийн газрын 2025.12.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр Сайдын 2025.12.15-ны өдрийн 01/4640 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | |
| 5.1.10. | "Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын баримт бичгийг батлуулна. | Техникийн зохицуулалтын төсөлд ЗГ-ын гишүүдээс санал авч, ирүүлсэн саналыг тусган ЗГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулна. | "Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын баримт бичгийн төслийг "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-аас 2025.11.19-ний өдрийн 01/3288 дугаар албан бичгээр ирүүлсэн. "Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын төслийг ажлын хэсгээр хэлэлцүүлсэн.<br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/154 дугаар тушаалаар өөрчлөлт оруулан батлуулсан. "Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын төсөлд дүгнэлт гаргуулахаар СХЗГ-т хүргүүлэх бэлтгэл хангасан. | 70% |
| 5.1.11. | "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам"-ын төсөлд холбогдох байгууллагаас санал авч, нэгтгэн батлуулна. | - "Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам"-ын төслийг боловсруулж 2025.06.04-ний өдөр "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-т тус журмын хэрэгжилтийг дүгнэж, журмыг шинэчлэн боловсруулах, холбогдох байгууллагуудаас санал авах ажлыг зохион байгуулж, саналыг авч журмын төсөлд тусган ирүүлэх талаар 03/2213 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>- "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-аас 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/2024 дугаар албан бичгээр тус журмын төсөлд Монголын Архитекторуудын эвлэл, Монголын барилгын инженерүүдийн холбоо, Монголын барилгын төсөвчдийн холбоо, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо болон салбарын зөвлөх зэрэгтэй инженер, архитектор буюу 60 гаруй экспертүүдээс санал авч ирүүлсэн. Журмын төслийн эцсийн хувилбарт тус яамны газар хэлтэс болон дээрх төрийн бус байгууллага болон экспертүүдээс ирүүлсэн саналыг тусган боловсруулж, журмын төслийг сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. | 100% |
| 5.1.12. | Эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй ногоон барилгын материалын үйлдвэрлэлийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ. /"Алсын хараа-2050" 6.4.10./, /БХБСХХЯБТ-ний 1.1.4, 3.2.1/, | Барилгын материалын "ногоон" үнэлгээний аргачлалуудыг харьцуулан судлах судалгаа гаргах ажлыг зохион байгуулна. | Ногоон барилгын материалыг олон улсад ямар, ямар аргачлалаар үнэлдэг талаар харьцуулан судалж, илтгэл боловсруулсан.<br>Олон улсад "ногоон" барилгын материалыг голчлон "барилгын материалд шингэсэн эрчим хүч" буюу "материалын амьдралын мөчлөгийн үнэлгээ" болон "хүний эрүүл мэндэд ээлтэй байх" зэрэг үзүүлэлтээр үнэлж, гэрчилгээжүүлэн, шошго олгодог. Монгол Улсад шинээр батлагдан мөрдөгдөж эхэлж буй "BestGER" Ногоон барилгын үнэлгээнд эдгээр шалгуур туссан боловч хэрхэн үнэлэх аргачлал байхгүй, хүний нөөц дутмаг байна. <u>Иймээс салбарын яамнаас уг үнэлгээг хийх</u> | 80% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.1./ | | үндэс суурийг бэлдэх зорилгоор дараах ажлуудыг хийгээд байна. Үүнд:<br><br>1./ БОАЖС-ын тушаалаар батлан мөрдөж байсан “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, тус журмын төсөлд "эко тэмдэг, ногоон гэрчилгээнд тавигдах шаардлагыг хангасан эсэх дүгнэлтийг **итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага гаргана,** тус байгууллага нь үндэсний болон олон улсын стандартын шаардлага, эко тэмдэг, ногоон гэрчилгээ авах шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг үнэлж, тохирлын гэрчилгээ олгоно." гэж тусган өмнөх зохицуулалтыг өөрчилсөн.<br>2./ “Барилгын материалд шингэсэн эрчим хүч /карбон/-ийг үнэлэх аргачлал боловсруулах” хүсэлтийг “УБ хотын угсармал орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” төсөлд 2025.02.07-ны өдрийн 03/450 дугаартай албан бичгээр хүргүүлж, 2025 оны төлөвлөгөөнд нь тусгуулсан. Тус төслөөс “Ногоон барилгын хүрээлэн” ТББ-тай байгуулсан 83492037 дугаартай гэрээндээ уг ажлыг тусгаснаар “Ногоон барилгын хүрээлэн” ТББ уг аргачлалыг боловсруулж байна. | |
| 5.1.13. | Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь, нэмрийн хэрэгжилтийг хангана.<br>**ЗГҮАХХҮТ /2024-2028/** | Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь, нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус яамны хариуцах чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, салбарын 1 тайланг хүргүүлсэн байна. | Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн 2 жил тутмын ил тод байдлын 1, 2-р тайлан, Үндэсний 4-р тайлан илтгэлд тусгах салбарын тайланг Уур амьсгалын өөрчлөлтийн хамтын ажиллагааны төвийн ccrccmongolia@gmail.com цахим хаягаар 2025.01.22-ны өдөр илгээсэн.<br>Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (ҮТХН буюу NDC)-ыг шинэчлэх ҮТХН3.0 -ыг боловсруулах үүрэг бүхий Үндсэн ажлын хэсэг болон Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг БОУАӨ-ийн сайдын 2024.11.22-ны өдрийн А/807 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсэгт гишүүнээр, салбарын дэд ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар ажиллаж, Засгийн газрын 2025 оны 91 дүгээр тогтоолоор батлуулахад дэмжлэг үзүүлж, ЗГ-ын тогтоолын төсөлд өгөх саналыг 2025.09.04-ний өдрийн 01/335 тоот албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын тэргүүн Шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайд, БОУАӨ-ийн сайдын 2025.01.21-ний өдрийн хамтарсан А/32/09 тушаалаар "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг" байгуулагдсан. Тус ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж салбарын асуудлыг тусгах, хуулийн төслийг боловсруулахад хамтран ажиллаж байна. | 100% |
| 5.1.14. | Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | “Барилга, хот байгуулалтын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан, тус газрын хэрэгжүүлэх арга хэмжээг | 1.“Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр 2025.02.03-04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Ерөнхий хяналтын сонсголд сайдын тавих илтгэл, салбарын 2018-2024 онуудад хийгдсэн ажил, арга хэмжээний танилцуулга, холбогдох мэдээллийг бэлтгэж Ж.Чинбүрэн УИХ-ын гишүүнд /УИХ-ын тамгын газарт/ 01/232 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Илтгэл, танилцуулгыг бэлтгэсэн. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | **ЗГҮАХХҮТ /2024-2028/** | хэрэгжүүлэхэд чиглэсэн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан байна. | 2.Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2025.08.01-ний өдрийн байдлаар гарган 2025.08.19-ний өдрийн 02/3083 дугаартай албан бичгээр БОУАӨЯ, АББҮХороонд хүргүүлсэн. Мөн хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх хэлэлцүүлэгт 2025.08.29-ний өдөр оролцож, салбарын зүгээс тайлбар гаргаж, танилцуулга хийсэн.<br>3.Ипотекийн 6%-ийн зээлийн журамд Ногоон барилгын үнэлгээний BestGER системээр үнэлэн олгосон гэрчилгээг үндэслэн зээл олгох өөрчлөлт оруулах боломжтой талаар Монгол банкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал, холбогдох мэргэжилтнүүд болон Монголын Ногоон барилгын хүрээлэнгийн төлөөлөлтэй хамт 2025.09.25-ны өдөр Монголбанкинд уулзалт хийсэн. Хамтын ажиллагааг өргөжүүлж, энэ ондоо багтаан журмын өөрчлөлтийг хийж, иргэдэд Ногоон зээлийг хувийн орон сууцанд олгож эхлүүлэхээр тохиролцсон.<br>4.ААНОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэгт заасан хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, түүнд хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах чиглэлээр ТЕГ-ын Хурлын танхимд 2025.10.16-ны өдөр зохион байгуулсан хэлэлцүүлэгт ХББОСЯ-ыг төлөөлж оролцож чиглэл авч, санал солилцсон.<br>5.ХББОС-ын Сайдын 2025 оны 105 дугаар тушаалаар баталсан "ААНОАТ-ын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага"-ын талаар мэдээлэл солилцож зөвлөгөө өгсөн. Үүнд:<br>-Татварын мэргэшсэн зөвлөхүүдтэй уулзалт 2025.10.28-ны өдөр;<br>-"Вертекс майнинг партнер" ХХК-ийн хуулийн албаны дарга болон мэргэжилтэнтэй хийсэн уулзалт 2025.10.29-ний өдөр. | |
| 5.1.15. | Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох, цахим системийн үйл ажиллагааны чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна.<br>**ЗГҮАХХҮТ /2024-2028/** | Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, хөтлөх, бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулсан байна. | Барилгын ХХЯ-ын хэмжээг тоолох цахим системийг хөгжүүлэх, системийн талаарх салбарын болон хангагч байгууллагуудын мэргэжилтнүүдийн чадавхыг дээшлүүлэх сургалт, хэлэлцүүлгийг 2025.12.05-ны өдөр НҮБХХ-ийн "Уур амьсгалын амлалт 2" төслтэй хамтран зохион байгуулж, 30 гаруй мэргэжилтэн оролцож, системийн хөгжүүлэлт, найдвартай ажиллагаа, мэдээллийн эрэлт, нийлүүлэлтийн талаар илтгэл хэлэлцүүлсэн. | 100% |
| 5.1.16. | Ногоон барилгын чиглэлээр салбарын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй | Салбарын аж ахуйн нэгж байгууллагатай хүлэмжийн хийн ялгарал багатай, эрчим хүчний хэмнэлттэй барилга | 1.Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг иргэдэд сурталчлан танилцуулах, оролцогч байгууллагуудын уялдааг хангах зорилгоор "Дулаан байшин" өдөрлөгийг БОУАӨЯ, | 90% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | барьсан, материал үйлдвэрлэсэн, шинэ инновац, технологи нэвтрүүлсэн, импортолсон болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах, өдөрлөг, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулна. | ЭХЯ, НЗДТГ-тай хамтран Сүхбаатарын талбай дээр 2025.05.05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгт 82 бүүт ажиллуулж, үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч ААН байгууллагуудыг байрлуулсан. Тус өдөрлөгт салбарын ТББ, ААН, ОУ-ын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбарын нийт 91 байгууллагын төлөөлөл оролцож, давхардсан тоогоор 29,562 иргэнд эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг танилцуулсан.<br>2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт заасан ногоон барилга, саарал ус, тохижилтын зориулалтаар оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгт хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдуулан салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, үйл ажиллагааны талаар хүсэлт ирүүлсэн “Хера холдинг” ХХК-д 2025.08.19-ний өдрийн 02/3083 дугаар албан бичгээр “Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарт хөнгөлөлт эдлэх, бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах шаардлага” болон холбогдох дүрэм, журам, стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх талаар хариу хүргүүлсэн.<br>3.Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээний босго хэмжээг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2025 оны А/60 дугаар тушаалаар байгуулсан. АХ-ийн 3 удаагийн хуралд оролцож шаардлагатай мэдээлэл цуглуулах, солилцох, босго үнийн үндэслэлийг шинээр тодорхойлох талаар АХ-ийн төлөвлөгөө гаргасан. | |
| 5.2. Барилга, барилгын материалын салбарын төсөл, хөтөлбөрийг зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих зорилтын хүрээнд: | | | | 93.57 |
| 5.2.1. | Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх гол нэр төрлийн материал болох ган туйван, цемент, хавтгай шилийг эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэж, импортыг бууруулах ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.4, 481/, /МУ-ын 5 жилийн Үндсэн чиглэлийн 3.2.4/ | Эх орны эрдэс түүхий эд /шохойн чулуу/-ээр дотооддоо үйлдвэрлэж буй цемент, шохойн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжиж, үйлдвэрлэлийн хэмжээг 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллана. | <u>**1. Цемент үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд:**</u><br>Ховд аймагт хэрэгжсэн “Вестерн холд” ХХК-ийн цементийн үйлдвэрийн төслийн “Албан татвар төлөх хугацааг 2 жил хүртэл хугацаагаар сунгах тухай” гурван талт гэрээний төслийг боловсруулан. Сангийн сайдад 2025.04.30-ны өдрийн 01/1534 дугаартай албан бичгээр хүргүүлэн гэрээг сунгуулснаар тус үйлдвэрлэлийн үйл ажиллагаа жигдэрч жилд 300 мянган тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал нэмэгдсэн. Ингэснээр МУ-ын нийт цементийн үйлдвэрлэл жилд 4.53 сая тонн болж, дотоодын хэрэгцээнээс давсан хүчин чадал үүсээд байна.<br><u>**2. Элс, хайрга, дайрганы үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд:**</u><br>Эх орны эрдэс түүхий эд, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгуудаас 2025.03.12-ны өдрийн 03/880 дугаартай албан бичгээр судалгаа авч, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн асуудал боловсруулж, Бүсчилсэн хөгжлийн өргөтгөсөн хуралдаануудад Хангайн | 90% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | бүст 2025.04.14-нд, Хойд бүст 2025.04.28-нд, Говийн бүст 2025.05.12-нд тус тус танилцуулсан. Мөн Төвийн бүсийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөлд уг асуудлыг тусгах санал өгсөн. | |
| 5.2.2. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, цементийн үйлдвэрүүдийг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.6. 484/ | Түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгааг шинэчилэн боловсруулж, бодлогын хувилбар гаргана. | Барилгын үндсэн түүхий эд болох элс, хайрга, дайрганы судалгааг нарийвчлан гаргахаар Аймгуудын ГХБХБГ-уудад 2025.03.12-ны өдрийн 03/880 дугаартай албан бичиг хүргүүлэн хариуг авч, нэгтгэн боловсруулалт хийв.<br>- Уг судалгаанд үндэслэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын хүртээмжийг сайжруулах талаар холбогдох яамд хамтран ажиллах тухай асуудал боловсруулж, Бүсүүдийн зөвлөгөөнүүд /Хангайн бүст 2025.04.14-нд, Хойд бүст 2025.04.28-нд, Говийн бүст 2025.05.12-нд, Төвийн бүст 2025.05.28-нд/-д танилцуулсан.<br>- Түгээмэл тархацтай ашигт малтмалын хүртээмжийг сайжруулах тухай заалтыг Төвийн бүсийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолд тусгуулахаар санал боловсруулж, СБТХББЗГ-т өгсөн.<br>- АҮЭБЯ-ны Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын солбицол батлуулах тухай ЗГ-ын тогтоолын төсөлтэй танилцаж, 2025.05.07-ны өдрийн 01/1672 дугаартай албан бичгээр санал хүргүүлэв.<br>- “Өршөөлт хайрхан” ХХК-иас ирүүлсэн хаягдал хайрга бутлан элс үйлдвэрлэх тухай хүсэлттэй танилцан 2025.07.01-ний өдрийн 03/2581 дугаартай албан бичгээр дэмжсэн хариу хүргүүлэв.<br>- “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд аймаг орон нутгийг ТТАМ-ын ашиглалтыг нэмэгдүүлэх заалт тусган боловсруулсан. Уг хөтөлбөрийн төсөлд чиглэл авахаар ЗГХЭГ-т 2025.12.03-ны өдрийн 01/4480 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 90% |
| 5.2.3. | Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулах ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 3.3.1.5. 613/ | Хөтөлийн болон Налайхын “Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ын хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | 1. Хөтөлийн болон Налайхын “Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-д байгуулах үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийг Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах талаар Ерөнхий сайдын албан даалгаварт тусгуулах санал өгсөн. ХББОССайдын Нийслэлийн Засаг даргатай хийх уулзалтын танилцуулгад оруулсан.<br>2. Хөтөлийн болон Налайхын “Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ын орчинд ажиллах үйлдвэрүүдийнхээ ТЭЗҮ-ийг ХББОСЯ-ны дэргэдэх “Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах чиглэлийг "Эрдэнэс ҮТП" ХХК, Налайхын Үйлдвэрлэл технологийн парк" ХК-д 2025.06.02-ны өдрийн 03/2182 дугаар албан бичгээр хүргүүлэв. | 100% |
| 5.2.4. | Хөшигийн хөндий болон Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логистикийн төв | Чөлөөт бүсүүдийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд туссан газрын | 1. “Барилгын материалын нэгдсэн хангамж, авто тээврийн логистикын төв” байгуулах төслийн санал боловсруулж, холбогдох талуудын уулзалтын хөтөлбөр болон ажлын хэсэг байгуулах сайдын тушаалын төсөл боловсруулсан боловч уг | 90% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгуулах ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 1.3.5.4. 138- 139/ | хэмжээнд нийцүүлэн "Барилгын материалын хангамжийн төв"-ийн төслийн санал боловсруулж, холбогдох байгууллагад саналыг хүргүүлнэ. | асуудлаар тусгай элч С.Баяр ажиллах болсонтой холбогдуулан уг ажлын хэсгийг байгуулаагүй.<br>2. Монгол Улсын "Барилгын материалын нэгдсэн хангамж"-ийн төслийг 2025.04.14-ны өдөр Тусгай элч С.Баярын туслах Ж.Бямбацогтод танилцуулсан.<br>3. Барилгын материалын нэгдсэн хангамжийн төсөлтэй холбоотой дараах мэдээллүүдийг бэлтгэн Тусгай элч С.Баярын туслах Ж.Бямбацогтод и-мэйлаар хүргүүлсэн. Үүнд:<br>- Хамтарсан Засгийн газрын хэрэгжүүлэх "14 мега төсөл"-д шаардагдах барилгын материалын талаар мэдээллийг 2025.04.09-нд<br>- "Барилгын материалын нэгдсэн хангамж"-ийн төслийн танилцуулгыг 2025.04.15-нд<br>- Мега төсөлд шаардагдах тусгай зориулалтын цементийн мэдээллийг 2025.04.18-нд<br>4. Бүсчилсэн хөгжлийн өргөтгөсөн хуралдаан Хангайн бүст 2025.04.14-нд зохион байгуулагдахтай холбогдуулан Өвөрхангай аймагт байгуулах "Барилгын материалын хангамж" төслийн концепц, PPT танилцуулга болон илтгэл, асуулт, хариулт боловсруулж, Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.<br>5. Бүсчилсэн хөгжлийн өргөтгөсөн хуралдаан Төвийн бүст 2025.05.28-нд зохион байгуулагдахтай холбогдуулан Хөшигийн хөндий болон Алтанбулаг чөлөөт бүст байгуулах "Барилгын материалын хангамж" төслийн концепц, PPT танилцуулга болон илтгэл, асуулт, хариулт боловсруулж, Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. | |
| 5.2.5. | Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжиж ажиллана. /ЗГҮАХХАХТ-ний 3.3.1.8. 622-623/, /МУ-ын 5 жилийн Үндсэн чиглэлийн 9.5.4/ | Налайхын БМҮТП-ын захиргаа, Нийслэлийн ЗДТГ-тай хамтран ажиллаж, тус паркад байгуулах барилгын материалын үйлдвэрүүдэд мэргэжил, аргазүй, бодлогын зөвлөмж, дэмжлэг үзүүлнэ. | 1. Налайхын "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-д байгуулах үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийг Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах талаар Ерөнхий сайдын албан шуурхай даалгаврын төсөлд тусгуулж, ХББОССайдын Нийслэлийн Засаг даргатай хийх уулзалтын танилцуулгад оруулсан.<br>2. Налайхын "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ын хүсэлтийг судлан асуудал боловсруулж, 01/731 тоот албан бичгээр Эдийн засгийн хөгжлийн сайдад уламжилсан.<br>3. Налайхын "БМҮТП"-ын 1000 м3 цэвэрлэх байгууламжийг барих ажилд шаардагдах 5,325,917,742 төгрөгийг 2026 оны улсын төсвийн тухай хуульд тусгуулах саналыг Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.<br>4. Налайхын "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ын орчинд ажиллах үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийг ХББОСЯ-ны дэргэдэх "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах чиглэлийг Налайхын Үйлдвэрлэл технологийн парк" т 2025.06.02-ны өдрийн 03/2182 тоот албан бичгээр хүргүүлэв. Одоогоор Налайхын паркад орж ажиллах "Айвуун аргалант" ХХК-ын автоклавын хийт бетон эдлэлийн үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Мэргэжлийн зөвлөлийн 2025.05.12-ны өдрийн 2/2025 хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргасан. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5.2.6. | Эх үүсвэрээ бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй "Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны загвар төсөл"-ийг сумын засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. /Улсын хэмжээнд/" /ЗГҮАХХАХТ 1.1.3.7.48, 2.4.1.6.473/ | "Сумдад мэргэжлээрээ ажиллаж буй төрийн албан хаагчдад зориулсан 8 айлын орон сууцны барилга барих, ашиглах" үйл ажиллагааг цогцоор нь сумдын Засаг дарга нар болон ТОСК-тай хамтран зураг төслийг батлуулан, барилга угсралтын ажлыг 70 хувьд хүргэх ажлыг зохион байгуулна. | - "Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны загвар төсөл"-ийг 12 аймгийн 12 сумдад хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажлыг эхүүлээд байна. Тус төсөл арга хэмжээг 2024-2025 онд эхлүүлсэн эхний 12 аймгийн 12 сумын байршилд 8 айлын нийт 96 айлын төрийн албан хаагчийн орон сууцыг ашиглалтад оруулахаар захиалагчийн хяналтыг ТОСК гүйцэтгэн, сумын Засаг даргатай хамтран хэрэгжүүлж байна. Төслийн нийт гүйцэтгэл 80 хувтай хэрэгжиж байна. Үүнээс:<br>- Үүнээс 10 сумын зураг төслийг боловсруулж дууссан, магадлалаар баталгаажсан байна. 2 сумын зураг төсөл нь магадлалаар хянагдаж байна.<br>- 6 сумын барилга угсралтын ажил 50-80 хувь, 6 сумын төсөл бүрэн дуусч 100 хувьд хүрсэнээс 3 сумын төсөл дээр барилга байгууламжийг ашглалтад авах комисс ажиллаж, ашиглалтад хүлээн аваад байна. | 100% |
| 5.2.7. | "Гамшигт тэсвэртэй, эрчим хүчний алдагдал багатай, дэвшилтэт технологи бүхий "Амины орон сууц"-ны загвар төсөл хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ. | - "Амины орон сууц"-ны загвар төсөл хэрэгжүүлэх гүйцэтгэгчтэй гэрээг байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангана.<br>- Батлагдсан 60м2 бүхий амины орон сууцны холболтын зураг төслийг боловсруулж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулна. | - "Амины орон сууцны загвар төсөл"-ийг Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэгт хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, "Монголын ногоон барилгын хүрээлэн" НҮТББ гүйцэтгэгчээр шалгарч, гэрээг байгуулан ажлыг эхлүүлээд байна. Тус төслийн хүрээнд батлагдсан "Амины орон сууцны /60 м2/ нэг маягийн зураг төсөл"-ийг холбож, холболтын зураг төслийг боловсруулж дууссан.Төслийн талбайг бэлтгэж барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл хангасан.<br>- Гэвч газрын зориулалт таарахгүй байгаа болон зориулалтыг өөрчлөх асуудал нь удаашралтай байгаа тул захиалагчийн хүсэлтээр төслийг зогсоогоод байна. | 80% |
| 5.2.8. | "Амины орон сууцны мэдээллийн төв"-ийг ЧД, СБД, БГД-т байгуулна. /ЗГҮАХХ АХТ-ний 2.4.1.6.474/ | "Амины орон сууцны мэдээлийн төв /ЧД, СБД, БГД/"-ийг байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | - "Амины орон сууцны мэдээлийн төв /ЧД, СБД, БЗД/"-ийг байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, "Монголын амины орон сууцны инноваци хөгжлийн төв" НҮТББ -тай гэрээ байгуулж, тус тусын үйл ажиллагааг жигдрүүлсэн.<br>- Чингэлтэй, Сүхбаатар дүүргийг байршил болон мэдээллийн төвийг ажиллуулах байрны боломжоос хамаарч хамтад нь Чингэлтэй дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийн газраас суллаж өгсөн 2 хурлын заалыг тохижуулан "Амины орон сууцны мэдээлийн төв"-ийг нээж үйл ажиллагааг явуулж байна.<br>- Баянзүрх дүүргийн хувьд түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байна.<br>- Мөн яамны<br>- Дээрх амины орон сууцны мэдээллийн төвөөр нийт 5-н аж ахуй нэгж, 30,000 иргэн үйлчлүүлж, мэдээлэл, үйлчилгээ авсан байна. Үүнээс нийт 5 удаагийн сургалтаар өөрийн гэр болон байшингаа дулаалах болон шинээр амины орон сууц барихад чиглэсэн зөвлөгөө мэдээллийн сургалтад 2,500 иргэн хамрагдсан байна.<br>- Засгийн Газрын 2025 оны 133 дугаар "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | БОУАӨЯ, НЗДТГ-тай хамтран Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн оршин суугч, айл өрхүүдэд эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны пассив стандарт, хийн түлшний болон цахилгаан халаагуур, бусад дэвшилтэт технологийн шийдлийг хэрэглэх талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлан таниулах зорилгоор “Дулаан байшин” өдөрлөгийг 2025.05.04-07-ны өдрүүдэд Нийслэлийн төв талбайд зохион байгуулж, салбарын төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбарын нийт 91 байгууллагын төлөөлөл оролцож нийт 10,000 орчим, давхардсан тоогоор 29,562 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. | |
| 5.2.9. | “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журам”-ыг салбарын инженер техникийн ажилчидад сургалт зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1083, 1084, 1085/ | Салбарын ИТА-ын мэргэжлийн зэрэг горилох, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журам”-ын талаар сургалтын багц цаг орохоор тусган зохион байгуулсан байна. | “Монголын барилгын инженерүүдийн холбооны түншлэл”-ээс 2025 онд зохион байгуулах барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох, сунгах сургалтын нэгдсэн төлөвлөгөөний 1.7, 1.8, 1.9, 1.10, 1.11, 1.22, 2.1, 3.1 дэх сургалтын кодуудтай сургалтын багц цагуудад барилгын чиглэл тус бүрээр ногоон барилга (Bestger)-ын шаардлагыг төлөвлөлт, угсралтад хангуулах агуулгаар тусгасан. Мөн Ногоон барилгын аудиторын сургалтын хөтөлбөрт тусгасан.<br>“Ногоон барилгын аудитор, сургагч багш бэлтгэх журам”-ыг 2025.05.16-ны өдрийн 114 дүгээр тушаалаар баталсан.<br>Ногоон барилгын аудитор бэлтгэх анхны сургалтыг 2025.05.19-27-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 53 ИТА хамрагдаж, шалгалтад тэнцсэн, 17 аудиторт гэрчилгээ олгосон. Хоёр дахь сургалтыг 2025 оны 10 дугаар сард зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 11 аудиторт тус яамны ТНбД-ын А/158 дугаар тушаалаар гэрчилгээ олгосон. | 100% |
| 5.2.10. | “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журам”-ыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1083, 1084, 1085/ | Салбарын ИТА-дад “Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журам”-ыг сурталчлан таниулах, контент хийх ажлыг зохион байгуулна. | ХБХОС-ын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 74 дүгээр тушаалаар “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал, “Ногоон барилгын (Bestger) гэрчилгээ олгох журам”-ийг сурталчлан таниулах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс хэвлэл мэдээлэл, олон нийтийн ТВ-ийн хэлэлцүүлэг хийх ажлыг зохион байгуулсан.<br>- ЖДҮ, барилгын бригадуудад зориулан 2025.03.20, 21, 22-ны өдөр зохион байгуулсан “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны чадавхижуулах сургалт”-д ногоон барилгын үнэлгээ, гэрчилгээ олгох, аудитор бэлтгэх дүрэм, журам, ногоон барилгын материал, үйлдвэрлэл, бүтээгдэхүүний талаар мэдээлэл хийсэн;<br>- Дархан, Эрдэнэт, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймгийн ГХБХБГ-ын инженер, техникийн ажилчид болон ААНБ-дад “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BESTGER) гэрчилгээ олгох журам”-ийн талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан;<br>Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг сурталчлан танилцуулах, оролцогч байгууллагуудад мэдээлэл өгөх, мэргэжилтнүүдийг байнгын мэдээллээр хангах зорилгоор контент, рийл хийж олон нийтийн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | сүлжээнд болон яамны сайт, “Ногоон барилгын хүрээлэн” ТББ-ийн цахим хуудсанд байршуулсан.<br>“Дулаан байшин” Амины орон сууцны өдөрлөгийг БОУАӨЯ, ЭХЯ, НЗДТГ-тай хамтран Сүхбаатарын талбайд 2025.05.05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгт эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг танилцуулж, цахимаар загвар ногоон сууцнуудад 3D технологийг ашиглан дотор нь байгаа мэтээр үзэх, танилцах боломжтой кентент хийж танилцуулсан. Яамны цахим хуудсанд байршуулсан.<br>-Үндэсний Итгэмжлэлийн Төвтэй хамтран “Ногоон барилга-Ногоон санхүүжилт-Баталгаажуулалт” сэдэвт хэлэлцүүлгийг 2025.12.03-ны өдөр хамтран зохион байгуулж, ногоон барилгын үнэлгээний систем, Ногоон барилгын үнэлгээ (BESTGER)-ний аргачлал, гэрчилгээ олгох аудитор, сургагч багш талаар танилцуулга хийж, хамтын ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлох, баталгаажуулалтын хүрээг нэмэгдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтыг бий болгох чиглэлээр хэлэлцүүлсэн. | |
| 5.2.11. | УИХ-ын 2024 оны 52 дугаар тогтоолын 1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, үйл ажиллагааны тайланг холбогдох газарт хүргүүлнэ. | УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангуулан холбогдох арга хэмжээг авч, Сангийн яаманд магадлал хийсэн ажлын тайлан, мэдээллийг хүргүүлнэ. | Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолын 1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 95 дугаар тушаалын 3 дахь заалтыг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн төсөвт өртгийн цалингийн зардалд тарифт цалингийн жишгийг шинэчлэн тооцож, магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан төсөл, арга хэмжээний ТЕЗ-аас ирүүлсэн 69 төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт магадлал хийсэн үйл ажиллагааны тайланг Сангийн сайдад 2025.02.10-ны өдрийн 01/466, 2025.05.02-ны өдрийн 01/1570 дугаартай тус тус албан бичгээр хүргүүлсэн. Харин Сангийн сайдаас 2025 оны 01/6770 дугаартай албан бичгээр хөндлөнгийн аудит, шинжээчийн дүгнэлт гаргуулан ирүүлэх чиглэлийн дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/152 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.<br>“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т 2024 онд тарифт цалингийн жишгийг шинэчлэн тооцож, магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан 69 төсөл, арга хэмжээний 49.2 тэрбум төгрөг, 2025 онд 62 төлөл, арга хэмжээний 55.1 тэрбум төгрөг зөрүү үүссэн байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй нийт 100 төсөл, арга хэмжээний 66.4 тэрбум төгрөгийн зөрүү санхүүжилт шаардлагатай гэсэн тооцоолол гарсан байна. Мөн Ажлын хэсгээс гарсан шийдвэрийн дагуу Төсвийн байнгын хороонд 2025.11.03-ны өдрийн 01/4067 дугаартай албан бичгээр Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн 4.3.1-т тусгагдсан 35.3 тэрбум төгрөгийн саналыг хэвээр үлдээх тухай дурдан хүргүүлсэн. | 100% |
| 5.2.12. | Барилга байгууламжийн зураг төсөлд | Барилга байгууламжийн зураг төсөлд | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд хэрэгжих барилга байгууламжийн зураг төсөлд хийсэн захиалагчийн техник хяналт | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайланг тухай бүр авч ажилласан байна. /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоол/ | захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг нэгтгэнэ. | хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайланг 2025.12.03-ны өдрийн байдлаар хүлээн авч, хянаад байна.<br>- Энэ хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд хэрэгжих нийт 65 барилга байгууламжийн зураг төслийн боловсруулалтын явцад гэрээний үндсэн дээр захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсэн байна. Нийт барилга байгууламжийн зураг төслийн боловсруулалтын явц 90 хувь. Үүнээс:<br>- Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны нийт 16 барилга байгууламжийн зураг төсөл, боловсруулалтын явц 100 хувь;<br>- Эдийн засаг хөгжлийн яамны нийт 38 барилга байгууламжийн зураг төсөл, боловсруулалтын явц 85 хувь;<br>- Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн 11 барилга байгууламжийн зураг төсөл, боловсруулалтын явц 85 хувь. | |
| 5.2.13. | Орон сууц, олон нийтийн барилга, байгууламжийн зураг төсөл төлөвлөлтийн норм, нормативын шаардлагыг хангуулж барилга байгууламжийн гадна, дотор хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.1.1.24.218/ | -Орон сууц, олон нийтийн барилга, байгууламжийн зураг төсөл төлөвлөлтийн норм, нормативын шаардлагын дагуу барилга байгууламжийн гадна, дотор орчны хүртээмжтэй байдлыг хангуулан зураг төслийг боловсруулах, хянах, магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр баталгаажуулах ажлыг зохион байгуулна.<br>-Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааны тайланг хүлээн авч, хянасан байна | - Улсын төсөв болон хувийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд хэрэгжих барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааны тайланг 2025.12.01-ний өдрийн байдлаар хүлээн авч, хянаад байна.<br>- Нийт 2,473 ажлын гэрээ байгуулан барилга байгууламжийн ажлын зураг төсөл, төсөвт магадлал хийх ажлыг зохион байгуулж,"Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНбД 35-01-22/ барилгын норм дүрэм болон холбогдох төлөвлөлтийн норм, нормативын шаардлагын дагуу барилга байгууламжийн гадна, дотор орчны хүртээмжтэй байдлыг хангасан 2,252 зураг төслийг магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр баталгаажуулсан байна. Үүнээс:<br>- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,563, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 910 төсөл арга хэмжээний ажлын зураг төсөл, төсвийг баталгаажуулсан байна. | 100% |
| 5.2.14. | Үндэсний ногоон барилгын үнэлгээний системийг нэвтрүүлж, хөгжүүлэх /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1011 | Ажлын даалгавар боловсруулж батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна. | “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”-д үндэслэн үндсэн өгөгдлүүдийг оруулж, эрх бүхий Ногоон барилгын аудиторуудын үнэлгээний дүгнэлт бүртгэгдсэнээр Гэрчилгээг цахимаар олгох үйл ажиллагааны цар хүрээг тогтоож, “Ногоон барилгын үнэлгээний систем”-ийг бий болгохоор техникийн даалгаврын төслийг боловсруулсан, батлагдах шатанд байна. ББННС-ын 2026 оны үйл ажилллагааны төлөвлөгөөнд тусгуулахаар ажиллаж байна. Мөн Үндэсний Итгэмжлэлийн Төвтэй хамтран баталгаажуулалтын хүрээг нэмэгдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтыг бий болгох чиглэлээр “Ногоон барилга-Ногоон санхүүжилт-Баталгаажуулалт” сэдэвт хэлэлцүүлгийг 2025.12.03-ны өдөр хамтран зохион | 60% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | байгуулж, ногоон барилгын үнэлгээний системийн талаар илтгэл тавьж, танилцуулга хийсэн. Цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг нарийвчлан тодорхойлох талаар хэлэлцүүлсэн. | |
| 5.3. Барилгын салбарт мэдээлэлтэй загварчлал /BIM/ нэвтрүүлэх ажлын хүрээнд: | | | | 95 |
| 5.3.1. | Барилгын төслийн удирдлага, мэдээллийн нэгдсэн систем /BIM/-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах. | - Монгол Улсын хэмжээнд Барилгын төслийн удирдлага, мэдээллийн нэгдсэн систем /BIM/-ийг нэвтрүүлэх богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө батлуулна.<br>- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын "Барилгын салбарт мэдээлэлтэй загварчлал /BIM/ нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх" ажлын хэсгийн тушаал батлуулна. | "Барилгын мэдээлэлтэй загварчлал-BIM"-ийг нэвтрүүлэх 2025.06.04 өдрийн А/102 дугаартай Ажлийн хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн хавсралтад хийх ажлын төлөвлөгөө гарсан. Мөн 2025.11.24-ний өдөр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын элчин сайдын яамны төлөөлөл, стандартын газар, хувийн хэвшлийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж, 2025.11.27-ны өдөр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс–Монголын Дэд бүтцийн форум: Дижитал бүтээн байгуулалт арга хэмжээг зохион байгуулсан. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний төсөвт өртөг Үндэсний аудитын газар 2025 онд гүйцэтгэсэн Нийцлэлийн аудитын зөвлөмжид энэхүү арга хэмжээг эрчимжүүлэхээр зөвлөмжийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулсан. | 90% |
| 5.3.2. | Шаардлагатай Стандартыг боловсруулах ажлыг зохион байгуулна. | Барилгын мэдээлэлтэй загварчлалыг хэрэгжүүлэхэд шаардлагай стандартын төсөл боловсруулах ажлыг ББННС-ын үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгуулж, зөвлөхтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан байна. | 2025.11.18-ний өдрийн 2025/22 дугаараар "BIM гарын авлага: эзэмшигч, дизайнер, инженер, гүйцэтгэгч, байгууламжийн менежерүүдэд зориулсан барилгын мэдээллийн загварчлалын гарын авлага"-ыг орчуулах, оюуны өмчийн эрхийг худалдан авах, хэвлэх ажлын техникийн даалгавар, 2025.11.18-ны өдрийн 2025/21 дугаар, "Барилга, барилгын ажлын талаарх мэдээллийг зохион байгуулах, дижитал болгох, үүнд барилгын мэдээллийн загварчлал (BIM)-ын загварчлалыг ашиглан мэдээллийн менежмент" ISO 19650 стандартчлах техникийн даалгавар, 2025.11.23-ны өдрийн 2025/24 дугаар "Барилга, байгууламжийн менежментийн салбарт мэдээлэл солилцоход зориулагдсан аж үйлдвэрийн суурь анги" ISO 16739 стандартын техникийн даалгавар тус тус батлуулж "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-т 2025.11.28-ны өдрийн 02/4390 дугаар албан бичгээр хүргүүлсэн. "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ-аас гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийн зарыг цахимд байршуулсан. | 100% |
| 5.4. Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих зорилтын хүрээнд: | | | | 88.33 |
| 5.4.1. | Барилга байгууламжийн норм, нормативын санг бүрдүүлэх, зарцуулах болон сангийн үйл ажиллагааг бодлогын удирдамж, чиглэлээр хангаж, сангийн удирдах зөвлөлийн хуралдааныг тухай бүр зохион | Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 80,0 хувьд хүргэсэн байна. | Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, 2025.03.14,19-ний өдрүүдэд тус сангийн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан 25 ажлын техникийн даалгаврыг шинээр боловсруулж, ХББОСЯ-ны ТНБД-аар батлуулсан. Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үргэлжлүүлэн шинэчлэх /68/ болон шинээр боловсруулах /49/ нийт 117 ажил төлөвлөгөөнд тусгаснаас жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 77.21 хувьтай байна. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгуулж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллана. /Барилгын тухай хуулийн 5.1, 33.1.2 дахь заалт/ | | | |
| 5.4.2. | Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт үзлэг хийх ажлыг зохион байгуулна. /Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоол/ | Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулсан байна. Ажлын даалгаврыг батлуулан салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичигт техникийн үзлэг хийх ажлыг эхлүүлсэн байна. | Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт үзлэг хийх ажилд шаардагдах санхүүжилтийг барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулсан.<br>Тус ажлын техникийн даалгаврыг боловсруулж, 2025.06.24-ний өдөр ТНБД-аар батлуулсан бөгөөд гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аас 2 удаа зарласан боловч тендерүүд амжилтгүй болсон.<br>Тус ажлыг зохион байгуулах, зохицуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг ТНБД-ын 2025 оны А/111 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгийн 2025.11.18-ны өдрийн хурлаар дараах шийдвэрийг гаргасан. Үүнд:<br>1. Ажлын нийт төсөвт өртгийг шинэчлэн тооцож, Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөөнд тусган батлуулах;<br>2. Техникийн даалгаврыг шинэчлэн боловсруулж, холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах.<br>Тус ажлын хэсгээс хот байгуулалт, барилгын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 83 цогцолборын 409 барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг батлагдсан оноор нь ангилан дүн шинжилгээ хийж, үзлэгийн ажлыг эхлүүлсэн. Үзлэгийн үр дүнд 2000 оноос өмнө батлагдсан 26 норм, нормативын баримт бичгийн жагсаалтыг гарган холбогдох яамдын чиг үүрэгт хамаарах болон салбар хоорондын асуудлыг зохицуулсан норм, нормативын баримт бичгийг шинэчлэн боловсруулах, хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар санал авахаар 5 яаманд албан бичиг хүргүүлээд байна. | 100% |
| 5.4.3. | Салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулна. /Шинжлэх ухаан, техник, технологийн тухай хуулийн 5.2, 9.1, 9.2, Барилгын тухай хуулийн 33.1.8, Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоол/ | Салбарын Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудлуудыг хянан үзэж, шаардлага хангасан асуудлуудыг тухай бүр хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулан хурлын тэмдэглэлийг албажуулсан байна. | Салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хуралдааныг 2025 онд нийт 8 удаа зохион байгуулж, шаардлага хангасан 26 асуудлыг хэлэлцүүлж, 18 асуудал нь дэмжигдэж, 8 асуудлыг дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Тухай бүр хуралдааны шийдвэр, хурлын тэмдэглэлийг албажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | 100% |
| 5.4.4. | Барилгын ажлын төсөв, үнэ бүрдлийн норматив баримт бичгийг | Барилгын ажлын төсвийн суурь нормуудыг шинэчлэн | Барилгын ажлын төсвийн суурь нормуудын 87 эмхэтгэлийг шинэчлэн боловсруулах ажлыг эрчимжүүлэх талаар 2025.04.02-ны өдөр Барилгын хөгжлийн төвийн Норм нормативын | 85% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төсвийн томсгосон норм, жишиг үнэлгээнд шилжүүлэх ажлын хүрээнд төсвийн суурь нормыг батлуулах ажлыг зохион байгуулна. /Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого 1.3.6/ | боловсруулах ажлыг зохион байгуулж, томсгосон үнэлгээнд шилжих нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | хэлтсийн дарга, мэргэжилтэн болон уг төслийн гүйцэтгэгч болох Барилгын төсөвчдийн холбоотой хамтарсан уулзалтыг зохион байгуулж, 2025.05.15-ны өдөр төслийг эцсийн байдлаар хүлээлгэн өгөхөөр болсон. Мөн тус яаманд 2025.06.03-ны өдөр нормын гүйцэтгэгч болон БХТ-ийн нормын хэлтсийн мэргэжилтнүүдтэй төсвийн суурь нормын боловсруулалтын талаар санал солилцсон. Нормын боловсруулалт болон шүүмж хийгдсэн, редакцын ажил дууссан, Мэдээллийн санд оруулах ажлыг яаралтай дуусган, МЗХ-аар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. “Эдийн засаг, төсөв үнэ бүрдлийн мэргэжлийн зөвлөл”-ийн 2025.08.29-ний өдрийн ээлжит хурлаар “Барилга, сантехник, цахилгаан, холбоо дохиолол, засварын ажлын төсвийн суурь норм”-ын 81 эмхэтгэлүүдийг шинэчлэн болон шинээр боловсруулсан ажлыг хэлэлцүүлэн дэмжигдсэн. Яамны дэргэдэх ШУТТЗ-ын хурлаар хэлэлцүүлэхээр мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн саналыг тусган ажиллаж байна. | |
| 5.4.5. | “Барилга байгууламжийн 2023, 2024 оны үнийн индекс”-ийг батлуулна. /БТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1.10 дахь заалт/ | Зураг төслийн өмнөх шатанд барилга байгууламжийн өртгийг урьдчилан тодорхойлох нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Барилга байгууламжийн 2023, 2024, 2025 оны үнийн индекс”-ийг боловсруулж, батлуулахаар санал хүргүүлэн, төлөвлөгөөний 13-т тусгагдан батлагдсан. Барилгын хөгжлийн төвөөс 2025.05.15-ны өдрийн 02/1097 дугаартай албан бичгээр техникийн даалгаврыг боловсруулан ирүүлсэн. ТНБД 2025.06.09-ний өдрийн 06/2025 дугаартай батлагдсаныг 2025.06.10-ны өдрийн 07/2301 дугаартай албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2025.09.16-ны өдөр гэрээ байгуулан ажлыг эхүүлсэн бөгөөд эхний тайланг хүлээн авсан. | 70% |
| 5.4.6. | "Барилгын машин ашиглалтын нэгж машин цагийн жишиг үнэ"-ийг батлуулна. | Барилгын төсөв зохиоход хэрэглэгдэх машин, механизмын тариф шинэчлэгдэнэ. | Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийхэд хэрэглэгдэх “Барилгын машин ашиглалтын нэг машин цагийн үнэ тодорхойлох аргачлал” /БД 81-111-25/, “Барилгын машин ашиглалтын нэг машин цагийн үнэ” /БД 81-112-25/ барилгын дүрмийг Барилгын хөгжлийн төвөөс 2025.05.08-ны өдрийн 02/1051 дугаартай албан бичгээр батлуулахаар ирүүлснийг хянаж, ХББОССайдын 2025.06.06-ны өдрийн 138 дугаартай тушаалаар баталсан. Тушаалын хэрэгжилтийг хангуулахаар 2025.06.10-ны өдрийн 07/2302 дугаартай албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. | 100% |
| 5.4.7. | Барилга угсралтын ажлын тэмдэглэл /улаан журнал/-ыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, батлуулна. | Холбогдох байгууллагуудаас санал авч, холбогдох мэргэжлийн зөвлөл, ШУТТЗ-ын хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, батлуулна. | Барилгын угсралтын ажлын тэмдэглэл /улаан журнал/ дүрмийг шинэчлэн боловсруулах зөвлөх "Масс бетон барилгын чанарын холбоо" ТББ-тай 2023.05.16-ны өдөр 110/2023 дугаартай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Олон улсад хэрэглэж байгаа энэ төрлийн норматив баримт бичгийг судалж харьцуулалт хийсэн “Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл”-ийн жагсаалтыг гарган эхний тайланг хүлээн авсан. Мөн яаманд 2025.06.03-ны өдөр нормын гүйцэтгэгч болон БХТ-ийн нормын хэлтсийн мэргэжилтнүүдтэй төслийн явц болон боловсруулалттай холбоотой тулгамдаж байгаа асуудлаар санал солилцсон. Ажлын цар хүрээнээс хамаарч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацааг 2025.05.23-ны өдөр | 70% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | сунгасан байна. Боловсруулалтын ажил бүрэн дуусаж, редакц, шүүмж хийгдсэн төслийг эцэслэн Барилгын угсралтын ажлын тэмдэглэл /улаан журнал/ ажлыг 2025.10.31-ний өдөр Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт, тоног төхөөрөмжийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар оруулж гишүүдийн санал зөвлөмжийг тусган дахин хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. | |
| 5.4.8. | Барилгын ажлын ил далд ажлын акт /Шалгах хуудас/-ыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, батлуулна. | Холбогдох байгууллагуудаас санал авч, холбогдох мэргэжлийн зөвлөл, ШУТТЗ-ын хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж, батлуулна. | Ил далд ажлын акт шинэчлэх Техникийн даалгавар БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар 2023.03.17-ны өдрийн 07/2023 дугаартай батлуулсан. Ил далд ажлын акт шинэчлэн боловсруулах ажилд зөвлөх "Масс бетон барилгын чанарын холбоо" ТББ-тай 2023.09.27-ны өдөр 2023/192 дугаартай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Эхний төсөлд боловсруулалт хийгдэж байгаа бөгөөд Олон Улсын Техникийн Шаардлагын Институтийн техникийн шаардлагын баазын хүрээнд нийт 691 ш шалгах хуудас боловсруулж байгаа ба ойролцоогоор 5000 орчим хуудас загвар баримт бичиг байна. Ил далд ажлын акт 2024.11.22-ны өдөр Барилгын үйлдвэрлэл, зохион байгуулалт, технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Ажлын цар хүрээнээс хамаарч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацааг 2025.05.23-ны өдөр сунгасан байна. Мөн яаманд 2025.06.03-ны өдөр нормын гүйцэтгэгч болон Барилгын хөгжлийн төвийн нормын хэлтсийн мэргэжилтнүүдтэй төслийн явц болон боловсруулалттай холбоотой тулгамдаж байгаа асуудлаар санал солилцсон. Боловсруулалтын ажлыг эхний ээлжид шаардлагатай 250 гаруй актыг бүрэн дуусгаж, редакц, шүүмж хийлгэж, батлуулах чиглэлийг өгсөн. | 70% |
| 5.4.9. | "Пассив барилгын стандартын шаардлага"-ийг боловсруулах ажлын даалгаварыг боловсруулах, батлуулах /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.7/ | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, норм дүрмийг Олон улсын мөрдөж буй пассив барилгын стандартад нийцүүлэх шаардлагыг боловсруулах Ажлын даалгаврыг боловсруулах ажлыг зохион байгуулна. | Пассив барилгын барилгын стандартын шаардлага боловсруулах ажлын техникийн даалгаврын төслийг боловсруулж, санал авахаар viber системээр "Пассив барилгын хүрээлэн" ТББ-д хүргүүлсэн. Техникийн даалгавар батлуулснаар ажлын тоо хэмжээ тодорхой болж төсөв гарна. Барилга, хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан 2021.12.02-ны өдрийн А/257, А/252 дугаартай тушаалаар батлагдсан "Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам"-ын дагуу 319 барилгын зураг төсөлд 2025 оны эхний хагас жилийн байдлаар орон тооны бус экспертүүдээр хянагдаж, эрчим хүчний гэрчилгээ олгогдсон. | 100% |
| 5.5. Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, газар хөдлөлтийн чиглэлээр норм, дүрэм, журмыг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд: | | | | 90.71 |
| 5.5.1. | Өмнөговь, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалыг олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | Өмнөговь, Хөвсгөл аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал тайлан хянаж, олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. | Олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлж геопорталд байршуулахын тулд дараах ажлуудыг зохион байгууллаа. Өмнөговь аймгийн Даланзадгад, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвийн газар хөдлөлийн аюулын үнэлгээ ба бичил мужлалын судалгаа, зураглалыг “Инженер геологи, геотехник, барилга бүтээц, газар хөдлөлтийн арга хэмжээний орон тооны бус мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэхээр Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2025.11.12-ны өдрийн 07/4197 | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэх төлөвлөгөөнд тусгуулсан.<br>Мөн Шинжлэх ухааны академийн физик, математик, информатикийн салбарын бага чуулганы 2025.12.03-ны өдрийн хурлаар дээрх аймгуудын судалгааны тайланг хэлэлцэж, зорилтоо биелүүлсэн гэсэн шийдвэр гарсан байна. 2026 оны 02 дугаарын сарын ХББОСЯ-ны дэргэдэх ШУТТЗХ-р хэлэлцүүлж, хэрэглээнд 1 дүгээр улиралд багтаан нэвтрүүлэхээр ажиллаж байна. | |
| 5.5.2. | Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын төсвийг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлсэн байна. | Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалын төсвийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна. | Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2025 оны төлөвлөгөөний 53 дугаарт Увс, Ховд аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх ажлыг тусгуулж, батлуулсан. Гэрээг сунгахтай холбогдуулан Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирал, төслийн удирдагч Ч.Одонбаатар, тус хүрээлэнгийн Газар хөдлөлтийн аюулын үнэлгээний лабораторийн эрхлэгч М.Дэмбэрэлдулам, яамны санхүү Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Ж.Орхонбаяр, Барилгын чанар, аюулгүй байдлын бодлого, зохицуулалт харицсан ахлах шинжээч Б.Баярдулам нарыг оролцуулан 2025.10.22-ны өдөр хуралдсан. Хурлаас Өмнөговь, Хөвсгөл аймгуудын газар хөдлөлийн бичил мужлалын зураглалын ажлын тайланг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах, шинээр хийх 2 аймгийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэр гарсан. Нэмэлт гэрээний төсөл, хурлын тэмдэглэл боловсруулан бусад материалыг бүрдүүлэн ТЗУГ-ийн Хуулийн хэлтсээр хянуулахад сунгах боломжтой дүгнэлт гаргасан. 2025 оны 12 дугаар сарын 04-ны өдөр ТНбД хянан үзэж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахгүй, шинээр худалдан авах ажиллагааг зарлах чиглэл өгсөн. Үүний дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. | 100% |
| 5.5.3. | Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг улсын хэмжээнд эрчимжүүлэх талаарх саналыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.4.44/ | Тулгамдаж буй асуудлаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах ажлыг зохион байгуулна. | Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх “Барилгын хүчитгэлийн үйл ажиллагааны урт хугацааны төлөвлөгөө (2025-2034)”-ний төсөлд холбогдох саналыг тусгуулахаар 2025.12.16-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газарт албан бичгээр хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд Японы улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төслийн багтай хамтран 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 12-ны хооронд 3 удаа уулзалт зохион байгуулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах төсөл дээр хамтран ажилласан болно. | 90% |
| 5.5.4. | Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт барилга байгууламжийн паспортжуулах ажлын төсвийг тусгуулах, холбогдох | Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт барилга байгууламжийн паспортжуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн | Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ, барилгын хүчитгэлийн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах болон сургууль, цэцэрлэгийн барилгуудыг газар хөдлөлтийн гамшгийн үед хоргодох байраар ашиглахад арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр чадавхижуулах цахим сургалтыг 2025.12.03-ны өдөр зохион байгуулсан. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | сургалтыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 1.1.3.4.44/ | төсвийг тусгуулж, сургалт зохион байгуулна. | Сургалтад 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын болон хяналтын хэлтсийн 45 гаруй албан хаагчид хамрагдлаа. Сургалтын явцад аймгийн хэмжээнд одоо ашиглагдаж буй барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтийг тэсвэрлэх байдлыг шалгах багаж, тоног төхөөрөмжийн судалгааг гаргасан.<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тухайн жилийнхээ төсвийн 1-ээс дээш хувийг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэр дундаа барилга байгууламжийг паспортжуулах ажилд тусган хамтран ажиллах тухай 2025.11.27-ны өдрийн 01/4357 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. | |
| 5.5.5. | Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан "Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл"-ийн биелэлтийг хангуулна. | Биелэлтийг хангаж ажилласанаар газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий "Байнгын ажиллагаатай дэд зөвлөл"-ийн 2025 оны ээлжит хуралдаан 2025.10.10-ны өдөр зохион байгуулагдаж, оролцсон.<br>"Байнгын ажиллагаатай дэд зөвлөл"-ийн 2025 оны үйл ажиллаганы төлөвлөгөөний биелэлт, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг 2025.11.10-ны өдрийн 02/4144 дугаар албан бичгээр Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.<br>"Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн III үе шатны (2026-3030) арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгээс боловсруулсан төлөвлөгөөний төсөлд газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах талаар саналыг 2025.12.04-ний өдөр цахимаар хүргүүлсэн. | 100% |
| 5.5.6. | Газар хөдлөлтийн албан даалгаварын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна. | Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана. | Барилга, хот байгуулалтын сайдын хуучнаар/ "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2023/01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн тайланг ирүүлэх тухай 2025.09.16-ны өдрийн 07/3445 дугаартай албан бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-т хүргүүлсэн. Барилгын 2025.11.07-ны өдрийн 01/3120 дугаартай бичгээр Архангай, Увс, Баянхонгор, Дундговь, Баян-Өлгий аймгийн хэмжээнд ашиглаж байгаа барилга байгууламжийн газар хөдлөлтийн судалгааг ирүүлсэн. Уг судалгааны нэгтгэлээр паспортжуулах шаардлагатай болон буулгаж шинээр барих шаардлагатай барилга байгууламжийн нэгдсэн тоо гарсан.<br>21 аймгийн Засаг дарга нарт барилга байгууламжийн паспортжуулалтын ажилд 2026 онд авах арга хэмжээний санал ирүүлэх, хамтран ажиллах тухай 2025.11.27-ны өдрийн 01/4357 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.<br>Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд шинээр 2, шинэчилсэн 3 буюу нийт 5 барилгын дүрмийг боловсруулж, батлуулан ажиллалаа. | 100% |
| 5.5.7. | Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, | Барилгын салбарт ХАБЭА-г хангуулах төлөвлөгөөг гаргаж, | Барилгын салбарын ХАБЭА-н салбар хороог Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын | 80% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | эрүүл ахуйн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна. | хэрэгжилтийг зохион байгуулна. | 2025.02.26-ны өдрийн 49 дүгээр тушаалаар байгуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар тогтоолоор Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсантай холбогдуулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.09.17-ны өдрийн 217 дугаар тушаалаар шинэчлэн зохион байгуулсан.<br>БХТ ТӨААТҮГ, МБҮА ТББ-тай хамтран 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр "Барилгын салбарын удирдах ажилтны ХАБЭА" сэдэвт сургалтыг зохион байгуулж 87 удирдах ажилтан хамрагдсан.<br>Барилгын салбарт ХАБЭА-г хангуулах төлөвлөгөөний хэрэгжилт 83%-тай байна. | |
| 5.5.8. | "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" аяныг зохион байгуулж, эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулна. | Барилгын салбарын үйлдвэрлэлийн ослын тоог бууруулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.02.13-ны өдрийн 2025/01 дугаар "Барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай" албан даалгаврыг СХГ-аас боловсруулан баталсан тул дахин даалгавар боловсруулаагүй болно.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2025.04.04-ний өдрийн "Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны удирдамж батлуулан 21 аймаг, нийслэл, салбарын төрийн бус байгууллагуудад хүргүүлсэн. Удирдамжийн биелэлтийг Архангай аймаг, Булган аймаг, Говь-Алтай аймаг; Өмнөговь аймаг, Сэлэнгэ аймаг, Увс аймаг, Хөвсгөл аймаг, Хэнтий аймаг аймгаас ирүүлсэн.<br>Аяны хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад 286 иргэн, 64 аж ахуйн нэгж байгууллага дээр сургалт сурталчилгаа зохион байгуулж, 275 обьектод шалгалт зохион байгуулсан байна.<br>2024 онд үйлдвэрлэлийн осол барилгын салбарт 63 бүртгэгдсэн бол 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар барилгын салбарт 54 осол бүртгэгдсэн байна. https://inspection.hudulmur-halamj.gov.mn/ | 90% |
| 5.5.9. | Барилгын салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангуулах Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын албан даалгавар батлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна. | Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг нэгтгэнэ. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.02.13-ны өдрийн 2025/01 дугаар "Барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай" албан даалгаврыг СХГ-аас боловсруулан батлуулсан тул дахин даалгавар боловсруулах шаардлагагүй гэсэн чиглэлийг ТНбД-аас өгсөн. | 30% |
| 5.5.10. | Улсын хэмжээнд орон сууцны | Улсын хэмжээнд шинэчлэх | Монгол Улсын хэмжээнд 1982 оноос 2024 онд ашиглалтад орсон нийт 9549 цахилгаан шат | 90% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | барилгад ашиглаж байгаа цахилгаан шатны судалгааг нэгтгэж, ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан шатыг шинэчлэх тухай саналыг холбогдох Засаг дарга нарт хүргүүлнэ. | шаардлагатай цахилгаан шатны судалгааг гаргаж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна. | бүртгэлтэй байна. Үйлдвэрлэгч байгууллагаас тогтоосон ашиглалтын хугацаа дууссан 268 цахилгаан шат байна.<br>Монгол улс нь жилд 700 гаруй лифт, лифтний тоног төхөөрөмжийг БНХАУ, БНСУ, БНТУ, ОХУ - аас импортлон угсарч, ашиглаж байна. Нийт импортолсон лифтний 90%-ийг БНХАУ-ийн лифт тоног төхөөрөмж эзэлж байна. Үлдсэн хувийг бусад орнууд эзэлж байна.<br>2025 онд орон нутгийн өмчийн хөрөнгөөр Улаанбаатар хот 42, орон нутагт 8 нийт 50 лифтийг 6,2 тэрбум төгрөгөөр шинэчилсэн байна.<br>Лифтний бүртгэлийг СХШҮДАГ хөтлөн бүртгэдэг бөгөөд "Өргөх байгууламжийн бүртгэл, хяналтын мэдээллийн цахим системийн хөгжүүлэлтийг хийж, ашиглалтад оруулах" цахим бүртгэлд шилжүүлэхээр норм нормчлолын сангийн 2025 оны төлөвлөгөөнд 40,0 сая төгрөгийг тусгасан. | |
| 5.5.11. | "Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт" баримт бичгийг даган гарах 12 стандартыг боловсруулах ажлыг зохион байгуулна. | "Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалт" баримт бичгийг даган гарах 12 стандартыг Стандарт хэмжил зүйн газраар батлуулах ажлыг зохион байгуулна. | Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалтыг боловсруулж байгаа Зөвлөх багтай 2025.01.29-ний өдөр уулзалт зохион байгуулж, гүйцэтгэлийн явцтай танилцсан. Лифтний аюулгүй байдлын техникийн зохицуулалтын хамт дагаж мөрдөх 12 стандартын төслийг 2025.03.28-ны өдрийн "Барилгын механикжуулалт, машин механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн мэргэжлийн зөвлөл"-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. Стандарт хэмжил зүйн газрын даргын 2025.09.10-ны өдрийн С/32 дугаар тушаалаар 12 стандарт батлагдсан. | 100% |
| 5.5.12. | Барилгын материалын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм, дүрмийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулна. | Барилгын материалын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн норм дүрмийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулна. | "Барилгын материалын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм"-ийг "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар 2024.11.14-нд хэлэлцүүлсэн. Хурлаас гарсан санал, зөвлөмжийн дагуу тус дүрмийг хэрхэн сайжруулан боловсруулах талаар 2025.03.19-ний өдөр боловсруулагчтай зохион уулзалт байгуулсан. Өгөгдсөн санал зөвлөмжийг тусгасан, боловсруулсан төслийг гүйцэтгэгчээс 2025.09.20-ны хүлээн авсан. Дүрмийн боловсруулагч "Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөл"-ийн хурлаар дахин хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. | 90% |
| 5.5.13. | Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл 2 дугаар үе шатыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | Барилга байгууламжийн хүчитгэх норм, дүрэм, зургийг боловсруулах ажлыг зохион байгуулна. | "Гамшгийн үед түр байраар ашиглах сургууль, цэцэрлэгийн төлөвлөлтийн гарын авлага", "Газар хөдлөлт тэсвэрлэлтийг хангах барилгын хүчитгэлийн үйл ажиллагааг зохион байгуулах заавар"-ыг ХББОСС-ын 2025.10.28-ны өдрийн 238 дугаар тушаалаар батлуулсан.<br>Шинээр болон шинэчлэн боловсруулсан "Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал" /БД 22-105-25/, "Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал" /БД 22-106-25/, "Том хавтгаалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал" /БД 22-107-25/, "Ган бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх заавар" /БД 22-108-2025/ барилгын дүрмийн төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | техник технологийн зөвлөлийн 2025.9.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжсэн шийдвэр гарсан. Хуралдааны шийдвэрийн дагуу санал, зөвлөмжийг тусган Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.12.08-ны өдрийн 261, 262, 263, 264 дүгээр тушаалаар тус тус батлуулсан. | |
| 5.5.14. | Паспортжуулсан барилга байгууламжид нэгдсэн байдлаар ашиглалтын гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохион байгуулна. | Барилга байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулна. | Энэ ажлын хүрээнд 2025 онд дараах 4 барилгын паспортжуулалтын дүгнэлт гаргасан. Дурдвал: Төв аймгийн Баянцагаан сумын ерөнхий боловсролын сургууль, Засгийн газрын 12 дугаар байрны барилга /5 блок/, Барилгын хөгжлийн төвийн барилга, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨҮГ-ын төв байр болон соёлын төвийн барилга. Тагнуулын ерөнхий газрын Төв аймгийн Борнуур сумын нутагт байрлах "Ёл хад" нөхөн сэргээх төвийн барилгын паспортжуулатын дүгнэлтийн ажил хийгдэж байна.<br>Мөн Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар Улаанбаатар хотын хэмжээнд олон нийт, орон сууц, инженерийн дэд бүтцийн 23 барилга байгууламжийн паспортжуулалтын ажил хийгдэж байна.<br>Дорноговь болон Дундговь аймгуудад шинээр баригдсан 4 барилгад ногоон гэрчилгээ олгогдсон байна. | 100% |
| 5.6. Барилгын материалын үйлдвэрлэлийн хяналт, шинжилгээний лабораторийн нэгдсэн сүлжээг бий болгох, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд: | | | | 92 |
| 5.6.1. | Бүтээн байгуулалтын “мега” төслүүдэд шаардагдах барилгын материалын эрэлт нийлүүлэлтийн судалгаа хийнэ. | Бүтээн байгуулалтын “мега” төслүүдэд шаардагдах гол нэр төрлийн материалын судалгаа хийснээр дотоодын үйлдвэрлэл болон импортын хангамжийг төлөвлөх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | Нийслэлийн хэмжээнд хийгдэх томоохон төслүүдэд хэрэглэх гол нэр төрлийн материалын судалгааг дэлгэрэнгүй гаргасан. Барилгад хэрэглэх 12 гол нэр 79 нэр төрлийн /5400/ барилгын материалын үнийг гаргасан.<br>Мөн импортоор орж ирж буй гол нэр төрлийн барилгын материалын судалгааг Гаалийн ерөнхий газраас тогтмол авч, дэлгэрэнгүй анализ судалгааг хийж ажиллаж байна. | 100% |
| 5.6.2. | Замын-Үүд хилийн боомтын барилгын материалын сорил шинжилгээний түргэвчилсэн лабораторийг үйл ажиллагаанд оруулах тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.5.482/ | Барилгын материалын лабораторийг тоног төхөөрөмжөөр хангаж, хилээр нэвтрэх импортын барилгын материалын чанарт хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтод байрлалтай Барилгын материалын сорилт, шинжилгээний түргэвчилсэн лабораторийн 2025 оны эхний ээлжинд нийлүүлэгдэх /керамик эдлэхүүн, цемент, цонх, хаалга, хуванцар болон цхаилгаан утас/ лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмжийг хүлээн авхаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.12.11-ний өдрийн Б/98 дугаар тушаалаар ажлын хэсэг байгууллагдан 2025.06.05-07-ын өдрүүдэд ажиллаж, тоног төхөөрөмжийг хүлээн авсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2025.10.27-ны өдрийн А/148 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, үлдсэн тоног төхөөрөмжийг хүлээн авах, суурилуулах, хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Төслийн гүйцэтгэл 90%-тай явж байна. | 100% |
| 5.6.3. | Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод будаг, | Барилгын материалын лаборатори | Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод байрлалтай Хими, будгийн лабораторийн тоног төхөөрөмжийг 2024, 2025 онд хүлээн авах үүрэг | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | химийн лаборатори байгуулах ажлыг зохион байгуулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.5.483/ | байгуулж, хилээр нэвтрэх импортын барилгын материалын чанарт хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна. | бүхий ажлын хэсэг ТНБД-ын 2024.12.11-ний өдрийн Б/98 дугаар тушаалаар байгууллагдан Хими, Будгийн зарим нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан. Мөн 2025.10.27-ны өдрийн А/147 дугаар туушаалаар байгуулагдсан ажлын хэсэг үлдсэн тоног төхөөрөмжийг хүлээн авах, суурилуулах, хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг хангаж байна. Өнөөдрийн байдлаар төслийн явц 90%-тай явж байна | |
| 5.6.4. | Аймгуудын барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийг техник, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах ажлыг зохион байгуулна. | 3 аймаг холбогдох багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Жил бүрийн Монгол Улсын төсвийн тухай хуулийн жагсаалтад тусгуулах санал хүргүүлдэг боловч дэмжигдээгүй тул төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд байгуулсан гэрээнд тусгуулсан.<br>Улсын Хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Монгол Улсын 2026 оны төсвийн саналд Төв, зүүн, хойд бүсийн барилгын материалын сорилт шинжилгээ хийх нөхцөлийг хангуулахаар лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмжийн саналыг Эдийн засаг, хөгжлийн яамруу 2025.01.15-ны өдрийн 01/159 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Өвөрхангай аймагт Бетоны бат бэх тодорхойлогч хэт авианы багаж;<br>Сүхбаатар аймаг нь Бетоны үл эвдэх багажийг авсан.<br>Мөн 2024 оны улсын төсөвт Замын-Үүдийн лабораторийн тоног төхөөрөмжийн санхүүжилтэнд нийт 16,753.8 сая.төгрөг, Алтанбулаг хилийн боомтын лабораторийн тоног төхөөрөмжийн санхүүжилтэд нийт 6,470.0 сая төгрөг тус тугагдсан. Үүнийн дагуу 2025 онд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг хүлээн авхаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.10.27-ны өдрийн А/148 дугаар тушаалаар ажлын хэсэг байгууллагдан ажиллаж, өнөөдрийн байдлаар дээрх 2 төсөл 90%-тай явагдаж байна. Өнөөдрийн байдлаар Металл хийц эдлэхүүний, Цонх хаалганы, Цементийн, Керамик материал, Будгийн, Химийн, Хуванцар болон цахилгаан утасны иж бүрэн тоног төхөөрөмжийг хүлээн аваад байна. | 90% |
| 5.6.5. | Барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийн барилгын ажлыг үргэлжлүүлэх арга хэмжээг авна. | Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулна. | 2023 онд Барилгын физик, өргөх машин механиз-цахилгаан утасны лабораторийн зориултаар ашиглах боломжтой гэж үзэж Ажлын хэсэг нийт 4 удаа хуралдаж барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулахаар 2023 онд ЭЗХЯ-ны сайдын багцад тусаж "Говь-Трайвел" ХХК-тай гэрээ байгуулж 2024 оны 1 сард өөрчлөлтийн зураг төслийг дуусган хүлээлгэн өгсөн.<br>Мөн өөрчилөлтийн зураг төслийн дагуу 2025 барилгын ажлыг эхлүүлж 2025 онд Улсын төсөвт 1,261,3 сая төгрөг суугдсан. Энэ онд 24.0 x 29.0м хэмжээтэй В блокийн барилгын төмөр бетон шал, сэндвич ханын төмөр бетон түшиц хана хийгдсэн, барилгын дотор шинээр төлөвлөж буй оффисийн хэсэг болох 15.4 x 13.4м хэмжээтэй металл багана, дам нуруу хийгдсэн. | 70% |
| 5.7. Салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох, цахимжуулах ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд: | | | | 90 |
| 5.7.1. | Цахим системээр барилгын үйл | Мэргэжлийн байгууллагаар | Энэ оны 1 дүгээр сараас 2025.11.30-ны өдрийн байдлаар 38 удаагийн баталгаажуулалтаар | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажиллагааны болон барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавьж, ХББОССайдын тушаалаар албажуулан хүргүүлнэ. /Барилгын тухай хуулийн 33.1.15, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.14.6/ | барилга байгууламж барих нөхцөлийг бүрдүүлнэ. | БҮАТЗ хүссэн нийт 2931 ААНБ-ын өргөдөл материал хянагдаж, баталгаажуулалт хийв. Үүнээс сунгалтаар 117, шинээр 2158, нэмэлтээр 631, дахин олголтоор 25 ААНБ-д БҮАТЗ олгов.<br>-Сунгалтаар 117 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар 102, Зураг төсөл боловсруулахаар 13, өргөх байгууламжаар 2, Шинээр 2158 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар 1827, Зураг төсөл боловсруулахаар 280, өргөх байгууламжаар 51, Нэмэлтээр 631 ААНБ-д БҮАТЗ-ийн ажилбар нэмж олгосноос: Барилга угсралтаар 491, Зураг төсөл боловсруулахаар 133, өргөх байгууламжаар 7 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулсан байна.<br>Дахин олголтоор 25 ААНБ-д БҮАТЗ олгосноос: Барилга угсралтаар 21, Зураг төсөл боловсруулахаар 4 ААНБ-д БҮАТЗ-ийн гэрчилгээг дахин олгов.<br>“МБМҮХ” ТББ-аас 2025.01.01-ээс хойш ирүүлсэн 10 удаагийн хүсэлтийг хянан үзэж, нийт 56 /шинээр 49 аж ахуй нэгж, сунгалтаар 6 аж ахуй нэгжийн/ хүсэлтийг Сайдын 9 удаагийн тушаалаар баталгаажуулан хүргүүлсэн. 3 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөл цуцлагдсан. 1 аж ахуйн нэгж Оноосон нэрээ өөрчилсөн. | |
| 5.7.2. | Барилгын материалын цахим мэдээллийн сан байгуулах ажлыг зохион байгуулна. | Барилгын материалын цахим мэдээллийн сангаас барилгын материалын мэдээлэл олон нийтэд ил тод болгох ажлыг зохион байгуулна. | “Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лаборатори”-ийн үйл ажиллагаа, барилгын материалын тохирлын гэрчилгээ, технологийн зааврын нэмэлт хөгжүүлэлтийн ажил цахимжих бөгөөд Гаалийн ерөнхий газраас Импортын барилгын материалын нээлттэй мэдээлэл, Татварын ерөнхий газраас Барилгад хэрэглэгдэх гол нэр төрлийн барилгын материалын үнийн мэдээлэл авахаар дээрх 2 байгууллагаас мэдээлэл авахаар ажиллаж байна. /2 байгууллага цахим системдээ хөгжүүлэлт хийж байгаа тул хүлээгдэж байна./ | 70% |
| 5.7.3. | Барилгын салбарын 99 жилийн ой “Барилгачдын өдөр”-2024, салбарын шилдэг 10 аж ахуйн нэгж байгууллага шалгаруулах ажлыг зохион байгуулна. **/Барилгын тухай хуулийн** 48.5.1/ | Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй шилдэг аж ахуйн нэгжийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна. | “Барилгачдын өдөр-2025” 99 жилийн ойн арга хэмжээг 2025.09.05-ны өдөр зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, 21 аймгийн ААН байгууллагын удирдлагууд болон салбарын инженер техникийн ажилчид оролцсон. Тус арга хэмжээний үеэр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан уламжлал ёсоор барилгын салбарын 2025 оны шилдэг 10-н ААН байгууллагуудын төлөөлөлд цом, өргөмжлөл гардуулав.<br>- Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 99 жилийн ой, “Барилгачдын өдөр - 2025” арга хэмжээг угтаж 2025 оны 09 дүгээр сарын 3, 4-ний өдөр “Барилгын салбарт Барилгын мэдээлэлтэй загварчлал (BIM) технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаа” сэдэвт сургалтыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ, БНСУ-ын “Мүүён Си Эм” ХХК, “Эйч Энд Эйч Консалтинг” ХХК-тай хамтран зохион байгуулсан.<br>-Сургалтад Салбарын ТББ, аж ахуй нэгж байгууллага, 21 аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт албан бичиг хүргүүлж, мэдээлэл өгч ажилласан ба нийт 206 архитектор, инженерүүд хамрагдсан бөгөөд Барилгын салбарын ажилтны давтан сургалт, | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалтын сонгон суралцах 1 багц цагийн гэрчилгээ олгож ажиллаа. | |
| 5.7.4. | Барилгын салбарын 100 жилийн ой зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | Барилгын салбарын 100 жилийн ой зохион байгуулах ажлыг хэсгийг байгуулж, төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Барилгын салбарын 100 жилийн ой зохион байгуулах ажлыг хэсгийг ХББОС-ын сайдын 2025.08.15-ны өдрийн 189 дүгээр тушаалаар байгуулсан. Барилгын салбарын 100 жилийн ойг тэмдэгдэх Засгийн газрын тогтоолын төслийн боловсруулсан. Тус ажлын хэсэг 2025.12.11-ний өдөр хуралдаж 100 жилийн ой зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, төлөвлөгөөг батлуулахаар ажлын хэсгээс шийдвэрлэсний дагуу эцэслэн батлуулахаар ажиллаж байна. | 90% |

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хагас жилийн байдлаар хэрэгжилт 70 хүртэл хувьтай "хангалтгүй" хэрэгжсэн 4 арга хэмжээ байна. Үүнд:

1. 5.1.7. "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг шинэчлэн боловсруулна;
2. 5.1.8. "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам"-ийг шинэчлэн боловсруулна. /ЗГҮАХХАХТ-ний 2.4.2.3.479/
3. 5.2.14. Үндэсний ногоон барилгын үнэлгээний системийг нэвтрүүлж, хөгжүүлэх /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1011/
4. 5.5.9. Барилгын салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангуулах Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын албан даалгавар батлуулах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.

**Дөрөв. Дүгнэлт:**

1. Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 64 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж жилийн эцсийн байдлаар **91.01** хувьтай буюу "бүрэн хангалттай" үнэлэгдсэн байна.
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зарим арга хэмжээний зорилтот түвшинг ажлын тоо хэмжээ, цаг зарцуулалтыг зөв тооцоолон үр дүнтэй байхаар төлөвлөх шаардлагатай байна.
3. Мөн хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний хувьд удирдлага болон бусад, дээд байгууллагын шийдвэрээс хамааран ажлууд зогсох, хэрэгжих боломжгүй болсон заалтууд байна.

5.1.2. Барилгын материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулна. Арга хэмжээний хүрээнд Сангийн сайдад боловсруулж хүргүүлсэн болovч Сангийн сайдаас шийдвэрлэх боломжгүй талаар хариу мэдэгдсэн байна.

5.2.7. “Гамшигт тэсвэртэй, эрчим хүчний алдагдал багатай, дэвшилтэт технологи бүхий “Амины орон сууц”-ны загвар төсөл хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ. Гэх заалтын хүрээнд холболтын зураг төсөл хийгдсэн болovч газрын зориулалт таарахгүй шалтгаанаар захиалагчийн зүгээс ажлыг зогсоосон байна.

**Тав. Санал, зөвлөмж**

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний "хангалтгүй" хэрэгжсэн 5.1.7, 5.1.8, 5.2.14, 5.5.9 дахь 4 арга хэмжээг 2026 оны нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч ажиллах;

2. Нэгжийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамааруулан тухайн жилдээ батлуулах боломжтой баримт бичиг болон он дамжин хэрэгжүүлж буй баримт бичгийн зорилтот түвшинг батлуулахаар, батлуулах боломжгүй хугацаа шаардах баримт бичгийн боловсруулалтын хугацааг нарийвчлан тооцож нөөцийг бүрэн ашиглан хэрэгжүүлэхэд хүрч болох түвшингээр тооцон төлөвлөж байх;

3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний үзүүлэлтийг тоогоор, чанараар хэрхэн хэмжиж болохыг урьдчилан нарийвчлан тооцох, тодорхойлох, тухайн арга хэмжээг гүйцэтгэх шат дамжлага дараалльн хувьд хуваалт хийн зорилтот түвшин, суурь түвшинг тодорхой байхаар төлөвлөгөөндөө тусгах;

4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хүрээнд 5.1.7. дахь арга хэмжээ болох "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг шинэчлэн боловсруулах ажлыг эрчимжүүлэх, Ажлын хэсэг байгуулах, хэлэлцүүлэх, санал авах, батлуулах ажлыг 2026 оны эхний улиралд багтаан хэрэгжүүлэх;

5. Төлөвлөгөөний 5.2.14.-т батлагдсан Үндэсний ногоон барилгын үнэлгээний системийг нэвтрүүлж, хөгжүүлэх /ЗГҮАХХАХТ-ний 3.4.3.7.1011/ арга хэмжээний хүрээнд техникийн даалгаврыг батлуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг эрчимжүүлж ажиллах;

6. Газрын төлөвлөгөөний суурь түвшин нь тоо баримт судалгаанд үндэслэх, зорилтот түвшин нь тооцоололд үндэслэсэн байх, тайлагнахдаа хийж хэрэгжүүлсэн ажлууд нь тухайн чиглэлд ямар ахиц, дэвшил үзүүлсэн үр дүнгийн үзүүлэлтээр товч тодорхой байхаар тайлагнаж байх;

7. Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт "Байгууллага болон зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн тайлангийн загвар"-ын шаардлагад нийцүүлэн, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан, товч тодорхой, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах зөвлөмжийг хүргүүлж байна.

Тайланг хянасан:
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал

Боловсруулсан:
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч Д.Мөнгөнсувд

БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

# ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 он

# ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025.12.15

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд бүтэн жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт өгч, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлүүлж гарсан цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмжийг ХБОСБЗГ-т болон холбогдох газар, хэлтэс, албан хаагчид хэрэгжилтийн хангуулахаар хүргүүлэх, яамны удирдлага, албан тушаалтанд холбогдох мэдээллийг өгөхөд энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын ЗОРИЛГО оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ыг тус тус баримтална.

Хоёр.Танилцуулга

Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус газраас ирүүлсэн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайланг үндсэн материал болгон ашиглав.

Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг үнэлэхдээ шаардлагатай тайлбарыг албан хаагчдаас авч, ярилцлага хийж тодруулга хийж гаргасан.

Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газар нь 2025 онд гурван зорилтын 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төлөвлөснөөс тайлант жилийн эцсийн байдлаар 93.5 хувьтай буюу "Бүрэн хангалттай" гэж үнэлэгдлээ.

Үүнд:

85-аас дээш хувьтай хэрэгжсэн 45, 70-85 хүртэлх хувьтай хэрэгжсэн 7, 70 хүртэлх хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ байна.

Хүснэгт 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн нэгдсэн товчоо /хувиар/

| № | Ажил үйлчилгээ | Зорилт | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн хувь | | | | Биелэлт (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 85-аас дээш | 70-85 хүртэлх | 70 хүртэлх | Хоцорч байгаа | |
| 1 | | 5 | 55 | 45 | 7 | 3 | | 93.4 |

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээний биелэлтийн дүн /хувиар/

| Дугаар | Гүйцэтгэл | Дугаар | Гүйцэтгэл | Дугаар | Гүйцэтгэл | Дугаар | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1 | **100** | 1.2.2.2 | 100 | 2.1.7 | 80 | 2.1.22 | 100 |
| 1.1.1 | 100 | 1.2.2.3 | 100 | 2.1.8 | 100 | 2.1.23 | 100 |
| 1.1.2 | 100 | 1.2.2.5 | 100 | 2.1.9 | 60 | 2.1.24 | 100 |
| 1.1.3 | 100 | 1.2.2.6 | 100 | 2.1.10 | 100 | 2.1.25 | 100 |
| 1.1.4 | 100 | 1.2.2.7 | 87.5 | 2.1.11 | 90 | 2.1.26 | 100 |
| 1.1.5 | 100 | 1.2.3 | **87.2** | 2.1.12 | 100 | 2.1.27 | 75 |
| 1.1.6 | 100 | 1.2.3.1 | 99.4 | 2.1.13 | 75 | 2.1.28 | 95 |
| 1.1.7 | 100 | 1.2.3.2 | 75 | 2.1.14 | 100 | 2.1.29 | 70 |
| 1.1.8 | 100 | 2.1 | **88.6** | 2.1.15 | 90 | 2.1.30 | 100 |
| 1.1.9 | 100 | **2.1.1** | **82.5** | 2.1.16 | 75 | 2.1.31 | 95 |
| 5.2 | **94.9** | **2.1.2** | 80 | 2.1.17 | 90 | 2.1.32 | 100 |
| 1.2.1 | **100** | **2.1.3** | **92.5** | 2.1.18 | 100 | 2.1.33 | 85 |
| 1.2.1.1 | 100 | **2.1.4** | 70 | 2.1.19 | 100 | 2.1.34 | 85 |
| 1.2.1.3 | 100 | **2.1.5** | **100** | 2.1.20 | 100 | 2.1.35 | 90 |
| 1.2.2 | **97.6** | **2.1.6** | **97.5** | 2.1.21 | 100 | 2.1.36 | 100 |
| 1.2.2.1 | 98.2 | | | | | **Бүгд** | **93.4** |

Хүснэгт 3. Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт /хувиар/

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Биелэлт /хувь/ |
|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО: ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧИГ, ДҮРЭМ, ЖУРМЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, УДИРДАМЖ, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ | | | | |
| 5.1. ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧИГ, ДҮРЭМ, ЖУРМЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХОТ, ТОСГОН, СУУРИН ГАЗРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ.САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ НЭГДСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, БОДЛОГЫН НЭГДСЭН УДИРДАМЖААР ХАНГАХ | | | | |
| 1.1.1 | УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/3349 дугээр албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх ажлыг эхэлсэнтэй холбогдуулан бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин”-ийн үзүүлэлт тус бүрээр хүрсэн түвшинг өссөн дүнгээр нэгтгэн тайлагнаж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | |
| 1.1.2 | УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого" Монгол Улсын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | Дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | "Шинэ сэргэлтийн бодлого" Монгол Улсын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. "Шинэ сэргэлтийн бодлого" Монгол Улсын дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | 100 |
| 1.1.3 | "Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан салбарт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана | "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан салбарт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | 100 |
| 1.1.4 | "Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан салбарт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан салбарт хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | 100 |
| 1.1.5 | УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан хөгжлийн төслүүдийн хэрэгжилт болон цогц мэдээлийг medgov.work төслийн цахим маягтаар дамжуулан илгээж, маягтын дагуу нэгтгэн 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 02/3118 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. ЭЗХЯ-аас хэрэгжих боломжоор нь үнэлж эрэмбэлсэн жагсаалтын тэргүүн ээлжид хэрэгжүүлэх төслийн жагсаалтад яамны хөгжлийн төслүүдийг нэмж тусгуулахаар холбогдох саналыг бэлтгэн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/3446 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.1.3 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн тайланг нэгтгэн Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн. | 100 |
| 1.1.7 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028” оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайланг боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024-2028 оны стратеги төлөвлөгөө”-г ХББОС-ын сайдын 2025 оны 132 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ТНБД-ын 2025 оны А/117 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хуваарь”-т заасны дагуу 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөрт багтаан тайлагнаж Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлнэ. | 100 |
| 1.1.8 | Монгол Улсын Ерөнхий сайдын “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 2025 оны 01 дүгээр, “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2025 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, холбогдох тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | МУЕС-ын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 177 дугаар тушаалаар батлуулсан.<br>Албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэн 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 01/3261, 2025 оны 09 дүгээр сарын 30-ны 01/3682, 2025 оны 11 дүгээр 06-ны 01/4107, 2025 оны 12 сарын 01-ны өдрийн 01/4415 дугаар албан бичгээр тус тус Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br>МУЕС-ын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэн 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 01/3070 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 100 |
| 1.1.9 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025-2028 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025-2028 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг шинэчлэн | ХББОС-ын салбарын 2025-2028 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн төслийг МУ-ыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин болон МУЗГ-ын 2024-2028 оны үйл | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | шинэчлэн боловсруулж батлуулах, Барилга, хот байгуулалтын яамны 2021-2024 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах. | боловсруулж батлуулсан байна.<br>Барилга, хот байгуулалтын яамны 2021-2024 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн хэрэгжилтийг холбогдох газарт хүргүүлсэн байна. | ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй уялдуулан шинэчлэн боловсруулсан.<br>МУЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-аас “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн биелэлт хасагдсан тул батлуулах шаардлагагүй болсон.<br>Яамны 2021-2024 оны “Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тогтоосон хугацаанд хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| 5.2.ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРТ НИЙЦСЭН ОРОН СУУЦЖУУЛАЛТ | | | | |
| 1.2.1 | ЗОРИЛТ 1: “ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГААР ДАМЖУУЛАН ИРГЭДИЙГ ОРОН СУУЦТАЙ БОЛОХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ, ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ. ЗГҮАХХАХТ: 2.4.1.1 | | | |
| 1.2.1.1 | Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх<br>**ЗГҮАХХАХТ: 2.4.1.1, N463** | Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулсан байна. | Үндэсний орон сууцжуулалтын анхдагч хуулийн анхны төслийн үзэл баримтлалын төслийг Сангийн сайд, ХББОС-ын, ХЗДХ-ийн сайд нар баталгаажуулж, ГБХНХ-ын сайд баталгаажуулаагүй.<br>Тус анхны төслийг ХББОСЯ-ны https://mcud.gov.mn/forum/42 цахим хаягт байршуулан иргэд олон нийтээс, Барилгын үндэсний ассоциаци ТББ, аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудад танилцуулан хэлэлцүүлсэн.<br>МУЕС-ын 2025.07.28-ны өдрийн 45 дугаар захирамж байгуулагдсан “иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, орлогод нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд орон сууцны санхүүжилтийн тусгай чиг үүрэг бүхий банк байгуулах асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах” үүрэг бүхий Ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын дагуу шинээр Орон сууцжуулалтын болон Орон сууцжуулалтын хөрөнгө оруулалттай холбоотой 2 тусдаа хуулийн төсөл боловсруулах шийдвэр гарсан.<br>ЗГХЭГ-ын даргын 2025 оны 112-р тушаалаар байгуулагдсан МУ-ын Ерөнхий сайдын 45 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, орон сууцжуулалтын банкны тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулах чиг үүрэг бүхий ХББОСЯ-ны ТНБД- | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | аар ахлуулсан дэд ажлын хэсгээс өгсөн үүрэг даалгаврын дагуу орон сууцжуулалтын тухай болон орон сууцны санхүүжилтын тухай хуулийн төслүүдийг боловсруулан Ажлын хэсгийн дэд даргад 2025.11.25-ны өдөр, Ерөнхий сайдад 2025.12.05-ны өдөр тус тус танилцуулаад байна. | |
| 1.2.1.3 | Бүсийн хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг хангах төсөл, арга хэмжээ, түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. **ЗГҮАХХАХТ: 1.4.1.5** | ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл - 1 | МУЗГ-ын 2025.05.21-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээр Залуус-1 төслийн талаар, 2025.07.02-ны хуралдаанаар нийслэлийн замын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн тус тус тэмдэглэл гарсан. | 100 |
| 1.2.2 | **"ӨРХИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРТ НИЙЦҮҮЛЖ ИПОТЕКИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЖ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ. ЗГҮАХ: 2.4.1.2, 2.4.1.3, 2.4.1.8, ЗГҮАХХАХТ: 2.4.1.2** | | | |
| 1.2.2.1 | "Миний анхны байр" хөтөлбөрийг хэрэгжүүлж, залуу гэр бүл анх удаа орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх **ЗГҮАХХАХТ: 2.4.1.2, N466** | 17,889 | Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан “Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд … орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх” гэж заасны дагуу хуримтлалын сангаар дамжуулан Уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн цэвэр ашгаас 2024 онд 495.65 тэрбум, 2025 онд 480.2 тэрбум төгрөгөөр орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн.<br>Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2024 онд 12,150 зээлдэгчид, 2025 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн байдлаар нийт 1,122.93 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 8,841 зээлдэгчид, нийт **17,730** зээлдэгчид олгожээ. | 98.2 |
| 1.2.2.2 | Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүүг ялгаатай тогтоох замаар зах зээлийн зарчимд нийцүүлэх **ЗГҮАХХАХТ: 2.4.1.2, N467** | Журамд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | "Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүүг ялгаатай тогтоох замаар зах зээлийн зарчимд нийцүүлэх нь” сэдэвт уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр холбогдох байгууллагуудын албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-295 дугаар тушаалаар батлагдсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын холбогдох заалтуудад өөрчлөлт оруулахаар тохиролцсон. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудад танилцуулан ҮБСОС-ын үндэсний хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр тохиролцсон боловч тус үндэсний хороо татан буугдсан.<br>Үндэсний хороо, Дэлхийн банкнаас хийгдсэн "Олон улсад амжилттай хэрэгжүүлсэн орнуудын сайн туршлага" судалгаанд үндэслэн банкны үйл ажиллагааны бүтэц, санхүүжилтийн схем, засаглалын шийдлийн талаарх саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан, | |
| 1.2.2.3 | "Миний сонголт орон нутаг" хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн зээлийг 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.<br>**ЗГҮАХ: 2.4.1.8**<br>**ЗГҮАХХАХТ: 1.2.2.2, 1.4.1.2, 2.4.1.2 N468, 2.4.1.8 N476** | 4,762 | Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулж, орон нутагт шилжин суурьшиж байгаа болон нийслэлийн алслагдсан Багахангай, Багануур, Налайх дүүрэгт байнгын оршин суугч иргэний тухайн орон нутгаас анх удаа, шинээр худалдан авч буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлийн жилийн 6%-ийн хүүг эхний 3 жилд 50 хувь буюу 3 нэгж хувийг Засгийн газраас татаас хэлбэрээр дэмжлэг үзүүлж, хүүгийн зөрүү мөнгөн хөрөнгийг төлөхөөр "Ипотекийн зээлийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ"-г ХББОС-ын, Сангийн сайд нар, Монголбанкны ерөнхийлөгч, арилжааны банкууд, Зээлийн батлан даалтын сан хамтран 2025.03.20-ны өдөр эцэслэн байгуулж баталсан. | 100 |
| | | 1,200 | 2025.12.05-ны өдрийн байдлаар орон нутагт 3,217 зээлдэгчид нийт 375.01 тэрбум төгрөгийн ипотекийн зээл авснаас 843 зээлдэгчид нийт 98.3 тэрбум төгрөгийн, өссөн дүнгээр **4,810** зээлдэгч тус хөтөлбөрт хамрагдсан<br>Зээлийн батлан даалтын сангаас урьдчилгаа ипотекийн төлбөрийн батлан даалтад 2025 онд 281 зээлдэгч 6.02 тэрбум төгрөгийн, өссөн дүнгээр батлан даалт гаргуулсан байна. Өссөн дүнгээр нийт **1,557** зээлдэгчид батлан даалт гаргасан байна. | |
| 1.2.2.5 | Ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршлуудад тэргүүн ээлжинд олгуулах арга | 8,178 | Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо, Монголбанк, ГБХНХЯ, ХББОСЯ, нийслэлийн Хот төлөвлөлт хотын стандартын газар, Орон сууцны бодлогын газар, "Шинэ Сэргэлтийн Бодлогын Хурдасгуур Төв" УТҮГ-ын хамтарсан "Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүүг ялгаатай тогтоох замаар зах зээлийн зарчимд | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэмжээг зохион байгуулна. **ЗГҮАХ: 1.1.3.3.** **ЗГҮАХХАХТ- 39** | | нийцүүлэх нь" сэдэвт уулзалтыг 2025.01.20-ны өдөр зохион байгуулж, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-295 дугаар тушаалаар батлагдсан "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ын холбогдох заалтуудад өөрчлөлт оруулахаар тохиролцон саналын төслийг холбогдох байгууллагуудад танилцуулагдсан. ЕС-ын 45 дугаар захирамж, ЗГХЭГ-ын даргын 112-р тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийн хүрээнд боловсруулж буй "Орон сууцны санхүүжилтын тухай" хуулийн төсөлтэй холбогдуулан хүлээгдэж байна. Ипотекийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 747.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 5,624 зээлдэгчид олгож, нийт **12,002** зээлдэгчид олгожээ. | |
| 1.2.2.6 | "Хашаандаа сайхан амьдаръя" хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц шинээр барих, засварлахад хөнгөлөлттэй зээл болон бусад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. **ЗГҮАХХАХТ: 1.1.3.7, 2.4.1.5, 2.4.2.2, 3.4.2.9** | Ипотекийн зээлийн журамд Шинээр амины орон сууц барих, худалдан авахад болон гамшигт тэсвэртэй, барилгын норм ба дүрмийг хангаж өөрийн орон сууцны нөхцөлийг сайжруулан засварласан өрхөд ипотекийн зээл олгодог өөрчлөлт оруулсан байна. | Амины орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийг ямар аргачлалаар олгох талаар 2025.01.20-ны өдөр "Монголын банкны холбоо" ГҮТББ-ийн Зээлийн эрсдлийн хороогоор хэлэлцүүлж, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ЕТ-г батлуулах, Ногоон барилгын аудитор бэлтгэсний дараа дахин хэлэлцэхээр тохиролцсон. Улаанбаатар хотод 2025.05.04-07-нд зохион байгуулсан "Дулаан байшин" сэдэвт өдөрлөгт холбогдох ТББ, аж ахуй нэгж, олон улс, банк санхүүгийн нийт 91 байгууллага оролцож 10000 орчим буюу давхардсан тоогоор 29562 иргэнд эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологи танилцуулагдсан. 2025.05.19-27-ны өдрийн хооронд зохион байгуулсан "Ногоон барилгын аудитор бэлтгэх" сургалтад 54 ИТА хамрагдсанаас 11 нь шалгалтад тэнцэж аудиторын гэрчилгээ авсан. Амины орон сууцанд ипотекийн зээл олгох үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс 2025.09.25-ны өдөр Монгол банк, Ногоон барилгын хүрээлэнтэй ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн тодорхой хувийг ирэх оноос амины орон сууцанд олгохоор хуваарилах, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн талаар хэлэлцэж, Монголбанкны | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ерөнхийлөгчийн 2016 оны А/295 дугаар тушаалаар баталсан журамд өөрчлөлт оруулахаар тохиролцлоо.<br>Ипотекийн хөтөлбөрийн хүрээнд энэ оны эхний хагаст нийт 1.3 тэрбум төгрөгийн зээлийг амины орон сууц худалдан авч буй зээлдэгчид олгосон. | |
| 1.2.2.7 | "Миний амины орон сууц" хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ.<br>**ЗГҮАХ: 2.4.1.7,**<br>**ЗГҮАХХАХТ: 2.4.1.7 N475, 3.4.2.9,** | Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд дэмжлэг үзүүлэх журмын төсөл боловсруулсан байна.<br>Томоохон хот суурин газар /хүн амын нягтрал өндөртэй хот, суурин/-т яндангүй бүсийг тогтоох ажлыг эхлүүлсэн байна. | Эрчим хүчний хэмнэлттэй хувийн сууцны урьдчилгаа төлбөрийн татаасын санхүүжилтийн журмын зорилго нь хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан амины орон сууцны бүсэд эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дээшлүүлэх, барилгын салбарт эрчим хүчний хэрэглээг бууруулахад урьдчилгаа төлбөрийн татаас бүхий эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих болон сайжруулахад 30 хүртэлх сая төгрөгийн татаас олгох нөхцөл, шаардлагыг тодорхойлох, татаасын санхүүжилтийг олгох, зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах 6 бүлэгтэй “Амины орон сууц шинээр барих болон сайжруулахад төрөөс татаас олгох журам”-ын төслийг боловсруулан ХББОСЯ-ны цахим хуудаст байршуулан санал авч байна.<br>Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд Улаанбаатар хотод 60 гаран мянган өрхийн багтаамжтай сайжруулсан гэр хорооллын бүсийг тогтоосон байгаа бөгөөд Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл УИХ-аар хэлэлцэгдэх хүлээгдэж байна. | 87.5 |
| 1.2.3 | **СТРАТЕГИЙН ЗОРИЛТ: "МИНИЙ ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ИПОТЕКИЙН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ӨМЧЛӨХ ХЭЛБЭРИЙН ОРОН СУУЦНЫ ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ. ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ** | | | |
| 1.2.3.1 | "Миний сонголт-Төрийн алба" Орон нутагт төрийн албан хаагчдын түрээсийн орон сууц барих<br>**ЗГҮАХХАХТ: 1.4.1.5 N154, 2.4.1.4 N472, 4.2.3.9** | 30 суманд 8 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлсэн байна.<br>Төрийн албан хаагчийн 80 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан байна. | “ТАХОС-жуулах цогц хөтөлбөр”-ийг 2024 онд 12 сумын төвд 8 айлын ТАХОС-ны төсөл эхлүүлснийг үргэлжлүүлэн Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд заасан бүсчлэлээр 2025-2027 оны хооронд нийт 90 суурин газарт хэрэгжүүлэхээр УТ-т 90 тэрбум төгрөг тусгагдан сонгон шалгаруулалт хийгдсэнээс орон нутгийн хөгжлийн төв суурин болох 26 сумын төв, нийслэлийн алслагдсан 2 дүүрэгт 15 айлын, хөгжлийн төвүүдийн таталцлын бүсэд хамаарах 38 сумын төвд 8 айлын ТАХОС-ны төсөл хэрэгжиж эхлээд байна. Төслийн үр дүнд:<br>-Говийн бүсэд орон сууцны 2666м$^2$ - 62 айлын;<br>-Хангайн бүсэд-150 айлын;<br>-Хойд бүсэд-31 айлын; | 99.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | -Баруун бүсэд-131 айлын;<br>-Төвийн бүсэд-39 айлын;<br>-Зүүн бүсэд-116 айлын;<br>-Нийслэлийн бүсэд-38 айлын, нийт **68** байршилд 597 ТАХОС-ны төслийг эхлүүлээд байна.<br>Тайлант онд Булган, Төв, Дорнод, Сүхбаатар аймгуудад тус бүр 8 айлын. мөн Сүхбаатар аймагт 15 айлын, нийт **79** айлан ТАХОС-ны барилга ашиглалтад орсон. | |
| 1.2.3.2 | Түрээсийн орон сууцанд хамрагдах журмын төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулсан байна. | ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | "1008 айлын орон сууцны төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 137 дугаар тогтоолыг үндэслэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 253 дугаар тушаалаар түрээсийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах журмыг шинэчлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсаны дагуу журмын төслийг эцэслэн боловсруулж, холбогдох газруудаас санал авч нэгтгэсэн. Журмын төслийг тогтоолын төслийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна. | 75 |
| ЗОРИЛГО 2: ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ, НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧИГ, ДҮРЭМ, ЖУРМЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, УДИРДАМЖ, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ | | | | |
| 2.1. ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧИГ, ДҮРЭМ, ЖУРМЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ХОТ, ТОСГОН, СУУРИН ГАЗРЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ. | | | | |
| 2.1.1. | Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.<br>**МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-3.6.1 МУЗГҮАХ/2024-2028/- 4.2.4.3, МУЗГҮАХХАХТ-4.2.4.3.1286.**<br>**МУ-ыг хөгжлийн 2025 оны төлөвлөгөө - 2.1.1.9,** | - ХББОС-ын сайдын тушаалаар Ажлын хэсгийг шинэчлэн томилсон байна.<br>-Хуулийн зөвлөх багаас боловсруулсан хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн анхны төсөл, бусад холбогдох тайланг хүлээн авсан байна.<br>-Хуулийн төслийн үзэл баримтлалыг эцэслэн боловсруулж батлуулсан байна. | ХББОС-ын сайдын 2024 оны 79 дүгээр тушаалаар байгуулагдсан Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн нийт 5 удаагийн хурлыг зохион байгуулсан.<br>Хуулийн төсөл боловсруулах зөвлөх "Хууль зүйн бичигт хүрээлэн" НҮҮТББ хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний **тайлан**, давхардал, хийдэл, зөрчлийн шинэчилсэн **судалгаа**, хот байгуулалт, түүний эрх зүйн орчны SWOT, PESTLE **шинжилгээ**, гадаадын улс орнуудын хот байгуулалт, төлөвлөлтийн талаарх эрх зүйн зохицуулалтын тойм **судалгаа**, хуулийн үзэл баримтлалын төсөл хуулийн анхны төсөл, танилцуулга зэргийг агуулсан 2025.02.19-ний өдөр **дундын шатны тайланг** хүлээлгэн өгсөн.<br>Хуулийн үзэл баримтлалын төсөлд СЯ, ЭЗХЯ, ХЗДХЯ, ГЗБГЗЗЕГ, | 82.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | -Хуулийн төслийг олон нийт, ТББ-аар хэлэлцүүлж, санал авч тусгасан байна.<br>-Хуулийн төсөл яамдуудаас санал авсан байна.<br>-Хуулийн төслийг боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | БХТ, МАЭ, МБЗТЗХ зэрэг төрийн болон ТББ-аас 2025.09.10-ны өдрийн 02/3384 тоот албан бичгээр санал авч тусган, ХББОС-ын сайдаар батлуулан ХЗДХ-ийн сайдад 2025.10.29-ний өдрийн 01/4006 тоот албан бичгээр хүргүүлсэн. ХЗДХЯ-аас өгсөн чиглэлийн дагуу хуулийн үзэл баримтлалыг ЗГХЭГ-ын даргаар батлуулахаар ЗГХЭГ-т 2025.11.27-ны өдрийн 01/4361 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Монголын хуульчдын холбоотой хамтран 2025.04.25-ны өдөр зохион байгуулсан "Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлэгт "20 минутын хот" Үндэсний хороо, "20 минутын хот" хөгжлийн төв, НЗДТГ, Нийслэлийн Хот байгуулалт, Хотын стандартын газар, нийслэлийн Ерөнхий архитекторын ажлын алба, Барилгын хөгжлийн төв, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх зэрэг байгууллагуудын 45 гаруй төлөөлөл оролцсон. | |
| 2.1.2. | Хот, суурины ногоон байгууламжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулна.<br>**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, МУЗГ-ын 2021.11.17-ны өдрийн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 350 дугаар тогтоол, МУЗГҮАХ/2024-2028/- 1.1.4.1,**<br>**МУЗГҮАХХАХТ-1.1.4.1.52** | -ХББОС-ын сайдын тушаалаар Ажлын хэсгийг шинэчлэн томилсон байна.<br>-Хуулийн төсөл болон үзэл баримтлалыг боловсруулсан байна. | ХББОСС, БОУАӨС нарын хамтарсан 2025 оны 51/А/104 дүгээр тушаалаар Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан бөгөөд хуулийн үзэл баримтлал, анхдагч хуулийн төслүүдийг боловсруулж, олон улсын ижил төстэй хуулийн судалгааг хийж гүйцэтгэсэн.<br>Хуулийн төслийг боловсруулахад техникийн туслалцаа авах хүрээнд "Монголын хүртээмжтэй ногоон хотууд" төслийг хамтран хэрэгжүүлэх тухай" 2025.05.07-ны өдрийн 03/36 албан бичгийг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчид санал хүргүүлж, НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр (НҮБ-Хабитат)-т хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд саналаа тусгуулсны үр дүнд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн техник туслалцааны "Монголын хүртээмжтэй ногоон хотууд" төслөөр 2026 оны I улирлаас Хот, суурины ногоон байгууламжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж эхлэхээр болсон. | 80 |
| 2.1.3. | Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын | -ХББОС-ын сайдын тушаалаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг | ХББОСЯ, Монголын хуульчдын холбоотой хамтран 2025.04.25-нд зохион байгуулсан "Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлэгт | 92.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төслийг боловсруулна. **МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-2.5.2, МУЗГҮАХ/2024-2028/- 1.1.3.4, МУЗГҮАХХАХТ-1.1.3.4.40,** **МУ-ыг хөгжлийн 2025 оны төлөвлөгөө - 2.1.1.9** | шинэчлэн томилсон байна. -Хуулийн төсөл болон үзэл баримтлалыг боловсруулсан байна. Холбогдох судалгааг хийсэн байна. | ХСГДХТ хуулийн хэрэгжилт, хуулийг шинэчлэх судалгааны талаар танилцуулж, оролцогчдоос санал авсан. ХСГДХТ тухай хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний 2025/15 дугаартай ажлын даалгаврыг 2025.09.03-ны өдөр ХББОСЯ-ны ТНБД баталсан. ББННС-ийн 50.0 сая төгрөгөөр ХСГДХТ хуулийн төсөл, холбогдох судалгааг хийх ажлыг гүйцэтгэхээр "И Эм Эс Консалтинг" ХХК-г шалгаран 2025.10.17-ны өдөр БХТ/20250203297 тоот гэрээ байгуулсан. ХББОС-ын сайдын 2025 оны 221 дүгээр тушаалаар байгуулагдсан "ХСГДХТ хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох тооцоо, судалгааг боловсруулах чиг үүрэг бүхий" ажлын хэсгийн хурлыг 2025.11.20-ны өдөр зохион байгуулж, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийн хэрэгжилтийн байдал болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн **үр дагаврын үнэлгээ**, хуулийн шинэчилсэн найруулгын төслийн **үзэл баримтлалын төслийг** хэлэлцүүлэн санал авч үзэл баримтлалын төсөлд тусгасан. ХСГДХТ хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Зөвлөх багтай хамтран боловсруулсан хуулийн төслийн үзэл баримтлалын төслийн эхний хувилбарыг 2025.11.25-ны өдөр олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал авсан. Хэлэлцүүлэгт төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд, газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигч иргэний төлөөлөл, төрийн болон төрийн бус байгууллагын нийт 53 хүн оролцож санал солилцсон. | |
| 2.1.4. | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн баримт бичиг боловсруулах ажлыг зохион байгуулна. **МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-3.6.6** | -"Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн баримт бичгийн эцсийн тайланг хүлээн авсан байна. - Тайланг ЭЗХЯ-д хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн байгаль орчны стратегийн үнэлгээний тайланг хүлээн авч БОУАӨЯ-ны Дэд бүтэц, ХАА, үйлдвэрлэл, химийн бодисын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан хэлэлцэх 21 дүгээр хурлаар 2025.11.28-ны өдөр хэлэлцүүлж, дэмжигдсэн. Хурлаас өгөгдсөн зөвлөмж, саналыг тусган ХАНСХЕТ-ийн эцсийн шатны тайланд оруулах ажил хийгдэж байна. | 70 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.1.5. | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн байгаль орчны стратегийн үнэлгээг боловсруулах ажлыг зохион байгуулна. | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн байгаль орчны стратегийн үнэлгээний тайланг хүлээн авсан байна.<br><br>Тайланг ЭЗХЯ-д хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | "МУНСХЕТ"-ийн байгаль орчны стратегийн үнэлгээний тайланг боловсруулж дуусган, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас 2025.04.11-ний өдрийн 03/201 дугаартай албан бичгээр 9 заалт бүхий шинжээчийн дүгнэлтийг гаргуулж, гүйцэтгэгч "Мон газар экологи" ХХК-иар шинжээчдийн санал дүгнэлтийг тайланд тусган боловсруулсан. Шинжээчийн дүгнэлтийг үндэслэн Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн ерөнхий дүгнэлт гаргуулахаар Дэд бүтэц, ХАА, үйлдвэрлэл, химийн бодисын байгаль орчны нөлөөллийн нарийвчидсан үнэлгээний тайлан хэлэлцэх 21 дүгээр хурлаар 2025.11.28-ны өдөр хэлэлцүүлж, дэмжигдсэн. БОУАӨЯ-аас Дүгнэлт албажиж ирүүлэх ажил хүлээгдэж байна. | 100 |
| 2.1.6. | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, УИХ-аар батлуулах ажлыг зохион байгуулна.<br>**МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-3.6.1, МУЗГҮАХ/2024-2028/- 4.2.4.3, МУЗГҮАХХАХТ-4.2.4.3.1286.**<br>**МУ-ыг хөгжлийн 2025 оны төлөвлөгөө - 2.1.1.9,**<br>**Хот байгуулалтын тухай хуулийн 5.1.5 дахь заалт** | - "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г УИХ-ын тогтоолоор батлуулсан байна. | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, ХББОС-ын сайд Ж.Батсуурь, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Сангийн сайд Б.Жавхлан, МУ-ын сайд, 20 минутын хот үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн нар 2024.12.31-ний өдөр хамтран баталсан.<br>"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний баримт бичгийг 2025.01.08-ны өдөр ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, 2-р тэмдэглэлээр УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэн өргөн барьсан.<br>УИХ-ын 2025.01.24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэж, ТББХ-нд шилжүүлсэн. УИХ-ын даргын 2025.01.28-ний өдрийн 65 дугаар захирамжаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр ажиллах дэд ажлын хэсгийг ТББХ-ны ахлах зөвлөхөөр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. | 97.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Дэд ажлын хэсэг 2025.03.12, 2025.04.01-нд, УИХ-ын гишүүн, ТББХ-ны даргаар ахлуулсан ажлын хэсэг 2025.04.23, 2025.06.09-ний өдөр тус тус хуралдаж, төслийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлж батлуулахаар бэлтгэн ажиллаж байна. | |
| 2.1.7. | "Шинэ Хархорум" хотын төлөвлөлтийн суурь судалгаа, ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, үе шатны ажлын зураг төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах<br><br>**МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө 2.3.2.4, МУЗГҮАХ/2024-2028/- 1.3.1.1, МУЗГҮАХХАХТ-1.3.1.1.106.** | -Археологийн хайгуул судалгаа болон байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний эцсийн тайлангуудыг хүлээн авч, гэрээг эцэслэн дүгнэсэн байна.<br><br>-Шинэ хотын дэд бүтцийн эх үүсвэрийн ТЭЗҮ-г тус тус боловсруулж, экспертизийн дүгнэлтийг гаргуулсан байна.<br><br>- Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний зураг төслүүдийг боловсруулсан байна.<br><br>-Гэрээний дагуу судалгаа, зураг төслийн тайлангуудыг хүлээн авсан байна. | 1.ХББОСЯ болон Археологийн хүрээлэн хооронд байгуулсан 2024 оны 2024/119 дугаар гэрээний дагуу зөвлөх нь "Шинэ Хархорум" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай Археологийн хайгуул судалгааны ажлын эцсийн тайланг ССАЖЗЯ-ны дэргэдэх "Археологийн мэргэжлийн зөвлөл", "Палеонтологийн мэргэжлийн зөвлөл", "Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл"-ийн 2025.06.30-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлэн дэмжигдсэн. Эцсийн тайланд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн тухай "Хархорин" хотын ЗАА-ны 2025.08.20-ны өдрийн 2024/14 дугаартай дүгнэлт, тайлан болон 2025.08.21-ний өдрийн 01/273 дугаартай албан бичгээр ирүүлсэн тайлбарыг үндэслэн гэрээг эцэслэн дүгнэсэн.<br>2. "Шинэ Хархорум" хотын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх ажлын эцсийн тайланг БХБЯ болон БОАЖЯ-ны хамтран баталсан 024/03 дугаартай ажлын даалгаврын дагуу БОУАӨЯ-ны дэргэдэх Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2025.05.21-ний өдөр хэлэлцүүлж, зөвлөмж, дүгнэлтийг гаргуулсан. Холбогдох засварыг хийсэн эцсийн тайланг ЗХХ дүгнэлт, актаар хүлээн авсан.<br>3. ХББОС-ын сайд болон Хархорум хотын Захирагч нар хамтран 2025.04.11-ний Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг баталсан. ЕТ боловсруулах шаардлага хангах оролцогч шалгараагүй, Хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв татагдсантай холбоотойгоор 2026 оны улсын төсөвт санал өгсөн.<br>"Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал"-ыг ЗГ-ын 2025 оны 165 дугаарт тогтоолоор дэмжин Хархорум хотын захирагчид батлахыг зөвшөөрсөн.<br>4. ."Шинэ Хархорум" хотын унд ахуйн зориулалттай ундны усны эх үүсвэрийн эрэл-хайгуулын судалгаа | 80 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хийх ажил нь эхний ээлжийн ажлын усны эх үүсвэр БОУАӨЯ-аас 8 сард батлагдсантай холбоотойгоор ажил удаааширч, 10 худгийн цооногийн өрөмдлөгийн ажил хийгдэж, хур тунадас, цаг агаарын нөхцөл хүндэрсний улмаас зогсолт хийсэн.<br>Шинэ хотын дэд бүтцийн эх үүсвэрийн ТЭЗҮ-ийн эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ-ийг ЭХЯ-ны ШУТЗ-ийн 2025.05.30-ны өдрийн ээлжит Ү хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр дэмжиж батлагдсан. Цэвэрлэх байгууламжийг ТЭЗҮ-ийг БХТ-ийн 2025.07.08-ны өдрийн ЭЗ-001/2025 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлт гарч, эцсийн тайланг ЗХХ дүгнэлт, актаар хүлээн авсан.<br>5.-"Шинэ Хархорум" хотын байр зүйн зураг зохиох, ортофото зураг үүсгэх ажлын эцсийн тайланг 2025.06.10-ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын төрийн архивд 2025/ГБЗЗ/11 дугаартай актаар 1:2000 масштабтай байр зүй, ортофото зургийн бүрэн тайланг хүлээлгэн өгсөн. ЗХХ байгууллагын дүгнэлтийн хамт, актаар хүлээн авсан.<br>-Шинэ Хархорум" хотын эхний ээлжийн авто зам, замын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний тайланг ЗТЯ-ны ШУТЗ-аар хэлэлцүүлж, 20 км авто замын ажлыг дэмжиж, зураг төслийг магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталсан. Хотын дотор 30 км замыг хотын ХЕТ-тэй уялдуулах зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлын үнэлгээг тохиролцон, гэрээг эцэслэн дүгнэхээр шийдвэрлэсэн.<br>-2025 онд УТХО-аар хэрэгжиж буй "Шинэ Хархорум" хотын II ээлжийн авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ, инженерийн нарийвчилсан зураг төсөл /Хархорин сум-Хөшөө цайдам-Өгийнуур-Дашинчилэн чиглэлийн замтай холбох/, "Шинэ Хархорум" хот дахь "Хэлтгий цагаан" нуур сэргээх, бохирдолт, ширгэлтээс хамгаалах судалгаа, зураг төсөл, Арвайхээр-Хархорум хот чиглэлийн 220 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын зураг төслийн ажлуудыг гэрээний дагуу дундын тайлангуудад ЗХХ дүгнэлт гаргуулан хүлээн авсан. | |
| 2.1.8. | "Шинэ Хархорум" хотын хүн амын унд ахуйн | Гэрээний дагуу эцсийн шатны | Судалгааны ажлын тайланг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Усны нөөцийн зөвлөлийн хурлаар | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийн эрэл хайгуулын судалгаа хийх ажлыг зохион байгуулна. **МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө 2.3.2.4, МУЗГҮАХ/2024-2028/- 1.3.1.2, МУЗГҮАХХАХТ-1.3.1.2.107.** | тайланг хүлээн авсан байна. | хэлэлцүүлж дэмжигдсэн. Хархорум хотын хүн амын унд, ахуйн зориулалттай газрын доорх усны ордын нөөцийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/281 дүгээр тушаалаар баталсан. Эцсийн тайланд хийсэн захиалагчийн хяналтын дүгнэлт, тайланг хянасан. | |
| 2.1.9. | Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг ЭЗХЯ, Орхон аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулна. | -Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна. | ЭЗХЯ, Орхон аймгийн ЗДТГ болон “Нью-Урбанизм” ХХК-ийн хооронд 2024.12.06-ны өдөр байгуулсан УТ2406600094021/ЭЗХЯ202451 дугаартай гэрээний дагуу “Бүсийн тулгуур төв, Орхон аймгийн Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж дэмжлэг, зохицуулалтаар хангах болон санал, зөвлөмж өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/43 тушаалаар байгуулсан.<br>Ажлын хэсгийн хурлыг 2025.03.25-ны өдөр зохион байгуулж, гүйцэтгэгч “Нью Урбанизм” ХХК-ийн боловсруулсан ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийн төслийг хэлэлцэж, холбогдох үүрэг даалгаврыг өгсөн.<br>Эхлэлийн тайланг Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т 2025.04.23-ны өдөр, ажлын гүйцэтгэлийг 2025.05.14-ний өдөр ЭЗХЯ-нд тус тус хүргүүлсэн. | 60 |
| 2.1.10. | Аймаг, сумын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг орон нутагтай хамтран зохион байгуулна. | -Орон нутгийн төсвийн санхүүжилтээр аймаг, сумын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр болон шинэчлэн боловсруулж, экспертизийн дүгнэлтийг гаргуулсан байна. | Улсын хэмжээнд 330 сумаас хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй 146 сум, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй 87 сум, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа 97 сум байна<br>Боловсруулж байгаа 97 хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнөөс 2025 онд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол-5, сумын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө-11, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-29 нийт улсын хэмжээнд 45 сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг хянан зөвшилцөж батлуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 2025 онд АИТХ-ын тогтоолоор 5 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталсан. Үүнд:<br>1.Булган-Рашаант,<br>2.Сүхбаатар-БаруунУрт,<br>3.Өмнөговь-Булган,<br>4.ГовьАлтай-Есөнбулаг /Алтай/,<br>5.Завхан-Дөрвөлжин,<br>Засгийн газрын тогтоолоор 2 ерөнхий төлөвлөгөө батлагдсан. Үүнд<br>1.Хөшигийн хөндийн чөлөөт бүс,<br>7.Цагааннуур чөлөөт бүс,<br>Нийт 7 еөрнхий төлөвлөгөө батлагдсан | |
| 2.1.11. | “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулна.<br>**МУЗГҮАХ /2024-2028/- 1.2.1.1, 3.2.2.12, МУЗГҮАХХАХТ-1.2.1.1.79,**<br>**ХБТХ-ийн 6.1.7, Чөлөөт бүсийн тухай хуулийн 24.1** | -Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | “Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс”-ийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын 2025.01.08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2025 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан. | 90 |
| 2.1.12. | Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын техник туслалцааны хүрээнд “Төв аймгийн Хөшгийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс, шинэ хотын хөрөнгө оруулалт, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | -Төслийн зохицуулах хороо, ажлын хэсгийг үйл ажиллагааг Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан), Зөвлөх багтай хамтран зохион байгуулсан байна.<br>-Зөвлөх үйлчилгээний үе шатны тайланг хүлээн авсан байна.<br>-Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан байна. | 1. Төслийн хамтарсан зохицуулах хорооны 2 дугаар хуралдааныг МУ-ын Шадар сайдын ажлын алба болон ЖАЙКА, төслийн хэрэгжүүлэгч багтай хамтран 2025.05.16-ны өдөр ХББОСЯ-нд дээр зохион байгуулж, холбогдох шийдвэрийг гаргуулав. Уг хуралдааны шийдвэрийн дагуу МУ-ын Шадар сайд, ХББОС-ын сайдын хамтарсан 2025 оны 103/140 тушаалаар төслийн зохицуулах хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт, нэмэлт оруулсан.<br>2. ХББОС-ын сайдын 2025 оны 121 болон 207 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, 8 удаагийн ажлын хэсэг, 4 удаагийн дэд ажлын хэсгийн хурлыг зохин байгуулж, "Хотын бүсчлэлийн дүрэм”, “Төсөл сонгон шалгаруулалтад оролцох этгээдэд тавих шаардлага, төсөл шалгаруулах журам”, Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл, Хүннү хотын институтын тогтолцооны төслүүдийг хэлэлцэж, санал өгч, шийдвэрүүдийг төслийн зөвлөх багт хүргүүлж ажилласан.<br>3. ЖАЙКА-ийн төслийн зөвлөх багаас боловсруулсан төслийн дунд шатны тайланг 2025.06.03-ны өдөр цахим шуудангаар ирүүлснийг хянаж, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | холбогдох санал, зөвлөмжийг хүргүүлсэн.<br>4. ХББОСЯ, ШСАА, СЯ, Хүннү хотын ЗАА, ХХЭЗЧБЗ, нийслэлийн ХБХСГ, Төв аймгийн ГХБХБГ зэрэг байгууллагуудын 16 хүний бүрэлдэхүүнтэй боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх сургалтыг Япон улсад 2025.04.16-04.23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэ үеэр ЖАЙКА-ийн Токио дахь төв, Японы ЗГХЭГ-ын Орон нутгийн хөгжлийг дэмжих ажлын алба, Японы ГДБЗТАЖЯ-ны Хот байгуулалтын газар зэрэг 7 байгууллагатай хатарсан уулзалт хийж, бүтээн байгуулалтын ажлуудтай танилцаж туршлага судалсан.<br>Мөн төслийн хамтарсан зохицуулах хороо, ажлын хэсгийн гишүүдэд зориулсан дотоод сургалтыг 2025.05.08-ны өдөр БХТ-ийн хурлын танхимд зохион байгуулсан. | |
| 2.1.13. | БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын техник туслалцааны хүрээнд “Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол улсын бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | -“Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол улсын бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл”-ийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | 1.Төслийн зөвлөх баг 2025.03.19-28-нд Монгол улсад ирж холбогдох судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгааны явцад ЗГХЭГ-ын тэргүүн дэд дарга /2025.30.24/, Хархорум хотын захиргаа /2025.03.20,26/, Хүннү хотын захиргаа /2025.03.25/, НЗДТГ /2025.03.27/, ССАЖЗЯ /2025.03.21/-тай, Төр захиргааны байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх асуудалтай холбогдуулан 2025.09.02-ны өдөр ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргатай, автозам, төмөр зам, нисэх онгоцны буудлын асуудалтай холбогдуулан 2025.09.03-ны өдөр ЗТЯ-ны төлөөлөлтэй, 2025.09.04-ний өдөр ХХААҮЯ-ны, 2025.12.01-ний өдөр Боловсролын яам, 2025.12.04-ний өдөр ССАЖЗЯ-ны, 2025.12.02,03-ны өдрүүдэд Хархорум хотын болон Хүннү хотын захиргааны албан тушаалтнуудтай хийх уулзалтыг тус тус зохион байгуулж, шаардлагатай мэдээллийг бүрдүүлэн авсан.<br>КОЙКА байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ЗГХЭГ, ССАЖЗЯ-наас холбогдох мэдээллийг гаргуулан авч тус яамны 2025.06.04-ны өдрийн 05/2216 тоот албан бичгээр хүргүүлэв.<br>2.ХББОС-ын сайдын 2025.10.15-ны өдрийн 226 дугаар тушаалаар Төслийн зохицуулах хороог байгуулж, хорооны анхдугаар хурлыг 2025.12.05-ны өдөр зохион байгуулсан. Төслийн батлагдсан төлөвлөгөөний дагуу БНСУ-ын төр, захиргааны байгууллага, төрийн албадыг орон нутаг руу шилжүүлсэн | 75 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | бодлого, үйл ажиллагаа, туршлагатай газар дээр нь очиж танилцах сургалтыг 2025.05.18-24-ний өдрүүдэд зохион байгуулж, ЗГХЭГ-ын Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар, ХББОСЯ, ТЕГ-ын төслийн нэгж, Хүннү хотын ЗАА-ны нийт 10 албан хаагч хамрагдсан. | |
| 2.1.14. | АХБ-ны Техник, туслалцааны хүрээнд “Хөшигийн хөндийд байгуулагдах даван туулах чадавхтай, ногоон шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах” зөвлөх үйлчилгээний төслийн ажлыг зохион байгуулна. | -АХБ-тай хамтран техник туслалцааны төслийн Зөвлөх багийн боловсруулсан судалгаа, ТЭЗҮ-ийн эцсийн тайланг хянаж, хүлээн авсан байна. | Төслийн ТЭЗҮ-ийн эцсийн тайланг хүлээн авч, ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.04-ний өдрийн 03/1156 дугаар албан бичгийг төслийн Зөвлөх баг /”АЛМЕК” корпораци/-т хүргүүлсэн. Төслийн ТЭЗҮ-ийг хүлээн авахтай холбогдуулан АХБ-ны төлөөлөлтэй 2025.03.27 болон 2025.04.02-ны өдрүүдэд ажлын уулзалтыг ГХАХ-тэй хамтран хийж, тайлангийн үр дүнг хэлэлцсэн. БОУАӨЯ-аар уг төслийн ТЭЗҮ-ийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулж, 2025.05.06-ны өдрийн 12/2243 дугаар албан бичгээр хүлээн авсан. Төслийг МУЗГ, АХБ хооронд байгуулсан "Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр"-ийн 2025 оны санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгуулахаар тус яамны 2024 оны 01/892 тоот албан бичгээр ЭЗХЯ, СЯ-нд тус тус хүргүүлсэн. СЯ-ны 2024 оны 01/5148 албан тоотын дагуу төслийг МУХТЖҮЧ, УХОХ-т тусгуулахаар 2025 оны 01/3123 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлээд байна. | 100 |
| 2.1.15. | “Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулна. **МУЗГҮАХ/2024-2028/- 3.2.2.12, МУЗГҮАХХАХТ-3.2.1.11.580,** **Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.7, Чөлөөт бүсийн тухай хуулийн 24.1 дэх заалтууд** | Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. | “Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2025 оны 09 дүгээр тогтоолоор батлуулсан. | 90 |
| 2.1.16. | Замын-Үүд, Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, | Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан), Замын-Үүд, Алтанбулаг чөлөөт бүсийн | 1.Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн албатай хамтран боловсруулж, Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан МУ-ын Шадар сайд, ХББОС-ын сайд нараар батлуулсан.<br>ТХАА-ны газраас уг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах | 75 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. **МУЗГҮАХ/2024-2028/- 3.2.1.12** | Захирагчийн албадтай хамтран:<br>- Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна.<br>- Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна. | тендерийг зохион байгуулсан боловч гүйцэтгэгч шалгараагүй.<br>АХБ-ны “Замын-Үүд” эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл /3936-Мон/”-ийн удирдах хороо 2025.05.06-нд, ГХ-ны сайдын 2024 оны А/75 дугаар тушаалаар байгуулсан Монгол, Хятадын “Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-ийг хооронд нь хил дамнасан байгууламжаар холбох, улсын хилийг огтлон гарах цэгийн байршлыг тогтоох үүрэг бүхий ажлын хэсгийн хурал 2025.05.16-нд тус тус зохион байгуулагдаж хоёр улсын хилийн холболтын үндсэн гол гарц, байгууламжийг барих урьдчилсан нөхцлийг хэлэлцсэн.<br>2."Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар"-ыг “Алтанбулаг” чөлөөт бүсийн захирагчийн албатай хамтран боловсруулж, МУ-ын Шадар сайд (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал хариуцсан) болон ХББОС-ын сайд нараар батлуулсан.<br>Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр Идеал групп ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж байна. Ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг ХББОСЯ-ны ШУТТЗХ-аар **2025.12.05**-ны өдөр хэлэлцүүлсэн. | |
| 2.1.17. | Нийслэлд байрлах “Их тэнгэрийн амны цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулна.<br>**/маш нууц/** | -Их тэнгэрийн амны цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, экспертизийн дүгнэлт гарсан байна. | Маш нууц.<br>“БХТ” ТӨААТҮГ-аас Зураг төслийн иж бүрдэлд экспертүүдийн өгсөн дүгнэлтийн дагуу холбогдох засвар өөрчлөлтийг гүйцэтгэж байна. Үүнд:<br>Авто зам барилгын ажил болон Замын экспертээс ерөнхий төлөвлөгөөний зурагт өөрчлөлт оруулахаар барилгын ажлын 9, замын 8 дүгнэлт гарсан бөгөөд Экспертүүдийн дүгнэлтийн дагуу засвар хийгдэж байна. Нийт явц 75 %. Үүнд:<br>Эдийн засгийн хэсэг- засвар хийгдсэн 100%-ийн,<br>Цахилгаан хангамжийн хэсэг- засваргүй 100%-ийн, холбоо мэдээллийн хэсэг- засвар хийгдсэн 100%-ийн,<br>Дулаан хангамжийн хэсэг- засвар хийгдсэн-100 %-ийн, газар зохион байгуулалтын хэсэг 90% -ийн, УХАТ-ын хэсэг засвар хийгдэж байгаа 90% хувийн, өндөржилт улаан шугамын хэсэг 100%-ийн, инженерийн бэлтгэл арга хэмжээний хэсэг 100%-ийн гүйцэтгэлтэй байна. | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Архитектур орон зайн төлөвлөлтийн хэсэг дээр дурдсан хэсгүүдийн засвар дууссаны дараа шинээр хийхээр хүлээгдэж, нийт ажлын явц 85%-тай байна. | |
| 2.1.18. | Нийслэл, аймаг, сумын төвийн хөгжлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын бүсчлэлийг тусган боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | -Нийслэл, аймаг, сумын төвийн шинээр болон шинэчлэн боловсруулсан ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулалтын бүсчлэлийг тогтоон батлуулж хэрэгжүүлсэн байна. | Тус яамны ХБОСБЗГ-аас 2025 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан, Дорнод, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 11 аймгийн 26 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 11 сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 5 хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын даалгаврыг хянаж, батлуулсан. Даалгаварт тухайн хотын нутаг дэвсгэрийн бүсчлэл, дэд бүсүүдэд мөрдөх давхар талбайн харьцаа (FAR), барилга бүрхэцийн харьцаа (BCR)-ны шийдлийг тусгаж байх заалт, шаардлагыг оруулсан болно.<br>1.Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлийг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулсан.<br>2. Говь-Алтай аймгийн төв Алтай хотын, Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг, бүсчлэлээр Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн нэгдсэн цахим системд орсон.<br>3. Төлөвлөлтийн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд тайлант онд нийт 23 хот суурин газрын ерөнхий төлөвлөгөө, төлөвлөгөөний тодотгол, шинэчлэлтийн баримт бичиг, бүсчлэлийг оруулснаар төлөвлөлтийн системд нийт хот байгуулалтын төлөвлөлтийн 108 баримт бичиг /ерөнхий төлөвлөгөө/, бүсчлэл орж бүртгэгдэн тухайн суурин гзарт батлагдсан ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлийн дагуу тухайн жилийн газар зохион байгуулалт, хийгдэж, зориулалтын дагуу газар эзэмшүүлэх, зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, барилгын ажилд хяналт хэрэгжүүлж байна | 100 |
| 2.1.19. | Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахад аж ахуйн нэгж, оршин суугчдын саналыг авч тусгах арга хэмжээг төслийн захиалагч, гүйцэтгэгч | -Нийслэл, аймаг, сумын төвийн шинээр болон шинэчлэн боловсруулсан ерөнхий төлөвлөгөөнд "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий | ХБОСБЗГ-аас 2025 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан, Дорнод, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 11 аймгийн 26 сумын хөгжлийн, 11 сумын хэсэгчилсэн, 5 хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын даалгаварыг хянаж, зөвшилцөн "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгууллагуудаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.<br><br>**Хот байгуулалтын тухай хуулийн 17 дугаар зүйл,**<br>**МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө 2.1.1.9.** | төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ыг мөрдүүлсэн байна. | төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ын дагуу олон нийтээс санал авч байх заалт, шаардлагыг тусган батлуулсан.<br>1.Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд иргэд олон нийт, аж ахуйн нэгжүүдээс цахим болон бусад хэлбэрээр хэлэлцүүлэн санал авах ажиллагааг гүйцэтгэгч Хот төлөвлөлт, зураг төслийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулж гарсан саналыг төлөвлөгөөний төсөлд тусгасан<br>2.Эрдэнэт, Баруун-Урт, Алтай хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаварт заасны дагуу гүйцэтгэгч байгууллага орон нутгийн захиргаатай хамтран иргэд, олон нийт болон аж ахуйн нэгжүүдээр ерөнхий төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэн санал авах, тусгах ажлыг зохион байгуулж байна. Баруун-Урт, Алтай хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэгдэн батлагдсан.<br>3.2025 онд Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан, Дорнод, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 11 аймгийн 26 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 11 сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 5 хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, нийт 42 төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах ажлын даалгаварт "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ын дагуу олон нийтээс санал авч байх заалт, шаардлагыг тусган оруулж батлагдсан. | |
| 2.1.20. | Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх /тусгай зөвшөөрөл/ олгох, сунгах, цуцлах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулна.<br>**Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.4 дэх заалт** | -Аж ахуйн нэгж, байгууллагын ирүүлсэн хүсэлтийг хянаж, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох, сунгах, цуцлах ажлыг зохион байгуулсан байна. | 2025 оны жилийн эцсийн байдлаар 10 аж ахуйн нэгжээс хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлтийг барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн цахим "license.mcis.gov.mn" системээр ирүүлснийг хянан шалгаж, Зөвшөөрлийн тухай, Хот байгуулалтын тухай хуулийн дагуу ХББОС- сайдын 2025.05.14-ны өдрийн 110 дугаар тушаалаар 1, 2025.05.22-ны өдрийн 119 дугаар тушаалаар 1, 2025.06.12-ны өдрийн 142 дугаар тушаалаар 1 аж ахуйн нэгжид тус тус холбогдох тусгай зөвшөөрлийг олгож, гэрээ байгуулан | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон.<br>ХББОС-ын сайдын 2025.05.22-ны өдрийн 120 дугаар тушаалаар тусгай зөвшөөрлийн гэрээ, гэрчилгээний загвар батлагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 3 аж ахуйн нэгжид хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөл шинээр олгосон ба тусгай зөвшөөрөл нь хүчинтэй 22 аж ахуй нэгж байна. | |
| 2.1.21. | Эрх бүхий /тусгай зөвшөөрөлтэй/ аж ахуйн нэгж, байгууллагын боловсруулсан хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх ажлыг холбогдох хууль, дүрмийн дагуу зохион байгуулна.<br><br>**Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.5 дахь заалт** | -Холбогдох хууль, дүрмийн дагуу хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх ажлын хэсгийг ХББОС-ын сайдын тушаалаар байгуулж, БХТ-өөр экспертизийн нэгтгэсэн дүгнэлтийг гаргуулсан байна. | ХББОС-ын сайдын 2025.11.25-ны өдрийн 251 дүгээр тушаалаар орон тооны бус экспертүүдийн ажлын хэсгийг байгуулагдан, БХТ экспертизийн нэгтгэсэн дүгнэлт боловсруулах ажлыг зохион байгуулж байна. /Дундговь аймгийн Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө/<br>1.“XII.4.6, Хорооны төлөвлөлтийн зураг, төсөв /Улаанбаатар, Багануур дүүрэг 2 дугаар хороо/"-ны баримт бичигтэй холбогдох материалуудыг хавсарган ирүүлээгүй байх тул 2025.08.14-ны өдрийн 05/2984 дугаартай албан бичгээр, "Архангай аймгийн Хайрхан, Булган, Хотонт сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний зураг төслийн баримт бичгүүдийг Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай тул 2025.10.15-ны өдрийн 05/3847 дугаартай албан бичгээр, "Цагаан Дэл-Уул хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний зураг төслийн баримт бичигтэй холбогдох материалуудыг хавсарган ирүүлээгүй, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх нь 2023.01-р сард дуусгавар болсон тул 2025.11.17-ны өдрийн 05/4235 дугаартай албан бичгээр, "Булган аймгийн Бугат сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” болон “Өвөрхангай аймгийн Бүрд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө“-ний зураг төслийн баримт бичигтэй холбогдох материалуудыг хавсарган ирүүлээгүй байх тул 2025.11.28-ны өдрийн 05/4371 дугаартай албан бичгээр тус тус буцаасан. | 100 |
| 2.1.22. | Аймаг, нийслэлийн Засаг даргын хот байгуулалтын чиглэлээр 2025 онд хийгдсэн | Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2025 тайланг хүлээн | ХББОС-ын сайд болон 21 аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд байгуулсан ЗГ-ын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 2 дугаар хавсралтын 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ажлын тайланг хүлээн авах, нэгтгэх ажлыг зохион байгуулна.<br><br>**Хот байгуулалтын тухай хуулийн 9.1.6 дахь заалт** | авч, нэгтгэсэн байна. | хэмжээний төлөвлөгөөнд Хот байгуулалтын чиглэлээр тухайн жилд хийгдсэн ажлын талаарх тайланг 2025.12.15-ны өдрийн дотор гаргаж ирүүлэхээр тусган батлуулж, тухайн жилд аймаг, нийслэлд хийх ажлын талаар удирдамж, чиглэл, зөвлөгөө өгөх уулзалтыг 21 аймгийн ГХБХБГ-ын дарга нарыг оролцуулан 2025.01.31-нд, 21 аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын сургалтыг 2025.04.18-нд тус тус ХББОСЯ-ны байранд зохион байгуулсан. Гэрээний жилийн эцсийн тайлангийн биелэлтийг ирүүлэх тухай албан бичгийг 21 аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. | |
| 2.1.23. | “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар”-ын дагуу 2024 оны хэрэгжилтийн нэгдсэн тайланг гаргаж дүгнэнэ.<br><br>**Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.9 дэх заалт** | Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлтийн 2024 оны тайланг нэгтгэн дүгнэж, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлтийн 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлэх тухай” ТНБД-ын 2025.04.09-ний өдрийн 03/1241 дугаар албан бичгийг 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газарт тус тус хүргүүлсэн.<br>11 аймаг, нийслэлээс 2024 оны хэрэгжилтийн тайлангаа ирүүлснийг нэгтгэн дүгнэж холбогдох зөвлөмжийг 2025.06.26-ны өдрийн 03/2512, 03/2514 албан бичгүүдээр хүргүүлсэн.<br>Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлтийн 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хугацаандаа ирүүлэх тухай албан бичгийг нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлсэн. | 100 |
| 2.1.24. | Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын 2024 оны ажлын тайланг хүлээн авч, нэгтгэн дүгнэнэ.<br><br>**Хот байгуулалтын тухай хуулийн 10.1 дэх заалт** | Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэн дүгнэж, холбогдох зөвлөмжийг аймаг, нийслэлийн Засаг дарга болон ерөнхий архитекторуудад хүргүүлсэн байна. | Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын 2024 оны үйл ажиллагааны тайланг 19 аймаг, нийслэлээс хүлээн авч нэгтгэн дүгнэж, 2025.04.18-ны өдөр зохион байгуулсан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудын чадавхижуулах сургалтад үр дүнг танилцуулсан. Тайлангийн үнэлгээгээр Архангай, Улаанбаатар, Орхон, Төв, Завхан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторуудыг эхний 5 байрт шалгаруулж урамшуулав.<br>Холбогдох зөвлөмжийг бэлтгэн ХББОС-ын сайдын 2025.05.30-ны өдрийн 01/2157 тоот албан бичгээр 19 аймгийн Засаг дарга нарт, ерөнхий архитекторын тайлангаа ирүүлээгүй Баянхонгор, Сэлэнгэ аймгийн Засаг | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дарга нарт ХББОС-ын сайдын 2025.05.30-ны өдрийн 01/2155, 01/2156 тоот албан бичгээр холбогдох арга хэмжээ авах тухай мэдэгдлийг хүргүүлсэн.<br>“Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын 2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлэх тухай албан бичгийг Улаанбаатар хотын ерөнхий архитектор, 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн. | |
| 2.1.25. | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулна.<br>**Хот байгуулалтын тухай хуулийн 26.1 дэх заалт,**<br>**МУЗГҮАХ/2024-2028/- 4.2.2.2** | -Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, хөтлөх ажлыг ГЗБГЗЗЕГ-тай хамтран зохион байгуулж, яамны холбогдох газруудад хэрэглэгчийн эрхийг олгосон байна. | ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулж байгаа хот байгуулалтын кадастрын цахим систем (urban.gov.mn)-ийг хөгжүүлэх ажлын даалгаварт аймаг, нийслэл хотын ерөнхий архитекторын үйл ажиллагааны тайлан, хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлтийн тайланг системээр авах саналыг тусгуулан батлуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр “Эрхэт-инноваци” ХХК шалгарч 2025.05.07-ны өдөр 2025/76 дугаар гэрээг ГЗБГЗЗЕГ-тай байгуулан ажлыг эхлүүлж 2025.11.12-нд 2025/ГБЗЗ/46 тоот актаар хүлээн авсан.<br>Хот байгуулалтын кадастрын цахим систем (urban.gov.mn)-ийн админы эрхийг ХББОСЯ-ны ХББЗГ-ын /хуучнаар/ даргад холбогдох журмын дагуу олгох тухай 2025.01.20-ны өдрийн 03/203 албан бичгийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ХББОСЯ-ны холбогдох албан хаагчдад хэрэглэгчийн эрхийг олгосон. | 100 |
| 2.1.26. | Аймаг, сумын төвүүдийн шинээр болон шинэчлэн боловсруулсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хот төлөвлөлтийн мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулна. | -Аймаг, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг файл/тоон/ хэлбэрээр гүйцэтгэгчээс хүлээн авч, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан байна. | 1.Булган аймгийн Могод, Бүрэгхангай, Сэлэнгэ, Увс аймгийн Түргэн, Зүүнхангай, Наранбулаг, Тариалан, Өмнөговь, Төв аймгийн Сэргэлэн, Баянжаргалан сумдын төвийн хөгжлийн, Булган аймгийн Орхон сумын Халиун 2 дугаар баг, Мааньт 4 дүгээр багуудын суурьшлын бүсийн, Ховд аймгийн Жаргалант сумын 5, 12 дугаар багийн амины орон сууцны, 4, 5, 11, 12 дугаар гэр хорооллын, 1, 4, 5, 7, 12 дугаар багуудын холимог бүсийн, 1 дүгээр багийн худалдаа үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Баян-Өлгий аймгийн Өлгий хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг боловсруулах зургийн даалгаварт хот төлөвлөлтийн мэдээллийн санд оруулах шаардлагыг тусгаж батлуулсан.<br>2. 2025 оны жилийн эцсийн байдлаар Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд Архангай аймгийн Төвшрүүлэх, Булган аймгийн Хутаг-Өндөр, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Өвөрхангай аймгийн Уянга, Сант, Завхан аймгийн Тосонцэнгэл, Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон, Төв аймгийн Сэргэлэн, Өмнөговь аймгийн Ноён, Номгон, Говьсүмбэр аймгийн Сүмбэр зэрэг сумын төвийн хөгжлийн ЕТ-ний баримт бичгийг файл/тоон/ хэлбэрээр гүйцэтгэгчээр гаргуулан, мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулсан.<br>3.Төлөвлөлтийн Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд тайлант онд нийт 23 хот суурин газрын ерөнхий төлөвлөгөө, төлөвлөгөөний тодотгол, шинэчлэлтийн баримт бичиг оруулснаар төлөвлөлтийн системд нийт хот байгуулалтын төлөвлөлтийн 108 баримт бичиг орж бүртгэгдэн тухайн суурин газарт батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын кадастрын системээр архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах, зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, барилгын ажилд хяналт хэрэгжүүлэх ажлыг хийж байна | |
| 2.1.27. | НҮБ-ын “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үндэсний тайлан /2020-2024/-г боловсруулна.<br>**МУЗГҮАХ/2024-2028/- 3.4.3.7,**<br>**МУЗГҮАХХАХТ-3.4.3.7.1086** | - Шалгарсан зөвлөх багтай гэрээ байгуулсан байна.<br>- Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон байна.<br>- Зөвлөх үйлчилгээний эхлэлийн тайланг хүлээн авч, Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | ХББОСЯ-ны ТНБД-аар 2024.12.16-ны өдрийн 2024/16 дугаартай “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын 2020-2024 оны Монгол улсын тайлан боловсруулах ажлын даалгаврыг батлуулан, шаардагдах 100.0 сая төгрөгийн санхүүжилтийг “Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө”-нд тусгуулан батлуулсан.<br>ХББОСЯ-ны ТНБД-ын 2024.12.09-ний өдрийн А/36 дугаар тушаалаар байгуулагдсан Зөвлөх багийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо тендер зарлан “Динамик анализ интернэйшнл” ХХК шалгарч. БХТ-тэй гэрээг байгуулан, тайлан боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. ХББОС-ын сайдын 2025.11.28-ны өдрийн 255 дугаар тушаалаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2016.12.23-ны өдрийн RES/71/256 дугаар тогтоолоор батлагдсан “Хабитат III” буюу “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн үр дүн, 2020-2024 оны хэрэгжилтийн явцын Монгол Улсын тайланг боловсруулах ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсэг шинэчлэн байгуулагдан ажиллаж байна. | 75 |
| 2.1.28. | Хот байгуулалтын норм, нормативын баримт бичгийг | -Хот байгуулалтын | “БХТ” ТӨААТҮГ-аас Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба | 95 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | боловсронгуй болгох ажлыг зохион байгуулна.<br><br>**МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-3.6.1,**<br>**МУ-ыг хөгжлийн 2025 оны төлөвлөгөө - 2.3.1.23** | норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох судалгаа хийж, Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/-ийг шинэчлэх ажлыг зохион байгуулсан байна. | дүрэм БНбД 30-01-04-ийг шинэчлэн боловсруулж, ШУТТЗХ-аар хэлэлцүүлэх хүсэлтийг 2025.08.20-ны өдрийн 01/2163 тоот албан бичгээр ирүүлсэнийг хянан үзэж, норм ба дүрмийн төсөлд ХББОСЯ-ны 2024.10.09-ний өдрийн 03/807 дугаартай албан бичгээр өгсөн санал, зөвлөмжийг хэрхэн тусгаж ажилласан талаарх тайлбар болон бүлэг тус бүрд сэдэвчилсэн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, холбогдох орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлуудаар хэлэлцүүлсний дараа дахин ирүүлэх шаардлагатай гэж үзэн 2025.09.02-ны өдрийн 02/3298 тоот албан бичгээр буцаасан. БХТ-өөс нормын дүрмийн төслийг боловсруулахад шаардлагатай нэмэлт материал орчуулах, дахин боловсруулалт хийх саналыг гаргасан тул гэрээний хугацааг сунгахаар шийдвэрлэсэн. | |
| 2.1.29. | Тогтвортой, ухаалаг хотын үзүүлэлтийн батлагдсан стандартыг нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.<br>**МУЗГҮАХ/2024-2028/- 3.4.3.7,**<br>**МУЗГҮАХХАХТ-3.4.3.7.1086** | -Тогтвортой, ухаалаг хотын үзүүлэлтийн батлагдсан стандартуудыг нэвтрүүлэх чиглэлээр орон нутаг зөвлөмж хүргүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна. | "Тогтвортой хот ба олон нийтийн хамтын ажиллагаа. Нэр томьёоны тайлбар толь" /MNS ISO 37100:2024/, "Тогтвортой хөгжил. Менежментийн үйл ажиллагаанд тавих шаардлага" /MNS ISO 37101:2024/, "Тогтвотой хот ба олон нийтийн хамтын үйл ажиллагаа. Хотын үйлчилгээ, амьдралын чанарын үзүүлэлт" /MNS ISO 37120:2024/, "Тогтвортой хот ба олон нийтийн хамтын үйл ажиллагаа. Ухаалаг хотын үзүүлэлт" /MNS ISO 37122:2024/, "Тогтвортой хот ба олон нийтийн хамтын үйл ажиллагаа. Тэсвэртэй хотын үзүүлэлт" /MNS ISO 37123:2024/ үндэсний стандартуудыг нэвтрүүлэх ажлын хүрээнд хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг зураг төслийн байгууллагууд, 21 аймгийн ЗДТГ, ГХБХБГ-ууд, аймгийн ерөнхий архитекторуудад сургалт зохион байгуулах асуудлаар СХЗГ-т 2025.06.04-ны өдрийн 03/2229 дугаар албан бичгээр хүргүүлж, 2025.07.08-ны өдөр уулзалт зохион байгуулан хамтран ажиллах талаар санал солилцсон. Зохиогчийн багтай хамтран сургалт зохион байгуулахаар ярилцсан боловч зохиогчийн багийн үндсэн гишүүд нь гадаад түр хугацаагаар ажиллаж байгаатай холбогдуулан сургалтыг 2026 оны 1 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөөд байна. | 70 |
| 2.1.30. | Номтын аманд баригдах төр захиргааны нэгдсэн байрны | -Төр захиргааны нэгдсэн байрны хэсэгчилсэн ерөнхий | ЗГХЭГ-аас Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр Номтын аманд баригдах төр, захиргааны нэгдсэн байрны хэсэгчилсэн ерөнхий | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана./маш нууц/ **МУЗГҮАХ/2024-2028/- 1.2.2.1,** **МУЗГҮАХХАХТ-1.2.2.1.92** | төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх Ажлын хэсэгт орж ажилласан байна. | төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх Ажлын хэсэг байгуулагдсан.<br>Ажлын хэсгийн хурал 2 удаа зохион байгуулагдаж, 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр төлөвлөлтийн байршлын газар дээр ажилласан.<br>Тус ажлын хэсгийн гишүүдийн төлөөллийг оролцуулсан БНСУ-ын төр, захиргааны байгууллага, төрийн албадыг орон нутаг руу шилжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, туршлагатай газар дээр нь очиж танилцах сургалтыг 2025.05.18-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан ЗГХЭГ-аас чиглэл хүлээгдэж, түр хойшлогдоод байна. | |
| 2.1.31. | "20 минутын хот" буюу нийгмийн үйлчилгээний хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлогын баримт бичгийг боловсруулна. | -“20 минутын хот үзэл баримтлал”-ын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан байна.<br>-20 минутын хөгжлийн төвийн дотоод бүтцийн нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн батлуулсан байна.<br>- Төвийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг батлуулсан байна.<br>-Төвийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайланг хэлэлцсэн байна. | “20 минутын хот” хөгжлийн төвөөс боловсруулсан “20 минутын хот үзэл баримтлал” -ын төсөл, үзэл баримтлал батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг хянан дахин боловсруулж, “20 минутын хот үзэл баримтлал батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг ХЗДХ-ийн сайдаар батлуулахаар 2025.10.24-ний өдрийн 01/3977 тоот албан бичгээр хүргүүлсэн. ХЗДХЯ-аас 2025.11.10-ны өдрийн 01/2136 албан бичгээр “20 минутын хот үзэл баримтлал батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8.2 дахь заалтын дагуу буцаан чиглэл өгөгдсөн чиглэлийн дагуу “20 минутын хот үзэл баримтлал батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох танилцуулгын хамт боловсруулж 2025.11.28-ны өдрийн 01/4383 тоот албан бичгээр ЗГ-ын гишүүдээс санал авахаар хүргүүлсэн.<br>Үзэл баримтлалыг ЗГ-ын 2025.12.----ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>ТНБД-ын 2025 оны 222 дугаар тушаалын дагуу “20 минутын хот хөгжлийн төв”-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, санал зөвлөмжийн хүрээнд хөгжлийн төвийн бүтэц, орон тооны асуудлыг судлан үзэж, “Хот байгуулалт хөгжлийн төв” болгон өөрчлөх Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч, Засгийн газрын | 95 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал хүргүүлсэн. | |
| 2.1.32. | Автомашингүй гудамж бий болгох, явган хүний дугуй зам байгуулж, авто зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | Гэрээний дагуу үе шатны тайлангуудыг хүлээн авсан байна. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2025.06.25-ны өдрийн хууль, Засгийн газрын 2025.07.09-ний өдрийн 22 дугаар тогтоолын дагуу дараах гэрээт ажлууд шилжин ирж гэрээг байгуулан захиалгчийн хяналтыг ХББОС-ын сайдын 2025 оны 204 дүгээр тушаалаар "БХТ" ТӨААТҮГ, "20 минутын хот хөгжлийн төв"-өөр дамжуулан хэрэгжүүлж байна. Үүнд:<br>1) "Авто машингүй гудамж-авто зогсоолын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв" ажлыг "Татах хүч" ХХК-тай 2025.09.04-ний өдөр байгуулсан 2025/283 дугаарт гэрээ;<br>2) "Явган хүн, энгийн болон цахилгаан хөдөлгүүрт дугуй зам, байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв" ажлыг "ТГТ" ХХК-тай 2025.09.04-ний өдрийн 2025/284-2025/287 дугаар 4 багц гэрээ.<br>Тус гэрээт ажлуудын эхлэлийн тайлан, түүнд хийсэн захиалагчийн хяналтын дүгнэлтийг хүлээн авч дүгнэж байна. | 100 |
| 2.1.33. | "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-ын төслийг шинэчлэн боловсруулна. | Журмын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна. | БХБ-ын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар баталсан "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, журмын төслийг батлах тухай ХББОС-ын сайдын тушаалын төслийг боловсруулж, ХББОС-ын сайдын 2025 оны 01/1751 дүгээр албан бичгээр нийслэлийн Засаг даргад, 02/2964 дугаар албан бичгээр нийслэл болон аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, 02/2967 дугаар албан бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл, ГЗБГЗЗЕГ, ТОСК зэрэг байгууллагад тус тус хүргүүлэн санал авч, журам, тушаалын төслийг эцэслэн боловсруулсан.<br>Нийслэлийн ЗДТГ-аас Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар баталсан "Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам"-ыг бүхэлд нь шинэчлэн боловсруулах санал гаргасны дагуу холбогдох саналыг ирүүлэх тухай яамны 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 02/4227 дугаар албан | 85 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | бичгийг нийслэлийн Засаг даргад хүргүүлээд байна. | |
| 2.1.34. | "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын төслийг шинэчлэн боловсруулна. | Журмын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулсан байна.. | БХБ-ын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар баталсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, журмын төслийг батлах тухай ХББОС-ын сайдын тушаалын төслийг боловсруулж, ХББОС-ын сайдын 2025 оны 01/1751 дүгээр албан бичгээр нийслэлийн Засаг даргад, 02/2964 дугаар албан бичгээр нийслэл болон аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, 02/2967 дугаар албан бичгээр Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл, ГЗБГЗЗЕГ, ТОСК зэрэг байгууллагад тус тус хүргүүлэн санал авч, журам, тушаалын төслийг эцэслэн боловсруулсан.<br>Нийслэлийн ЗДТГ-аас Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар баталсан "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ыг бүхэлд нь шинэчлэн боловсруулах санал гаргасны дагуу холбогдох саналыг ирүүлэх тухай яамны 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 02/4227 дугаар албан бичгийг нийслэлийн Засаг даргад хүргүүлээд байна | 85 |
| 2.1.35. | Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийг хэрэгжүүлэх, инженерийн шугам сүлжээг төлөвлөн барихад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.<br>**МУЗГҮАХХАХТ-1.1.3.4.** | Нийслэл, орон нутагт хот дахин төлөвлөлтийн төслүүдийн инженерийн шугам сүлжээг төлөвлөн барих үйл ажиллагааны мэдээ, тайланг нэгтгэсэн байна.<br><br>-Өгөгдөл мэдээллийг бүрдүүлж, хот байгуулалтын кадастрын цахим системд оруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. | 1. Улсын хэмжээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсэд инженерийн дэд бүтэц төлөвлөх ажлын хүрээнд орон нутаг төсөвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 9 төсөл арга хэмжээнүүдийн биелэлтийн тайлан, танилцуулгыг улирал бүр гарган ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа Хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах 5, Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах 121, Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих 87 төслүүд, нийслэлийн Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах 35 төслийн хэсэгчилсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, тэдгээрийн тоон мэдээ мэдээллийг авч нэгтгэн дүгнэж Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хуулийн шинэчилсэн найруулгын | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ажлын хэсэг, хуулийн төслийн багт 2025.11.07-ны өдөр танилцуулж мэдээлэлийг хүргүүлэн ажилласан.<br>2. ХБКС-ийн хөгжүүлэлтийн үр дүнд Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн 80 бүс, аймгуудын ГХБХБГ-тай хамтран орон нутагт Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу дахин төлөвлөлт хийхээр орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан 5 төрлийн төслүүдийн байршлуудыг оруулаад байна.<br>Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалтай нийслэлийн хэмжээний 378 барилгыг мэдээлэл оруулах эрхийн тохируулга хийх тухай хүсэлтийг ГЗБГЗЗЕГ-т 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр 02/4135 дугаарт албан бичгээр хүргүүлэн өгөгдөл дата мэдээллийг бүрдүүлж байна. | |
| 2.1.36. | Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн инженерийн хангамж бүхий орон сууцны нийлүүлэлтийн чиг хандлагын судалгаа хийх ажлыг зохион байгуулна.<br>**МУЗГҮАХХАХТ-1.1.3.4, 1.1.3.6** | Судалгааны ажлын тайланг хүлээн авч, гэрээг дүгнэсэн байна. | "Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн инженерийн хангамж бүхий орон сууцны нийлүүлэлтийн чиг хандлагын судалгаа"-ны ажлын 2024/268 дугаар гэрээт ажлыг гүйцэтгэгч "Тэнхлэг зууч" ХХК-аас ирүүлсэн эцсийн тайланг 2025.06.06-ны өдөр хүлээн авч дүгнэн, 2025.06.13-ны өдөр гэрээг дүгнэн актаар хүлээн авсан. | 100 |

Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4-т заасан аргачлалаар бодсон бөгөөд Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 2.4.1, 2.4.2, 2.4.3 дахь заалтын дагуу боловсруулаагүй арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг арга хэмжээнд илүү холбоотой байх "шалгуур үзүүлэлт", "зорилтод түвшин"-ийн аль нэгээр тооцож гаргасан болно.

Хэд хэдэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдсон арга хэмжээний биелэлтийн хувийг тодорхойлохдоо шалгуур үзүүлэлт бүрийн хэрэгжилтийг гарган тэдгээрийн архметик дундажаах тооцож үнэлэв.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 55 арга хэмжээнээс жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 70 хүртэл хувьтай "Хангалтгүй" хэрэгжсэн 3 арга хэмжээнүүд байна. Үүнд:

1. 2.1.4. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн баримт бичиг боловсруулах ажлыг зохион байгуулна.
2. 2.1.9. Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах ажлыг ЭЗХЯ, Орхон аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулна,

3. 2.1.29. Тогтвортой, ухаалаг хотын үзүүлэлтийн батлагдсан стандартыг нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ:

1. Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 98.0 хувьтай үнэлж ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд "Бүрэн хангалттай" буюу 93.4 хувьтай үнэлэгдэж байна.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасан арга хэмжээний 30% нь шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтод түвшин нь хоорондоо утга, илэрхийлэл зөрүүтэй, суурь түвшнээс ямар хэмжээнд нэмэгдүүлэх, ямар үр дүнд хүрэх нь тодорхойгүй, оновчтой тусгаагүй.

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн тайлагнахдаа хэт нуршуу, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаагүй 5 арга хэмжээ

4. Шалгуур үзүүлэлтээр "Ажлын хэсэг", "тайлан" гэх мэт тодорхойлогдсон ажлууд нь үр дүнд хүрэх ажилбарууд байна.

5. Үр дүнг үнэлэхэд "хот байгуулалтын баримт бичиг боловсруулах даалгаварт тусган батлуулсан" гэх 2.1.18, 2.1.19, 2.1.26 арга хэмжээнүүд байгаа бөгөөд эдгээр арга хэмжээнүүдийг нэг биш тус тусдаа албан хаагчил хариуцсан байгаа бөгөөд зургийн даалгаварт тусгагдсан зорилт нь хэрхэн хэрэгжсэн нь тодорхойгүй байна.

6. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.21, 2.1.35 дахь арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг арга хэмжээтэйгээ уялдаа, холбоогүй тодорхойлсон.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө төлөвлөхдөө хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хагас, бүтэн жилээр төлөвлөж, хүрэх буюу зорилтот түвшин, суурь түвшинийг хэмжиж болохуйц тоогоор илэрхийлж, төлөвлөгөөндөө тусгах;

2. Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг зоорилт, арга хэмжээтэй уялдаа холбоотойгоор тодорхойлж төлөвлөх

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний "Хангалтгүй" гэж үнэлэгдсэн 2.1.9, 2.1.29 заалтуудын биелэлтийг хангах;

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ нь бүрэн дуусаагүй, цаашид үргэлжлүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дахин тусгаж хэрэгжилтийг бүрэн хангуулах арга хэмжээг авах

5. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.10, 2.1.18, 2.1.19 дахь арга хэмжээнүүдийг нэгтгэн үр дүнд хүрэхээр шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хүрэх түвшинг тоон утгаар оруулах,

6. Тус газар нь дахин гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг оновчтой тусган, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаж байх;

7. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хариуцан гаргаж байгаа албан хаагчдын ажлын чиг үүргийг давхардуулахгүйгээр оновчтой хуваарьлах.

8. "Хот байгуулалтын цахим кадастрын цахим систем" болон "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-ийн үйл ажиллагааг сайжруулахад

2026 онд илүү анхаарч тодорхой ажил төлөвлөн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах,

9. Газрын дарга албан хаагчдын хэвийн ажиллах нөхцлийг хангах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээ авах,

10. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ өгөх, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах аргачлал, зааварыг гарган аймаг, нийслэлийн ерөнхий архитекторт, орон нутгийн хот байгуулалт, барилгын асуудал хариуцсан төрийн байгууллагуудад чиглэл өгөх шаардлагатай байна.

Тайланг хянасан:

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — Б.Найрамдал

Боловсруулсан:

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын Хот байгуулалт, орон сууцны бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — Б.Одбаатар

ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

# НИЙТИЙН АЖ АХУЙ, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 он

ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025.12.17

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримталсан.

## Хоёр. Танилцуулга

Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус газраас ирүүлсэн төлөвлөгөө, тайлангийн биелэлтийг үндсэн материал болгон ашигласан.

## Гурав. Хяналт-шинжилгээний ажлын үнэлгээ

Тус газар нь 2025 онд 4 зорилтын 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 92,9 хувьтай буюу "бүрэн хангалттай" үнэлэв. Үүнд: 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 26 арга хэмжээ, 70-85% хүртэлх хэрэгжсэн 1 арга хэмжээ, 70 хүртэлх хэрэгжсэн 3 арга хэмжээ, хугацаа болоогүй /ХБ/ 0, арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээний биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1, хүснэгт-1.1-д тус тус үзүүлэв.

*Хүснэгт-1*

| № | Ажил үйлчилгээ | Зорилт | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэл | | | ХБ | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 85-аас дээш хувьтай | 70-85% хүртэлх | 70 хүртэлх | | |
| 1 | Нийт арга хэмжээ | 4 | 30 | 26 | 1 | 3 | - | **92.9** |

*Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:*

Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт

| **Д/Д** | **Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж** | **Зорилтот түвшин** | **Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол тайлбар/** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|---|

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Стратегийн зорилт 4. Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, зохицуулалтаар хангах, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, салбарын хууль тогтоомж, бодлого, зохицуулалт, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсронгуй болгох, төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах.** | | | | |
| **Зорилт 4.1.нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журмыг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.** | | | | |
| 4.1.1 | 21 аймаг болон эрсдэлтэй хот, суурин газарт үерийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг бодлого зохицуулалтаар хангана. (ЗГҮАХ-2.4.3.5) | 8 | 1.ХББОС-ын сайдын 2025 оны “Шар усны болон уруйн, хур борооны үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах тухай” 02 дугаар албан даалгаврыг 2025.02.18-ны өдөр шинэчлэн баталж, хэрэгжилтийг тус яамы СХШҮДАГ-тай хамтран нийслэл болон 21 аймгийн хэмжээнд хянан ажилласан. Уг албан даалгаврын 1.2-т ИБАХ-ний мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах талаар тусгагдсан.<br>2. Уг ажилтай холбоотой ГЭБҮЗ-ийн 2024 оны 01 дүгээр зөвлөмжийн 2.4-т туссан арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн 21 аймагт ИБАХ-ний мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах үүднээс “Дэмжлэг хүсэх, хамтран ажиллах тухай” 2025.05.15-ны өдрийн 01/1797 дугаар албан бичгийг ГЭБҮЗ-д хүргүүлсэн. ГЭБҮЗ нь ГЭБ орон нутгийн зөвлөлийн дарга нарт холбогдох чиглэлийг 2025.08.14-ний өдрийн 3/27 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>3. Уг арга хэмжээний ач холбогдлыг ойлгуулах, хамтран ажиллах үүднээс 2025.06.19-20-ний өдрүүдэд ГЭБҮЗ, ОБЕГ, ГЗБГЗЗЕГ-тай хамтран “Үерийн эрсдийн үнэлгээ хийх” сургалтыг 2025.06 сарын 19, 20-ны өдрүүдэд цахимаар, нийт 11 сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Сургалтад нийт 53 байгууллагын асуудал хариуцсан албан хаагч, мэргэжилтэн оролцосон болно.<br>4. Баян-Өлгий аймгийн Засаг даргаас тус яамнаас өгсөн чиглэлийн дагуу “Баян-Өлгийн аймгийн Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулан ажлын даалгавар”-ыг 2024.12.30-ны өдрийн 1-01/1715 дугаар албан бичгээр батлагдсан Ажлын далагврыг ирүүлсэн. Тус ажжлын даалгавартай холбогдох материалыг шаардсан 2025.03.20-ны өдрийн 01/977 дугаартай албан тоотыг хүргүүлсэн.<br>6. Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8.1 дүгээр заалтын дагуу 21 аймгийн Ерөнхий архитекторуудад Инженерийн бэлтгэл ажилд хийсэн хяналтын тайланг ирүүлэх, тус яамнаа 2024 оны 401 дугаартай албан бичгээр хүргүүлсэн Ажлын даалгаврын төслийг яаралтай баталж ирүүлэх чиглэлийг 2025.12.03-ны өдрийн 01/4477 дугаар албан бичгээр хүргүүлсэн. . Үүний дагуу дараах 7 аймаг ажлын даалгавараа баталж ирүүлсэн. Үүнд:<br>- Говь-Алтай /2025.12.08, 0002/25 дугаартай/;<br>- Говьсүмбэр /2025.12.10, 01 дугаартай/;<br>- Дорноговь /2025.12.10, 11/25 дугаартай/;<br>- Өвөрхангай /2025.12.02, 01 дугаартай/;<br>-Сүхбаатар /205.12.08, 043/ЗД-2025 дугаартай/;<br>- Сэлэнгэ /2025.12.08, 01 дугаартай/;<br>- Хэнтий /2025.12.10, ЗД-2025/021 | 87.5 |
| 4.1.2 | Улаанбаатар хотын Төв цэвэрлэх | 100 | ХББОСЯ-ны ТНБД-ын 2025.05.22-ны өдрийн А/93 дугаар тушаалаар “Лагийн менежментийн урт | 86.1 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгууламжийн лагийг хатаах, шатаах байгууламжийн ТЭЗҮ, лагийн урт хугацааны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. (ЗГҮАХ-2.4.3.3) | 90 | хугацааны төлөвлөгөө" боловсруулах ажилд санал, дүгнэлт өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.<br>ХББОСЯ, ММС-ийн захиалгаар "Лагийн урт хугацааны менежментийн төлөвлөгөө боловсруулах, лаг боловсруулах технологиудын харьцуулсан судалгаа гүйцэтгэх, урьдчилсан ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ"-г АНУ-ын Хэйзэн энд Сойер компани хэрэгжүүлж байна.<br>Зөвлөх байгууллагаас лаг хатаах, шатаах байгууламжийн харьцуулсан судалгааны дүнг ажлын хэсгийн хуралд танилцуулсан.<br>Улаанбаатар хотын лагийн урт хугацааны менежментийн төлөвлөгөөг (2026-2030) боловсруулах ажил үргэлжлэн хийгдэж байна.<br>ХББОС-ын сайдын 2025.09.26-ны өдрийн "Санхүүжүүлэлт шийдвэрлүүлэх тухай" 01/3639 дугээр албан бичгээр цэвэрлэх байгууламжийн хаягдал лаг болон ахуйн хог хаягдал шатаах цогцолбор байгууламж барих төслийн санхүүжүүлэлтийг шийдвэрлэж өгөх талаар саналыг СЯ-нд хүргүүлсэн. | |
| 4.1.3 | "Ус хангамж. Барилгын гадна систем ба ус хангамжийн ерөнхий шаардлага" стандартын төслийг боловсруулна.<br>(ЗГҮАХ-2.4.3.2) | 100 | "Ус хангамж. Барилгын гадна систем ба ус хангамжийн ерөнхий шаардлага" стандартыг боловсруулах 2024/16 дугаартай ажлын техникийн даалгаврыг ХББОСЯ-ны ТНБД-ын 2024.12.17-ны өдөр батлуулж, 2024.12.18-ны өдрийн 07/1838 дугаартай "Техникийн даалгавар хүргүүлэх тухай" албан бичгээр БХТ-д хүргүүлсэн.<br>БХТ-ийн захирлын 2025.09.08-ны өдрийн А/481 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, 2025.09.11-ны өдөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчээр "Монголын ус сувгийн ассоциаци" НҮТББ шалгаруулж, 2025.10.01-ний өдрийн 2025/178 дугаар гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч стандартын төслийг боловрсуулах ажлын эхний тайланг ирүүлсэн ба холбогдох газруудаас санал авах ажлыг БХТ зохион байгуулан ажиллаж байна.<br>Гэрээний үнийн дүн: 35,575.600 төгрөг<br>Гэрээний дуусах хугацаа: 2026.12.20 | 44.4 |
| 4.1.4 | 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 6-р хэсэг: Септик танкны бохир ус цэвэрлэгээнд зориулсан угсармал цэвэрлэгээний байгууламж /төхөөрөмж/" стандартын төслийг боловсруулна.<br>(ЗГҮАХ-2.4.3.2) | 50 | ХББОСЯ-ны ТНБД-аар 2024.12.17-ны өдөр стандартыг боловсруулах 2024/15 дугаартай ажлын техникийн даалгаврыг батлуулж, 2024.12.18-ны өдрийн 07/1838 дугаартай "Техникийн даалгавар хүргүүлэх тухай" албан бичгийг БХТ-д хүргүүлсэн.<br>Барилгын хөгжлийн төвийн захирлын 2025.09.08-ны өдрийн А/481 дугаар тушаалаар үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг 2025.09.11-ны өдөр зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Монголын ус сувгийн ассоциаци" НҮТББ шалгарсан ба 2025.10.01-ний өдөр 2025/177 дугаар гэрээ байгуулагдсан. Гүйцэтгэгч стандартын төслийг боловрсуулах ажлын эхний тайланг 2025.10.13-ны өдөр ирүүлсэн ба холбогдох газруудаас санал авах ажлыг БХТ зохион байгуулан ажиллаж байна.<br>Гэрээний үнийн дүн: 14,600,000.0 төгрөг, Гэрээний хугацаа: 2026.12.20 | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | |
| 4.1.5 | 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 7-р хэсэг: Гүн цэвэрлэгээний угсармал байгууламж /төхөөрөмж/" стандартын төслийг боловсруулна. (ЗГҮАХ-2.4.3.2) | 50 | ХББОСЯ-ны ТНБД-ын 2024.12.17-ны өдрийн 2024/17 дугаар стандартыг боловсруулах ажлын техникийн даалгавар баталсан.<br>ХББОСЯ-ны 2024.12.18-ны өдрийн 07/1838 дугаартай "Техникийн даалгавар хүргүүлэх тухай" албан бичгийг БХТөвд хүргүүлсэн.<br>Стандартын гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар 2025.05.30-ны өдөр barilga.gov.mn-д зар байршуулсан бөгөөд гүйцэтгэгч шалгараагүй тул 2025.08.19-нд байгууллагын вэб хуудсанд байршуулсан. Уг зарлалын дагуу 2 байгууллага материалаа ирүүлснээс "Ногоон сууц" ТББ шалгарсан. Барилгын хөгжлийн төвийн захирлын 2025 оны А/32 дугаар журмын хавсралт №3-ын дагуу "Шууд худалдан авалтын зөвшөөрлийн хуудас"-аар "Ногоон сууц" ТББ-тай 2025.09.15-ны өдрийн 2025/165 дугаартай гэрээг байгуулсан.. Гүйцэтгэгч стандартын төслийг боловрсуулах ажлын эхний тайланг 2025.10.13-ны өдөр ирүүлсэн ба холбогдох газруудаас санал авах ажлыг БХТ зохион байгуулан ажиллаж байна.<br>Гэрээний үнийн дүн: 14,307,075.0 төгрөг, Гэрээний хугацаа: 2026.11.20 | 100 |
| 4.1.6 | Усны барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулна. | 3<br>3<br>1 | 1. 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03/130 дугаартай албан 3 төрлийн ТД-ын төслийг боловсруулж ирүүлэх чиглэлийг мэргэжлийн холбоодод хүргүүлсний дагуу<br>"Цэнхэр алт ногоон хэрэм" Монголын Үндэсний усны ассоциаци НҮТББ нь 2025<br>оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 005/2025 дугаартай албан бичгээр төслүүдийг<br>ирүүлснийг БХТ ТӨААТҮГ-ын ННХ-т 2025.03.12-ны өдрийн 07/877 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн ББННС-ыйн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний санал тусган ББМБЗГ-т хүргүүлсэн.<br>2. "Барилга байгууламжийн норм, нормативын сан"-гийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний 3-р хавсралтын 25, 28-д тусгагдсан дараах ТД-ыг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 13/2025, 14/2025 дугаартай тус тус батлуулсан. Үүнд:<br>-"Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам" /БНбД 33-01-03/ барилгын норм ба дүрмийг шинэчлэн "Усны барилга байгууламжийн зураг | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | төсөл төлөвлөх” барилгын дүрэм болгон боловсруулах ажлын техникийн даалгавар /13/2025/;<br>-“Голын гидротехникийн барилга байгууламж” /БНбД 33-03-05/ барилгын норм ба дүрмийг шинэчлэн барилгын дүрэм болгон боловсруулах ажлын техникийн даалгаварыг БХТ ТӨААТҮГ-т 2025.09.16 № 06/3452 дугаартай албан бичгээр;<br>3. “Барилга байгууламжийн норм, нормативын сан”-гийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний 3-р хавсралтын 23-т тусгагдсан “Усны барилгын төсвийн суурь норм” БД 81-33-10 шинэчлэх ажлын ТД-ийн төслийг тус яамны 2025.03.12-ны өдрийн 07/877 дугаар албан бичгээр БХТ ТӨААТҮГ-т хүргүүлсэн. Тус газраас барилга, сантехник, цахилгаан, холбоо дохиололын ажлын төсвийн суурь норм, засварын ажлын төсвийн суурь нормын 32 эмхэтгэлүүдийг шинэчлэх ажилтай давхцаж байгаа тул төлөвлөгөөнөөс хасуулах саналтай байгаагаа мэдэгдсэн. Албан бичгээр хариу ирүүлээгүй байгаа.<br>4. “Усны барилга байгууламжийн угсармал төмөр бетон бүтээцийн нэг маягийн цомог /альбом/, эргийн бэхэлгээ, далангийн налуу, сувгийн доторлогоо бэхэлгээний хавтангийн нэг маягийн цомог /альбом-1,2,3/ шинээр боловсруулах ажлын төслийг цахим системд байршуулж холбогдох 15 байгууллагууд руу санал авахаар БХТ ТӨҮГ газраас 2025.05.15-ны өдөр 01/1100 дугаартай албан бичиг хүргүүлсэн /Гэрээ №: 2024/191, төсөлд хянан тохиолдуулга /2025.07.25-ны өдөр Р-35/2025/, шүүмж /2025.07.24-ний өдөр Ш-31/2025/ хийлгэх ажил хийгдэж, 2025.09.08-ны өдөр гэрээ дүгнэсэн актыг баталгаажсан. Хянан тохиолдуулга, шүүмжийн саналын дагуу төслийг засаж, холбогдох ОТБ мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр 2025.11.12-ны өдөр хүргүүлсэн.<br>Гүйцэтгэгч: Хайдродизайн прожект<br>Эхлэх огноо: 2024-12-03<br>Дуусах огноо: 2025-12-31/<br>5. “Гадаргын усны үзүүлэлт” БНбД 33-11-25 барилгын норм, дүрмийг эрх зүйн актын системд бүртгүүлсэн. | |
| 4.1.7 | Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний санал боловсруулна. | 2/100 | Монгол Улсын 2026 оны төсвийн хязгаарын саналд:<br>- **Хөрөнгө оруулалт:** нийт 99,393,6 сая төгрөгийн төсөв өртөг бүхий 67,598.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 40 төсөл, арга хэмээ<br>- **Урсгал зардал:** нийт 2,310,0 сая төгрөгийн дүнтэй 10 арга хэмжээ<br>тус тус тусгаж, Санхүү, хөрөнгө оруулалтын газарт дотоод бичгээр хүргүүлсэн.<br>Сангийн сайдын 2023 оны 137 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу 2026 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийг урьдчилсан үнэлгээний PIMIS системд оруулах ажлын хүрээнд инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн /өргөтгөл/ 18, их засварын 3, ТЭЗҮ-гийн 16, тоног төхөөрөмжийн 1, нийт 148.2 тэрбум төсөвт өртөг бүхий, 70.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 38 төсөл, арга хэмжээний ажлын саналыг тусгуулах ажлыг зохион байгуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | ХББОС-ын сайдын 2025.07.25-ны өдрийн “2026 оны төсвийн төсөл хүргүүлэх тухай” 01/2780 дугаар албан бичгээр Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгах нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, хүргүүлэн ажилласан. | |
| 4.1.8 | Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | 1/100 | ХББОС-ын сайдын 2025.03.07-ны өдрийн 01/841 дүгээр албан бичгээр “Засгийн газрын хуралдаанд төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах тухай” албан бичгийг ЗГХЭГ-т хүргүүлж, “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Засгийн газрын 2025.04.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>Засгийн газрын 2025.04.02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл албажсан.<br>ХББОС-ын сайдын 2024.09.24-ний өдрийн 52 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын 53 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд заасны дагуу "Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах ажлын хэсгийн өргөтгөсөн хурлыг 2025.04.03-ны өдөр "Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн талбайд зохион байгуулсан. Хуралд ХББОСЯ, ЭМЯ, НЗДТГ, НБОГ, НХБХСГ, ХСУХАТАУЗХ, GIZ, ОСНААУГ, БХТ, УСУГ, УБ хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн нэгж, Усны газар, Туул голын сав газрын захиргаа, Төвийн бүсийн хүнс, хөнгөн үйлдвэрлэл технологийн цогцолбор ТӨХХК, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК, Жайка, Монголын Мянганы сорилтын сан, МСК, ҮАГ, Хэвлэлийн хүрээлэн, Экобиотех ХХК, Монос хүнс ХК зэрэг 22 байгууллагын 50 хүн оролцсон.<br>Засгийн газрын 2025.04.02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах талаар Сангийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, БОУАӨ-ийн сайд, ХХААХҮ-ийн сайд нарт хандан ХББОС-ын сайдын 2025.04.14-ний өдрийн 01/1313, 01/1316, 01/1315, 01/1314 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.<br>БОУАӨ-ийн сайд, ХББОС-ын сайдын 2025.09.03-ны өдрийн А/705, А/205 дугаар “Хаягдал усанд агуулагдах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай” хамтарсан тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу ХЗДХЯ-аас хянаад захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7360 дугаарт бүртгэсэн.<br>Шинэ нэгж байгуулах талаар Засгийн газрын тогтоолын төсөлд санал бэлтгэн, ХББОС-ын сайдын 2025.10.24-ний өдрийн 01/3958 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| 4.1.9 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан Орон нутгийн хөгжлийн 91 төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн судалгаа хийж, эрэмблэн цаашид | 1/100<br><br>1/100 | 21 аймаг, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас тухайн нутаг дэвсгэр дэх хүн амыг ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар тэгш, хүртээмжтэй хангаж буй талаар нэгдсэн судалгааг авч, боловсруулсан.<br>ХББОСайдын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Засгийн газрын хуралдаанаар асуудал танилцуулах тухай” 01/4564 дугаар албан бичгээр хүн амыг ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар тэгш хангах, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | | хүртээмжийн ялгааг бууруулах зорилгоор улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах арга хэмжээний саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн | |
| 4.1.10 | Хот, суурины хүн амын ундны ус хангамжид гадаргын болон гүний усны холимог эх үүсвэрийг ашиглах, саарал усыг цэвэрлэн дахин ашиглах төслийн санал боловсруулж, холбогдох байгууллагад уламжлах | 1/100 | Хот, суурины хүн амын ундны ус хангамж, цэвэрлэсэн усыг дахин ашиглах чиглэлээр Техник туслалцааны төслийг Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж, цаашдын хамтын ажиллагаагаа эхлүүлэх хүсэлтийг ХББОСЯ-ны 2025.05.26-ны өдрийн 03/2007 дугаартай албан бичгээр Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчид хүргүүлсэн.<br>Төслийн саналыг нэгтгэн боловсруулж, Дэлхийн банканд 2025.10.01-нд adavaajargal@worldbank.org цахим хаягаар хүргүүлсэн. | 100 |
| **Зорилт 4.2. хот, тосгон, суурин газарт ус хангамж, ариутгах татуурга, халаалтын шугам сүлжээ, эх үүсвэр, цэвэрлэх байгууламж, төвлөрсөн болон хэсэгчилсэн инженерийн хангамжийн системийг төлөвлөх, байгуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулалтаар хангах.** | | | | |
| 4.2.1 | Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ.<br><br>(МУХТЖҮЧ-4.2.7, 9.3.3, МУХ2025 оны Т-2.3.2.6, ЗГҮАХ-2.4.3.4, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 14.1.1, “ШСБ”-ыг хэрэгжүүлэх ҮАХ-ийн 4.2.7, 4.3.2, 4.3.3, Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөний 3.3.1) | 25 | Засгийн газрын 2025.01.14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр Бүсийн зөвлөлүүдийг байгуулж, 2025 оны II улиралд багтаан бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулах болсны дагуу 2025.04.14-ний өдөр Хангайн бүс, 2025.04.28-ний өдөр Хойд бүс, 2025.05.12-ны өдөр Говийн бүсийн өргөтгөсөн хуралдаан болж, уг Засгийн газрын хуралдаанд орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын 2025 оны 181, 182, 204, 209 дугаар тогтоолуудад салбарыг асуудлыг тусгуулсан.<br>ХББОС-ын сайдын 2025.04.29-ны өдрийн 91 дүгээр тушаалаар нийслэлийн 3 дүүрэг, 10 аймаг 19 суманд инженерийн дэд бүтцийн нийт 22 ажил баталсан. Эдгээрээс орон нутгийн хөгжлийн төвүүдэд 2025-2027 онд нийт 167,485.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. 2025 онд хэрэгжих инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хүрээнд 41,551.4 тэрбум төгрөгийн санхүүжилттэй 22 ажилд гүйцэтгэгч шалгарч, гэрээний нийт хэрэгжилт 28%-д хүрээд байна.<br>Тухайн оны гүйцэтгэл -100%. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.2.2 | Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барьж, ашиглалтад оруулна.<br><br>(МУХТЖҮЧ-9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 14.1.1, “ШСБ”-ыг хэрэгжүүлэх ҮАХ-ийн 4.2.7, 4.3.2, 4.3.3, Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөний 3.3.1) | 98 | МУЗГ, АНУ-ын Мянганы сорилтын корпорац хооронд 2018.07.27-ны өдөр байгуулсан Мянганы сорилтын хоёр дахь компакт гэрээ (Компакт гэрээ)-ний хүрээнд хэрэгжиж буй<br>Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц 99.9% хувьтай хэрэгжиж, туршилт тохируулгын ажил хүлээгдэж байна.<br>“Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилттэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд тусгах саналыг боловсруулан ХББОС-ын сайдын 2025.09.23-ны өдрийн 01/3612 дугаар албан бичгээр СЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 4.2.3 | Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлнэ.<br><br>(МУХТЖҮЧ-9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 14.1.1, “ШСБ”-ыг хэрэгжүүлэх ҮАХ-ийн 4.2.7, 4.3.2, 4.3.3, Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөний 3.3.1) | 100 | Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төслийн хүрээнд 17 байршлын 13,3 км хоолойн шинэчллэлийн угсралтын ажил бүрэн дууссан бөгөөд барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комисс ажиллах бэлтгэл ажлыг хангаж ХББОС-ын сайдын 2025.11.11-ний өдрийн 01/4162 дугаар албан бичгээр Дархан-Уул аймгийн Засаг даргад Улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүргүүлсэн.<br>Мөн 15000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур, холбох хэрэгсэл болон 17 ширхэг Гэйтвэй антенн авч, суурилуулахаас нийт 10000 ширхэг тоолуур, 17 ширхэг Гэйтвэй антенн суурилуулсан.<br>3-р ээлжийн 5000 ширхэг цэвэр усны ухаалаг тоолуур суурилуулах ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангаад байна. | 78.7 |
| 4.2.4 | Сумын хөгжил инженерийн дэд бүтцийн төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 25 | “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын 2021.06.01-ний өдрийн 161 дүгээр тогтоолоор батлагдан хэрэгжиж байна.<br>Төслийн хүрээнд нийт 13 суманд инженерийн дэд бүтцийн хангамжийн барилга байгууламжийг шинэчлэн барьж байгуулах ажлыг гүйцэтгэж байна. Ажлын | 94.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | (МУХТЖҮЧ-8.1.10, МУХ2025 оны Т-2.3.2.6, ЗГҮАХ-2.4.3.4, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 14.1.1, ЗГ-ын 2023 оны 483-р тогтоолын 2.9 дэх заалт, "ШСБ"-ыг хэрэгжүүлэх ҮАХ-ийн 4.2.7, 4.3.2, 4.3.3) | | гүйцэтгэл 2025 оны 12 дугаар сарын байдлаар 7 төсөл арга хэмжээнд Улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад хүлээн авсан. (Дорнод- Дашбалбар; Өвөрхангай-Хужирт, Төв-Борнуур, Төв-Дэлгэрхаан, Төв-Сэргэлэн, Төв-Эрдэнэ, Хэнтий-Дэлгэрхаан), мөн 4 төсөл арга хэмжээ (Архангай-Ихтамир, Дундговь-Луус, ГовьАлтай-Алтай, Өвөрхангай-БатӨлзий, )-ын улсын комисс ажиллуулахаар хүсэлт хүргүүлсэн бөгөөд 2 ажил гэрээ сунгуулахаар хүлээгдэж байна. Үүнд:<br>• Өвөрхангай аймгийн Уянга сум – 80 хувийн гүйцэтгэлтэй,<br>• Төв аймгийн Баянчандмань сум – 90 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 4.2.5 | Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ. (Улаанбаатар, Дорнод, Завхан, Баян-Өлгий, Увс, Говьсүмбэр, Орхон, Говь-Алтай )<br>(АХ-6.4.22, МУХТЖҮЧ-8.1.8, ЗГҮАХ-3.4.3.4, "ШСБ"-ыг хэрэгжүүлэх ҮАХ-ийн 4.2.7, 4.3.2, 4.3.3, ЗГ-ын 2017 оны 98-р тогтоолын 4.2.8, Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөний 2.3.4) | 5/100 | "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн барилга угсралт, цахилгаан хангамж, дэд станц, ус, дулааны шугам, УДДТ, холбооны шугам зэрэг дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний ажил бүрэн дууссан. Дэд бүтцийн ажлуудыг улсын комисс хүлээн авсан. Төслийн барилга угсралтын ажил 98%-тай, 2025.07.24-ний өдөр хаягдал усыг хүлээн авч туршилт тохируулгын ажлыг эхлүүлэн өдөрт 50000 м.куб усыг MNS 4349-2015 стандартад нийцүүлэн цэвэрлэж байна. Цэвэрлэх байгууламжийн хэмжээнд 2025.09.29-ний өдөр техникийн комисс ажиллуулж, 12 дугаар сарын 01-ний өдрийн 05/2025 дугаар техникийн комиссын дүгнэлтээр улсын комисс ажиллуулах хүсэлтийг захиалагчид тавих зүйтэй гэж дүгнэсэн. 2025 оны 12 сард багтаан ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулахаар төлөвлөж байна. Төслийн хэрэгжилт 98%-тай байна.<br><br>"Аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих" төслийн Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4200 м.куб/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга, байгууламжийг 2025.06.11-ний өдрийн ББКД-83-0011/25 дугаартай комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Хэрэгжилт: 100%<br>Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2000 м3/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025.12.01-ний өдөр ажилласан. Хэрэгжилт: 97.11%<br>Завхан аймгийн Улиастай сумын 3000 м3/хоног хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг баталж, комисс 2025.11.17-ны өдөр ажилласан. Хэрэгжилт: 97.04%<br>Увс аймгийн Засаг даргын 2025.11.19-ний өдрийн А/603 дугаар захирамжаар Увс аймгийн Улаангом суманд баригдсан хоногт 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг баталж, комисс 2025.11.20-ны өдөр ажилласан. Хэрэгжилт: 96.27% | 95.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Дорнод аймгийн 10,000 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлын зураг, төсөв Барилгын хөгжлийн төвийн 2025.09.02-ны өдрийн 1551/2025 дугаартай Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр батлагдсан. Хэрэгжилт - 33.3%-тай.<br><br>"Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт 3000м3/хоног /Говь-Алтай, Есөнбулаг сум/-ийн ажлыг “Сайн коншракшн” ХХК барилга, угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Хэрэгжилт: 15%<br>Засгийн газрын 2025.04.28-ны өдрийн 204 дүгээр “Хойд бүсийн хөгжлийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.2.8-д “Орхон аймгийн Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийг ашиглалтад оруулах ажлыг шуурхай зохион байгуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр нарт, тус өргөтгөлийн барилга байгууламжийг бүрэн дуусгах, туршилт, тохируулга хийх ажилд шаардлагатай санхүүжилтийг 2025 оны хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу шийдвэрлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Г.Ёндон)-т” гэж заасан. | |
| 4.2.6 | Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг шинээр барих төслийг хэрэгжүүлнэ. (МУХТЖҮЧ-9.3.3, Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөний 1.3.3) | 100 | Төслийн хаягдал ус хүлээн авах худгийн барилга-100%, шахуургын станц №1 99.9%, тогтворжуулах сан 99.6%, хөдөлгөөнт био реакторын байгууламж 99.2%, ламелла тунгаагуурын байгууламж 99.3%, ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилга-99.5%, халдваргүйжүүлэх сан-99.5%, шахуургын станц №2-99.5%, ус зайлуулах сангийн барилга-99.9%, хлор бэлтгэлийн барилга 98.3-тай. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр 2025.11.18-ны өдөр цэвэрлэсэн ус хүлээн авч, зүгшрүүлэх, туршилт, тохируулын ажлыг эхлүүлсэн.<br>ХББОСЯ-ны ТНБД-ын 2025.05.21-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар байгуулсан Засгийн газрын 2025 оны 6 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар болон УБ хотын шинээр баригдаж буй төв цэвэрлэх байгууламжийн төслийн ажлыг эрчимжүүлж, Компакт гэрээний урьдчилсан болзолт нөхцөлүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зүгшрүүлэх, туршилт, тохируулгыг эхлүүлэх, зохион байгуулах, төслүүдийн ажлын уялдаа холбоог хангах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан 7 хоног бүрийн 4 дэх өдөр тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн, төслийн ажлыг шуурхай явуулахад бүхий л талаар дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.<br>Төслийн хэрэгжилт 97.3%-тай. | 95.1 |
| 4.2.7 | Аймгийн төвүүдэд үерийн хамгаалалтын барилга, байгууламж барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга | 2 | 1. АХБ-ны “Хөшигийн хөндийд байгуулагдах даван туулах чадвартай, ногоон шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах төсөл (TA-10059 MON)”-ийн ТЭЗҮ-тэй танилцаж, 2 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцож Шинэ Зуунмод /Хүннүү хот/-ын үерийн хамгаалалтын 2 сувгийн хүрээнд хийгдсэн зөвлөхүүдийн саналыг судалж, хариуцсан асуудлынхаа хүрээнд холбогдох арга хэмжээг авч АХБ-ны санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зүйн зөвлөлгөө өгнө.<br><br>(АХ-4.2.8, 7.3.16) | | саналд тусгуулсан.<br>2. Улсын хэмжээнд 2025 онд нийт 30.6 км ҮХББ баригдсан болно. Үүнд:<br>1. Дархан-Уул, Дархан сум, 31-р хороолол/ - 5.4 км;<br>2. "Шинэ Зуунмод" Суваг-1-ийн 1,9 км хийгдсэн;<br>3. Нийслэлд:<br>- "Сэлбэ сэргэлт" төслийн хүрээнд БЗД-ийн 29 дүгээр хороо, СБД-ийн 13, 14 -р хороо, Сэлбэ голын үерийн оргил урсцыг сааруулах зорилго бүхий 5 шатлалт, 1.3 сая м3 эзэлхүүнтэй ус хуримтлуулах сан байгуулах ажил -15 %<br>- СБД-ийн 14 дүгээр хороо, ЧД-ийн 14, 18 дугаар хороо, "Сэлбэ дэд төв"-ийн ИБАХ, хөрсний ус зайлуулах 6'780м барилга байгууламж, шугам сүлжээ хийх ажил 30 хувийн хэрэгжилттэй байна - 2'034 м;<br>- БГД-ийн 16-р хороо, - 1'180 м;<br>- БЗД-ийн 11-р хороо,- түшиц хана 409 м;<br>- ХУД-ийн Яармаг орчимд 5 км суваг – 10 % буюу 500м;<br>- ЧД-т 2.3 км суваг 40% -920 м;<br>- Сэлбэ голын (S'Outlet) 1.4 км далан- 90 9– 1.260 км;<br>- БЗД-ийн 700м суваг-100%;<br>- ХУД-ийн 21-р хороо 400м суваг – 100%;<br>- СХД-ийн 33-р хороо, ус зайлуулах 1.2 м шугам 100%<br>- Нийслэлийн 10 байршилд нийт 16,3км борооны ус зайлуулах шугам -70% - 11.4 км;<br>- СХД-ийн 4, 5, 26, 27-р хороо, СБД-ийн 15, 16, 18, 20-р хороо Бэлх, Сэлхийн орчимд нийт 11км үерийн далан, суваг, шугам сүлжээ – 30% - 3.3 км.<br>3. Мэргэжил, арга зүйн дэмжлэг, зөвлөгөө өгөх үүднээс 2025:06:19-20-ны өдрүүдэд "Үерийн эрсдэлийн үнэлгээнд шаардагдах өгөгдөл, мдээлэл" сэдэвт сургалтыг зохион байгуулсан, мөн салбарын өгөгдлийг баяжуулах ажлын хүрээнд ҮХББ-ийн мэдээллийг бүрдүүлэх үүднээс 2025.10.15-ны өдрийн 02/3842 дугаар албан бичгийг 21 аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн /5 аймаг мэдээллээ бүрдүүлж ирүүлсэн болно/. | |
| 4.2.8 | Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн эргийн хамгаалалтын 30км далан болон ус зайлуулах 100км суваг шинээр барьж, дөрвөн байршилд усан сан, хөв, цөөрөм байгуулж хот доторх гол, горхины урсцад тохируулгах хийх Төслийг 2025-2028 онуудад үе шаттай хэрэгжүүлэх | 100 | 1. МУ-ын ЗГҮАХХАХТ-.ий 1.1.4.6 дахь зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хүрээнд нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах болсон тул 2025.01.24-ний өдөр 03/267 дугаартай албан бичгийг НЗДТ-т хүргүүлсэн. НЗДТГ-аас 2025.03.11-ний өдрийн 02-01/1423 дугаартай албан бичгээр "Голууд дээр үерийн хамгаалалтын далан, тохируулгатай усан санг барьж ашиглалтад оруулах" арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж ирүүлсэнтэй танилцаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>2. НҮБ-ын Хабитат төслийн хүрээнд боловсруулагдаж байгаа Толгойт гол, Бэлхийн голын үерийн хамгаалалтын барилга байгууламж барих зураг төслийг хийж гүйцэтгэж байгаа төсөл арга хэмжээний таницуулгад оролцож, танилцсан, холбогдох санал зөвлөмжийг өгсөн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нарийвчилсан төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсру улна.<br><br>(Ерөнхий сайдын 2024.09.18-ны албан даалгавар - 2.2.8.1, 2.2.8.2, 2.2.8.3) | | 3. Нийслэлийн ЗД-ын 2025.06.25-ны өдрийн 01/4167 дугаар албан бичгээр Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгах саналаа Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулсныг ХББОСЯ-ны СХОГ-тай хамтран шалгаж, ҮХББ-ийн нийт 10 байршилд хийгдэх 9 км ҮББ-ийг 9.5 тэр бум төгрөгөөр хийх зураг төслийн ажлын саналыг СЯ-руу 2025.07.25-ны өдрийн 01/2780 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>4. Нийслэлийн ГУББГ-аас нийт 12 байршилд 13,8 км борооны ус зайлуулах шугам болон бусад холбогдох барилга байгууламжийн төсвийн саналыг нийслэлийн 2026 оны төсөвт тусгуулахаар хүргүүлсэн санал 2025.12 сард батлагдсаны дараа, ХББОС-ын сайдын 2024 оны 99 дүгээр тушаалаар байгуулагдсан АХ-ийг шинэчлэн байгуулж хуралдуулахаар ажиллаж байна.<br>5. УБ хотын ЗА-аас 2025.11.20-ны өдрийн 01/1945 дугаартай албан бичгээр Дэлхийн банкны санхүүжилтээр “Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах, бохир усны шугам хоологй шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төсөл”-ийн ТЭЗҮ-ний дунд шатны тайланд санал авахаар ирүүлснийг судалж, нэмэлт материалыг татан авч холбогдох саналаа боловсруулан 2025.12.09-ний өдрийн 02/4586 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>6. Туул голын сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөний төсөлд холбогдох саналыг боловсруулан 2025.09.22-ны өдрийн 02/3567 дугаартай албан бичгээр “Престиж инженеринг” ХХК-д хүргүүлсэн. Мөн 2 удаагийн хэлэлцүүлэгт оролцсон болно. | |
| 4.2.9 | 1000 айлын орон сууцны хорооллын гадна дулаан хангамжийн шугам сүлжээний бүтээн байгуулалтыг хийнэ.(Дорнод, Хэрлэн сум, 3 дугаар баг, МУ2025 оны ТТХ-XYIII.1.5)<br>(МУХ2025 оны Т-2.3.1.2) | 60 | Төсөл арга хэмжээний гүйцэтгэч “Чандмань тал” ХХК-тай 2024.09.13-аас 2026.10.30-ны өдөр хүртэл хэрэгжих нөхцөлтэй, 17,354,573 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хүрээнд дараах барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Үүнд:<br>• УДД төвийн барилга: 12.0 м x 12.0 м хэмжээтэй;<br>• Дулаан хангамжийн шугам: нийт урт L=8,150.0 м;<br>• Гадна цахилгааны шугам: нийт урт L=520.0 м.<br>Төслийн нийт санхүүжилт 10,856,861,177 төгрөг бөгөөд үүнээс:<br>• 2024 онд 5,393,561,177 төгрөг,<br>• 2025 онд 5,463,300,000 төгрөгийг санхүүжилт тус тус олгогдсон.<br>2025 оны 12 дугаар сарын байдлаар барилга угсралтын ажил 65%-ийн гүйцэтгэлтэй, төлөвлөсөн хугацааны дагуу хэвийн үргэлжилж байна. | 100 |
| 4.2.10 | Японы Олон Улсын хамтын ажиллагааны ЖАЙКА-аас хэрэгжүүлж буй “УБ хотын үйлдвэрийн хаягдал усны | 80 | “Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл” /2022-2025 он/-ийн 14 үйл ажиллагааны хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.<br>"Улаанбаатар хотын үйлдвэрийн хаягдал усны хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хамтарсан зохицуулах зөвлөлийн хурлыг 2025.03.19, 2025.09.12-ны өдөр зохион байгуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хяналтын чадавх бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлнэ. | | ХББОСЯ, Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран төслийн тайлангийн семинарыг 2025.09.11-ний өдөр зохион байгуулж, тус яамнаас үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх танилцуулга хийсэн.<br>Төслийн хүрээнд “Үйлдвэрийн хяналт шалгалтын гарын авлага”, “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжийг зохистой суурилуулах нь /ҮААН-үүдэд зориулсан зааварчилгаа/”, Хаягдал ус урьдчилан цэвэрлэх байгууламжаас гарах лагийг ангилах, хадгалах, цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, боловсруулах болон устгах журмын төсөл, Төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй үйлдвэр, аж ахуйн нэгжийн бохирын цооног (хаягдлын сан)-т тавих ерөнхий шаардлага” стандартын төсөл зэргийг боловсруулсан. | |
| 4.2.11 | Нам даралтын халаалтын зуух бүхий барилгуудын дулаан хангамжийг нүүрс болон сэргээгдэх эрчим хүч хосолсон технологиор шинэчлэх загвар төслийг хэрэгжүүлнэ.<br><br>(Барилга, хот байгуулалтын салбарт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөний 2.3.2) | 100 | Агаар, хөрс, усны бохирдол бууруулах чиглэлээр иргэдийн бүлгийн оролцоонд суурилсан инженерийн хангамж, дэд бүтцийн туршилтын төслийг Сүхбаатар дүүргийн 16-р хорооны Бэлхийн 8-р гудамжны 10 айлын хүрээнд хэрэгжүүлж бие даасан инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг зохион байгуулсан.<br>Төслийн гүйцэтгэгчээр “Хатан хүч наран” ХХК шалгарч, БХБЯ/20240103093 дугаартай гэрээг байгуулан ажилласан ба төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэж, зохион байгуулан ажилсан. Үүнд:<br>- УСУГ-аас цэвэр, бохир усны холболт хийх Техникийн нөхцөлийг гаргуулсан;<br>- ТНБД-ын 2025.04.10-ны өдрийн ажлын зураг боловсруулах 2025/04 дугаартай ажлын даалгаврыг батлуулсан;<br>- ХББОС-ын сайдын 2025.07.02-ны өдрийн “Комисс томилох тухай” 135 дугаартай тушаалаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссыг байгуулж, 2025.07.02-ны өдөр төслийн талбай дээр ажиллаж, тухайн барилга байгууламж, холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийх ажлыг зохион байгуулж, техникийн комиссын актыг баталгаажуулсан.<br>ТНБД-ын 2025.10.23-ны өдрийн А/143 дугаар тушаалаар “Агаар, хөрс, усны бохирдол бууруулах чиглэлээр иргэдийн бүлгийн оролцоонд суурилсан инженерийн хангамж, дэд бүтцийн туршилтын төсөл хэрэгжүүлэх үйлчилгээний хүрээнд гэр хорооллын 10 айлын бие даасан инженерийн шугам сүлжээний төсөл”-өөр бий болсон хөрөнгийг ашиглалтад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2025.11.03, 2025.11.13-ний өдрүүдэд хуралдаж, 2025.11.24-ний өдөр газар дээр нь очиж танилцсан. Ажлын хэсгийн гишүүд болон иргэдийн Эко-78 бүлгийн төлөөлөлтэй зөвшилцөн төслийн хүрээнд бий болсон хөрөнгө, түүний ашиглалтыг иргэдийн бүлэгт хүлээлгэн өгөхөөр тогтсон. | 100 |
| **Зорилт 4.3. Орон сууцны ашиглалтын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичиг, дүрэм, журмыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4.3.1 | Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл боловсруулна. (ЗГҮАХ-2.4.3.1) | 100 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.12.10-ны өдрийн “Ажлын хэсгийг шинэчлэн батлах тухай” 123 дугаар тушаалаар Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.<br>Хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр ХББОС-ын сайдын 2025.01.16-ны өдрийн 01/180 дугаартай албан бичгийг ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Хуулийн төсөл боловсруулах ажлын төлөвлөгөөг 2025.01.29-ний өдөр ТНБД-аар батлуулсан.<br>Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Кей вишн" ХХК /БХБЯ/20240203097/-тай Ажлын хэсэг хамтран дараах баримт бичгүүдийг эхний байдлаар боловсруулж, удирдлагуудад танилцуулсан. Үүнд:<br>1. "Орон сууцны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан",<br>2. "Олон улс дах орон сууцны талаарх эрх зүйн зохицуулалтын тойм судалгааны тайлан"<br>3. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эхний байдлаар боловсруулж дууссан.<br>“Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал”-ыг боловсруулж, сайдаар батлуулж, 2025.05.22-ны өдрийн “Үзэл баримтлах батлуулах тухай” 01/1965 тоот албан бичгийг ХЗДХЯ-нд хүргүүлсэн.<br>УИХ-ын гишүүн О.Номинчимэгийн санаачлан боловсруулж байгаа Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон тус яамнаас боловсруулж байгаа Орон сууцны банкны тухай хуулийн төсөл, Орон сууцны нийлүүлэлтийн тухай хуулийн төслүүдтэй уялдуулах зорилгоор уг хуулийн төслийг боловсруулж, батлуулах ажил түр хүлээгдэж байна.<br>Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлыг хэсгийг ХББОС-ын сайдын 2025.11.27-ний өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн батлах тухай” 252 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Энэхүү ажлын хэсэг нь уг хуулийн төслийг холбогдох бусад хуулиудтай уялдуулан нийцүүлж, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан УИХ-д өргөн барих ажлыг зохион байгуулна. | 66.7 |
| 4.3.2 | “Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн зориулалттай орон сууцны барилгын менежмент. Орон сууцны барилгын дундын өмчлөлийн засвар үйлчилгээ. Ерөнхий шаардлага” стандартын | 90 | ХББОСЯ-ны ТНБД-ын 2024.12.17-ны өдрийн 2024/18 дугаар стандартыг боловсруулах ажлын техникийн даалгавар баталсан.<br>Стандартын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар 2025.05.30-ны өдөр barilga.gov.mn-д зар байршуулсан.<br>"Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо" ТББ-тай 2025.08.13-ны өдрийн 2025/145 дугаар гэрээг байгуулсан.<br>Зөвлөхөөс эхний шатны тайланг 2025.11.04-ны өдөр ирүүлсэн ба санал авахаар холбогдох байгууллагуудад 2025.11.06-ний өдөр БХТ-ийн ННХ-ээс хүргүүлсэн. Уг зөвлөх үйлчилгээний гэрээ 2026.10.16-ний өдөр дуусах ба дараагийн шатны тайлан болон стандартын төслийг 2026 оны 01 дүгээр сард хүлээн авна. | 50 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төслийг боловсруулна. (ЗГҮАХ-2.4.3.1) | | | |
| **Зорилт 4.4.Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэх, холбогдох байгууллага, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх.** | | | | |
| 4.4.1 | Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг дурьдсан хугацаанд холбогдох байгууллага, газарт хүргүүлнэ. | Тайлан мэдээний тоо-10 | • МУ-ын ЗГ-ын 2025.01.29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэлээр ЗГ-ын 2021.03.03-ны өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг эрчимжүүлж, биелэлтийг ЗГ-т танилцуулахыг ХББОС-ын сайдад даалгасны дагуу 2025.04.02-ны өдөр ЗГ-ын хуралдаанд танилцуулж, 15 дугаар хуралдааны тэмдэглэлийг гаргуулсан.<br>• Монгол Улсын Засгийн газрын 2025.01.14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр Бүсийн зөвлөлүүдийг байгуулж, 2025 оны II улиралд багтаан бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулах болсны дагуу 2025.04.14-ний өдөр Хангайн бүс, 2025.04.28-ний өдөр Хойд бүс, 2025.05.12-ны өдөр Говийн бүсийн өргөтгөсөн хуралдаанд болж, уг Засгийн газрын хуралдаанд орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын 2025 оны 181, 182, 204, 209 дугаар тогтоолуудад салбарыг асуудлыг тусгуулсан.<br>• “20 минутын хот” Үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж 2025 оны 01 дугаартай дотоод албан бичгээр тус яамны ХББЗГ-т хүргүүлсэн.<br>• Боомтын сэргэлтийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах санал болон тус хорооны хурлаар хэлэлцүүлэх асуудалд санал боловсруулж 2025 оны 03 дугаартай дотоод албан бичгээр тус яамны ХББЗГ-т хүргүүлсэн.<br>• БХБ /хуучин нэрээр/-ын сайдын 2023 оны “Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай” 02 дугаар албан даалгаврыг шинэчлэн боловсруулах төсөлд санал боловсруулан 2025 оны 02 дугаар дотоод албан бичгээр тус яамны СХГ-т хүргүүлсэн.<br>• ХББЗГ-аас ирүүлсэн "Журам шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл болон "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам"-ын төсөл /шинэчилсэн/-тэй танилцаж холбогдох саналаа дотоод бичгээр хүргүүлсэн.<br>• "Монгол Улсын Хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-ний төслийг боловсруулахад шаардагдах нөхцөл байдлын шинжилгээг хариуцсан асуудлаараа шинэчлэн боловсруулж, СХОСБЗГ-т хүргүүлсэн.<br>• “Улсын хэмжээнд 2025 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж хүргүүлсэн;<br>• Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах АХ-т холбогдох | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | мэдээллийг бэлдэж саналаа тус яамны СХОСБЗГ-т 2025 оны 02 дугаар сард хүргүүлсэн;<br>• "Журам шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөл болон "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам"-ын төсөл /шинэчилсэн/-тэй танилцаж холбогдох саналаа дотоод бичгээр ХББЗГ-т хүргүүлсэн;<br>• УОК-ын 2025.06.22-ны өдрийн 02, 2025.08.11-ний өдрийн 3 дугаар хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлтийг гарган ХББОССайдын 2025.10.13-ны өдрийн 01/3811 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т, ХББОСЯ-ны 2025.10.14-ний өдрийн 02/3826 дугаар албан бичгээр УОК-ын Ажлын албанд тус тус хүргүүлсэн.<br>• “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” МУ-ын Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг гарган 2025.10.28, 2025.11.28-нд тус тус ХБОСБЗГ-т хүргүүлсэн.<br>• ЗГҮАХХАХТ, МУЖТ-ний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025.11.10-ны өдрийн 01/26 дугаар удирдамжаар батлагдсан МУХБ-ын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг газар дээр нь хянан үзэж, дүн шинжилгээ хийх ажлын хэсэгт болон тус яамны СХДАГ-т хүргүүлсэн.<br>• Нийслэлилйн 2026 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд холбогдох саналыг хүргүүулсэн. | |
| 4.4.2 | Төв суурин газрын орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны өвөлжилтийн бэлэн байдлыг хангуулж, үр дүнг талаарх танилцуулгыг Засгийн газарт хүргүүлэх | 1/100 | ХББОС-ын сайдын 2025.06.12-ны өдрийн 2025/03 дугаартай “Орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай” албан даалгаврыг баталж, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудад хүргүүлж, мэдээ, тайланг 14 хоног тутамд нэгтгэн, мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>ХББОС-ын сайд Э.Бат-Амгалан, ТНБД М.Баяраа болон яамны холбогдох газар, нэгжийн дарга, харьяа байгууллагын удирдлагууд, аймгийн Засаг дарга, Ерөнхий архитектор, ГХБХБГ-ын дарга, ТЗЭБ-ын удирдлага, ерөнхий инженер нар оролцож “Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэх хангах” цахим уулзалтыг зохион байгуулсан бөгөөд уулзалт 80 гаруй байгууллагын 110 гаруй албаны хүмүүс оролцсон. Мөн ХББОС-ын сайд Э.Бат-Амгалан Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаарх танилцуулгыг 2025.08.13, 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. ХББОС-ын сайдын 2025.08.19-ний өдрийн 198 дугаар тушаалаар Төв, суурин газрын орон сууц, нийтийн аж ахуйн байгууллагуудын ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаанд өвөлжилтийн бэлэн байдалд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох мэдээ, мэдээллийг нэгтгэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажилласан. | 93.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | УОК-ын 2025.06.22-ны өдрийн 02, 2025.08.11-ний өдрийн 3 дугаар хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлтийг гарган ХББОССайдын 2025.10.13-ны өдрийн 01/3811 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-т, ХББОСЯ-ны 2025.10.14-ний өдрийн 02/3826 дугаар албан бичгээр УОК-ын Ажлын албанд тус тус хүргүүлсэн.<br>Салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар Засгийн газрын 2025.10.15-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>ХББОСЯ-ны 2025.10.15-ны өдрийн 02/3489, 2025.10.21-ний өдрийн 02/3908 дугаар, 2025.11.06-ны өдрийн 02/4126 дугаар албан бичгээр салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх мэдээллийг албан бичгээр болон uok@nema.gov.mn цахим хаягаар УОК-ын Ажлын албанд хүргүүлсэн.<br>ХББОС-ын сайдын салбарын өвөлжилтийн талаарх ээлжит цахим хурлыг 2025.11.11-ний өдөр зохион байгуулж, Аймгуудын Засаг дарга, Ерөнхий архитектор, ГХБХБГ-ын дарга, ТЗЭБ-уудын удирдлага, ерөнхий инженерүүд нийт 58 албан хаагчийн төлөөлөл оролцсон бөгөөд өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн ханган дуусган ажиллах талаар чиглэл өгсөн. ХББОС-ын сайдын 2025.11.27-ны өдрийн 01/4356 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг Аймгийн Засаг дарга нарт хүргүүлж хэрэгжилтийг дүгнэн ажилласан. 2025.12.05-ны өдрийн байдлаар Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажил 93.5%-ийн биелэлттэй байна. | |
| 4.4.3 | Хүн амыг ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар тэгш хангах, хүртээмжийн ялгааг бууруулах зорилгоор улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх | 1 | Аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас тухайн нутаг дэвсгэр дэх хүн амыг ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар тэгш, хүртээмжтэй хангаж буй талаар нэгдсэн судалгааг авч, боловсруулсан.<br>ХББОСайдын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Засгийн газрын хуралдаанаар асуудал танилцуулах тухай” 01/4564 дугаар албан бичгээр хүн амыг ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар тэгш хангах, хүртээмжийн ялгааг бууруулах зорилгоор улсын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах арга хэмжээний саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| 4.4.4 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ. | 20 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд тайлант хугацаанд ХББОССайд, ТНБД-ын баталсан тушаал, удирдамжийн дагуу 9 аймгийн 23 сумдад ажилласан. Үүнд:<br>1. ХББОССайдын 2025 оны 22 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр”-т хамрагдсан 4 аймгийн 14 сум, нийслэлийн 2 дүүргийн төрийн албан хаагчийн 8 айлын орон сууцыг барих төслийн газрын сонголт болон дулаан, ус, ариутгах татуурга, цахилгаан хангамжийн шугам сүлжээний хүртээмжийг газар дээр нь үзэж, | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | шинжлэн судлах, мөн тухайн аймгуудын төв болон сумдад сайдын багцын хүрээнд хэрэгжсэн болон хэрэгжүүлж байгаа, 2025 онд шинээр эхлэх улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийн хөрөнгө оруулалтын талаар аймгуудын Засаг дарга, ИТХ-ын дарга, сумдын Засаг дарга, удирдлагуудтай санал солилцож, холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авч, зөвлөмж, чиглэл өгч ажиллалаа.<br>2. ХББОС-ын яамны ТНБД-ын 2025 оны Б/45 дугаар “дотоод томилолтоор ажиллах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн дагуу 4 аймгийн 6 сумдад хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд хяналт хэрэгжүүлж ажилласан.<br>ХББОСЯ-ны 2025.08.29-ний өдрийн 02/3262 дугаартай “Сумын дэд бүтцийн ашиглалтын тухай” албан бичгийг Төв аймгийн Сэргэлэн сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолоор батлагдсан “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд “Сумын төвийн инженерийн шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил (Төв, Баянчандмань сум)” барилга угсралтын ажлын талаар судлан БХТ-д илэрсэн зөрчлийг арилгуулах тухай ХББОСЯ-ны 2025.10.10-ны өдрийн 03/3781 дугаар албан бичиг хүргүүлсэн. | |
| 4.4.5 | Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2026-2028 оны хамтын хэлэлцээрийг байгуулах, 2024 оны төлөвлөгөөг дүгнэж, 2025 оны төлөвлөгөөг батлуулж хамтран ажиллана. | 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг дүгнэсэн байна | ХББОСЯ, “Монголын орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны үйлдвэрчний холбоо” “Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо” ТББ хамтран 2023.06.13-ны өдөр хамтран баталсан “Монголын орон сууц нийтийн аж ахуйн салбарын 2023-2025 оны хамтын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг талууд 2025.06.06-ны өдөр хэлэлцэж, хэлэлцээрийн хэрэгжилтийг 85 хувийн биелэлттэй гэж дүгнэн, тайланг холбогдох байгууллагуудад танилцуулсан.<br>2023-2025 оны хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийн тайланд үндэслэн талууд Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2026-2028 оны хамтын хэлэлцээрийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, 2026 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна.<br>ХББОС-ын сайдын 2025.02.18-ны өдрийн “Хамтын хэлэлцээрт оролцох, байгуулах тухай” 41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас орон сууц, нийтийн аж ахуйн 2025-2028 оны гурван талт хамтын хэлэлцээрт оролцож, гарын үсэг зурах албан тушаалтнуудын нэрс”-ийг шинэчлэн батлуулахаар холбогдох байгууллагуудаас нэрсийг ирүүлэх тухай 2025.12.01-ний өдрийн 06/4418, 06/4420 дугаартай албан бичгүүдийг хүргүүлээд байна. | 95 |
| 4.4.6 | “Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах ажилтны зөвлөгөөн” зохион байгуулна. | Зөвлөгөөн зохион байгуулсан. | Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах ажилтны 2025 оны зөвлөгөөнийг Барилгын хөгжлийн төвтэй хамтран 2025.05.02-ны өдөр Улаанбаатар хотод “Бүсчилсэн хөгжил-Салбарын санхүүгийн чадамж-Нийгмийн баталгаа” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд нийт 200 гаруй төлөөлөгч оролцсон.<br>Зөвлөгөөнөөр “Бүсчилсэн хөгжил”, “Салбарын санхүүгийн чадамж”, “Нийгмийн баталгаа” сэдвийн дор | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 3-н салбар хэлэлцүүлэг явагдаж, хэлэлцүүлэг тус бүрээс гаргасан санал, хүсэлтийг үндэслэн 9 арга хэмжээ бүхий зөвлөмж гаргаж, төлөвлөгөө боловсруулан 2025.05.22-ны өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНбД-аар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 4.4.7 | Салбарын 94 жилийн ой, Нийтийн аж ахуйн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, салбарын шилдэг аж ахуйн нэгж байгууллага шалгаруулна. | 1 | Салбарын 94 жилийн ой, Нийтийн аж ахуйн ажилтны өдрийг угтан "Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын 2024 оны шилдэг байгууллага" төрлөөр сумын төвийн хүрээнд 3, аймгийн төвүүдийн хүрээнд 5, хувийн хэвшлийн орон сууцны ашиглалтын хүрээнд 5, УБ хотын хүрээнд 2 буюу нийт 15 аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах ажлыг БХТ, ХСУСАТАҮЗХ-тай хамтран зохион байгуулж, дараах аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгаруулсан. Үүнд:<br>УБ хотын "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ, "Багануур ус" ААТҮГ, Сүхбаатар аймгийн "Дөрвөлж" ОНӨААТҮГ, Дорноговь аймгийн "Чандмань илч", Говьсүмбэр аймгийн "Илчлэг шивээ" ОНӨААТҮГ, "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ, Дархан-Уул аймгийн "Дулаан шарын гол" ТӨХК, УБ хотын "Хүрээ хаус" ХХК, "Адтай ноён" ХХК, "Таван өндөр" ХХК-д өргөмжлөл тус тус гардуулсан.<br>Монгол Улсад Орон сууц, нийтийн аж ахуйн салбар үүсч хөгжсөний 94 жилийн ойг тохиолдуулан "Хэрэглэгчээ сонсъё" нээлттэй хаалганы өдөрлөгийг тэмдэглэн өнгөрүүлэхээр Зохицуулах хорооны даргын батлагдсан удирдамжийн дагуу 2025.09.25-ны өдөр улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлсэн. "Нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны өдөр"-ийн сайдын мэндчилгээ бэлтгэж, байгууллагын цахим хуудас дээр 2025.10.09-ний өдөр байршуулж, нийтэд түгээх ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Салбарын 94 жилийн ойн хүрээнд Нийслэл, 21 аймгийн Нийтийн аж ахуйн байгууллагуудын удирдах ажилтнуудын хэлэлцүүлэгийг 2025.12.11-12-ны өдрүүдэд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороотой хамтран зохион байгуулсан. | 100 |

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хагас жилийн байдлаар хэрэгжилт 70 хүртэл хувьтай "хангалтгүй" хэрэгжсэн 3 арга хэмжээ байна. Үүнд:

1. 4.1.3. "Ус хангамж. Барилгын гадна систем ба ус хангамжийн ерөнхий шаардлага" стандартын төслийг боловсруулна;
2. 4.3.1. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл боловсруулна.
3. 4.3.2. "Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн зориулалттай орон сууцны барилгын менежмент. Орон сууцны барилгын дундын өмчлөлийн засвар үйлчилгээ. Ерөнхий шаардлага" стандартын төслийг боловсруулна.

**Дөрөв. Дүгнэлт:**

1. Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **92,9** хувьтай буюу "бүрэн хангалттай" үнэлэгдсэн байна.

2. Газар, нэгжүүд дутуу орон тоогоор ажиллах, албан хаагчдын тогтвор суурьшилгүй байгаа нь ажлын гүйцэтгэл удаашрах, ажил цалгардах байдлаар гүйцэтгэлийн үр дүнд шууд нөлөөлж байна.

**Тав. Санал, зөвлөмж**

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 2026 онд төлөвлөхдөө хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хагас, бүтэн жилээр төлөвлөж, "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын 3-р хавралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хүрээнд хүрэх буюу зорилтот түвшин, суурь түвшнийг чанар, тоогоор илэрхийлж төлөвлөгөөндөө тусгах;

2. 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхдөө Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд туссан хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тухайн жилийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх түвшингээр төлөвлөж биелэлтийг хангаж ажиллах;

3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний "хангалтгүй" хэрэгжсэн 4.1.3, 4.3.1, 4.3.2 дахь 3 арга хэмжээ биелэлтийг хангах;

4. Газар, нэгжүүдийн төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай, хэвийн ажиллах нөхцөл бололцоог хангахад Төрийн захиргааны удирдлагын газартай хамтран ажиллаж ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар /М.Ням-Очир/-т даалгах.

Тайланг хянасан:
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Найрамдал

Боловсруулсан:

Салбар хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын ахлах шинжээч А.Гэрэлт-Од

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ**

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 он

# САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.12.12

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг тус тус баримталсан.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ:

Санхүү, хөрөнгө оруулалтын газар нь 2025 онд 4 зорилтын хүрээнд 21 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **94.95** хувьтай, **“БҮРЭН ХАНГАЛТТАЙ”** гэж үнэлэв.

100 хувьтай 9 арга хэмжээ , 90-99 хувьтай 9 арга хэмжээ байна.

*Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:*

Хүснэгт-1

| № | Гэрээнд туссан арга хэмжээ | Зорилт | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн түвшин | | | | | | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 90-100% | 80-89% | 79-70% | 69-60% | 59-50% | 0% | |
| 1 | **Арга хэмжээ** | **4** | **21** | **18** | **2** | **0-** | **-** | **-** | **-** | **94.95** |

Дундаж үнэлгээ **94.95**

| № | Дугаар | Гүйцэтгэл хувь | Дугаар | Гүйцэтгэл хувь | Дугаар | Гүйцэтгэл хувь | Дугаар | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | **6.1** | | **6.2** | | **6.3** | | **6.4** | |
| 1 | 6.1.1 | 100.0 | 6.2.1 | 100.0 | 6.3.1 | 100.0 | 6.4.1 | 90.0 |
| 2 | 6.1.2 | 100.0 | 6.2.2 | 90.0 | 6.3.2 | 100.0 | 6.4.2 | 95.0 |
| 3 | 6.1.3 | 100.0 | 6.2.3 | 90.0 | 6.3.3 | 80.0 | 6.4.3 | 90.0 |
| 4 | 6.1.4 | 100.0 | 6.2.4 | 92.9 | 6.3.4 | 100.0 | 6.4.4 | 100.0 |
| 5 | 6.1.5 | 100.0 | 6.2.5 | 88.0 | 6.3.5 | 90.0 | 6.4.5 | 95.0 |
| 6 | | | 6.2.6 | 90.0 | | | | |
| Дундаж дүн | | **100.0** | | **91.8** | | **94.0** | | **94.0** |

*Хэрэгжилтийг зорилт, арга хэмжээ тус бүрээр харуулбал:*

**Стратеги төлөвлөгөөний зорилго 6**. Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбарын гадаад болон дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|
| **Зорилт 6.1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (ТЕЗ)-ын багцийн төсвийн хязгаар, төсвийн төслийг төлөвлөх, хуваарилах, хяналт тавих** | | | | |
| 6.1.1 | **Арга хэмжээ 6.1.1:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (ТЕЗ)-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын урсгал зардлын 2026 оны төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг боловсруулж холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгын хамт Сангийн яаманд хүргүүлнэ. | Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын 2025 оны төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэн 2025 оны 06 дугаар сарын 10 болон 07 дугаар сарын 25-ны өдөр тус тус хүргүүлэх. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (ТЕЗ)-ын багцын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг боловсруулж, хүргүүлнэ. | 1.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын урсгал зардалд 14.7 тэрбум төгрөг тусгуулах саналыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/1057 дугаартай албан бичгээр Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>2.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хязгаарын саналд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын урсгал зардалд 139.6 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцооллыг боловсруулж, холбогдох тайлбарын хамт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/2272 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>3. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /ТЕЗ/-ын багцын 2026 оны урсгал зардалд шаардагдах 177.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн саналыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/2780 дугаартай албан бичгээр болон холбогдох цахим системээр Сангийн яаманд, 01/2782 дугаартай албан бичгээр УИХ-д, 01/2781 дугаартай албан бичгээр ҮАГ-т тус тус хүргүүлсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.1.2 | **Арга хэмжээ 6.1.2:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (ТЕЗ)-ын багцад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны урьдчилсан үнэлгээ, төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгын хамт Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлэх | Төсвийн тухай хууль болон журамд заасан хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын 2026 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналын урьдчилсан үнэлгээ, төсвийн хязгаар, төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн хүргүүлнэ. | 1. Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан хугацаанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын 2026 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээнүүдийн урьдчилсан үнэлгээг аймгууд болон чиг үүргийн газруудаас ирүүлсэн санал үндэслэн боловсруулснаар нийт 734,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 385.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 62 төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/574 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээр мөн илгээсэн.<br>2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулахаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 943.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг холбогдох тайлбарын хамт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/2272 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>3. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн хязгаарт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаас хүргүүлэх саналыг нэгтгэн боловсруулах ажлыг зохион байгуулснаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд шаардагдах 1 их наяд 44.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийн саналыг холбогдох тайлбарын хамт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/2272 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>4. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд /ТЕЗ/-ын багцын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулсан бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардалд шаардагдах | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 592.7 тэрбум төгрөгийн саналыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/2780 дугаартай албан бичгээр болон холбогдох цахим системээр Сангийн яаманд, 01/2782 дугаартай албан бичгээр УИХ-д, 01/2781 дугаартай албан бичгээр ҮАГ-т тус тус хүргүүлсэн.<br>5. Сангийн яамнаас ирүүлсэн 2025 оны 02/7190 дугаартай албан бичгийн дагуу Засгийн газрын 2024 оны 93 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-д зааснаар ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төслийг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдөр танхимаар, 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрийн хооронд яамны цахим хуудсаар тус хэлэлцүүлэн санал асуулга авч нийт 106 хуудас бүхий хэлэлцүүлгийн тайланг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02/3050 дугаартай албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн. | |
| 6.1.3 | **Арга хэмжээ 6.1.3:**<br>Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдээс гадаад хөрөнгө оруулалтын талаар төсвийн хязгаарт санал авч, 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа, тайлбар танилцуулгын хамт хүргүүлэх. | • Төсвийн саналын тоо-8,<br>• Сайдын тушаал-23 | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 8 төслийн хүрээнд гадаад зээл, тусламжаас 183,589.74 сая төгрөг, Улсын төсөв /Монголын талын хөрөнгө/-т 25,318.21 сая төгрөгийн саналыг холбогдох төслийн танилцуулгын хамт 2026 оны төсвийн хязгаарт хүргүүлсэн. Гадаадын зээл тусламжаар хэрэгжих нийт 9 төслийн 2026 төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг нэгтгэлд холбогдох тооцоо, судалгаа тайлбарын хамт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 01/1057 дугаартай албан бичгийн 3 дугаар хавсралтаар Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| 6.1.4 | **Арга хэмжээ 6.1.4:**<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцийн батлагдсан төсвийн санхүүжилтийн хуваарийн саналыг боловсруулан Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв | Санхүүжилтийн сар, улирлын хуваарь-4 | 1.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад 2025 оны төсвийн жилд зарцуулахаар анх батлагдсан 354.1 тэрбум төгрөг;<br>2.Урсгал зардлын 78.8 тэрбум төгрөг буюу нийт Сайдын багцын 432.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийн сар, улирлын хуваарийн саналыг тус боловсруулан нэгтгэж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлуулсан. Мөн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгууллагад хүргүүлэх, батлуулах. | | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар буюу тодотголоор сайдын багцад батлагдсан нийт 411.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн сар, улирлын хуваарийн саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлуулсан. | |
| 6.1.5 | **Арга хэмжээ 6.1.5:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрхийг Засгийн газрын тогтоолын дагуу аймаг, нийслэлд шилжүүлэх, багц дүнгээр батлагдсан төсөл, арга хэмжээний задаргаа жагсаалтыг боловсруулан, батлуулж, холбогдох шийдвэрийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх. | Багц дүнгээр батлагдсан төсөл, арга хэмжээний задаргаа жагсаалтыг журамд заасан хугацаанд батлуулан хүргүүлэх | 1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад багц дүнгээр батлагдсан 235.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 63.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 3 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 40 төсөл, арга хэмжээний задаргаа жагсаалтыг тухай бүр боловсруулан “Жагсаалт батлах тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 20, 21, 46 дугаар, “Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай” 58 дугаар, "Жагсаалт шинэчлэн батлах тухай” 65, 91, 162 дугаар тушаалууд;<br>2. Үүнээс 63.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 11 төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоол болон “Жагсаалт батлах тухай” холбогдох тушаалуудыг үндэслэн боловсруулж аймаг, нийслэлийн Засаг даргад “Эрх шилжүүлэх тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 24, 25, 45, 92, 93 дугаар тушаалууд;<br>3. “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын дагуу 2024 онд зохицуулалт хийгдсэн 373.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 112.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 15 төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулж “Хөрөнгийн зохицуулалт хийх тухай” Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 13 дугаар тушаал,<br>4. 2024 онд зохицуулалт хийгдсэнтэй холбогдуулан 2025 онд шилжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалтад багц дүнгээр тусгагдсан 287.8 тэрбум | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | төгрөгийн төсөвт өртөгтэй 79.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүн бүхий 5 багц төсөл, арга хэмжээний задаргаа болох 46 төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн боловсруулж "Жагсаалт батлах тухай" Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 14 дугаартай тушаал буюу нийт дээр дурдсан 14 тушаалыг тус тус батлуулж журамд заасны дагуу хугацаанд нь Сангийн яам болон холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргад албан бичгээр хүргүүлсэн. | |
| **Зорилт 6.2. Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах** | | | | |
| 6.2.1 | **Арга хэмжээ 6.2.1:** Улсын төсөв, зээл, тусламжаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 4 багц төсөл, арга хэмжээнээс тус яаманд хэрэгжүүлэх 2 багц төсөл, арга хэмжээний задаргааны нийт 39 ажлын тендерийг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороо байгуулах тушаалын төсөл боловсруулж, батлуулах, тендер шалгаруулалт зарлуулсан байна. Мөн Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулах 2 багц төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгаврыг хүргүүлж, тендер | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад 4 багц төсөл батлагдсан ба 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 20, 21, 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тушаалуудаар задаргааны жагсаалт батлагдсан. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоол, Сайдын 2025 оны 24,25,45,92,93 дугаар тушаалуудын дагуу "Шинэ Хархорум" хотын эхний ээлжийн барилгажилтын төсөл, инженерийн бэлтгэл арга хэмжээ, нэвтрэх хонгилын систем, 2-р ээлжийн инженерийн шугам сүлжээ авто замын зураг төслийн задаргааны 7 ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн худалдан авах ажиллагааны газарт, Сүхбаатар, Ховд, Дархан-Уул, Увс, Сэлэнгэ, Хэнтий, Булган зэрэг аймгуудад хэрэгжүүлэх инженерийн шугам сүлжээний ажлуудын эрхийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчдад тус тус шилжүүлсэн ба Бусүүдэд хэрэгжүүлэх инженерийн шугам сүлжээний 19 төсөл, арга хэмжээ, төрийн албан хаагчдын 8,15 айлын орон сууцжуулах төслийн 19, нийт 38 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тус яаманд зохион байгуулсан.<br>Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувьд Сайдын багцын нийт 57 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа 100 хувь зохион байгуулагдсан ба 40 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдсан буюу гэрээ байгуулсан төслөөр авч үзвэл 70 хувьтай хэрэгжсэн.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд зохион байгуулсан 38 ажлаас 38 ажлын тендер | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | зарлуулсан байна. | зарласан буюу хэрэгжилт 100 хувь, үүнээс 29 ажилд гэрээ байгуулсан. | |
| 6.2.2 | **Арга хэмжээ 6.2.2:** Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй нийт 6 төслийн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийг, мөн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардлын төсвийг тус тус хянан баталгаажуулах | • Гадаад зээл ашиглалтын хувь- 90%.<br>• Хөрөнгө оруулалт /Монголын тал/-ын гүйцэтгэл 80 дээш хувьд хүргэнэ.<br>• Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хувь-90 хувь. | Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа дараах 7 төслийн хүрээнд 2025 оны хөрөнгө оруулалтад 336.7 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд гүйцэтгэлд өссөн дүнгээр 31.61 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хянаж, шийдвэрлүүлсэн. Хэрэгжилтийн хувь буюу 10% байна.<br><br>Төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийн 1, 2 улирлын үйл ажиллагааны зардлын 8 удаагийн төсвийг хянаж баталгаажуулан Сангийн яаманд хүргүүлсэн ба хэрэгжилт 30%. Аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төслийн 3 багц ажлын гэрээний нэмэлт, өөрчлөлтийг 2025/131, 2025/132, 2025/133 баталгаажуулж, Сангийн яаманд хүргүүлсэн. | 90 |
| 6.2.3 | **Арга хэмжээ 6.2.3:** Салбарын хэмжээнд гадаад зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлүүлэх саналыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгуулах. | • Гадаад зээл, тусламжийн хөрөнгийн өмчлөлийн жагсаалт, санал<br>• Улсын төсвийн хөрөнгийн өмчлөлийн судалгаа, санал | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарт гадаад зээл, тусламж болон улсын төсвийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хөрөнгийн өмчлөлийн 2020-2025 оны судалгааг он оноор нэгтгэн гаргасан. Мөн тус яамны холбогдох газрууд, төсөл хэрэгжүүлэх нэгжид хөрөнгийн бүртгэлийг “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн систем” болох http://pcsp.gov.mn цахим системд байршуулах арга хэмжээг авахад хамтарч ажиллах талаар мэдээллийг хүргүүлсэн. Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төслүүдийн хөрөнгийн өмчлөлийн судалгааг гарган удирдлагад танилцуулсан. Энэ оны хагас жилийн байдлаар дараах 4 төслийн хүрээнд нийт 137.77 тэрбум төгрөгийн хөрөнгийг нийслэл, орон нутгийн өмчлөлд бүртгүүлэх 4 саналыг ТӨБЗГ-т албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Улсын төсвийн хөрөнгөөр 2013-2023 онд хэрэгжүүлж дуусгасан 157.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 87 төсөл, арга хэмжээ, 2024 онд дуусгасан 113.5 тэрбум төгрөгийн өртөгтэй 51 төсөл, арга хэмжээ буюу нийт 271.3 тэрбум төгрөгийн | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | өртөгтэй 138 төсөл, арга хэмжээний хөрөнгийн өмчлөлийг шийдвэрлүүлэхээр Төрийн өмчийн бодлого,зохицуулалтын газарт хүргүүлсэн.<br>Эдгээр төсөл, арга хэмжээний хүчин чадал болон хөрөнгө тус бүрийн үнэ өртгийг нарийвчлан ирүүлэх чиглэлийн дагуу Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газар, Барилгын хөгжлийн төвд холбогдох судалгааг гарган өгч, энэ дагуу нийт 78.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийн баримт материалыг бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2/3936, 2/3367, 2/4286, 2/4251, 2/4253, 2/4255 дугаартай албан бичгээр дахин хандсан.<br>Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2025 онд хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон нийт 31.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг Хүннү хотын захиргааны өмчлөлд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын дагуу тус яамны "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А160, А/161 дүгээр тушаалаар тус тус шинэчлэн байгуулсан.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 396 дугаар тогтоолын хүрээнд "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн хурлыг 2 удаа зохион байгуулж, яамны дансанд бүртгэлтэй 106.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хасах санал дүгнэлтийг гаргуулсан.<br>Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулж байгаатай холбогдуулан гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 4 төслийн "Төсөл хэрэгжүүлэх нэгж"-ийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн судалгааг авч үүнээс 150.8 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг актлах саналыг "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **6.2.4** | **Арга хэмжээ 6.2.4:** Улсын төсвөөс санхүүжих төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хянан баталгаажуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлж, тооцоо нийлж, бүртгэлд тусгана. | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг 85-90 хувьд хүргэхээр хэрэгжилтийг хангаж ажиллана. | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 56 төсөл, арга хэмжээнд 334.7 тэрбум төгрөг батлагдсан. 2025.12.05-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 81 төсөл, арга хэмжээнд 158.6 тэрбум төгрөг санхүүжүүлсэн буюу гүйцэтгэл 48.0%-тай байна.<br>Санхүүжилтийн эрхийг нээхдээ Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг удирдлага болгож, гэрээ байгуулагдсан төслүүдэд нийт давхардсан тоогоор 160 гүйцэтгэлийг хянаж, эрх нээлгэхээр Сангийн яаманд хүргүүлсэн. Сангийн яаманд хүлээгдэж байгаа гүйцэтгэл 6.1 тэрбум төгрөг, захиалагч дээр хүлээгдэж буй гүйцэтгэл 12.1 тэрбум төгрөг, аж ахуйн нэгж, аймаг, нийслэл, Барилгын хөгжлийн төвд хүлээгдэж байгаа гүйцэтгэл 88.9 тэрбум төгрөг байгаа ба гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 80-85 хувь хүрэх төлөвлөгөөтэй байна.<br>Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын 5.4.4 дахь заалтын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгэх хөрөнгө оруулалтын тооцоог Сангийн яамтай нийлж нягтлан бодох бүртгэлд тусгасан. | 92,9 |
| **6.2.5** | **Арга хэмжээ 6.2.5:** Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шилжин хэрэгжүүлэх 781,3 тэрбум төгрөгийн 253,9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 83 төсөл, арга хэмжээнээс тус яаманд гэрээтэй 63 төсөл, арга хэмжээнээс 2025 онд хэрэгжиж дуусах 40 төсөл, | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шилжин хэрэгжихээр батлагдсан, 2025 онд тус яаманд гэрээтэй нийт 40 төсөл, арга хэмжээнээс жилийн эцсийн байдлаар 28 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусаад байна. Үлдсэн 12 төслөөс 60 хувьтай-4, 65 хувьтай-1, 70 хувьтай-2, 85 хувьтай-5 төсөл, арга хэмжээ байна. | 88 |
| **6.2.6** | **Арга хэмжээ 6.2.6:** Засгийн газрын тогтоолын хүрээнд барьцаа хөрөнгийн дансанд авсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | | 2024 оны жилийн эцсийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан 19 төсөл, арга хэмжээнээс 16 төсөл, арга хэмжээ бүрэн дуусаж, 3 төсөл, арга хэмжээ нь газар чөлөөлөлт, техникийн нөхцөл, зураг төсөв, гүйцэтгэгчийн чадамжгүй байдал зэргээс шалтгаалж, 2025 оны төсвийн жилд бүрэн хэрэгжих боломжгүй болоод байна. | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, бүрэн дуусгасан байна.<br>Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс 2024 оны жилийн эцэст барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн 19 төсөл, арга хэмжээг бүрэн дуусгасан байна.. | | |
| **Зорилт 6.3: Төрийн сангийн гүйлгээ гүйцэтгэх, тайлан, баланс гаргах.** | | | | |
| **6.3** | **Зорилт 6.3:**<br>Төрийн сангийн гүйлгээ гүйцэтгэх, тайлан, баланс гаргах. | Төрийн сангаар хийж гүйцэтгэх гүйлгээний тоо 1500 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын хэмжээнд 2025 оны 12 сарын 08-ны өдрийн байдлаар Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох заавар журмын дагуу нийт 131,8 тэрбум төгрөгийн 2426 ширхэг төлбөрийн гүйлгээг хянан баталгаажуулсан. | 100 |
| **6.3.1** | **Арга хэмжээ 6.3.1:**<br>ТЕЗ-ийн 2025 оны төсвийн багцад тусгагдсан урсгал зардлын гүйцэтгэл, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж, тайлагнах, зарцуулалтад хяналт тавих. | 2025 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээний тоо -12 /хуулийн хугацаанд/. | 2025 оны эхний 11 сарын байдлаар 210,049.7 сая төгрөгийн санхүүжилт авснаас цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой 4,828.8 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 617.9 сая, байр ашиглалттай холбоотой 231.2 сая, хангамжийн материал 101.1 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 101.0 сая, дотоод болон гадаад томилолт 65.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээнд 286.4 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 53.9 сая, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 43,497.4 сая, урсгал шилжүүлэг 367.8 сая төгрөг буюу урсгал зардал нийт 50,151.7 сая төгрөг, хөрөнгө оруулалтад 151,302.8 сая төгрөг зарцуулсан. нийт зарцуулалт 205,954.5 сая буюу 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүлээгдэж буй гүйцэтгэл 184,790.9 сая төгрөг байна. | 100 |
| **6.3.2** | **Арга хэмжээ 6.3.2:**<br>Төсвийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу Төсвийн ерөнхийлөн | • Хуулийн хугацаанд хянаж, нэгтгэх тайлангийн тоо-9; | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын харьяа байгууллагууд, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн 2024 оны | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | захирагчийн багцад хамаарах байгууллагуудын санхүүгийн тайланг хүлээн авах, хагас, бүтэн жилээр нэгтгэн Үндэсний аудитын газарт хүргүүлэн аудит хийлгэх, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн баталгаажуулах. | • Аудитлагдсан байх тайлангийн тоо-1. | жилийн эцсийн санхүүгийн тайланг НББОУСтандартын дагуу үнэн зөв бэлтгэн боловсруулж, хуулийн хугацаанд гарган Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Мөн Сангийн яамны Е-Тайлан цахим сайтад шивж Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгүүлсэн. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын 2024 оны жилийн эцсийн тайлан тэнцэлд Үндэсний аудитын газраас аудит хийн баталгаажуулж, 2025 оны 02 сарын 25-ны өдрийн 07/740 дугаартай албан бичгээр ҮАГ-ын "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ХББОСЯ-ны төв аппарат, улсын төсвийн хөрөнгө оруулалт, "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК, "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ, "Цемент шохой" ТӨХХК, "Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо", Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа, Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа, 21 аймаг болон нийслэлийн ГХБХБГ, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын хаалтын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Замын-Үүдийн дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргаа, Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц төсөл, зэрэг 33 байгууллагын санхүүгийн тайланд нэгтгэгдэн 2024 оны жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн.<br>Өмнөх оны аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг гаргаж цаасаар болон аудитын цахим системд байршуулсан. Сайдын багцын 2024 оны хөтөлбөр хүрэх үр дүнгийн биелэлтийг нэгтгэн Сангийн яам болон УИХ төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлсэн. | |
| 6.3.3 | **Арга хэмжээ 6.3.3:**<br>Норм, нормативын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын санхүүжилтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хянах | Норм, нормативын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын санхүүжилтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хагас, | Барилга, байгууламжийн норм нормативын сангийн үйл ажиллагааны 2025 оны батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан 9.6 тэрбум төгрөгийн өртөг 170 ажлын хүрээнд 2.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 63 ажлын санхүүжилтийг хянасан. | 80 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | бүтэн жилээр тухай бүрд нь хянах | | |
| 6.3.4 | **Арга хэмжээ 6.3.4:** Ажилчдын цалин хөлсийг олгож, нийгмийн даатгалын санд болон Татварын албанд төлөх татвар хураамжийг хуульд заасан хугацаанд багтаан төлж барагдуулан тайланг хүргүүлэх. | Ажилчдын цалин хөлсийг олгож, нийгмийн даатгалын тайланг 6 удаа, татварын тайланг 2 удаа хуульд заасан хугацаанд илгээж, төлбөр хураамжийг сар болгон төлнө. Тооцоо нийлсэн актаар өр авлагыг баталгаажуулна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын хэмжээнд эхний 11 сарын байдлаар 32 удаа удаагийн цалин олголтоор 4.8 тэрбум төгрөгийн цалин олгосон.<br>Сайдын багцын хэмжээнд Татварын тайлан 4 удаа илгээсэн. Үүнд:<br>- Яамны 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1,2,3 дугаар улирал,<br>- "20 минутын хот хөгжлийн төв"-ийн 2025 оны 3-р улирлын тайланг хуулийн хугацаанд хийж илгээсэн.<br>Сайдын багцын хэмжээнд Нийгмийн даатгалын тайлан 12 удаа илгээсэн. Үүнд:<br>- Яамны 1-11 сарын нийгмийн даатгалын тайлан,<br>- "20 минутын хот хөгжлийн төв"-ийн 7-11 сарын тайланг хуулийн хугацаанд хийж илгээсэн. Хүлээгдэж буй гүйцэтгэл 2025 оны 12 дугаар сарын багцын хэмжээний 2 удаагийн тайлан илгээнэ. | 100 |
| 6.3.5 | **Арга хэмжээ 6.3.5:** Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангуулах. | • Төлөвлөгөө батлуулах-1;<br>• Хэрэгжилтийн хувь 90 хувь | БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтэц" төсөл"-ийн хүрээнд бий болсон нийт 3.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 491 дүгээр тогтоолоор "Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэх шийдвэр гаргуулсан.<br>Энэ дагуу хөрөнгийг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулах явцад "Хангай хотхон" ХХК-аас 2 удаа шүүхэд хандсаны улмаас хөрөнгийн өмчлөлийн асуудал удаашралтай болсон.<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 128/ШШ2023/0032 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 221МА2023/0322 дугаар магадлалаар тус тус Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 491 дүгээр тогтоолоор төрийн өмчийг бүртгэх, хөрөнгө хүлээлцэхээр шийдвэрлэснийг хууль бус гэж үзээгүй учир дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/128 дугаар тушаалаар "Ажлын хэсэг" ажиллаж байна. Ажлын хэсгийн байгуулагдан хурлыг 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр хуралдуулахаар | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | төлөвлөсөн хэдий ч ашиглагч байгууллагын хүсэлтийн дагуу 2 удаа хойшлуулаад байна.<br>Мөн тус яамны "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах" төслийн хүрээнд бий болсон "Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргаа"-ны бүртгэлд байгаа 1,208.0 сая төгрөгийн үлдэгдэл хөрөнгийн үнэлгээ нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэмт хэргийн шинжтэй эсэхэд хуулийн дүгнэлт авахаар холбогдох баримт бичгийг Хуулийн хэлтэсд 2025 оны 4/1234 дугаартай албан бичгээр хандсан байгаа. | |
| **Зорилт 6.4: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах** | | | | |
| **6.4.1** | **Арга хэмжээ 6.4.1:**<br>Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төсөл, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн талаар шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд байршуулах. | • Шилэн дансанд байршуулах мэдээллийн тоо-26;<br>• Хэрэгжилт-100% | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг 1 удаа, дараа жилийн төсвийн төслийн 1 удаа, тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон эсэх мэдээллийг 11 удаа, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон эсэх мэдээллийг 11 удаа тухай бүр шилэн дансанд тогтмол мэдээлж, хуулийн хугацаанд байршуулсан.шилэн дансны системд 26 удаагийн мэдээлэл байршуулсан. | 90 |
| **6.4.2** | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр), Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, Санхүүгийн тайлан, Байгууллагын батлагдсан төсөв, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн | Хуулийн хугацаанд Шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд холбогдох 92 мэдээллийг байршуулсан байна. | "Шилэн дансны тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын дагуу www.shilendans.gov.mn цахим хуудсанд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 2025 оны эхний 11 сарын байдлаар 88 мэдээлэл байршуулахаас хуулийн хугацаанд 92 мэдээллийг байршуулсан. | 95 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан болон бусад мэдээллүүдийн талаар шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд байршуулах. | | | |
| **6.4.3** | **Арга хэмжээ 6.4.3:** Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтын төлөвлөгөө гүйцэтгэлийн мэдээлэл оруулах. | Хуулийн хугацаанд Шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд холбогдох 13 мэдээллийг байршуулсан байна. | Шилэн дансны хуулийн дагуу Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлийг шилэн дансны цахим хуудсанд тухай бүр, сар бүр, улирал бүр, жилээр оруулах мэдээ мэдээллийг сар бүрийн 8-ны дотор шилэн дансны системд нийт 13 мэдээлэл байршуулсан. | 90 |
| **6.4.4** | **Арга хэмжээ 6.4.4:** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн гүйцэтгэлийн талаар шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд байршуулах | Хуулийн хугацаанд Шилэн дансны цахим мэдээллийн хуудас / https://info.shilendans.gov.mn/-нд байршуулах үүрэг бүхий 25 мэдээллийг бүрэн байршуулсан байна. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд уг хуулийн 6.1.1, 3.6.3, 6.4.6 дахь заалт буюу /shilendans.gov.mn/ цахим системийн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт цэсийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны тайлан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, бусад цэсийн худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн гэсэн нийт 25 мэдээлэл оруулахаас 25 мэдээллийг оруулсан. Хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй. Хэрэгжилт 100 хувь. | 100 |
| **6.4.5** | **Арга хэмжээ 6.4.5:** Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /ТШЗ/-ын төсөв, гүйцэтгэлийн бүх мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн талаар шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд байршуулах | 2025 онд шилэн дансны мэдээ /Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн мэдээлэл/-ний тоо-25 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг 1 удаа, тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон эсэх мэдээллийг 11 удаа, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон эсэх мэдээллийг 11 удаа сар бүр шилэн дансанд тогтмол мэдээллэн хугацаанд нь байршуулсан.<br>Хүлээгдэж буй гүйцэтгэл 2025 оны 12 дугаар сарын 14 мэдээллийг байршуулана. | 95 |

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **94.95** хувьтай, **"БҮРЭН ХАНГАЛТТАЙ"** гэж үнэлэгдэж байна.

Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах зорилтын хагас жилээр хэргэжээд бүтцээр ТЗУГ-т шилжсэн арга хэмжээнүүдийг жилийн эцсийн тайлангийн хяналт-шинжилгээнд оруулаагүй болно.

Тус газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээ, зорилтот түвшин нь хэрэгжилттэй нийцэхгүй, тухай газрын албан хаагчдаас шалтгаалан нийцэх боломжгүй ажлуудаа зорилтод түвшиндээ тусгасан нь үнэлгээ буурахад нөлөөлж байна.

Арга хэмжээ 6.2.2, 6.2.3-ын хувьд албан бичиг холбогдох газруудруу явуулснаар тайлагнасан, цаад байгууллагын шийдвэрийг харгалзан үзэж шийдвэр гаргаагүй, 6.2.4 төлөвлөсөн гүйцэтгэлийн 79 хувь нь хэрэгжсэн нь хэрэгжилтийн 92.9 хувь, 6.3.3 тоон мэдээлэл дутуу байна.

Мөн холбогдох албан газруудад явуулсан бичгээр биелэлтээ хаасан нь хангалтгүй, бичгийнхээ үр дүнг үзээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим нэгдсэн хуудсанд байршуулах зорилтын хүрээнд хугацаа хоцролт, хавсралт файл оруулах, төсөвт байгууллагын "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт"-ийг оруулаагүй байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

_Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ц.Ариунсанаа/-т зөвлөмж болгох нь:_

1. Шилэн дансанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроохгүй хуулийн хугацаанд иж бүрэн байршуулах /хавсралт мэдээллийг цаг тухайд нь оруулах, хоцорч оруулахаар хугацаа хоцорсон ангилалд шилжинэ/;

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөө, бусад бодлогын бичиг баримтуудад тусгагдсан ажлуудыг арга хэмжээ тус бүрээр тухайн жилдээ хэрэгжих боломжтой зорилтот түвшинг тодорхойлж, зорилт, арга хэмжээ нь хоорондоо уялдсан, тухайн шалгууртай үнэлэх боломжтойгоор, бодит үр дүнд хүрэх, хэрэгжихэд нөлөөлөх гадны хүчин зүйлсээ тооцож төлөвлөгөөг гаргахад анхаарч ажиллах.

ХЯНАСАН:

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАЙРАМДАЛ

БОЛОВСРУУЛСАН:

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЧИНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

# САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 он

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

# САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.12.18

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримталсан.

## Хоёр. Танилцуулга

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлангийн биелэлтийг үндсэн материал болгон ашигласан.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын нь 2025 онд 6 зорилтын хүрээнд 59 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар **96.35 хувьтай** буюу "бүрэн хангалттай" үнэлэв. Гүйцэтгэлийн тайланд 85-аас дээш хувьтай хэрэгжсэн 59 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээний биелэлтийн хувийг товчоолон хүснэгт-1, хүснэгт-1.1-д тус тус үзүүлэв.

*Хүснэгт-1*

| № | Ажил үйлчилгээ | Зорилт | Арга хэмжээний тоо | Гүйцэтгэл | | | Биелэлт /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 85-аас дээш хувьтай | 70-85% хүртэлх | 70 хүртэлх | |
| 1 | Нийт арга хэмжээ | 6 | 59 | 59 | - | - | **96.35** |

*Хүснэгт-1.1*

| № | Дугаар | хувь | Дугаар | хувь | Дугаар | хувь | Дугаар | хувь | Дугаар | хувь | Дугаар | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | **6.1** | **95.5** | **6.2** | **97.8** | **6.3** | **92.5** | **6.4** | **95.0** | **6.5** | 97.1 | **6.6** | 96.3 |
| 1 | 6.1.1 | 90 | 6.2.1 | 90 | 6.3.1 | 100 | 6.4.1 | 100 | 6.5.1 | 100 | 6.6.1 | 100 |
| 2 | 6.1.2 | 90 | 6.2.2 | 100 | 6.3.2 | 90 | 6.4.2 | 90 | 6.5.2 | 100 | 6.6.2 | 100 |
| 3 | 6.1.3 | 90 | 6.2.3 | 100 | 6.3.3 | 90 | 6.4.3 | 100 | 6.5.3 | 100.0 | 6.6.3 | 90 |
| 4 | 6.1.4 | 90 | 6.2.4 | 90 | 6.3.4 | 90 | 6.4.4 | 90 | 6.5.4 | 90.0 | 6.6.4 | 100 |
| 5 | 6.1.5 | 90 | 6.2.5 | 90 | | | | | 6.5.5 | 100.0 | 6.6.5 | 90 |
| 6 | 6.1.6 | 100 | 6.2.6 | 90 | | | | | 6.5.6 | 90.0 | 6.6.6 | 100 |
| 7 | 6.1.7 | 100 | 6.2.7 | 100 | | | | | 6.5.7 | 100.0 | 6.6.7 | 90 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 6.1.8 | 100 | 6.2.8 | 100 | | | | | | | 6.6.8 | 100 |
| 9 | 6.1.9 | 100 | 6.2.9 | 100 | | | | | | | 6.6.9 | 100 |
| 10 | 6.1.10 | 100 | 6.2.10 | 100 | | | | | | | 6.6.10 | 90 |
| 11 | 6.1.11 | 100 | 6.2.11 | 100 | | | | | | | 6.6.11 | 95 |
| 12 | | | 6.2.12 | 100 | | | | | | | 6.6.12 | 100 |
| 13 | | | 6.2.13 | 100 | | | | | | | 6.6.13 | 100 |
| 14 | | | 6.2.14 | 100 | | | | | | | 6.6.14 | 100 |
| 15 | | | 6.2.15 | 100 | | | | | | | 6.6.15 | 90 |
| 16 | | | 6.2.16 | 100 | | | | | | | | |
| 17 | | | 6.2.17 | 100 | | | | | | | | |
| 18 | | | 6.2.18 | 100 | | | | | | | | |

## Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

*Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:*

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| 2.4.7.хууль тогтоомж, сайдын шийдвэр, салбарын бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, нэгдсэн тайлан гаргах, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах; | | | | |
| 6.1 | Хууль тогтоомж, бодлого төлөвлөлт, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгдсэн тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргах | | | 95.5 |
| 6.1.1 | Монгол Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-т туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. | ХШҮ хийж, ЗГХХГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж тайлан, дүгнэлтийг 2025.9.01-ний өдрийн 08/3281 бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн. | 100 |
| 6.1.2 | Монгол Улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах. | ХШҮ хийж, ЗГХХГ-т хүргүүлж (https://unelgee.gov.mn/)-д баталгаажуулсан байна. | - Үндэсний аудитын газраас 01.08-01.28-ны хооронд "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан яамны эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэсэн бөгөөд хэрэгжүүлсэн 21 арга хэмжээ, болон батлагдсан 5 хавсралтын хамт 2021-2024 оны өссөн дүнгээр нэгтгэн тайлагнаж, батлагдсан төсөв, зарцуулсан санхүүжилт гүйцэтгэлийг нотлох баримтаар баталгаажуулах ажлыг зохион байгуулж холбогдох судалгааг гаргаж өгч ажилласан. Тус яам 54.5 хувьтай үнэлэгдсэн талаар 2025.02.05-ны өдөр танилцуулж удирдлагуудаар баталгаажуулсан. | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | - "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан санал авч нэгтгэн 2025.04.13-ны өдрийн 03/1309 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.<br>- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025.11.11-ний өдрийн 01/27 дугаартай баталсан удирдамжийн хүрээнд МУХОХ-т тусгагдсан Ногоон нуур 1008 орон сууцны төсөл, санхүүжилт шийдвэрлэх шаардлагатай Шинэ Зуунмод хотын хөрөнгө оруулалт, зураг төсөл ТЭЗҮ боловсруулах шаардлагатай ажлын хэрэгжилтийн талаар АХ 2025.11.14-ний өдөр тус яаманд ажилласан бөгөөд холбогдох хэрэгжилт санхүүжилтийн мэдээлэл, нотлох баримтуудыг газруудаас гарган нэгтгэж 2025.11.20-ны өдөр очиж тулгалт хийсэн. | |
| 6.1.3 | Монгол Улсын Их Хурлын 2024 35 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-нд туссан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, ЗГХХГ-т хүргүүлж (https://unelgee.gov.mn/)-д баталгаажуулсан байна. | - Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолын хавсралтаар батлагдсан журмын цагалбараар жилийн эцэст тайлагнана. /Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/<br>- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ нь яамнаас хүргүүлсэн санал мөн эсэх, санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэрийг нэг бүрчлэн нягталж, хэрэгжүүлэх боломжгүй, хамааралгүй ажлын талаарх мэдээллийг гаргах, мөн тус яамны эрхлэх асуудлын хүрээний төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зарцуулсан хөрөнгө, нотлох баримтын хамт ирүүлэх талаар 2025.04.30-ны өдрийн 10/1126 дугаартай албан бичгийг газруудад хүргүүлсэн.<br>- Хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн 2025.07.01-ний өдөр цахим системд баталгаажуулан, 01/2575 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.<br>- "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-нд туссан эрхлэх асуудлын хүрээний арга хэмжээний хэрэгжилт хагас жилийн байдлаар "үр дүн хүлээгдэж байгаа" гэж үнэлэгдсэн тул төсөл, арга хэмжээг батлагдсан зорилтот түвшинтэй уялдуулан холбогдох арга хэмжээг авч эрчимжүүлэх, эзэнжүүлэх, хэрэгжилтийг бүрэн хангах талаар анхаарч ажиллах шаардлагатай байгааг 2025.11.10-ны өдрийн 08/1270 дугаартай дотоод албан бичгийг газруудад хүргүүлсэн.<br><br>- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025.11.11-ний өдрийн 01/26 дугаартай баталсан удирдамжийн хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2024-2028, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй төсөл | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | арга хэмжээний хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийх ажлын хэсэг тус яаманд 2025.11.17,24-ний өдөр ажилласан бөгөөд холбогдох 16 төсөл арга хэмжээний хэрэгжилт, хэрэгжилт хангалтгүй нөхцөл шалтгаан, санхүүжилтийн гүйцэтгэл, нотлох баримтын хамт 2025.11.27-ны өдөр хүргүүлсэн. | |
| 6.1.4 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218-р тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, ЗГХЭГ-т хүргүүлж (https://unelgee.gov.mn/)-д баталгаажуулсан байна. | “Салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогиоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хуваарь шинэчлэн батлах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08-р сарын 29-ны өдрийн А/117 тушаалыг батлуулж газруудад 2025 09-р сарын 01-ны өдрийн 08/1222 тоот дотоод албан бичгээр хүргүүлсэн.<br>Хагас жилийн биелэлтийг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан ирүүлэх тухай” 2025 оны 06-р сарын 02-ны өдрийн 10/1180, жилийн эцсийн биелэлтийг “Тайлан ирүүлэх тухай” 2025 оны 12-р сарын 02-ны өдрийн 08/1289 дугаар албан бичгийг хүргүүлж биелэлтийг авч хяналт-шинжилгээ хийсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолоор батлагдсан журмын 1-р хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын хүрээнд, цагалбарын хугацаанд цахим систем (https://unelgee.gov.mn/)-д хагас жилээр 7-р сарын 01-ны өдөр баталгаажуулсан.<br>2025 оны жилийн эцсийн биелэлтийг журмын цагалбараар 12-р сарын 20-ны дотор баталгаажуулна.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 90 |
| 6.1.5 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, ЗГХХГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолоор батлагдсан журмын 1-р хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын цагалбарын хугацаанд жилийн эцсээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж цахим систем (https://unelgee.gov.mn/)-д баталгаажуулна. | 90 |
| 6.1.6 | Салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаа тайлагнах хуваарийг шинэчлэн батлуулах. | Шинэчлэгдэн гарсан байна. | “Салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогиоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хуваарь шинэчлэн батлах тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08-р сарын 29-ны өдрийн А/117 тушаалыг батлуулж газруудад 2025 09-р сарын 01-ны өдрийн 08/1222 тоот дотоод албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.1.7 | Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, тайлан нэгтгэх . | 2025 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 4 зорилт, 42 арга хэмжээтэйгээр төлөвлөн боловсруулж, төсвийн шууд захирагчаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 42 арга хэмжээний 39 арга хэмжээний биелэлтийг хагас жилээр нэгтгэж, 3 арга хэмжээг ХБ үнэлж тайлганасан.<br>Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуулийн хүрээнд бүтэц хийгдэж Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар болсноор газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 58 арга хэмжээтэйгээр төлөвлөж батлуулсан. Тайлан нэгтгэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдэж байна.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 100 |
| 6.1.8 | Сайдын шуурхайд танилцуулах мэдээллийг бэлдэх, өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэж тайлагнах. | Мэдээллийг бэлдэж, үүрэг даалгавар хэрэгжсэн байна. | 2025 оны жилийн эцсийн байдлаар 12 удаагийн сайдын шуурхай хуралдаанд ХШҮДАГ-ын мэдээлэл бэлдэж, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг цаг хугацаанд 100% хангаж ажиллалаа. | 100 |
| 6.1.9 | Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны баримт материалыг архивлах | Архивын нэгж үүсгэн үдсэн баримтуудыг архивт хүлээлгэн өгсөн байна. | Газрын 2024 оны 28 боть баримт бичгийн цаасан болон цахим бүрдлийг хангаж, архив бичиг хэрэгт хүлээлгэн өгсөн. | 100 |
| 6.1.10 | Газрын ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтөлж, хяналт тавих | Бүртгэл хөтлөгдөж, дүн мэдээ тайланд тусах. | 2024 оны жилийн эцсийн байдлаар бусад албан байгууллагаас нийт 1287 албан бичиг тус газарт ирсэн байна. Ирсэн бичгүүдээс хариугүй 459, хариу хүргүүлсэн 794, судлагдаж байгаа 31 бичиг байна.<br>Явсан бичиг 517 албан бичгийг байна. Хугацаа хоцорсон бичиг байхгүй. | 100 |
| 6.1.11 | Газрын өргөдөл, гомдлын бүртгэл хөтөлж, хяналт тавих | Бүртгэл хөтлөгдөж, дүн мэдээ тайланд тусах. | 2024 оны жилийн эцсийн байдлаар 4 гомдол бүртгэгдэж хуулийн хугацаанд нь шийдвэрлэлээ. | 100 |
| 6.2 | Сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нэгдсэн тайлан зөвлөмж, гаргах | | | 97.8 |
| 6.2.1 | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын | ХШҮ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж (https://unelgee.gov.mn/)-д баталгаажуулсан байна. | Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолоор батлагдсан журмын цагалбарын хугацаанд цахим систем (https://unelgee.gov.mn/)-д 7-р сарын 01-ний дотор баталгаажуулж, тайланг хүргүүлсэн.<br>2025 оны жилийн эцсийн биелэлтийг журмын цагалбараар 12-р сарын 31-ны дотор баталгаажуулна.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | | | |
| 6.2.2 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж яамны удирдлагуудад танилцуулсан байна. | Сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн хооронд батлан гаргасан нийт 61 тушаалыг хяналтад авч 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар хэрэгжилтийг нэгтгэн тооцлоо. Үүнээс 33 тушаал 100 хувь хэрэгжиж дууссан, 8 тушаал хүчингүй болсон тул хяналтаас хассан. Ажил үргэлжилж байгаа 10-90 хувийн хэрэгжилттэй 10, хугацаа болоогүй 10 арга хэмжээ тус тус байна.<br>Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн хооронд батлан гаргасан нийт 70 тушаалыг хяналтад авч 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Үүнээс 52 тушаалын хэрэгжилт бүрэн хэрэгжсэн, 3 хүчингүй болсон тул хяналтаас хассан. Ажил үргэлжилж байгаа 8, хугацаа болоогүй 4, хүчингүй болгох 3 арга хэмжээ тус тус байна.<br>Удирдлагын зөвлөлийн 2025.08.29, 2025.10.13-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлсэн. | 100 |
| 6.2.3 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг гаргаж, тайлагнах | Үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг цаг хугацаанд нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн байна. | Яамны 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нэгдсэн тайланг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 02-р сарын 27-ны өдрийн “Тайлан хүргүүлэх тухай” 01/788 дугаар албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт холбогдох журмын цагалбарын хугацаанд хүргүүлсэн.<br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 02/747 тоот албан бичгээр яамны 2024 оны нэгдсэн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн албан бичгийн хүрээнд 11 зөвлөмжийн биелэлтийг гарган “Зөвлөмжийн биелэлт хүргүүлэх тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10-р сарын 28-ны өдрийн 02/3983 тоот албан бичгийг хүргүүлсэн. | 100 |
| 6.2.4 | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, тайланг Сайдын зөвлөлийн хуралд танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах талаар яамны дотоод газруудад “Хагас жилийн биелэлт ирүүлэх тухай” 2025 оны 06-р сарын 02-ны 10/1181 дугаар албан бичгийг хүргүүлж биелэлтийг авч хяналт-шинжилгээ хийж байна.<br>Монгол улсын Хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2025 оны 43-р тогтоолоор батлагдсан журмын 3-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын цагалбарын хугацаанд цахим систем (https://unelgee.gov.mn/)-д 7-р сарын 01-ны дотор баталгаажуулсан ажиллаж байна.<br>2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт ирүүлэх 2025 оны 06-р сарын 02-ны өдрийн 10/1180, жилийн | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | эцсийн биелэлт ирүүлэх талаар “Тайлан ирүүлэх тухай” 2025 оны 12-р сарын 02-ны өдрийн 08/1289 дугаар албан бичгийг хүргүүлж биелэлтийг авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр ажиллаж байна.<br>Журмын хүрээнд үнэлгээг хийж цахим систем (https://unelgee.gov.mn/)-д 12-р сарын 31-ны дотор баталгаажуулна.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | |
| 6.2.5 | Харьяа байгууллагын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах **/БХТ/** | ХШҮ хийж, удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 94 хувьтай үнэлэгдсэнийг Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.<br>Жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхээр ажиллаж байна.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 90 |
| 6.2.6 | Харьяа байгууллагын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах **/“ТОСК” ТӨХХК/** | ХШҮ хийж, удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК–ийн 2025 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг 6хагас жилээр үнэлсэн.<br>Жилийн эцсийн үнэлгээг хийж байна.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 90 |
| 6.2.7 | Төсвийн ерөнхийлөн захирагчтай аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2024 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргаж, тайлагнах | ХШҮ хийж, ТЗУГ-т хүргүүлсэн байна. | Төсвийн ерөнхийлөн захирагч аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2024 оны гэрээний 1502 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 87,4%-тай буюу “тодорхой үр дүн хүрсэн” үнэлж, 2025 оны 01-р сарын 09-ны өдрийн 02 дугаар дотоод албан бичгээр Төрийн захиргаа удирдлагын газарт хүргүүлсэн. | 100 |
| 6.2.8 | ТЗУГазрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, яамны удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах талаар яамны дотоод газруудад “Хагас жилийн биелэлт ирүүлэх тухай” 2025 оны 06-р сарын 02-ны 10/1181 дугаар албан бичгийг хүргүүлж биелэлтийг авч хяналт-шинжилгээ хийсэн.<br>2025 оны жилийн эцсийн биелэлтийг хуваарийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр авч хяналт шинжилгээ хийнэ.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 100 |
| 6.2.9 | СХОГазрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, яамны удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах талаар яамны дотоод газруудад “Хагас жилийн биелэлт ирүүлэх тухай” 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10/1181 дугаар албан бичгийг хүргүүлж биелэлтийг авч хяналт-шинжилгээ хийж байна.<br>2025 оны жилийн эцсийн биелэлтийг хуваарийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр авч хяналт шинжилгээ хийнэ.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 100 |
| 6.2.10 | ХБОСБЗГазрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, яамны удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | ХББОСБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд ХШҮ хийж, санал зөвлөмж, дүгнэлт гарган тайланг удирдлагын зөвлөлд танилцуулан зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.2.11 | НААБЗГазрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, яамны удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | Байгууллагын үйл ажиллагааг тайлагнах талаар яамны дотоод газруудад "Хагас жилийн биелэлт ирүүлэх тухай" 2025 оны 06-р сарын 02-ны 10/1181 дугаар албан бичгийг хүргүүлж биелэлтийг авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 86.2%-тай үнэлэгдсэн.<br>2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт ирүүлэх 2025 оны 06-р сарын 02-ны өдрийн 10/1180, жилийн эцсийн биелэлт ирүүлэх талаар "Тайлан ирүүлэх тухай" 2025 оны 12-р сарын 02-ны өдрийн 08/1289 дугаар албан бичгийг хүргүүлж биелэлтийг авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 92.9%-тай үнэлэгдсэн.<br><br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 100 |
| 6.2.12 | ББМБЗГазрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, яамны удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан тус газарт хүргүүлсэн.<br>Жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнахаар бэлтгэж байна.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 100 |
| 6.2.13 | СХШҮДАГазрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах | ХШҮ хийж, яамны удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | Жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнахаар бэлтгэж байна.<br>/Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 100 |
| 6.2.14 | Яамны сар бүрийн үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэн боловсруулж, тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан www.new.unelgee.gov.mn -д баталгаажуулах | ХШҮ хийж, яамны удирдлагуудад танилцуулж, Зөвлөмж гарган холбогдох газарт хүргүүлсэн байна. | Байгууллагын сар бүрийн гүйцэтгэсэн ажлын тайланг тухай бүр нэгтгэн new.unelgee.gov.mn цахим хаягт тухай бүр хугацаанд нь мэдээлэл оруулан хянуулж баталгаажуулсан. | 100 |
| 6.2.15 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан www.new.unelgee.gov.mn сайтаар баталгаажуулах | Үнэлгээ хийсэн тайланг Сайдын зөвлөлийн хуралд танилцуулж, яамны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланд хавсарган цаг хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, 2025.02.12-ны өдрийн 03/506 дугаар албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.2.16 | Яамны болон харьяа байгууллагуудын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн ажилд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | Үнэлгээ хийсэн тайланг Сайдын зөвлөлийн хуралд танилцуулж, Яамны нэгдсэн тайланд хавсарган цаг хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Яамны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын 2024 оны 46 арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан www.new.unelgee.gov.mn-д баталгаажуулж, тайланг 2025.01.02-ны өдрийн 03/03 дугаар албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн. | 100 |
| 6.2.17 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, ТББ-аар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний хүрээнд Төсвийн шууд захирагчийн ТББ-уудтай байгуулсан гэрээний 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргаж, тайлагнах | ХШҮ хийж тайланг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан байна. | "Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах" чиг үүргийг "Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 80.6 хувьтай "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлж, дүгнэлт, зөвлөмжийг 2025 оны 01-р сарын 15-ны өдрийн 10/162 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Мөн тус ТББ-д өгсөн дүгнэлт, зөвлөмжийг 2025 оны 01-р сарын 14-ны өдрийн 3 дугаар дотоод албан бичгээр ТЗУГ, ББМБЗГ-т хүргүүлсэн.<br>"Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-аар гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээний 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 70 хувьтай дүгнэгдсэн бөгөөд тайланг 2025.02.19-ний 10/651 тоот албан бичгээр "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-д хүргүүлсэн.<br>"Барилгын инженерүүдийн холбоо" ТББ-тай байгуулсан гэрээний 2024 оны хэрэгжилтэл хяналт шинжилгээ, үнэлгээг 2025 оны 2 дугаар сард хийж тайлан гарган удирдлагад танилцуулсан.<br>Үнэлгээгээр "Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны төлөвлөгөө", "баталсан чиг үүргийг гүйцэтгүүлэх ажлын төсөв нь гэрээний салшгүй хэсэг байна" гэсэн заалтууд хэрэгжээгүй<br>/яамнаас төсөв батлаагүй/ шалтгаанаар үнэлэх боломжгүй байсан болно.<br>БХБ-ын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар баталсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх удирдамжийг 2025.05.15-ны өдөр ТНБД-аар батлуулж, тус ТББ-д хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ хийсэн. | 100 |
| 6.2.18 | Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоол **"Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж"** төсөл, арга хэмжээний | ХШҮ хийж тайланг удирдлагын зөвлөлийн хурал | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сард өгсөн чиглэлийн хүрээнд Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоол **"Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл,** | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргаж, тайлагнах | танилцуулсан байна. | **арга хэмжээ, 2014-2021 онд хэрэгжсэн “Сумын төвийн шинэчлэл”, “Шинэ сум төсөл” зэрэг төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийлээ. Сумуудын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ нэвтэрсэн мэдээллийг яамны** Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газарт, харьяа “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аас авч авч нэгтгэсэн.<br>Нэгтгэлийн хүрээнд “Дотоод томилолтоор ажиллах тухай” Хот байгуулалт, Барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/45 дугаар тушаал батлуулан, тушаалын 1-р хавсралтаар батлагдсан удирдамжид заасан 6 **сумдын инженерийн шугам сүлжээний ашиглалтад** хяналт, шинжилгээ хийж тайланг танилцуулсан.<br>Хяналт-шинжилгээгээр 8 дүгнэлт, 8 зөвлөмжийг гаргаж, зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах талаар 2025 оны 04-р сарын 29-ны өдрийн “Хяналт-шинжилгээ хийсэн тайлан хүргүүлэх тухай” 10/1121 дугаар дотоод албан бичгийг Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн. | |
| 6.3 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | | | 92.5 |
| 6.3.1 | Албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журмыг хэрэгжүүлэн ажиллаж, тайлан мэдээ гаргана. | ХАСХОМ-73 | Төрийн нарийн бичгийн даргын 2025.02.25-ны өдрийн 03/716 дугаар албан бичгээр тус яамны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн 2024 оны тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | 100 |
| 6.3.2 | Шинээр томилогдох албан хаагчдын хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг гаргуулж, хянуулах | Шинээр томилогдох албан хаагчдын тоогоор | Яамны төрийн захиргааны зарим албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн 58 албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулж, Авлигатай тэмцэх газраар хянуулсан. | 90 |
| 6.3.3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай гаргасан мэдэгдэл, тайлбарыг бүртгэж, тайлагнах | Мэдэгдэл, тайлбар гаргасан тоогоор | Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг цахимаар авч бүртгэн хяналт тавин ажиллаж байна. | 90 |
| 6.3.4 | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тайлагнах | 2 удаа тайлагнах | Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 2025.01.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, холбогдох нэгжүүдэд албан бичгээр хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн Авлигатай тэмцэх газрын /http://khutulbur.iaac.mn/ цахим системд баталгаажуулсан. | 90 |
| 6.4 | Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн зарцуулалтад дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх | | | 95 |
| 6.4.1 | Яамны дотоод аудитын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтийг хангах | Яамны дотоод аудитын хороог шинэчлэн батлуулна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2025 оны төлөвлөгөө 4 арга хэмжээ төлөвлөн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулсан байна. | | |
| 6.4.2 | Яам, агентлаг, харьяа байгууллага, төслийн нэгжүүдийн шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж, улирал бүрийн нэгдсэн тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх | Шилэн дансны тухай хуульд заасан хугацаа, шаардлагыг хангаж тайланг улирал бүр Сангийн яаманд хүргүүлсэн байна. | Шилэн дансны тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон яамны шилэн дансанд байршуулсан мэдээллүүдийг нэгтгэн 1 дүгээр улирлын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 10/1287 дугаар албан тоот, 2 дугаар улирлын тайланг 2025 оны 07 дугаар сарын 09-ний 03/2691 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн тайланг https://auth.itc.gov.mn/- шилэн дансны цахим системээр цаг тухайд нь илгээсэн. 2025 оны 4 дүгээр улирлын тайланг 2026 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлнэ. /Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/ | 90 |
| 6.4.3 | Сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас гаргасан аудитын зөвлөмжийн биелэлтийг хангуулах | Үндэсний аудитын газраас гаргасан аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтэд хяналт тавьж биелэлтийг ҮАГ-т тухай бүр хүргүүлсэн байна. | Үндэсний аудитын газрын Санхүүгийн тайлангийн аудитын систем https://fas.audit.mn/ -д Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг нотлох баримтын шаардлага хангуулан хянан илгээсэн. Үндэсний аудитын газарт 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 01/3272 дугаартай албан бичгээр төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн. | 100 |
| 6.4.4 | Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр хийгдсэн 2025 оны үйл ажиллагаа, дотоод аудитын тоон болон бичмэл тайланг хүргүүлэх | Тайланг цаг хугацаанд нь СЯ-нд хүргүүлсэн байна. | Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, дотоод аудитын тоон болон бичмэл тайланг хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 100%-тай байна. | 90 |
| 6.5 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг үйл ажиллагааны стратегийн зорилтуудтай уялдуулан тодорхойлох, төлөвлөх, эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж, хэрэгжүүлэх, дүгнэх, нэгдсэн удирдлагаар хангана. | | | 97.1 |
| 6.5.1. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналт шалгалтын төлөвлөгөө, хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг батлуулах; | “Хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг ХҮҮХ-т хүргүүлж, батлуулсан байна. Эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг ХББОСайдаар | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^1$ дүгээр зүйлийн $5^1.3$-т заасны дагуу Хот байгуулалт, барилгын салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөг Хяналт үнэлгээний үндэсний хороонд 2024 оны 03/1091 дугаар албан бичгээр хүргүүлж, уг төлөвлөгөөг тус хорооны 2024 оны 02 дугаар тушаалаар батлуулсан.<br>“Хот байгуулалт, барилгын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн, 2025 онд хяналт шалгалтад хамрагдах 312 объектын жагсаалт”-ыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 119 дүгээр тушаалаар баталсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | батлуулсан байна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 339 объектын жагсаалт болон хяналт шалгалтын төлөвлөгөөг 2026 оны хяналт шалгалтад хамруулах зорилгоор 2025 оны 02/4044 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | |
| 6.5.2. | Хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт тавих, зохион байгуулах, эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтыг боловсруулж батлуулах; | 2025 онд 2664 объектод эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтээр эрсдэлийн үнэлгээ хийнэ. | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^5$ дугээр зүйлийн $5^5$.3-т заасны дагуу Хот байгуулалт, барилгын техник, цахилгаан, дулаан, өргөх байгууламжийн хяналтын чиглэлээр 3420 объектод эрсдэлийн үнэлгээ хийснээс их эрсдэлтэй 1417, дунд эрсдэлтэй 1682, бага эрсдэлтэй 321 эрсдэлтэй объект үнэлэгдсэнийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 50 дугаар тушаалаар батлуулсан. | 100 |
| 6.5.3. | Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журамд санал өгөх; | Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журамд санал өгсөн байна. | Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргын 2024.12.16-ны А/23 дугаар тушаалаар ажлын хэсэгт орж ажиллан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд 8 санал, Хяналт шалгалтын нийтлэг журамд тусгуулахаар 3 саналыг Хяналт, үнэлгээ үндэсний хороонд 2025.03.24-ний 11/1015 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 6.5.4. | “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулах | “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, батлуулсан байна. | “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Барилга байгууламжийн ашиглалт (ногоон, шар, улаан)-ын гэрчилгээ загвар”-ыг нэмэлтээр боловсруулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.05.22-ны өдрийн 118 дугаар тушаалаар батлуулсан. ХДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр 2025.05.26-ны өдрийн 01/2010 дугаар албан бичгээр хүргүүлсний дагуу ХЗДХС-аас “Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай” 2025.06.06-ны өдрийн 1/3116 дугаар албан бичгийг ирүүлж, Legalinfo.mn-д байршуулсан. “Журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” Аймаг, нийслэлийн Засаг дарга, НХШГ, аймгийн ГХБХБГ-т 2025.06.12-ны өдрийн 01/2323 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | 90 |
| 6.5.5. | Салбарын холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичиг болон төсөл хөтөлбөрийн төсөлд санал өгөх. | Салбарын холбогдох хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм нормативын баримт бичгийн төсөлд санал өгсөн байна. | Салбарын холбогдох 9 хууль, 6 норм ба дүрэм, 6 журам, 2 стандартын төсөлд санал өгч, 3 хуулийн шинэчилсэн найруулга, 3 норм ба дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллаж, 1 журмын нэмэлт өөрчлөлтийн боловсруулан батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн. | 100 |
| 6.5.6. | Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт | Хяналт шалгалтын | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 2025 оны хяналт | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тавих, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах | гүйцэтгэл 98.8 хувь байна. | шалгалтын хагас жилийн гүйцэтгэл, үр дүнг тооцож 97.1 хувьтай хэрэгжүүлсэн. | |
| | | Хяналт шалгалтын гүйцэтгэлийн жилийн эцсийн тайланг ХҮҮХ-т хүргүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын ХҮҮХ-ны 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг гаргаж **ncoe.gov.mn** цахим шуудангаар Засгийн газрын ХҮҮХ-д, 2025 оны жилийн эцсийн тайланг Засгийн газрын ХЭГ-т тайлагнаж 2025 оны 02/4612 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 6.5.7. | Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврын дагуу ажиллах; | Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг 100 хувь биелүүлсэн байна. | Сайд, Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн үүрэг даалгавар, Шүүх, АТГ, цагдаагийн байгууллагаас ирүүлсэн 15 тогтоол, ажлын хэсгийн 14 тушаал, шийдвэрийн дагуу ажиллаж, 5 албан даалгавар, ерөнхий байцаагчийн 3 дүгнэлт, шинжээчийн 10 дүгнэлт, 1 техникийн даалгаврыг гарган ажилласан.<br>Мөн ХБХБС, ЗТС-ын 8 тушаалын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллан, 35 үүрэг даалгавар өгч, тэдгээрийн биелэлтийг хангуулж ажилласан. | 100 |
| 6.6 | Хот байгуулалт, барилгын материал, өргөх байгууламж, техник, технологи, тоног төхөөрөмж, инженер геологи, барилга байгууламж, цэвэр ус, ариутгах татуурга, цахилгаан, дулаан хангамж, шугам сүлжээний зураг төсөл, угсралт, ашиглалтын явцад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилт, техникийн чанар аюулгүй байдлыг хангуулна. | | | 96.3 |
| 6.6.1. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 18 объектод төлөвлөгөөт шалгалт хийх;<br>АХ-2050- 2.5.11,<br>*МУХТЖҮЧ-8.1.8, 9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4, 4.2.4.3,* | Төлөвлөгөөт 18 объектод хяналт шалгалтыг хийж, хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ. | ХҮҮХ-ны 2024 оны 02 дугаар тогтоол, ХББОСС-ын 2024 оны 119 дүгээр тушаал, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02-00/04 дүгээр удирдамжийн дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 18 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 18 барилга байгууламжийг хяналт шалгалтад 100 хувьтай хамруулж, 138 зөрчил дутагдал илэрснээс 126 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 133 заалт бүхий 13 албан шаардлага, 5 дүгнэлт, 15 заалт бүхий 1 зөвлөмжийг хүргүүлэн 3 байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээг авч улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 88 хувьтай.<br>Улсын хэмжээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын 312 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 303 барилга байгууламжийг хяналт шалгалтад 97.1 хувьтай хамруулж, 1509 зөрчил дутагдал илэрснээс 1223 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 697 заалт бүхий 177 албан шаардлага, 18 заалт бүхий 5 дүгнэлт, 2 акт, 1440 заалт бүхий 105 зөвлөмжийг хүргүүлэн 12 байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээг авч 42.0 сая төгрөгийн торгууль шийтгэл ногдуулж, улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | бичгийн шийдвэрийн биелэлт 87 хувьтай, 301 барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангуулсан. | |
| 6.6.2. | Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр болон өргөтгөл, шинэчлэл хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх; *УХТЖҮЧ-9.3.2, 9.3.3, ЗГҮАХ-2.4.3.4* | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 720 объектод хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 02-00/06 дугаар удирдамжийн дагуу улсын хэмжээнд 1027 объектод хяналт шалгалтыг хийсэн. Улсын хэмжээнд Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжуудын дагуу 155 иргэн 870 аж ахуй нэгжийг байгууллагын 1025 барилга байгууламжийг хяналт шалгалтад хамруулж 4595 зөрчил илрүүлснээс 2552 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 874 заалт бүхий 170 албан шаардлага, 50 акт, 127 дүгнэлт, 3609 заалт бүхий 259 зөвлөмж, 731.550.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 60 барилга байгууламж, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг зогсоож, эрх бүхий албан тушаалтны албан даалгаврыг өгч, улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 86 хувьтай хэрэгжиж, 668 барилгын чанар аюулгүй байдлын хангуулж ажилласан. | 100 |
| 6.6.3. | Соёл урлаг боловсролын байгууллагын барилга байгууламжийн чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх; | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 19 объектод хийж гүйцэтгэсэн байна. | ХББОСЯ, БЯ-ны хамтарсан Салбарын улсын ерөнхий байцаагчдын баталсан 2025 оны 02-00/28, 03-00/12 дугаар удирдамжийн дагуу соёл, урлаг, боловсролын байгууллагын барилга байгууламжийн чанар аюулгүй байдалд соёл, урлаг, боловсролын 183 объект буюу барилгад хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтад хамрагдсан 64 сургуулийн барилгаас барилгын ашиглалтын төлөв байдал, орчны аюулгүй байдлын шаардлага хангаагүй 75 хувь буюу 48 сургууль, 68 цэцэрлэгийн барилгаас барилгын ашиглалтын төлөв байдал, орчны аюулгүй байдлын шаардлага хангаагүй 55.8 хувь буюу 38 цэцэрлэг нийт 86 барилга буюу 65 хувьтай байна. | 90 |
| 6.6.4. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэгцээ, шаардлагыг хангуулах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөлд тусгуулах, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх; *МУХТЖҮЧ-3.2.4.,* ЗГҮАХ-2.4.2.4 | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 825 объектод хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 02-00/06 дугаар удирдамжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор улсын хэмжээнд 2118 иргэн, ААНБ-ын шинээр баригдаж буй 822, ашиглагдаж байгаа 1296 барилгад хяналт шалгалт хийж гүйцэтгэн 12878 зөрчил илрүүлэн 8990 зөрчлийг арилгуулж, 107 албан шаардлага, 49 дүгнэлт, 2653 зөвлөмж, 3 акт, 11 иргэн, ААН-д эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, 72,000.000 төгрөгийн шийтгэл ногдуулан 62,000.000 төгрөгийг барагдуулж, улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 88 хувьтай, 1158 барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтөд тусгагдаж, 1962 налуу зам, 984 тэмдэг тэмдэглэгээ, 942 хөтөч зам, 940 ариун цэврийн өрөө, 865 авто зогсоол тус тус төлөвлөн хийгдсэн. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.6.5. | Бетон зуурмаг, бетон эдлэлийн үйлдвэрүүдэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх; *МУХТЖУЧ-3.2.4., МУЗГҮАХ-2.4.2* | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 30 объектод хийж гүйцэтгэн, хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилтийг 85 хувьд хүргэнэ. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 02-00/07 дугаар удирдамжийн дагуу улсын хэмжээнд Бетон зуурмаг, бетон эдлэлийн 105 үйлдвэрт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 17 албан шаардлага өгч, 14 ААН-д 79.5 сая төгрөгийн торгууль оногдуулж, барагдуулан, 14 эрх бүхий албан тушаалтын даалгаврыг хүргүүлж, улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 87 хувьтай, бүтээгдэхүүний технологийн шаардлагыг хангуулсан. | 90 |
| 6.6.6. | Цамхагт краны техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийх; | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 100 цамхагт кранд хийж гүйцэтгэсэн байна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 83 дугаартай тушаал, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025.01.15-ны өдрийн "Цамхагт краны техникийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 02-00/08 дугаартай удирдамж, 2025.04.11-ний өдрийн "Цамхагт краны техникийн аюулгүй байдлыг хангуулах тухай" 02-00/01, 02-00/02 дугаар албан даалгаврын хүрээнд 138 аж ахуйн нэгжийн 158 цамхагт краны техникийн аюулгүй байдалд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн 105 дүгнэлт, 31 албан шаардлага, 1 акт, 2 зөвлөмж хүргүүлж, илэрсэн зөрчилд 101 сая төгрөгний торгуулийн арга хэмжээ авч, бүрэн барагдуулж, хэрэгжилтийг хангуулан, ашиглалтын шаардлага хангахгүй 20 краныг буулгасан, Аяны хүрээнд 10 удаагийн танхимын сургалтыг зохин байгуулж, 320 ИТА хамрагдсан.<br>Улсын байцаагчийн гаргасан эрх зүйн баримт бичгийн шийдвэрийн биелэлт 89 хувьтай, 139 цамхагт краны техникийн аюулгүй байдлыг хангуулсан. | 100 |
| 6.6.7. | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх; | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар болон өргөдөл гомдол, ирсэн хүсэлтийг 100 хувь шийдвэрлэсэн байна. | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 557 иргэн, 4333 аж ахуйн нэгж, байгууллагын 4907 барилга байгууламжид хийж гүйцэтгэн 12621 зөрчлийг илрүүлснээс 10510 зөрчлийг арилгуулж, эрсдэлийн түвшин 5.7 хувиар буурсан бөгөөд улсын байцаагчийн 582 заалт бүхий 3662 албан шаардлага, 25 акт, 915 дүгнэлт, 6268 заалт бүхий 2316 зөвлөмжийг хүргүүлэн 17 байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээг авч 612.850.0 сая төгрөгийн шийтгэл ногдуулж, 25 иргэн, ААНБ-д эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 96.5 хувьтай байна. | 90 |
| 6.6.8. | Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх; | 2025 онд 4 объектод албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт | Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 385 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламжийг гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамруулж 609 зөрчил илрүүлэн 486 зөрчлийг арилгуулж, улсын байцаагчийн 47 заалт бүхий 130 албан шаардлагаар үүрэг өгснөөс 91.5 хувь биелж, 8.5 хувь нь хугацаа болоогүй, 8 акт, 484 заалт бүхий 34 | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | шалгалтыг хийсэн байна. | зөвлөмжийг холбогдох инженер, техникийн ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 4 байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээг авч, 46.5 сая төгрөгийн торгууль шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан. | |
| 6.6.9. | Техникийн магадлал, баталгаажуулалт хийгдсэн өргөх байгууламжийн улсын бүртгэл бүртгэх, техникийн магадлал баталгаажуулалт хийх, барилга байгууламжид гэрчилгээ олгох; | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу 550 өргөх механизмыг улсын бүртгэлд, барилга байгууламжид гэрчилгээ олгосон байна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” 02-00/01, 02-00/03, 02-00/10, 02-00/17 дугаар удирдамжуудын дагуу 2025 онд шинээр угсарсан 399 лифт, 36 эскалаторт бүрэн магадлал хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 2059 заалт бүхий 209 албан шаардлага өгч, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, лифт 417, кран 325, эскалатор 25, барилгын өргүүр 814, сагстай өргөгч 115, бетон зуурмагийн шахуургат тоноглол 28, манипуляторт кран 294 зэрэг нийт 2015 өргөх байгууламжийг улсын бүртгэлд шинээр бүртгэж, 4 барилгад ашиглалтын ногоон гэрчилгээ олгосон. | 100 |
| 6.6.10. | “Шар усны болон үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах тухай” албан даалгавар боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах; | Албан даалгаврын хэрэгжилтийг 70 хувьтай хангагдсан байна. | “Шар усны болон уруйн, хур борооны үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах тухай” 2025 оны 2025/02 дугаар ХББОСС-ын албан даалгаврыг батлуулж, 2025.02.21-ний өдрийн 1/693 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг даргад, 11/663 тоот албан бичгээр аймгийн ГХБХБГ, нийслэлийн Хяналт шалгалтын газар, ХБХСГ, ГУББГ, Монголын Үндэсний Асициаци ТББ, Монголын барилгачдын инженерүүдийн холбоо ТББ, холбогдох байгууллагад хүргүүлсэн.<br>Хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд улсын хэмжээнд 3 аймгийн төв, 7 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 10 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл батлагдсан, Үер, усны аюултай бүс болон үерийн хамгаалалтын зурваст байрлах иргэд, аж ахуйн нэгжид 533 сонсголын мэдэгдэл хүргүүлж, 716 айл өрхийг нүүлгэн шилжүүлсэн. Мөн зөвшөөрөлгүй газар ашигласан 51 айлын 36 хашааг албадан буулгаж, 38 байшингийн газар чөлөөлөх ажил үргэлжилж байна.<br>Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийт 2062 зөвлөмж, 2200 мэдээлэх хуудас, 110 сэрэмжлүүлэг бэлтгэн 8 телевиз, 15 сайтаар олон нийтэд түгээн, 13,616 айл өрхөд хүргүүлжээ.<br>Үерийн хамгаалалтын байгууламжийн лаг цэвэрлэгээний хүрээнд 38 байршилд 65.587 тонн лагийг цэвэрлэсэн. Авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээнд их цэвэрлэгээ хийж 1548.45 м³ лагийг ТХЦ-д тээвэрлэн хүлээлгэн өгсөн. Хөрсний усны мониторингийн ажлыг сар бүр тогтмол хийж, гүйцэтгэл 75 хувьтай байна. Мөн 185 байршлын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах инженерийн байгууламжид үзлэг шалгалт зохион байгуулсан. | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Гамшгийн үед дайчлагдах 287 нэр төрлийн багаж хэрэгсэл, 459 автотехник, 139 хүнд механизмыг бэлэн байдлыг хангаж, шинээр 27.73 км үерийн хамгаалалтын барилга байгууламж баригдаж, 2026 оны улсын болон орон нутгийн төсөвт 3.6 км далангийн бэхэлгээ, засварын ажлыг 9.5 тэрбум төгрөгөөр тусгуулж, биелэлт 95 хувьтай байна. | |
| 6.6.11. | “Барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангуулах тухай” албан даалгавар боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах; | Албан даалгаврын хэрэгжилтийг 80 хувьтай хангагдсан байна. | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын “Барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах тухай” 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 2025/01 дугаар албан даалгаврыг аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагуудад хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал, 2025.02.21-ний өдрийн 1/693 тоот албан бичгийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, мөн өдрийн 11/663 тоот албан бичгийг аймгийн ГХБХБГ, нийслэлийн Хяналт шалгалтын газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Геодези, усны барилга байгууламжийн газар, Монголын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын барилгачдын инженерүүдийн холбоо болон бусад холбогдох байгууллагад хүргүүлж, албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд нийт 717 объектод хяналт шалгалт хийж, илэрсэн 633 зөрчлөөс 308-г арилгуулан, хууль сахин мөрдөлтийн биелэлтийг 48 хувьтай хангаад байна. Шалгалтын үр дүнд улсын байцаагчийн 98 албан шаардлага, 7 акт, 228 дүгнэлт, 45 зөвлөмж гаргаж, 40 иргэн, хуулийн этгээдэд нийт 151.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулж, биелэлт 96 хувьтай байна. | 95 |
| 6.6.12. | Барилга байгууламжийн чанар аюулгүй байдал, өргөх байгууламжийн техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор улсын хэмжээнд аян зохион байгуулах тушаал боловсруулж батлуулах, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлэх, барилга чанар, аюулгүй байдлыг хангуулах | -Аян зохион байгуулах тушаал боловсруулан батлуулсан байна.<br><br>-1098 барилга байгууламжийн чанар аюулгүй байдлыг хангуулсан байна. | Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, техник, технологийн аюулгүй байдал, учирч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Аюулгүй барилга-Аюулгүй ажиллагаа” аяныг зохион байгуулах тухай 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 100/А101 дугаартай хамтарсан тушаал, Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, төлөвлөгөөг гарган батуула аймаг, нийслэлийн Засаг дарга, ХШГ, аймгийн ГХБХБГ, ХХҮГ, ТББ-д 2025.05.12-ны өдрийн 01/1737 дугаар албан бичгээр чиглэл болон тушаал, төлөвлөгөө, удирдамжийн хүргүүлсэн. Улсын хэмжээнд 2025.05.06-2025.06.30-ны өдрүүдэд болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1694 иргэн, аж ахуйн нэгжийг 1751 барилгад хийж гүйцэтгэн 10836 зөрчил илрүүлэн 8984 зөрчлийг арилгуулж, улсын /ахлах/ байцаагчийн 7027 заалт бүхий 726 албан шаардлагыг хүргүүлэн, биелэлт 95 хувьтай, 229 заалт бүхий 77 дүгнэлт, 286 мэдэгдэл, 348 заалт бүхий 111 зөвлөмжийг гарган 1030 аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, 97 иргэн, аж ахуйн нэгжид 175.85 сая төгрөгийн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | шийтгэл ногдуулж, 10 байгууллагад 73.34 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьж, 66 барилгын үйл ажиллагааг түр зогсоож, 5 барилгын үйл ажиллагааг сэргээж, 36 удаагийн үзүүлэх сургалтад 2409 аж ахуйн нэгжийн 8553 инженер техникийн ажилтныг хамруулан зохион байгуулж, 21 телевиз, вэб сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгч, 52 зөвлөмж, 51 постер, 26 вэб сайтын цахим хуудсанд нийтэлсэн, 1694 иргэн аж ахуйн нэгжийн 1751 барилгад хяналт шалгалт хийж гүйцэтгэн 1110 барилга байгууламжийн чанар, хөдөлмөр хамгаалалтын түр хашаа, хамгаалах тор, хаалт, хашлага, шат, мэдээллийн самбар, эрсдэлээс сэргийлэх тэмдэг тэмдэглэгээг хийлгүүлж, 95 цамхагт краны техникийн аюулгүй байдлыг хангуулсэн. Биелэлт 98 хувьтай байна. | |
| 6.6.13. | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах; | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээг авсан байна. | ХББОСЯ-ны салбарын хяналтаас 2025 онд нийт 36 зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хялбаршуулсан журмаар 27, зөрчлийн хэрэг нээсэн 2, гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан 4, харъяаллын дагуу шилжүүлсэн 3 хэрэг бүртгэгдсэн. 4 иргэн, 30 аж ахуйн нэгжийн 21 барилга, 15 краны үйл ажиллагааг эрх бүхий албан тушаалтны даалгавраар зогсоож, 207.8 сая төгрөгийн торгууль ногдуулж, барагдуулсан.<br>Улсын хэмжээнд 177 барилга байгууламжийн үйл ажиллгааг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр зогсоож, 1.433.500.000 төгрөгийн торгууль ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн. | 100 |
| Салбарын сургалт зохион байгуулах ажлын хүрээнд: | | | | |
| 6.6.14. | Салбарын хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалтыг цахим болон танхимын зохион байгуулах. | Сургалтыг зохион байгуулсан байна. | 1.ХББОСЯ-ны Салбарын хяналтын газраас Нийслэлийн хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэстэй хамтран хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, мэргэшүүлэх, салбарын төрөөс баримтлах бодлого, анхаарах асуудал, хяналт шалгалтын ажлын гүйцэтгэл, үр нөлөөг сайжруулах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, техникийн аюулгүй ажиллагааг хангуулах, тулгамдаж байгаа асуудлаар санал солилцох, туршлага судлах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой сургалтыг 2025.02.10-ны өдөр цахимаар, 2025.02.13-14-ний өдрүүдэд танхимаар зохион байгуулж, нийслэл Хяналт шалгалтын газар болон 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналт, барилга байгууламжийн техникийн хяналт, өргөх байгууламжийн хяналтын нийт 62 улсын (ахлах) байцаагчид хамрагдсан.<br>Хяналт, үнэлгээний Үндэсний хороо, Ёс зүйн хороо, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Засгийн газрын | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хяналт хэрэгжүүлэх газар, Улсын ерөнхий Прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-ын Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл, "Монкон" ХХК, "Монголын Ажил Олгогчдын Эвлэлийн Нэгдсэн Холбоо" ТББ, "Харилцагчийн зөвлөх Полиси төв" зэрэг байгууллагаас илтгэл мэдээллийг хийж, хамтран ажилласан.<br>2.Барилгын салбарын инженер, техникийн ажилтан болон удирдах албан тушаалтнуудын хууль, эрх зүйн мэдлэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор улсын хэмжээнд 36 удаагийн сургалт зохион байгуулж, 1518 аж ахуйн нэгжийн 12,480 ажилтныг хамруулан мэдлэг, мэдээллээр хангаж ажилласан. | |
| 6.6.15. | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивт хүлээлгэн өгөх. | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг 100 хувь шийдвэрлэн, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивт хүлээлгэн өгсөн байна. | Тайлант хугацаанд салбарын хяналтад нийт 1057 албан бичиг, 62 өргөдөл гомдол хүлээн авснаас 715 албан бичиг, 59 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, хариугүй 310, судлагдаж байгаа 32, явсан 313 албан бичиг, шийдвэрлэлт 95.4 хувьтай.<br>Хяналт шалгалтын 53 удирдамж, улсын ахлах байцаагчийн 240 албан шаардлага, 129 дүгнэлт, 5 албан даалгавар, 3 улсын ерөнхий байцаагчийн дүгнэлт үйлдэн архивт хүлээлгэн өгсөн. | 90 |
| | | | | **96.35** |

### Дөрөв. Дүгнэлт

1. Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын 59 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж жилийн эцсийн байдлаар **96.35** хувьтай буюу "бүрэн хангалттай" үнэлэгдсэн байна.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зарим арга хэмжээний зорилтот түвшинг ажлын тоо хэмжээ, цаг зарцуулалтыг зөв тооцоолон үр дүнтэй байхаар төлөвлөх шаардлагатай байна.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлууд нь Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журамд заасан цаглабарын дагуу жилийн эцсийн тайлангууд нь харилцан адилгүй хугацаанд илгээх, цахим системд баталгаажуулдаг тул хүлээгдэж буй гүйцэтгэлээр арга хэмжээнүүдийг 90 хувьтай үнэлгээ хийлээ.

### Тав. Санал, зөвлөмж

1. Нэгжийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамааруулан тухайн жилдээ хэрэгжүүлэх боломжтой зорилтот түвшинг тооцож гаргах, хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх хугацааг

нарийвчлан тооцож нөөцийг бүрэн ашиглан хэрэгжүүлэхэд хүрч болох түвшингээр тооцон төлөвлөх;

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний үзүүлэлтийг тоогоор, чанараар хэрхэн хэмжиж болохыг урьдчилан нарийвчлан тооцох, тодорхойлох, тухайн арга хэмжээг гүйцэтгэх шат дамжлага дарааллын хувьд хуваалт хийн зорилтот түвшин, суурь түвшинг тодорхой байхаар төлөвлөгөөндөө тусгах;

3. Газрын төлөвлөгөөний суурь түвшин нь тоо баримт судалгаанд үндэслэх, зорилтот түвшин нь тооцоололд үндэслэсэн байх, тайлагнахдаа хийж хэрэгжүүлсэн ажлууд нь тухайн чиглэлд ямар ахиц, дэвшил үзүүлсэн үр дүнгийн үзүүлэлтээр товч тодорхой байхаар тайлагнаж байх;

4. Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт “Байгууллага болон зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн тайлангийн загвар”-ын шаардлагад нийцүүлэн, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан, товч тодорхой, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах;

5. Бодлогын баримт бичиг болон холбогдох хяналт-шинжилгээ, үнэлгээний жилийн эцсийн тайланг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журамд заасан цаглабарын дагуу хугацаанд хүргүүлж ажиллахыг зөвлөмжийг хүргүүлж байна.

Тайланг хянасан:
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын дарга Б.Найрамдал

Боловсруулсан:

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын ахлах шинжээч Д.Мөнгөнсувд